



ХӨДӨЛМӨР,
НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН ЯАМ



ЗАСГИЙН ГАЗРЫН
ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ
ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮНИЙ
ХӨГЖЛИЙН ЕРӨНХИЙ ГАЗАР

ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛ БА ТЭГШ ХҮРТЭЭМЖ

2023

ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ
ОНОЛ ПРАКТИКИЙН
ХИ ХУРЛЫН ЭМХЭТГЭЛ



БОЛОВСРОЛ



ДЭД БҮТЭЦ



ХУУЛЬ,
ЭРХ ЗҮЙ



ЭРҮҮЛ
МЭНД



НИЙГМИЙН
ХАМГААЛАЛ



ХӨДӨЛМӨР
ЭРХЛЭЛТ

УЛААНБААТАР ХОТ
2023 он



ХӨДӨЛМӨР,
НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН ЯАМ



ЗАСГИЙН ГАЗРЫН
ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ
ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮНИЙ
ХӨГЖЛИЙН ЕРӨНХИЙ ГАЗАР

“ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛ СУДЛАЛ БА ТЭГШ ХҮРТЭЭМЖ–2023” ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ ОНОЛ ПРАКТИКИЙН ХИ ХУРЛЫН ЭМХЭТГЭЛ



БОЛОВСРОЛ



ДЭД БҮТЭЦ



ХУУЛЬ,
ЭРХ ЗҮЙ



ЭРҮҮЛ
МЭНД



НИЙГМИЙН
ХАМГААЛАЛ



ХӨДӨЛМӨР
ЭРХЛЭЛТ

УЛААНБААТАР ХОТ
2023 ОН

“ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛ СУДЛАЛ БА ТЭГШ ХҮРТЭЭМЖ–2023”
ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ ОНОЛ ПРАКТИКИЙН XI ХУРЛЫН ЭМХЭТГЭЛ

Хянан тохиолдуулсан:	Б.Амаржаргал
Хэвлэлд бэлтгэсэн:	Х.Сансармаа
Хэвлэлийн эх бэлтгэсэн:	Н.Сувд–Эрдэнэ

Цаасны хэмжээ:	210x297мм
Хэвлэлийн хуудас:	15 х.х
Хэвлэсэн газар:	“Туургатан Принтинг” хэвлэх үйлдвэрт хэвлэв.

ГАРЧИГ

ӨМНӨХ ҮГ	7
I БҮЛЭГ - БОЛОВСРОЛ	9
Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг ерөнхий боловсролын сургуульд тэгш хамруулан суралцахад дэмжлэг үзүүлж, хөгжүүлэх боломж, арга туршлага	10
Б.Энхтунгалаг ¹ , Я.Сэлэнгэ, Б.Наранцацралт, С.Шоовдор, С.Цэрэнчимэд, Н.Түмэн–Эрдэнэ, Ш.Сувдаа, Бямбажав ²	
<i>¹Бага ангийн багш, ²Орхон аймгийн Ерөнхий боловсролын 3, 4 дүгээр сургууль</i>	
Тэгш хүртээмжтэй боловсролыг олгох явцад хүүхдийн ахицыг үнэлэх туршлага, үйл ажиллагаа	12
Б.Ариунбилэг ¹	
<i>¹79 дүгээр сургуулийн сургалтын менежер</i>	
“Тэгш хамруулах хөтөлбөр”-ийн хэрэгжилтийн талаарх хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн эцэг эхийн хандлага	14
Э.Энх–Оюун ¹	
<i>¹ХУД-ийн 23-р хороо Арцатын 4-р гудамж 63 дугаар сургууль</i>	
Тэгш хамруулан сургах боловсролын үйлчилгээ, туршилт, үр дүн, асуудал	16
Э.Мөнхзул ¹	
<i>¹Орхон аймгийн 4 дүгээр сургуулийн бага ангийн багш</i>	
Сургуулийн өмнөх насны аутизмын хүрээний эмгэгтэй хүүхдийн танин мэдэх үйлийн онцлог	19
А.Хонгорзул ¹	
<i>¹МУБИС, БСС, БСАЗ-н тэнхим Боловсрол судлаач – III курс</i>	
Сонсголын бэрхшээлтэй хүүхдийн боловсролд тулгамдаж буй асуудал	21
Б.Дангаасүрэн, М.Ариунзул, О.Уртнасан, Ц.Алтанцэцэг, Г.Оюунгэрэл ¹	
<i>¹НЭБ-ийн 29 дүгээр сургууль</i>	
Сурагчдын бусдыг энэрэх чадвар болон академик чадвартаа итгэх итгэлд тэгш хамруулах боловсролын үзүүлэх нөлөөг судалсан нь	24
О.Анужин, Н.Болортунгалаг, Э.Жаргал, С.Хишигжаргал ¹	
<i>¹Монгол Улсын Их Сургууль, Сэтгэл Судлалын Тэнхим</i>	
Хөгжлийн бэрхшээлтэй суралцагчдыг хичээлээс гадуурх сургалтын үйл ажиллагаагаар хөгжүүлэх нь	26
Б.Адъяасүрэн, Г.Ганжаргал, Ө.Дэлгэрмөрөн, Б.Мөнхбадрал, З.Цолмонгэрэл ¹	
<i>¹Дундговь аймаг дахь Политехник коллежийн багш нар</i>	
Ялгаатай хэрэгцээтэй сурагчдын хөгжлийн ахиц	31
Д.Мөнхбаатар ¹ , Л.Жавзанпагма ² , А.Дуламсүрэн ³ , Б.Цэрэнханд ⁴	
<i>¹Захирал, ²Сургалтын менежер, ³Нийгмийн ажилтан, ⁴Тусгай хэрэгцээт боловсролын багш</i>	
Насан туршийн боловсролын төвд хөгжлийн ялгаатай хүүхдийн боловсролд хамрагдалт, өнөөгийн нөхцөл байдал	36
Б.Одбаяр, Б.Нансалмаа, Т.Алтанбаясгалан, М.Насанжаргал ¹	
<i>¹Чингэлтэй дүүргийн Насан туршийн боловсролын төв</i>	
Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн боловсролд насан туршийн боловсролын төв, нэгжийн оруулж буй үүрэг, оролцоо	39
Г.Халиун, Э.Баясгалан ¹	
<i>¹Боловсролын Судалгааны Үндэсний Хүрээлэн</i>	
Аутизмтай хүүхдийн суралцахуйг дэмжих туршилт, үр дүн	42
Д.Аззаяа ¹	
<i>¹Увс аймгийн Улсын Тэргүүний Ерөнхий боловсролын Лаборатори Нэгдүгээр Цогцолбор сургууль</i>	

II БҮЛЭГ - ДЭД БҮТЭЦ	45
Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн сурч боловсрох хүртээмж	46
Ц.Нямаа ¹ , Г.Ууганбаатар ² , ¹ УБЭИС, Инженерийн сургууль, судлаач, ² УБЭИС, ИС, судлаач	
Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн архитектур орон зайн хүртээмжийн ашиглалтын шинэлэг систем	49
Н.Нарантуяа ¹ ¹ Архитектор, Хот төлөвлөлтийн судлаач, ШУТИС, БАС, Архитектурын салбарын ахлах багш	
Тэргэнцэртэй иргэний суралцах орчны үнэлгээний асуудал	54
Б.Эрдэнэзул ¹ ¹ Шинэ Монгол Технологийн Дээд Сургууль	
Тусгай хэрэгцээт суралцагч оюутнуудын онцлогт тохирох сургалтын орчин бүрдүүлэх нь	56
С.Ариунцэцэг ¹ , Д.Наранцацрал ² ¹ ШУТИС, Бизнесийн Удирдлага Хүмүүнлэгийн сургуулийн Нийгмийн ухааны салбарын ахлах багш, докторант. ² ШУТИС, Бизнесийн Удирдлага Хүмүүнлэгийн сургуулийн Хүмүүнлэгийн ухааны салбарын ахлах багш	
Хүртээмжтэй налуу зам 2023–2024 “Угсармал налуу зам”	59
Э.Бумжинсүрэн ¹ , Д.Золзаяа ² ¹ Рояаль Олон Улсын Их сургуулийн Архитектурын 204-р бүлгийн оюутан. ² Рояаль Олон Улсын Их сургуулийн Архитектурын хөтөлбөрийн удирдагч багш	
Тэргэнцэртэй иргэдийн нийтийн тээврээр зорчих тэгш хүртээмжийг нэмэгдүүлэх арга замыг судалсан нь	63
А.Оюун–Эрдэнэ, Б.Пүрэвсүрэн ¹ ¹ МУИС-ийн Шинжлэх ухааны сургуулийн Нийгмийн ухааны сургууль	
III БҮЛЭГ - ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙ	65
Хорих ялаар шийтгүүлсэн хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн ял хэргийн байдлыг судалсан нь	66
Д.Өлзийчимэг, Б.Гомбо, Б.Бэхбаатар, Г.Цэрмаа ¹ ¹ 401 ХХА–НЭ, Мэдрэлийн тасаг	
Хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэй хоригдлын хорих ял эдлүүлэх ажиллагаанд тулгамдаж буй асуудал, шийдвэрлэх арга зам	68
Н.Удвалцэцэг ¹ ¹ 407 дугаар нээлттэй, хаалттай хорих ангийн нийгмийн ажилтан, хууль зүйн ухааны магистр, хошууч	
Хөгжлийн бэрхшээлтэй хүний орон байрны эрхийн талаарх мониторинг	70
Я.Авирмэд, Г.Давааням ¹ , Н.Тамирхүү, Х.Мөнхтуул ² , З.Насандэлгэр ³ , Д.Ууганбаяр ⁴ ¹ Түгээмэл хөгжил төв. ² Японы олон улсын хамтын ажиллагааны агентлагийн Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тогтолцоог бэхжүүлэх төсөл. ³ Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй гэр бүлийг дэмжих “Ундарга” төв. ⁴ ЖИ ПИ ЭИ Глобал Монгол ХХК, Менежер	
Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуульд хийсэн системийн арга зүйн шинжилгээ	72
Г.Уянга ¹ , Л.Долгор ² ¹ ХААИС-ийн багш, ² Нийгмийн эрүүл мэнд судлаач	
Сонсгол, хэл ярианы бэрхшээлтэй хүн гэмт хэргийн субъект болох нь тэдний биеийн хэлэмж, онцлог	74
Н.Бадамцэцэг ¹ ¹ Нийслэлийн Шүүх шинжилгээний газар, Цагдаагийн дэслэгч	
Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст хууль зүйн туслалцаа үзүүлж буй хятад улсын үндэсний тогтолцоо ба туршлага	77
А.Хандмаа LL.M ¹ ¹ Их Засаг ОУИС-ийн Их Засаг хууль зүйн сургууль, Эрх зүйн тэнхимийн ахлах багш	

IV БҮЛЭГ - ЭРҮҮЛ МЭНД	79
Аутизмын хүрээний эмгэгтэй хүүхдийн “Нийгмийн харилцааны хэв шинж”-ийг үнэлэх нь	80
С.Сувдмаа ¹ , Б.Дорждэрэм ² ¹ ХБХСЗХТөв, <i>Сэргээн засахын эмч</i> , ² <i>Сэтгэл зүйч</i>	
Аутизмтай хүүхдийг дэмжих үйл ажиллагаа	81
Б.Анхмаа, Ё.Ууганбаяр ¹ ¹ <i>Нийслэлийн 263 дугаар цэцэрлэг</i>	
Үгээрээ ярих чадвар маш бага эсвэл байхгүй аутизмтай хүүхдүүдийн хэл яриаг хөгжүүлэхэд “Миний хоолой” хэл яриаг орлуулах, хөгжүүлэх аппликейшнийг хавсруулан ашигласан судалгааны дүн	83
М.Нандинхүслэн ¹ , Ч.Сүрэнжав ^{1,2} , А.Долгорлхам ^{1,2} , Б.Солонго ^{1,3,4} ¹ <i>Аутизм ба Бусад Онцгой Хүүхдүүдийн Академи</i> , ² <i>Сэтгэл зүйч, Зан үйл засалч</i> , ³ <i>Хүний их эмч, Хөгжлийн эмгэг ба тэгш хамруулах боловсролын мэргэжилтэн, Зан үйл засалч, Колумбын Их Сургуулийн төгсөгч</i> , ⁴ <i>Төслийн удирдагч</i>	
Тархины саатай хүүхдийн булчингийн чангарлыг цохилтот долгионоор эмчилсэн үр дүн	85
Х.Туул, С.Сувдмаа, Б.Бат-Уянга ¹ , Ц.Наранцэцэг, А.Балжинням ² ¹ <i>Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн сэргээн засах хөгжлийн төв</i> , ² <i>АШУУИС АУС СЗАУТ</i>	
Аутизмын хүрээний эмгэгтэй хүүхдүүдэд зураг солилцох харилцааны систем (PECS)-ийг ашигласан үр дүн	87
Л.Лхагвасүрэн, Б.Цэнд-Аюуш, Б.Солонго ¹ , Б.Мөнх-Эрдэнэ ² ¹ <i>Нийслэлийн 186 дугаар цэцэрлэг</i> , ² <i>Бие Бялдар Судлалын Тэнхим, Сувилахуйн сургууль, АШУУИС</i>	
Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрт илрүүлэг, дэмжлэгийн үйлчилгээ	89
Э.Нэргүй ¹ ¹ <i>10-р цэцэрлэг</i>	
Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн шүд, нүүр амны өвчний эмчилгээний хүртээмжийг дээшлүүлэх нь	91
П.Эрдэнэбулган, Э.Билгүүн ¹ ¹ <i>АШУУСИ-НАСС, Нүүр амны технологи эрүүл ахуйн тэнхим</i>	
Хөгжлийн хөтөч вадемикум хэрэгслийг ашиглан хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн хөгжлийн түвшнийг үнэлэх нь	93
Э.Цэнгэл ¹ ¹ <i>Энэрэлийн Түүчээ ТББ-ын судлаач, багш</i>	
V БҮЛЭГ - НИЙГМИЙН ХАМГААЛАЛ	95
Түгшүүрийн түвшин, түүнийг бууруулах зарим арга зам	96
Г.Сумъяабаатар ¹ ¹ <i>(Ph.D), Архангай аймгийн ГБХЗХГ-ын мэргэжилтэн</i>	
Хөгжлийн бэрхшээлтэй иргэд сонгох, сонгогдох эрхээ эдлэхэд тулгардаг саад бэрхшээл, асуудал ба шийдэл	98
Х.Батчимэг ¹ ¹ <i>Монгол Улсын Их Сургууль, Социологи нийгмийн ажлын тэнхимийн магистрант</i>	
Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй эцэг эхчүүдийн стресс, түгшүүрийн судалгаа	100
А.Отгонбаатар ¹ ¹ <i>Хүслийн Ордон тусгай цэцэрлэг, Сэтгэл зүйч</i>	
Хөгжлийн бэрхшээлтэй иргэдтэй харилцах харилцаа, нийгмийн хандлага, хүний эрхэд бэлтгэх нь	102
Д.Цэндмаа ¹ ¹ <i>Говьсүмбэр аймаг, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн “Өөдрөг” зөвлөл холбооны тэргүүн</i>	

Хорих ял эдэлж буй хөгжлийн бэрхшээлтэй хоригдлыг нийгэмшүүлэх ажлын өнөөгийн байдал, тулгамдаж буй асуудал	104
Г.Батжаргал ¹ <i>¹Дотоод хэргийн их сургууль, Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн албаны сургууль</i>	
Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн хөгжлийн хэрэгцээг хангах асуудал	107
М.Довууч ¹ <i>¹Отгонтэнгэр их сургууль</i>	
Хөгжлийн бэрхшээл судлалын үр дүнгийн асуудалд	109
О.Баттуяа, М.Ганхөлөг, Ц.Цолмон, Ө.Гангамаа ¹ <i>¹Мандах их сургуулийн СШУИТ-н багш нар</i>	
Хөгжлийн бэрхшээлтэй хүнд үзүүлэх нийгмийн халамж, үйлчилгээний загвар, парадигмууд, чиг хандлага	111
Ц.Энхтүвшин ¹ <i>¹Олон Улсын Улаанбаатарын Их Сургууль, Нийгмийн Ажлын Тэнхим</i>	
Багш нарын түгшүүр болон ажлаас халшрах хам шинжийг харьцуулан судалсан нь	113
Э.Биндэръяа ¹ <i>¹МУБИС, БОСС сэтгэл судлалын магистрант</i>	
Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй эцэг эхийн хэрэгцээ шаардлагыг тодорхойлох нь	115
Т.Бадамцэцэг, Д.Одончимэг ¹ <i>¹Ховд аймгийн хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн төв</i>	
VI БҮЛЭГ - ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТ	117
Хөгжлийн бэрхшээлтэй хүний мэргэжлийн ур чадварыг үнэлэх нь хөдөлмөр эрхлэлтэд нөлөөлөх	118
Б.Энхзул, О.Болорчимэг ¹ <i>¹Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сургалт, үнэлгээ, судалгааны институтийн арга зүйч</i>	

ӨМНӨХ ҮГ

НҮБ-ын Ерөнхий Ассамблейгаас жил бүрийн 12 дугаар сарын 03-ны өдрийг Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн өдөр болгон зарласан бөгөөд уг өдрийг угтан хөгжлийн бэрхшээлийн талаарх олон нийтийн ойлголт, мэдлэгийг дээшлүүлэх, хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангахад тулгамдаж буй асуудлыг судалгаа, шинжилгээний үндэслэлтэй шийдвэрлэх, бодлогыг оновчтой томъёолоход нөлөөлөх, улмаар хөгжлийн бэрхшээл судлал салбар шинжлэх ухааныг хөгжүүлэх зорилготой “Хөгжлийн бэрхшээл судлал ба тэгш хүртээмж–2023” сэдэвт 11 дэх удаагийн эрдэм шинжилгээний хурлыг 12 дугаар сарын 01-ний өдөр амжилттай зохион байгууллаа.

Хуралд нийт 100 гаруй судалгааны өгүүлэл ирүүлснээс үзэхэд жил ирэх тусам хурлын цар хүрээ маань улам өргөжиж, салбар бүрийн оролцоо нэмэгдэж, бидэнд хамтран ажиллах, туршлага солилцох боломжийг олгож байгаад талархалтай байна.

Хөгжлийн бэрхшээлийн салбарт орж ирж буй судлаач бүхний оролцоог дэмжин, хичээл зүтгэлийг үнэлж өгүүлэл бүрийг эрдэм шинжилгээний хурлын эмхэтгэлд хэвлүүлдэг байсан бол энэ удаад бид судалгааны ажилд тавигдах гол шалгууруудыг хангасан шилдэг 8 илтгэлийг хуралд хэлэлцүүлж, нийт 50 гаруй өгүүллийг энэхүү эмхэтгэлд нэгтгэснийг та бүхэн хүндэтгэн хүлээн авч үзээрэй.

Тус эрдэм шинжилгээний онол, практикийн хурлыг зохион байгуулахад дэмжиж ажилласан салбарын хамт олон, Монгол Улсын Их сургууль, хамтран ажиллаж үнэтэй санал зөвлөмж өгсөн шүүгчдийн бүрэлдэхүүн, зочин илтгэгчид, өгүүлэл ирүүлсэн болон амжилттай илтгэлээ хэлэлцүүлсэн мэргэжилтэн, эрдэмтэн багш, судлаач, оюутнууддаа талархал илэрхийлж, цаашдын эрдэм судлалын ажилд нь амжилт хүсье.

ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮНИЙ
ХӨГЖЛИЙН ЕРӨНХИЙ ГАЗАР



I БҮЛЭГ

БОЛОВСРОЛ

ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮҮХДИЙГ ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛЬД ТЭГШ ХАМРУУЛАН СУРАЛЦАХАД ДЭМЖЛЭГ ҮЗҮҮЛЖ, ХӨГЖҮҮЛЭХ БОЛОМЖ, АРГА ТУРШЛАГА

Б.Энхтунгалаг¹, Я.Сэлэнгэ, Б.Наранцацралт, С.Шоовдор,
С.Цэрэнчимэд, Н.Түмэн–Эрдэнэ, Ш.Сувдаа, Ч.Бямбажав²

¹Бага ангийн багш, ²Орхон аймгийн Ерөнхий боловсролын 3, 4 дүгээр сургууль
tunga876@gmail.com

Үндэслэл

Дэлхийн улс орнуудын туршлагаас харахад хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн онцлог, суралцах хэрэгцээ шаардлагыг бүрэн хангахад чиглэсэн олон арга хэмжээг авч хэрэгжүүлдэг байна. Суралцаж байгаа хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн 44.4%-ийг сонсгол, хэл ярианы бэрхшээлтэй хүүхдүүд эзэлж байгаа тул эдгээр хүүхдүүдийг түлхүү оношилж арга зүйгээ туршиж, үр дүнг тооцох шаардлагатай байна.

Зорилго

Сонсгол, хэл ярианы бэрхшээлтэй хүүхдүүдийн хөгжлийн түвшинг судалгаагаар тодорхойлж, мэргэжлийн багш нарын тусламжтайгаар сэтгэл зүй, бие бялдрын хөгжлийг дэмжин хөгжүүлэх арга зүйг боловсруулж хэрэгжүүлэн үр дүнг тооцоход оршино.

Судалгааны арга зүй

Орхон аймгийн ЕБ-ын 4 дүгээр сургуулийн АУБ-тай хамтран суралцахууд суурилсан мэргэжлийн хөгжлийн бүлгээрээ хамтран “Сонсгол, хэл ярианы бэрхшээл”-тэй хүүхдүүд болон амжилттай суралцаж байгаа хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг үе тэнгийнхэнтэй нь харьцуулан судаллаа. Бага ангийн суралцагчдад ТХСБ-ын “Ганцаарчилсан сургалтын төлөвлөгөө”-г боловсруулан ажиллах явцдаа сургуулийн суралцахууд суурилсан “Судалгаа шинжилгээ”-ний мэргэжлийн хөгжлийн багаараа хамтран хүүхдийн хөгжлийн түвшинг тодорхойлох энгийн 4 чадварыг гүнзгийрүүлэн М.Хишиг–Ундрах Доктор (Ph.D) дэд профессорын сэтгэлзүйн зурган тестийн “Сэтгэц – геометрийн тест”, “Геометрийн дүрсээр хүн зуруулж оношлох арга”-аар оношиллоо.

Үр дүн

Манай сургуулийн нийт хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн тооноос харахад бага ангийн сурагчид 72.2% эзэлж байна. Үүнээс бага ангийн суралцагчдын дотор сонсгол хэл ярианы бэрхшээлтэй хүүхэд дийлэнх хувийг эзэлж байв. Хөгжлийн түвшинг тодорхойлох энгийн 4 аргад тулгуурлан ахисан түвшинд авсан судалгааг танилцуулж байна (Хүснэгт 1-ээс үзнэ үү).

Зураг 1. Орхон аймгийн Ерөнхий боловсролын 4 дүгээр сургуулийн хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн судалгаа (давхардсан тоогоор)



Амжилттай суралцаж байгаа “Сонсгол, хэл яриа”-ны хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн үе тэнгийнхэнтэй нь харьцуулан харьцуулан судалж үзэхэд үгийн баялаг, зарим үгийн утгыг төдийлөн сайн ойлгодоггүй боловч үе тэнгийнхэнтэйгээ ижил түвшинд суралцаж хөгжиж байна. Хүүхэд 4–1 нь сурах эрмэлзэл ихтэй, бие даан суралцах, өөрийгөө дайчлах чадвар сайтай, мөн эцэг эх асран хамгаалагчдын зүгээс анхаарал халамж их тавьдаг, АУБ-тай хамтран ажилладаг тул ангийн сурагчидтай хамт суралцах арга барил эзэмшсэн, усан бассейн, үндэсний сурын секц, зургийн дугуйлан зэрэгт хамрагдан сургуулийн хэмжээнд бие даасан үзэсгэлэнгээ гарган амжилттай суралцаж байна. Биеийн тамирын хичээлд тогтмол ордог, усан бассейны секцэд хамрагдсан

Хүснэгт 1. Хүүхдийн хөгжлийн түвшин

Энгийн чадвар	Чадвар	Ахисан түвшинг судлах	Хамтран ажиллах									
ӨҮЭЧ	Цэвэрлэх Гар угаах		Гэр бүлийн хамт, АУБ									
Хөдөлгөөн, үйл ажиллагаа	Бөмбөг тоглох		Биеийн тамирын багш, АУБ, МХБ-ийн багш нар									
	Дүрсийг хэвэнд хийх											
	Модон шор											
	Сав болон багаж хэрэгсэл, эд юмс											
	Цагираг ба уяа											
	Цахилгаан, товч, цаас											
	Модон дүрсийг “Пэг” тоглоомын сууринд хийх Үйл ажиллагаа											
Хэл яриа, танин мэдэхүй	Дүрс, өнгө болон эд юмсыг зориулалтаар нь нийлүүлэх, ялгах	<table border="1"> <thead> <tr> <th>Хүснэгт</th> <th>Дүрсийн дүрсээр хүн зурах төст</th> <th>Дүрсийн дүрсээр хүн зурах төст</th> </tr> </thead> <tbody> <tr> <td>4-1</td> <td> </td> <td> </td> </tr> <tr> <td>1-3</td> <td></td> <td></td> </tr> </tbody> </table>	Хүснэгт	Дүрсийн дүрсээр хүн зурах төст	Дүрсийн дүрсээр хүн зурах төст	4-1			1-3			Дүрслэх урлагийн багш, АУБ, МХБ-ийн багш нар
	Хүснэгт		Дүрсийн дүрсээр хүн зурах төст	Дүрсийн дүрсээр хүн зурах төст								
	4-1											
	1-3											
Зураг дүрс зурах, үсэг бичих												
Эд зүйлсийн шинж чанар												
Эд зүйлсийн зориулалт												
Харилцаа, нийгэмшгүй	Өөрийгөө илэрхийлэх	Хүүхдийн дүрс	Биеийн тамирын багш, АУБ, МХБ-ийн багш нар									
		4-1										
		1-3										

тул БЕХ-ийн үзүүлэлтүүд 4 шалгуур тус бүрээр, энгийн хүүхдийн БЕХ-ийн сорилын үзүүлэлтээс дундаж түвшинд ахисан нь судалгаанаас харагдаж байна. Хүүхдийн БЕХ-ийн үзүүлэлт ахих болсон нь биеийн тамирын хичээлдээ дуртай, спортоор хичээллэх хүсэл сонирхол нэмэгдсэн байдал нь нөлөөлсөн.

Дүгнэлт

Сонсгол, хэл ярианы бэрхшээлтэй хүүхдүүд “Эрдэмтэн”, “Түгшүүрийн” хэв шинжтэй байгаа нь тэд биеэ чагнадаг, төрөл бүрийн авьяастай амархан гомддог, өөртөө эргэлздэг, бусдаас урам сонсох дуртай хэв шинж давамгайлдаг, аливаа ажлыг дуустал хийдэг, хөдөлмөрч, хатуужилтай, идэвхтэй, дэг журамд дуртай байдаг нь эдгээр хүүхдүүдтэй ажиллахад үр дүнтэй байна гэсэн дүгнэлтэд хүрсэн. Орхон аймгийн ЕБ-ын 4 дүгээр сургуулийн суралцахууд суурилсан мэргэжлийн хөгжлийн бүлэг нь анги удирдсан багш, асран хамгаалагч болон эцэг эхчүүд, дэмжлэгийн багтай хамтран ганцаарчилсан сургалтын төлөвлөгөөнд тулгуурлан, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг үе тэнгийнхэнтэйгээ хамтдаа сурах, хөгжих боломжийг судлан, арга зүй боловсруулан, мэдлэг эзэмшүүлэн хөгжүүлж үр дүнд хүрлээ.

Түлхүүр үг: Тэгш хамран сургах боловсрол, мэргэжлийн бүлэг, сэтгэл зүйн тест.

Ашигласан материал:

1. IRIM (2018). “Монгол улсын хүүхэд бүрийг боловсролд тэгш хамруулах зарчмыг дэмжих нь” хэрэгцээ тодорхойлох судалгааны тайлан. Монгол Улс, Улаанбаатар хот.
2. ЖАЙКА (2019). “Тусгай хэрэгцээт боловсрол шаардлагатай хүүхдэд үзүүлэх эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын үйлчилгээг сайжруулах төсөл”-ийн судалгааны тайлан. Монгол Улс, Улаанбаатар хот.
3. Карин Шелциг & Кирсти Ньюман (2020). Монгол улсад тэгш хамруулах боловсролыг дэмжих нь.
4. ЖАЙКА (2019). ХБХ-ийн хөгжлийн түвшинг тодорхойлох, багшлах арга зүйн гарын авлага. Монгол Улс, Улаанбаатар хот.
5. Хишиг–Ундрах.М (2017). Сэтгэл зүйн зурган тестүүд. Монгол Улс, Улаанбаатар хот.

ТЭГШ ХҮРТЭЭМЖТЭЙ БОЛОВСРОЛЫГ ОЛГОХ ЯВЦАД ХҮҮХДИЙН АХИЦЫГ ҮНЭЛЭХ ТУРШЛАГА, ҮЙЛ АЖИЛЛАГАА

(79 дүгээр сургуулийн жишээн дээр)

Б.Ариунбилэг¹

¹79 дүгээр сургуулийн сургалтын менежер
ariunbilegbyambaa@gmail.com

Үндэслэл

“Тэгш хамруулан сургах боловсрол нь тулгарч буй аливаа бэрхшээлийг сайн туршлагад тулгуурлан шийдвэрлэхэд чиглэгдэнэ.” Үүний үндсэн дээр өөрийн сургуулийн туршлагаа түгээн дэлгэрүүлж үнэлгээний олон аргуудаас хуваалцана. Ирээдүй хойч үедээ зөв хандлага үлдээхийн тулд тэгш хамран сургах боловсролын хүрээнд тусгай хэрэгцээт боловсрол шаардлагатай хүүхдүүдээ зөв үнэлж дүгнэх, үнэлгээгээр дамжуулан хүүхдийнхээ бэрхшээлийг хүлээн зөвшөөрөхгүй байгаа эцэг эхчүүдийн хандлагыг өөрчлөх хэрэгцээ үүсээд байна. Судалгаагаараа ерөнхий боловсролын сургуульд хамрагдаж буй хүнд, хөнгөн хэлбэрийн бэрхшээлтэй, өөрийгөө хүлээн зөвшөөрсөн, эс зөвшөөрсөн боловсролын тусгай хэрэгцээ шаардлагатай сурагчдыг асран хамгаалагч, багш, сурагчдын хамтын үйл ажиллагаагаар хэрхэн илрүүлж, тэднийг хэрхэн үнэлж, амжилттай сургаж БОЛОВСРОЛД ТЭГШ ХАМРУУЛАХ талаар бага ч гэсэн аргагүйн санаа өгөх, удирдлага аргагүйгээр хэрхэн хангах талаар чиглэл өгөхөд оршино.

Зорилго

2016 оноос хойш Тэгш хамран сургах хөтөлбөрийн хүрээнд боловсролын тусгай хэрэгцээтэй хүүхдийн тоо яагаад нэмэгдэж байгаа, тухайн хүүхдүүд, асран хамгаалагчтай ажиллаж буй арга барил хэрхэн өөрчлөгдөж байгаа, хэрхэн үр дүн гарсан, асран хамгаалагч, багш, сурагчдын үнэлгээ хэрхэн хийгдэж, амжилттай болсон талаарх үр дүнг харуулна.

Судалгааны арга зүй



Түүвэрлэн судлах арга, хэлэлцүүлгийн арга, фокус бүлгийн ярилцлагын арга, ганцаарчилсан ярилцлагын арга, дүн шинжилгээ хийх арга, практик уялдаа холбоо, статистик тооцооллын арга

Үр дүн

Бид дүн шинжилгээ хийхдээ дараах 3-н чиглэлээр үйл ажиллагаа явуулж туршин үзэж хүүхдэд нь ахиц гарангуут эцэг эхийн хандлага хэрхэн өөрчлөгдөж байгааг харуулсан

- Бодит байдлын үнэлгээ /багш, сурагч, асран хамгаалагч/
- Өдөр тутмын явцын үнэлгээ /судлагдахуун, багш нар/
- Хичээлийн жилийн болон шалгалтын үнэлгээгээр дамжуулан эцэг эхчүүдэд уулзалт, хэлэлцүүлэг, сургалт тогтмол зохион байгуулж тэдний хандлага хэрхэн өөрчлөгдөж хүүхдийнхээ бэрхшээлийг хүлээн зөвшөөрч багш нартаа илүү сайн хамтран ажиллаж байгааг харлаа.

Эдгээр үйл ажиллагааны үр дүнд хүүхдүүд би бусад хүүхдүүдтэй адилхан юм байна, миний хүүхэд хичээж байна, чадаж байна, одоо би эцэг эхийнхээ хувьд хүүхэдтэйгээ ингэж ажиллах





юм байна гэсэн урам өгч мөн тухайн хүүхэдтэй ажиллаж буй багш би чадлаа гэсэн итгэл өгөх, өөрөөрөө бахархах боломжийг олгож байгаа нь сайшаалтай байлаа.

Дүгнэлт

Үнэлгээ гэдэг бол дан ганц хүний заасан сургасан үйлийн үр дүн биш харин хамтран хичээж, зүтгэсэн хэн бүхний хамтын бүтээлийн үр дүн юм гэдгийг харууллаа. Ганцаарчилсан сургалтын төлөвлөгөөгөөр хичээллэж буй сурагчдын ахиц, амжилтыг хамтран үнэлж, эцэг эхийн хандлагыг өөрчилснөөрөө манай сургуулийн хувьд жил ирэх тусам сурагчдын тоо нэмэгдэж, өөрийн хүүхдийн хүнд болон хөнгөн хэлбэрийн бэрхшээлийг хүлээн зөвшөөрч хүүхдийг үе тэнгийнхэн, найз нөхөдтэйг нь хамт дэвшин суралцаж, боловсролын тухай хуульд заасны дагуу ерөнхий боловсролыг эзэмшүүлэх эрхийг нь зөрчихгүй байх маш том ажил юм. Манай сургуулийн хувьд нийт 72 сурагчаас 21-н сурагч нь эрүүл мэндийн байгууллагын оноштой бөгөөд бусад сурагчид нь эцэг эхийн хүсэлтээр оношлуулахыг хүсдэггүй, хүүхдийнхээ бэрхшээлийг хүлээн зөвшөөрдөггүй, хэт их эрхлүүлсний үр дүн гэж хардаг эцэг эх, асран хамгаалагчид дийлэнх хувийг нь эзэлдэг байсан бол хэд хэдэн удаагийн эцэг эхийн сургалт, хэлэлцүүлэг, үнэлгээний үр дүнд тухайн хүмүүсийн хандлага өөрчлөгдөж өнөөдөр сургуулийн хэмжээнд оноштой 31-н сурагч болж, хөгжлийн онцлогтой хүүхдүүдтэй ажиллаж буй багшийн аргагүй нэмэгдэж тэгш хамран сургах боловсрол нь үр дүнтэй амжилттай хэрэгжиж байна.

Түлхүүр үг: Тэгш хамран сургах хөтөлбөр, үнэлгээ, ахиц.

Ашигласан материал:

1. Одгэрэл.Д, Ганболд.Д, Мөнхцэцэг.О & Нямдорж.Ч (2022). *Тэгш хамруулах боловсрол – ЕБС-ийн дунд ангийн багш нарт зориулсан мэргэжил дээшлүүлсэн сургалтын модуль*. Монгол Улс, Улаанбаатар хот.
2. Норовдоо.Б (2020). *Тэгш хамруулах боловсрол – Эцэг эх, олон нийт, сургуулийн ажилтнуудын мэдлэг ойлголтыг сайжруулах, оролцоог нэмэгдүүлэх арга зүй сургалтын модуль*. Монгол Улс, Улаанбаатар хот.
3. (2022). *Сургалтын үйл ажиллагааг дэмжих тусгай хэрэгцээт боловсролын арга зүй – дунд ангийн жишээн дээр*. Монгол Улс, Улаанбаатар хот.
4. Норовдоо.Б & Баясгалан.Ц (2021). *Тэгш хамруулах боловсрол – Хүүхдийн сурах үйл явцад эцэг эхийн оролцоог нэмэгдүүлэх арга зүй*. Монгол Улс, Улаанбаатар хот.
5. Карин Шелциг & Кирсти Ньюман (2020). *АХБ-ны Зүүн Азийн газраас эрхлэн гаргадаг техникийн цуврал тайлан*. Монгол Улс, Улаанбаатар хот.

”ТЭГШ ХАМРУУЛАХ ХӨТӨЛБӨР”-ИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ТАЛААРХ ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮҮХДҮҮДИЙН ЭЦЭГ ЭХИЙН ХАНДЛАГА

Э.Энх-Оюун¹

¹ХУД-ийн 23-р хороо Арцатын 4-р гудамж 63 дугаар сургууль
uugiibatkhana@gmail.com

Үндэслэл

Тэгш хамруулан сургах боловсрол нь хөгжлийн бэрхшээлтэй суралцагчдыг ердийн сургуулийн ангид ямарваа нэгэн бүтцийн өөрчлөлт хийхгүйгээр, жишээлбэл зохион байгуулалт, хичээлийн хөтөлбөр, заах ба суралцах арга зүй, стратегид өөрчлөлт оруулахгүйгээр суралцуулах нь тэгш хамруулж байна гэж үзэхгүй.

Зорилго

Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн боловсролын сонголт, сургуулиудын дэмжлэгийн баг, ганцаарчилсан төлөвлөгөө хэрхэн хэрэгжиж байгаа талаар эцэг эхийн үзэл бодол хандлагыг судлах зорилготой.

Судалгааны арга зүй

Тоон судалгааны загвар ашиглан нэг агшны судалгаа хийлээ. Судалгаанд хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн эцэг эхийн нийгмийн сүлжээний хаалттай тусгай 10 бүлгэмээр дамжуулан хөгжлийн онцлог ялгаатай хүүхэдтэй 59 эцэг эхийг сайн дураар хамруулж, 37 асуулт бүхий асуумжийг хэвлэлийн тойм уншиж судалсны үндсэн дээр боловсруулж, Google form ашиглан мэдээлэл цуглуулж SPSS–26 программаар статистик боловсруулалт хийлээ.

Үр дүн

Судалгаанд оролцогч эцэг эх асран хамгаалагчдын 83.1% нь Улаанбаатар хот, 16.9% нь орон нутгаас хамрагдсаны 86.4% нь ээжүүд байлаа. Аутизмын хүрээний эмгэг, дауны хам шинж, тархины саажилт, оюуны хомсдол, хэт хөдөлгөөнт хам шинж гэх мэт олон оноштой хүүхдүүд байсан. Хөгжлийн онцлог ялгаатай хүүхдүүдийн 22 (37.2%) нь төрийн өмчийн ЕБС-д, 31 (52.5%) нь тусгай сургуульд, 6 (10.1%) нь хувийн сургуульд сурдаг /график–1/ бөгөөд зөвхөн 37.3%-д (төрийн өмчийн ЕБС-ийн 40,9%, тусгай сургуулиудын 38.7%, хувийн сургуулиудын 16.7%) дэмжлэгийн баг ажилладаг, 62.7% (төрийн өмчийн ЕБС-ийн 59.1%, тусгай сургуулиудын 61.3%, хувийн сургуулиудын 83.3%) нь дэмжлэгийн баг ажилладаггүй байв. Ганцаарчилсан төлөвлөгөөг хэрэгжүүлдэг сургууль 40.7%, төлөвлөгөө гаргасан боловч хэрэгжүүлдэггүй сургууль 20.3%, огт хэрэгжүүлдэггүй сургууль 39% байсан.

ЕБС-ийн сургуульд хүүхдээ сургадаг эцэг эхчүүдийн 54.4%, тусгай сургуульд хүүхдээ сургадаг эцэг эхчүүдийн 80.6% нь хөгжлийн онцлог ялгаатай хүүхдүүдийг сурч хөгжихөд нь багш нар хүүхдийн онцлогийг бүрэн ойлгож тусалж дэмждэг гэжээ. Төрийн өмчийн ЕБС

Хүснэгт 1. Сургууль сонгоход нөлөөлөх онцлогууд (маш чухал)

Д/д	Сургууль сонгоход нөлөөлөх онцлогууд	Хувиар
1	Нийгмийн харилцаанд ороход сайнаар нөлөөлнө	89,8%
2	Хүүхдийг хөгжүүлэх боломжтой	81.3%
3	Өөртөө итгэлтэй болоход нь сайнаар нөлөөлнө	79.6%
4	Өдөр тутмын бие даасан байдлыг сайжруулж	78.0%
5	Энгийн чадварт нь илүү анхаардаг	72.8%
6	Бусад хүүхдээс үлгэр жишээ авах боломжтой	71.2%
7	Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй ажиллах туршлагатай багшийг хүссэн	71.2%
8	Нэг ангид байх хүүхдийн тоо цөөн	71.2%

Хүснэгт 2. Сургууль сонгоход нөлөөлөх онцлогууд (тийм ч чухал биш)

Д/д	Сургууль сонгоход нөлөөлөх онцлогууд	Хувиар
1	Сургууль нь гэрийн ойр байх	50.9%
2	Хөршийнхөө хүүхэдтэй хамт сурах	35.6%
3	Өдөр өнжүүлэх төв сайн ажилладаг	35.6%

болон тусгай сургуулиудад сурдаг хүүхдүүдийн сургуулийн орчинд шоолуулж дээрэлхүүлэх, гадуурхагдах гэх мэт сөрөг хандлагад орж байсан эсэхэд (график 1 дүгнэх статистик боловсруулалт хийж T-Test-ийг үзэхэд $p=0.0415$, хүүхдэд анхаарал халамж тавьдаг, тусалдаг, хүлээн зөвшөөрөгдсөн мэдрэмж авдаг зэрэг эерэг байдлын мэдрэмжийн p утга 0.019 буюу $p<0.05$) график байгаа нь тусгай сургуулиудад илрэх эерэг хандлагад үнэн магадлал бүхий ялгаатай их байгааг тус судалгаа харуулж байна.

Хөгжлийн онцлог ялгаатай хүүхдүүдийн суралцдаг сургуулиудад ажилладаг дэмжлэгийн багийн хэрэгжүүлэлт, ганцаарчилсан төлөвлөгөө одоогийн байдлаар хангалтгүй байна. Судалгаанд оролцогч эцэг эхчүүд хүүхдэдээ сургууль сонгоход нийгмийн харилцаанд ороход сайнаар нөлөөлөх, хүүхдийг хөгжүүлэх боломж, өөртөө итгэлтэй болоход нь сайнаар нөлөөлөх, хүүхдийн онцлогийг ойлгодог багш боловсон хүчин зэрэг онцлогууд маш чухал гэж үзэж байна. Ерөнхий боловсролын сургуульд тэгш хамруулах боловсролын хөтөлбөр дэмжлэгийн баг, ганцаарчилсан хөтөлбөр, туслах багшийн асуудал илүү их дэмжлэг хэрэгтэй харагдаж байна. Тусгай сургуулийн багш нар хүүхдийн онцлогийг ойлгодог, анхаарал халамж тавих байдал илүү ажиглагдлаа.

Түлхүүр үг: Хүртээмж, дэмжлэг, хандлага, хэрэгжилт.

Ашигласан материал:

1. Christian Klicpera, Markus Gebhardt, & Susanne Schwab (Received 2 February 2012; final version received 18 June 2012). Attitudes and experiences of parents regarding inclusive and special school education for children with learning and intellectual disabilities Barbara Gasteiger-Klicpera. *Inclusive Education*, University of Graz, Merangasse 70/II, Graz, A – 8010, Austria.
2. Хараат бус судалгааны хүрээлэн (2021). “Хүүхэд бүрийг боловсролд Тэгш Хамруулах зарчмыг дэмжих нь” (хү.9–13). Монгол Улс, Улаанбаатар хот: Монгол дахь Хүүхдийг ивээх сан.
3. Moliner, O. (2008). Condiciones, procesos y circunstancias que permiten avanzar hacia la inclusiyn educativa: retomando las aportaciones de la experiencia canadiense. *Revista Electronica Iberoamericana sobre Calidad*, 6 (2). Eficacia y Cambio en Educaciyn.
4. (2021). “Хүүхэд бүрийг боловсролд Тэгш Хамруулах зарчмыг дэмжих нь” (хү.9–13). Монгол Улс, Улаанбаатар хот.
5. Buckley.S, Bird.G, Sacks.B, & Archer.T (2006). A comparison of mainstream and special education for teenagers with Down syndrome: Implications for parents and teachers. *Down Syndrome Research and Practice*, 9, 54–67.
6. (2020). “Хүүхдэд ээлтэй аюулгүй, эрх тэгш, тэгш хамруулсан боловсролын сайн туршлага (Монголын болон бусад улсын жишээ)” (хү.6–23). Монгол Улс, Улаанбаатар хот.
7. БСШУ-ны Сайдын 2018 оны А/155, А/292, А/249 дугаар тушаал. Монгол Улс, Улаанбаатар хот.

График 1. Хүүхэд ангидаа сөрөг байдалд орж байсан эсэх талаар $p=0.0415$





График 2. Хүүхэд ангидаа эерэг байдлыг мэдрч байсан эсэх талаар $p=0.019$



ТЭГШ ХАМРУУЛАН СУРГАХ БОЛОВСРОЛЫН ҮЙЛЧИЛГЭЭ, ТУРШИЛТ, ҮР ДҮН, АСУУДАЛ

Э.Мөнхзул¹

¹Орхон аймгийн 4 дүгээр сургуулийн бага ангийн багш
zula.zulka8989@gmail.com

Үндэслэл

Хандлага, мөс чанар нь хүний дотоод ертөнцөд оршиж байдаг бөгөөд харин тэдгээрт үндэслэсэн зан үйл ил харагддагийг чадамжийн мөсөн уул Мак Клеландын загвар дээр суурилсан дараах зургаас харж болно (*Н.Норжинхорлоо, 2021*) гэсэн онолын санаанд тулгуурласан.

Зорилго

2019–2023 оны хичээлийн жилийн хугацаанд даан авсан ангийн хөгжлийн бэрхшээлтэй сурагчдын эцэг эхийн хандлагыг судлан, зөв хандлагыг бий болгох замаар сургалтын явц дахь бэрхшээл, зөрчлийг арилгаж, сурлагын чанарт ахиц гаргаж болно гэдгийг судалгааны ажлаараа дамжуулан илэрхийлэхийг зорилго.

Судалгааны арга зүй

Задлан шинжилж, нэгтгэн дүгнэх замаар тандалт, баримтын судалгаа хийж, сургалтын явц дахь бэрхшээлийг арилгах шийдлийг олох боломжийг судлан, тоон ба чанарын үнэлгээ хийх аргуудыг туршин хэрэгжүүлсэн болно.

Үр дүн

Баримт бичгийн судалгаа 1

Хууль тогтоомжуудын заалтуудыг нэгтгээд үзэхэд ХБХ-ийг судлан оношилж тэдэнд тэгш боловсрол эзэмшүүлж, хүүхдүүдийг ердийн сургалттай ерөнхий боловсролын сургуульд суралцахад нь тусгайлсан хөтөлбөр төлөвлөгөөтэй ажиллах шаардлага үүсэж байна.

Асуулга, тандалт судалгаа 2

Хөгжлийн бэрхшээлтэй сурагчдын эцэг эх, асран хамгаалагчдын өөрийн хүүхдийн хөгжил төлөвшилд өгөх хандлага, ойрын ба хэтийн ганцаарчилсан сургалтын төлөвлөгөө гарган дэлгэрэнгүй судлав.

Харьцуулалтын судалгаа 3

Орхон аймгийн 2, 4-р сургуулийн эцэг эх, асран хамгаалагч ганцаарчилсан сургалтын төлөвлөгөөгөөр ажиллахад гарсан давуу ба бэрхшээлтэй тал:

Суралцагчийн хувьд:

Хүснэгт 1.

Бие бялдрын хөгжил	Оюун ухааны хөгжил	Нийгэмшихүйн хөгжил
<ul style="list-style-type: none"> Бичих чадвар нэмэгдсэн Хөдөлгөөний хязгаарлагдмал байдал эерэг гарсан, 	<ul style="list-style-type: none"> Бусдад өөрийгөө таниулсан. Хэл ярианы хөгжил сайжирсан. Өнгө ялгаж сурсан. 	<ul style="list-style-type: none"> Суралцах хүсэл нэмэгдсэн. Бусдад өөрийгөө ойлгуулдаг болсон. Өөртөө итгэх итгэл нэмэгдсэн. Найз нөхөдтэй болсон. Эцэг эхийн дэмжлэг туслалцаа нэмэгдсэн.

Анги удирдсан багшийн хувьд:



Сургууль болон ХХТА-ны зүгээс:

Давуу тал	Бэрхшээлтэй тал
<ul style="list-style-type: none"> • Хүүхдийг онцлог давуу талыг мэдэж авсан. • Үйл ажиллагааны явцад ахиц гарч байгаа эсэхэд хяналт тавьдаг болсон. • Нийгмийн ажилтан болон эцэг эхийн хамтын ажиллагаа нэмэгдсэн. • Үйл ажиллагааны явцад нийгмийн ажилтан, сэтгэлзүйчийн зүгээс үнэлгээ дүгнэлт хийж зөвлөн тусалдаг болсон. • Багш гарын авлагатай болсон. • Сургалтын явцад хүүхдэд ахиц гарч өөртөө итгэх итгэл нэмэгдсэн. • ГСТ-өөр ажиллах дадлага туритагатай болсон. • Цаашид энэхүү төлөвлөгөөгөөр ажиллах хүсэлтэй болсон. • Хүүхэд хичээлд ирэх сонирхолтой болсон. • ГСТ-өөг ангийхаа бусад сурлагын хоцрогдолтой хүүхдэдтэй ажиллахад туршиж үзэх шинэ санаа төрсөн. 	<ul style="list-style-type: none"> • Эхний удаад ГСТ боловсруулахад төвөгтэй байсан. • Бичиг цаасны ажил нэмэгдсэн. • Тусгайлан ганцаарчлан ажиллахад илүү цаг шаардлагатай байсан. • Хичээлийн цагийн үед ганцаарчилан ажиллах боломжгүй нэмэлт цаг заавал шаардагддаг. • Ахиц гарч байх явцад хүүхэд эрүүл мэндийн шалтгааны улмаас олон хоногоор хичээлдээ ирэхгүй байх тохиолдолд ахиад эхнээс нь эхлэх.

Энэхүү хөтөлбөрөөр ажиллахад эцэг, эх, асран хамгаалагчийн зүгээс идэвх оролцоо урьд өмнөөсөө илүү нэмэгдсэн бөгөөд хүүхдийнхээ чадвар, хэрэгцээг олж мэдсэнээр хичээл сургалтын үйл ажиллагаанд идэвхтэй оролцох эерэг хандлага бий болсон.

Хөгжлийн бэрхшээлтэй сурагчдыг хичээл сургалтын үйл ажиллагаанд татан оролцуулах судалгаа 4:

Давуу тал	Бэрхшээлтэй тал
<ul style="list-style-type: none"> • Эцэг эхчүүдийн сургуулийн үйл ажиллагаанд оролцох оролцоо нэмэгдэж, эерэг хандлага бий болсон. • Эцэг эх, АУБ, нийгмийн ажилтантай байнгын холбоотой болж хүүхдийг эрүүл мэндэд гарсан өөрчлөлтийн талаар нээлттэй ярилцдаг болсон. • Туршлага, мэдлэгтэй болсон. • Эцэг эх, багш цаашид энэ хөтөлбөрөөр үргэлжлүүлэн ажиллах хүсэлтэй болсон. • Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэдтэй ажиллахаас гадна сурлагын болон ахуйн хоцрогдолтой хүүхдэдтэй ажиллах боломжтой. 	<ul style="list-style-type: none"> • ГСТ-өөр ажиллаж эхэлэхэд багш болон эцэг эхийн зүгээс төвөгшөөж хүлээж авч байсан. • ГСТ-өөг эхлэн боловсруулахад чадвар дутагдсан. • Багш нэг бүртэй ганцаарчилан уулзахад цаг зав их шаардагдаж байсан.


Дүгнэлт: Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэдтэй эцэг эх үргэлж өөрийн хүүхдээ хэт бөөцийлөх нэг үгээр байнга өрөвддөг, үргэлж урдуур нь орж муу зан сургадаг. Өөрийн хүүхэд үргэлж зөв гэж өөрийнхөө бодолд бат итгэлтэй байдаг. Харилцаа хандлага, оролцоо маш сул миний хүүхэд энэ зэрэгтэй сурч байгаа нь болно гэсэн бодолтой байдаг. Гэтэл тухайн хүүхэд өөрийн гэсэн үзэл бодолтой, өөрийн гэсэн чадварт суурилсан бусдын адил сурах бүрэн боломжтой байна.

Хичээлд оролцох хандлага, сонирхлыг нэмэгдүүлэх чиглэлээр хийсэн өөрийн ажлын туршлага, арга барил судалгаа 5:

Хүүхдийг зөв төлөвшилтэй болгохын тулд багшийн зүгээс:

- Хичээлээ бэлтгэлтэй заах
- Хүүхэд бүрийн эцэг эхтэй тогтмол хамтарч ажиллах
- Хүүхдийн авьяасыг хөгжүүлэх
- Хүүхдийг тал бүрээр нь дэмжиж ажиллах
- Хүүхэд болон эцэг эхчүүдээ ойлгож тогтмол тусалж байх зэрэг нь чухал юм.

Энэ бүгдээс харахад хүүхдийн хөгжил төлөвшилд багшийн үүрэг оролцоо “Ус агаар” мэт хэрэгцээтэй байна.



Хүүхэд бүрийг судлан, эцэг эхийн хандлагыг ажиглан тэмдэглэл хөтөлж, тэдэнд тохирсон арга зүйгээр хичээл сургалтаа явуулсны үр дүнд хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд ч ахиц гарч, эцэг эхийн хандлага эрс өөр болж, эерэг хандлагатай болсон нь ажиллахад зөрчил үүсэхгүй байсан.

Дүгнэлт

Хөгжлийн бэрхшээлтэй болон тэгш хамруулан сургах шаардлагатай хүүхдүүдийн эцэг эхийн сөрөг хандлагыг судалж, эерэг хандлага төлөвшүүлэхэд хамгийн гол нь хүүхдийнх нь ахицыг судлан, сайжруулах нь сургалтын амжилтад нөлөөлөх хүчин зүйлийн нэг тул үүнд анхаарлаа хандуулан, хүнд байдлаас гарч, эерэг байдалд орж буй багшийг урамшуулах тал дээр бодох цаг хэдийнээ иржээ. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг өөрийнх нь байгаагаар хүлээн авч хөгжүүлж, эцэг эхийн хандлагыг эерэг тал руу чиглүүлснээр сургалтын чанар сайжирч, ХБ-тэй хүүхэд бүр энгийн сургуульд тэгш суралцах боломжтой гэдгийг сургууль бүр анхаарч ажиллавал зохино.

Түлхүүр үг: *Эцэг эхийн хандлага, ёс зүй, шийдэл, арга зам, тогтвортой хөгжлийн боловсрол.*

Ашигласан материал:

1. Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчийн ёс зүйн дүрмийн 4 дүгээр бүлгийн 4.1 заалт. Монгол Улс, Улаанбаатар хот.
2. Сургууль, цэцэрлэгийн багшийн ёс зүйн дүрмийн 3 дугаар бүлгийн 3.1.1, 3.1.2, 3.1.3 заалт. Монгол Улс, Улаанбаатар хот.
3. (2021). *“Багшийн ёс суртахууны өнөөгийн байдал судалгааны тайлан”* (ху.33). Монгол Улс, Улаанбаатар хот.
4. Buuvei.Buuvei.mn
5. *“Хүүхдийн хөгжил төлөвшилд багшийн үүрэг роль”* (ху.28). Монгол Улс, Улаанбаатар хот.

СУРГУУЛИЙН ӨМНӨХ НАСНЫ АУТИЗМЫН ХҮРЭЭНИЙ ЭМГЭГТЭЙ ХҮҮХДИЙН ТАНИН МЭДЭХ ҮЙЛИЙН ОНЦЛОГ

А.Хонгорзул¹

¹МУБИС, БСС, БСАЗ-н тэнхим Боловсрол судлаач – III курс

Үндэслэл

Аспергерийн хам шинж 2013 оноос өмнө аутизмаас тусдаа онош байсан боловч одоо энэ эмгэгийг аутизмын хүрээний эмгэгт багтаадаг болсон. Аспергерийн хам шинж гэдэг нэр томъёог анх энэ эмгэгийг тодорхойлсон Австрийн хүүхдийн эмч Ханс Аспергерийн нэрээр нэрлэдэг. 1944 онд Аспергер эмчийн эмнэлэгт хандсан хүүхдүүдийн зарим нь хоорондоо их төстэй зан байдалтай байгааг эмч анзааран тэрхүү этгээд сонин байдлыг нь “Хүүхдийн аутист байдалтай зан байдлын эмгэг” гэж нэрлэжээ. Тэгэхээр энэ эмгэг нь сэтгэцийн гэхээсээ илүү зан байдлын эмгэг юм. Доктор Аспергер 30 гаруй жилийн судалгааны үр дүнд эдгээр хүүхдүүд онцгой чадвартай болохыг тогтоосон байдаг. Эдгээр хүүхдүүд дотор цаашдаа ажил хөдөлмөр эрхлэх боломжтой онцгой авьяастай хүүхдүүд ба хүмүүстэй насан туршийн харилцаа холбоо тогтоох боломжтой хүүхдүүд ч бий гэжээ. Харин сонгодог аутизмтай хүүхдүүдийг анх 1943 онд Австри–Америкийн хүүхдийн эмч Лео Каннер дүрсэлж тодорхойлсон учир Каннерын аутизм гэж нэрлэх тохиолдол байдаг. Энэ нэр томъёогоор гол төлөв аутизмын тухай үндсэн ойлголтыг тодорхойлж ирсэн байдаг ба сонгодог аутизмтай хүүхэд нийгэмшил, суралцахуй, зан үйлийн хувьд илэрхий бэрхшээлтэй байдаг. Өнөөдөр дэлхийн хүн амын 1% буюу 70 сая хүн Аутизмын Хүрээний Эмгэгтэй байна. Харин Монголын аутизмын холбоонд бүртгэлтэй 785 гэр бүл байгаагаас сургуулийн өмнөх нас буюу 3–5 насны 375 хүүхэд бүртгэлтэй байна.

Зорилго

Сургуулийн өмнөх насны аутизмын хүрээний эмгэгтэй хүүхдийн танин мэдэх үйлийн онцлогийг судлахад оршино.

Судалгааны арга зүй

Иймд сургуулийн өмнөх насны аутизмын хүрээний эмгэгтэй хүүхдүүдийн эцэг эхээс асуулга аван, тухайн хүүхдүүдээр анхаарлын тест ажиллуулан ажиглалтын аргаар судалгаа авсан. Мөн анги удирдсан багшаас ярилцлагын аргаар тухайн хүүхдийн тухай тодруулан судалсан.

Нийслэлийн А цэцэрлэгийн дунд, ахлах бүлэгт суралцдаг аутизмын хүрээний эмгэгтэй 5 суралцагчдын эцэг эх, асран хамгаалагчаас Монголын аутизмын холбооноос гаргасан аутизмын хүрээний эмгэгтэй хүүхдийг оношилдог асуулгыг ашиглан зохион байгуулсан. Сургуулийн өмнөх насны аутизмын хүрээний эмгэгтэй хүүхдийн танин мэдэх үйлийн онцлогийг судлах зорилгоор анхаарлыг шалгах тест боловсруулан суралцагчдаар ажиллуулсан. Нийт судалгаанд оролцогчдын талаарх зарим мэдээллийг тодруулахаар анги удирдсан 2 багшаас ганцаарчилсан ярилцлага хийсэн. Судалгааны мэдээллийг цуглуулан SPSS 25 программ дээр боловсруулан дүн шинжилгээ хийсэн.

Үр дүн

Асуулгын үр дүнг дүгнэх: 8–20 оноо АХЭ-тэй байх өндөр эрсдэлтэй, 3–7 оноо АХЭ-тэй байх дундаж эрсдэлтэй, 0–2 оноо АХЭ-тэй байх эрсдэлгүй гэж үзсэн. Нийт судалгаанд оролцогчдын 4 нь 8–20 оноо авч аутизмын хүрээний эмгэгтэй байх өндөр эрсдэлтэй гэж оношлогдсон бол 1 нь 3–7 оноо авч аутизмын хүрээний дундаж эрсдэлтэй гэсэн судалгааны үр дүн гарсан. Аутизмын хүрээний эмгэгтэй суралцагчдын танин мэдэх үйлийн онцлогийг судлах зорилгоор анхаарлын тестийг ашиглан тухайн хүүхдүүдэд үндэслэн рубрик боловсруулсан. Рубриkyг анхаарлаа тогтоох чадвар, анхаарлаа чиглүүлэх чадвар, анхаарлаа шилжүүлэх чадвар, анхаарсан зүйлээ санах чадвар зэрэг 4 шалгуураар боловсруулсан болно. Суралцагчдыг дээрх рубрикээр үнэлэхдээ судалгаанд оролцсон аутизмын хүрээний эмгэгтэй хүүхдийн анхаарлын тестийг ажиллаж буй байдлыг ажиглан үнэлсэн. Нийт 5 хүүхдийн 1 нь анхаарлын тестийг ажиллаж байх үед анхаарал төвлөрөхгүй байсан бол 2 нь өөр зүйл рүү анхаарал нь сарниж байсан. Харин 1 хүүхэд анхаарлын тестийг ажиллах явцад анхаарлаа бүрэн төвлөрүүлж байсан. Нийт 5 хүүхдийн 3 нь анхаарлын

тестийг ажиллах үед өгсөн хугацаанаас илүү хугацаанд алдааг олж дараагийн зураг руу шилжиж байсан бол 1 нь өгсөн хугацаанд алдааг олж дараагийн зураг руу шилжиж байсан. Харин 1 хүүхэд өгсөн хугацаанаас өмнө алдааг олж дараагийн зураг руу шилжиж байсан. нийт 5 хүүхдийн 3 нь анхаарлын тестийг ажиллаж дууссаны дараа зургийн ялгааг санаж байсан бол 1 нь зургийн ялгааг дарааллын дагуу санаж байсан. Харин 1 хүүхэд зургийн жижиг деталь бүрийн ялгааг санаж байсан. Анхаарлаа тогтоох чадварыг насны хувьд ялгаа байгаа эсэхийг авч үзэхэд нийт судалгаанд оролцогсдын 4 нь 3 настай бол 1 нь 4 настай. 3 настай суралцагчид 1–3, 4–7 зураг дээрх ялгааг олсон бол 4 настай суралцагч 8–10 зураг дээрх ялгаа олсон байгааг судалгааны үр дүнгээс харж болох юм. Аутизмын хүрээний эмгэгтэй суралцагчдын анги удирдсан багштай ярилцахад суралцагчид ихэвчлэн давтамжтай хөдөлгөөн хийдэг (гараа сэгсрэх, эргэлдэх), Тоглоомыг өрж жагсааж тавих, дүнгэнэх, хашхирах зэрэг зан үйлийг ихэвчлэн гаргадаг гэж хариулжээ. Мөн цэцэрлэгт анх ирэхдээ нэрээ мэддэггүй, хоолоо идэж чаддаггүй, хөл гарын хөдөлгөөн султай хүүхдүүд ирж байсан. Харин өнөөдөр нэрийг нь дуудахад мэддэг, хоолоо савардаад иддэг, хөл гарын булчин хөгжсөн зэрэг үр дүн гарсан гэж хариулжээ.

Дүгнэлт

Энэхүү судалгааг дүгнэж үзэхэд аутизмын хүрээний эмгэгтэй суралцагчид нь анхаарлаа тогтоох чадвар болон анхаарлаа чиглүүлэх чадвар, анхаарсан зүйлээ санах чадварууд сайн байгаа бол анхаарлаа шилжүүлэх чадвар сул байна. Тухайн хүүхдүүд нь анхаарлын тестийг сонирхон анхаарлаа чиглүүлж, тогтоож чадаж байгаа хэдий ч дараагийн зураг руу шилжихэд хугацаа шаардаж байсан. Аутизмын хүрээний эмгэгтэй суралцагчид анхаарлын тестийн ялгааг санаж байгаа хэдий ч утга санааг ойлгохдоо удаан байсан. Багшийн ярилцлагаас үзэхэд эдгээр хүүхдүүд нь танин мэдэхүйн хөгжил хэвийн ба нийгмийн харилцаанд орох нийгэмших бүрэн боломжтой ба маш олон эерэг үр дүн гарч байгаа юм. Үүнээс үзэхэд тухайн суралцагчдын танин мэдэхүйн хөгжил хоцрохгүй байх бүрэн боломжтой ба тохирсон арга зүй л шаардлагатай гэж үзэж байгаа юм. Мөн аутизмын хүрээний эмгэгтэй суралцагчид нь энгийн цэцэрлэгт явснаараа маш олон эерэг үр дүн гарч байгааг энэхүү судалгаагаар харж болох юм.

Түлхүүр үг: *Аспергериин хам шинж, сонгодог аутизм, аутизмын хүрээний эмгэг, бэрхшээл, танин мэдэх үйлийн онцлог.*

Ашигласан материал:

1. Амарбуян.А (2021). *Аутизмын хүрээний эмгэгтэй сурагчдыг боловсролд тэгш хамруулах нь.* Монгол Улс, Улаанбаатар хот.
2. Батдэлгэр.Ж (2018). *Хүний хөгжлийн сэтгэл судлал.* Монгол Улс, Улаанбаатар хот.
3. Батхишиг.С (2018). *Тусгай хэрэгцээт боловсрол.* Монгол Улс, Улаанбаатар хот.
4. Гангантогос–Өлзийбаясгаланы.Ю (2010). *Эрдэм шинжилгээ, судалгааны ерөнхий аргачлал.* Монгол Улс, Улаанбаатар хот.
5. Ичинхорлоо.Ш (2017). *Хүүхдийн хөгжил.* Монгол Улс, Улаанбаатар хот.

СОНГОЛЫН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮҮХДИЙН БОЛОВСРОЛД ТУЛГАМДАЖ БУЙ АСУУДАЛ

Б.Дангаасүрэн, М.Ариунзул, О.Уртнасан, Ц.Алтанцэцэг, Г.Оюунгэрэл¹

¹НЭБ-ийн 29 дүгээр сургууль

ganbaa.oyuha@gmail.com

Үндэслэл

Боловсролын ерөнхий шинэчилсэн хуулийн 6-р зүйлд зааснаар сонсголын бэрхшээлтэй суралцагчид боловсрол эзэмшүүлэх сургалт, үйл ажиллагааг эх хэл буюу монгол дохионы хэлээр явуулна гэж заажээ. Монгол улсын боловсролын шинэчлэлийн бодлогын хүрээнд сонсголын бэрхшээлтэй, хөгжлийн ялгаатай суралцагчдад тусгай хэрэгцээт боловсролыг тэдний онцлогт тохирсон аргаар эзэмшүүлэн оюун ухаан, ёс суртахуун, бие бялдрын хөгжлийг хангасан, нийгмийн амьдралд бие даан сурах, ажиллах, амьдрах чадвартай иргэн бэлтгэх шаардлагатайд оршино. Сонсголын бэрхшээлтэй хүүхдийн хувьд эрт илрүүлэлт, оролцоо нь хүүхдийн чадварыг хөгжүүлэх цаашлаад эцэг эх, гэр бүлийн гишүүдэд чухал ач холбогдолтой юм. Эцэг эхийн хувьд дөнгөж төрсөн бяцхан үрээ сонсголгүй гэдгийг мэдсэн ямар ч эцэг эх сэтгэл зүйн хямралд орж айдас, харамсал, өөрийгөө эсвэл хэн нэгнийг буруутгах гэх мэт олон олон бэрхшээл, асуудалтай тулгардаг. Сонсголын бэрхшээлтэй болон хөгжлийн ялгаатай суралцагчидтай ажиллах мэргэжлийн боловсон хүчний дутагдал, тусгай хэрэгцээт боловсролын арга зүйн шинэчлэл, эрүүл мэндийн салбар /эрт илрүүлэлт/, боловсролын салбар /эрт оролцооны төв/-ын хамтын ажиллагааг сайжруулах зэрэг олон талт асуудал (МУБИС-ийн ТХБ-ийн анги төгссөн багш нарын судалгаа, 2023) нь дараах судалгааг явуулах үндэслэл болж байна.

Зорилго

Сонсголын бэрхшээлтэй суралцагчдад хуулийн хүрээнд чанартай боловсролыг эзэмшүүлэхэд тулгамдаж буй өнөөгийн асуудлуудыг гаргаж, оновчтой зөв арга замыг эрэлхийлэхийг зорилоо.

Тулгамдаж буй асуудал:

1. Эрт илрүүлэлт, эрт оролцооны төв байгуулах
2. Багш боловсон хүчний дутагдал, багшийг чадавхжуулах
3. Бэлтгэл бүлэг
4. Өдөр өнжүүлэх үйлчилгээ.
5. Тэгш оролцоо, тэгш эрх

Судалгааны арга зүй

Энэхүү судалгааны ажлыг асуулгын аргаар (google forms) программ ашиглаж зарим хэсгийг excel программын графикаар үзүүлэв. Мөн харьцуулалтын арга, нэгтгэн дүгнэх арга зүйг ашиглаж, 29-р сургуулийн суралцагчдын судалгаа, эцэг эх асран хамгаалагч болон сонсголгүй хүүхэдтэй ажилладаг багш нараас дараах 4-н бүлэг болгон авч үзсэн.

- Багш боловсон хүчний дутагдал /согог зүйч болон ТХБ-ын багш/
- 29-р сургуулийн элсэгчдийн судалгаа /үечилсэн 14 жил/
- 29-р сургуулийн эцэг эх асран хамгаалагчаас
- Сонсголгүй хүүхэдтэй ажиллаж байгаа багш нараас

Үр дүн

Хүснэгт 1. Сонсголын бэрхшээлтэй суралцагчдын ангилал (29-р сургууль, 2023 оны байдлаар)

<i>Хавсарсан бэрхшээлтэй сурагчид</i>	<i>тоо</i>	<i>НХХЯ, ЭМЯ, БШУЯ-ны хамтарсан салбар комиссын албан ёсны оношгүй болон суралцахуйн бэрхшээлтэй сурагчид ороогүй болно.</i>
Оюун ухааны бэрхшээлтэй	4	
Хөдөлгөөний бэрхшээлтэй	12	
Даун синдром	1	
Аутизм, аутизмын хүрээний эмгэг	5	
Нийт	22	

Дүгнэлт

1. Монгол улсын хувьд хөгжлийн ялгаатай хүүхэдтэй эцэг эхэд сэтгэлзүйн зөвлөгөө, туслалцаа үзүүлэх үйлчилгээ байдаггүй. Гэтэл хөгжингүй орнуудад сонсголын бэрхшээлтэй хүүхэд төрөхөөс өмнө эцэг эх болон гэр бүлийн гишүүдэд сэтгэл заслын сургалт, үйлчилгээг үзүүлдэг нь хүүхдийнхээ онцлогийг танин мэдэх, харилцах, ойлголцох эхний шат болдог. Иймд манай улсад сонсголын бэрхшээлтэй хүүхдийн эцэг эх, асран хамгаалагчдад сэтгэл зүйн зөвлөгөө, үйлчилгээ үзүүлэх шаардлагатай юм.
2. /Судалгаа 2/ Эцэг эх, асран хамгаалагчдаас авсан судалгаанаас харахад (диаграмм–6) 0–3 насанд нь 64.6% нь сонсголын бэрхшээлтэй хэмээн илрүүлэн оношилсон нь сайшаалтай боловч сонсголын бэрхшээлтэй хүүхдүүд боловсрол, танин мэдэхүйн хөгжлийн хоцрогдолд орж байгаа нь эрт оролцооны төв шаардлагатай байгаа нь харагдаж байна.
3. Багш нараас авсан судалгааны асуулгын үр дүнгээс харахад сонсголын бэрхшээлтэй хүүхдүүдтэй ажиллаж байгаа багш нарт сонсголын бэрхшээлээс гадна хавсарсан бэрхшээлтэй хүүхэдтэй ажиллах тусгай сурганы арга зүй, тэдгээрийг мэргэшүүлэх сургалт ховор байдаг нь харагдаж байна. Мөн манай улсын боловсролын салбар нь багш боловсон хүчний дутагдалд орсноор сонсголын бэрхшээлтэй хүүхдийн боловсролд нөлөөлж байгаа нь харагдаж байна.
4. Өдөр өнжүүлэх үйлчилгээг зохион байгуулахад улсаас санхүүжилтийг шийдвэрлэж өгсөн тохиолдолд эрх зүйн орчин, боловсон хүчний асуудлыг журмын дагуу шийдэж, тогтвортой үйл ажиллагаа явуулах нөхцөл бүрдэнэ.
5. 29-р сургуульд элсэн суралцаж байгаа суралцагчдын эцэг эх, асран хамгаалагч, багш нараас авсан судалгаанаас харахад СӨБ-д 78.5% нь хамрагдсан 21.7% нь огт хамрагдаагүй байна. Үүнээс хөдөө орон нутагт тусгай хэрэгцээт шаардлагатай хүүхдүүдэд зориулагдсан цэцэрлэг байхгүй. Үүнээс ердийн цэцэрлэгт – 58.5%, 186-р тусгай цэцэрлэгт – 39,6%, сувиллын 10-р төвд – 1.9% нь хамрагдсан. Гэхдээ ердийн цэцэрлэгээс элсэн орж буй хүүхдүүдээс харахад дохионы хэлгүй, хэл ярианы хөгжил сул, танин мэдэхүйн хоцрогдолтой, өөрийгөө илэрхийлэх чадвар сул байдаг тул бэлтгэл бүлэг нээх шаардлагатай байна. Мөн манай улсад сонсголгүй хүүхдүүдэд зориулагдсан сургуулийн өмнөх боловсрол эзэмшүүлэх цэцэрлэг ганц байгаа нь хүртээмжгүй байна.
6. Сонсголын бэрхшээлтэй суралцагчид нь сургуулиас гадуурх гүнзгийрүүлсэн сургалт, дугуйлан секцэд хамрагдах байдал нь хязгаарлагдмал байдаг.
 - Хэлмэрч орчуулагч хүртээмжгүй
 - Суралцагчдын 44% нь хөдөө орон нутгаас ирж дотуур байранд амьдардаг
 - Сургалтын төвүүд төлбөртэй байдаг.

Санал:

1. 29-р сургуулийг түшиглэн эрт оролцооны төвийг нээн ажиллуулах
2. Сонсголын бэрхшээлтэй хүүхэдтэй ажиллаж байгаа багш нарыг багш солилцооны хөтөлбөрт хамруулах, гадаадад тусгай сурганы арга зүйгээр мэргэшүүлэн сургах
3. МУБИС-ийн Тусгай хэрэгцээт боловсролын тэнхим нь сонсголгүй хүүхдийн төрөлх хэл болох монгол дохионы хэлний кредит цагийг заавал судлах цагаар төлөвлөгөөндөө тусгах
4. Бэлтгэл бүлэг нээх
5. 29-р сургууль дээр өдөр өнжүүлэх үйлчилгээг нээн ажиллуулж, санхүүжилтийг төрөөс хариуцах

Түлхүүр үг: Эрт оролцоо, эрт илрүүлэлт, сонсголын бэрхшээл.

Ашигласан материал:

1. ХБХХЕГ (2013). “Хөгжлийн бэрхшээл судлал салбар шинжлэл ухааныг хөгжүүлэх нь” эрдэм шинжилгээний онол практикийн II хурлын эмхэтгэл. Монгол Улс, Улаанбаатар хот.
2. Нийслэлийн Боловсролын газар Тусгай боловсролыг дэмжих төв (2017). *Зуны мэргэшүүлэх сургалтын материал*. Монгол Улс, Улаанбаатар хот.
3. (2018). *Тусгай боловсрол*. Монгол Улс, Улаанбаатар хот.
4. Нийслэлийн Боловсролын газар Тусгай боловсролыг дэмжих төв (2018). *Өвлийн мэргэшүүлэх сургалтын материал*. Монгол Улс, Улаанбаатар хот.

5. ХБХХЕГ (2022). *“Хөгжлийн бэрхийлэл ба тэгш хүртээмж” эрдэм шинжилгээний онол практикийн Х хурлын эмхэтгэл*. Монгол Улс, Улаанбаатар хот.
6. Боловсролын тухай хууль. Монгол Улс, Улаанбаатар хот.
7. АНУ-ын Вержиний хамтын ажиллагааны их сургууль, ЭХЭМҮТ-ийн удамшлийн сектор, хүн судлалын төв, НЕБ-ын 29-р сургуулийн сонсгол судлалын кабинет. *“Хам шинжийн бус удамшлийн дүлийн судалгаа” төслөөс*. Монгол Улс, Улаанбаатар хот.
8. <https://www.aussiedeafkids.org.au/how-do-children-learn-sign-languages.html>

СУРАГЧДЫН БУСДЫГ ЭНЭРЭХ ЧАДВАР БОЛОН АКАДЕМИК ЧАДВАРТАА ИТГЭХ ИТГЭЛД ТЭГШ ХАМРУУЛАХ БОЛОВСРОЛЫН ҮЗҮҮЛЭХ НӨЛӨӨГ СУДАЛСАН НЬ

О.Анужин, Н.Болортунгалаг, Э.Жаргал, С.Хишигжаргал¹

¹ Монгол Улсын Их Сургууль, Сэтгэл Судлалын Тэнхим
20B1NUM0756@stud.num.edu.mn

Үндэслэл

Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг (ХБХ) ердийн сургуульд хамруулан сургах боломжийг хангахын тулд дэлхий даяар болон Монгол улсад тэгш хамруулах сургалтын тогтолцоо хэрэгжсээр байна. Хэдий тэгш хамруулах боловсролын талаар хууль тогтолцоо боловсруулагдсан байдаг ч мэргэжилтнүүд, багш нар, эцэг эхчүүдийн тэгш хамруулах боловсролын талаарх ойлголтын зөрүүтэй байдлаас шалтгаалан ялгаатай байдлыг үл хүлээн зөвшөөрөх, сургалтын үр дүнтэй байдал, нөлөөт талыг буруугаар ойлгох асуудлууд тулгамдаж байна.

Зорилго

Төрийн өмчит ерөнхий боловсролын сургуулийн ахлах ангийн сурагчдын бусдыг энэрэх чадвар болон академик чадвартаа итгэх итгэлд тэгш хамруулах боловсролын үзүүлэх нөлөөг судлах зорилгоор судалгааг хийв.

Судалгааны арга зүй

Сурагчдын энэрэх чадвар болон академик чадвартаа итгэх итгэлийг судлахдаа “Оксфордын бусдыг энэрэх чадварын асуулга (SOCS–O)” болон “Академик чадвартаа итгэх итгэлийн асуулга (AB)” асуулгуудыг ашиглаж, чанарын мэдээллийг фокус бүлгийн ярилцлагын аргыг ашиглан цуглуулав.

Үр дүн

ХБХ-ийг тэгш хамруулан сургах нь хамтран суралцаж буй хэвийн хөгжилтэй ангийн сурагчдад хэрхэн нөлөөлдөг болохыг судлахыг зорьсон. Үр дүнд сурагчдын бусдыг энэрэх чадварын хүрээнд бэрхшээлийн нийтлэг байдлыг ойлгох буюу хүн бүрд бэрхшээл тулгарч болохыг ойлгон хүлээн зөвшөөрөх чадварт нь эерэг нөлөө үзүүлсэн байна ($p=.000$). Мөн энэрэх чадварын бусад дэд чадварууд болон сурагчдын академик чадвартаа итгэх итгэлд нь ХБХ-тэй суралцах нь сөрөг нөлөөлөл үзүүлээгүй гэдгийг илрүүлсэн. Фокус ярилцлагын судалгааны үр дүнд ярилцлагад оролцож буй сурагчид хүн бүр ялгаатай байдаг талаар санал нэгдэж байсан бөгөөд ХБХ-ийг хөгжлийн хувьд ялгаатай хэдий ч бусадтай адил хүүхэд гэдгийг хүлээн зөвшөөрч байсан юм.

Дүгнэлт

Судалгааны үр дүнд тэгш хамруулах сургалтад сурдаг сурагчдын бэрхшээлийн нийтлэг байдлыг ойлгох байдал нь суралцдаггүй сурагчдаас өндөр байгаа нь ($p=.000$) ХБХ-тэй хамт сурдаг хэвийн хөгжилтэй сурагчдад хүн бүрд бэрхшээл тулгардаг талаарх ойлголт нэмэгддэг ба тэгш хамруулах сургалт нь хэвийн хөгжилтэй хүүхдүүдэд ч давуу талыг олгож чаддаг болохыг харуулж байна. Түүнчлэн фокус ярилцлагын хүрээнд сурагчид ялгаатай байдлыг хүлээн зөвшөөрч, бусдын ялгаатай байдалд хүлээцтэй ханддаг талаар хуваалцсан. Мөн ХБХ-тэй ялгаатай харилцах бус адил тэгш хандахыг илүүд үзэж, тэгш хамруулах сургалтын хэрэгжилтэд багш, сургуулийн захиргааны ойлголт, хандлага чухал нөлөө үзүүлдгийг сурагчид хэлж байв. Иймд цаашид уг сэдвийн дагуу судалгаа, шинжилгээ хийснээр ХБХ-тэй хамт суралцах болон тэгш хамруулах сургалтын талаар нийгэм, гэр бүлийн зүгээс ирэх таагүй ойлголтыг залруулан, тэгш хамруулах сургалтын давуу тал, өгөөжтэй байдлыг нээн илрүүлэн, олон нийтэд түгээх боломжтой хэмээн дүгнэж байна.

Түлхүүр үг: Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд, хэвийн хөгжилтэй хүүхэд.

Ашигласан материал:

1. World Health Organization (2011). *World Report on Disability*. Malta: World Health Organization. Retrieved from http://www.who.int/disabilities/world_report/2011/report.pdf
2. Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сургалт, үнэлгээ, судалгааны институт & Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын бодлогын судалгааны сектор (2023). “Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг тэгш хамруулан сургах, ойлголт, хандлага, нөхцөл боломж” Монгол Улсын хөдөлмөрийн зах зээлийн ерөнхий төлөв байдал (institute.gov.mn). Монгол Улс, Улаанбаатар хот.
3. Карин Шелциг & Кирсти Ньюман (2020). *Монгол улсад тэгш хамруулах боловсролыг дэмжих нь*. eawp-28-inclusive-education-mongolia-mn.pdf (adb.org)
4. Үндэсний Статистикийн Хороо (2022). *Статистикийн мэдээлэл*. Монгол Улс, Улаанбаатар хот.
5. Hehir, T., Grindal, T., & Eidelman, H. (2014). *Review of special education in the Commonwealth of Massachusetts*. Boston, MA: A synthesis report. Retrieved from <https://www.bostonpublicschools.org/cms/lib/MA01906464/Centricity/Domain/249/Hehir%20SynthesisReport.pdf>
6. Bandura, A. (2001). Social cognitive theory: An agentic perspective. *Annual Review of Psychology*, 52(1), 1–26.
7. Bong, M. (2001). Between- and within-domain relations of academic motivation among middle and high school students: self-efficacy, task-value, and achievement goals. *Journal of Educational Psychology*, 93(1), 23–34.
8. Hwang, M.H., Choi, H.C., & Lee, A. (2016). The Relationship Between Self-Efficacy and Academic Achievement: A 5-Year Panel Analysis. *Asia-Pacific Edu Res*, 25, 89–98. Retrieved from <https://doi.org/10.1007/s40299-015-0236-3>
9. Motlagh, S. E., Amrai, K., Yazdani, M. J., Altaib Abderahim, H., & Soury, H. (2011). The relationship between self-efficacy and academic achievement in high school students. *Procedia-Social and Behavioral Sciences*, 15, 765–768.

ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ СУРАЛЦАГЧДЫГ ХИЧЭЭЛЭЭС ГАДУУРХ СУРГАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААГААР ХӨГЖҮҮЛЭХ НЬ

(Дундговь аймаг дахь политехник коллежийн суралцагчдын жишээн дээр)

Б.Адьяасүрэн, Г.Ганжаргал, Ө.Дэлгэрмөрөн, Б.Мөнхбадрал, З.Цолмонгэрэл¹

¹Дундговь аймаг дахь Политехник коллежийн багш нар
tseveta40@gmail.com

Үндэслэл

Дундговь аймгийн хэмжээнд 2023 оны хагас жилийн статистик мэдээллээр хөгжлийн бэрхшээлтэй 1415 иргэн байгаа бөгөөд үүнээс ерөнхий боловсролын сургуульд 72 хүүхэд суралцаж байна. Эдгээр хүүхдийн 73% нь 11–16 насны хүүхдүүд байна. Политехник коллежийн хувьд 2020–2021 оны хичээлийн жилд хөгжлийн бэрхшээлтэй 1 хүүхэд суралцаж байсан бөгөөд түүнээс хойш 2023–2024 оны хичээлийн жилд 8 суралцагч болж нэмэгдсэн нь цаашид энэ тоо өсөх хандлагатай байгааг харуулж байна. Хөгжлийн бэрхшээлтэй суралцагчдын хувьд сурлагын хоцрогдол, төлөвшил хандлага, нийгэмшихүйн чадвар, хөгжлийн хувьд тодорхой ахиц өөрчлөлт гарахгүйгээр урсгалаараа явж байгаад төгсөж байсан харамсалтай дүр зураг 2022 он хүртэл үргэлжилсэн байна. Энэ асуудалд багш нар анхаарлаа хандуулж 2022 оноос хойш хөгжлийн бэрхшээлтэй суралцагчдыг хичээлээс гадуурх сургалтын ажлаар хөгжүүлэх зорилго тавин ажилласан юм. Энэхүү ажлын явц, хэрэгжилт, үр дүнд дүн шинжилгээ хийж цаашид сайжруулах арга замыг тодорхойлох зорилгоор энэхүү илтгэлээ бичлээ.

Зорилго

Дундговь аймаг дахь Политехник коллежид суралцаж буй хөгжлийн бэрхшээлтэй суралцагчдыг хичээлээс гадуурх сургалтад хамруулснаар гарсан ахиц өөрчлөлт, бэрхшээлд дүн шинжилгээ хийж цаашид сайжруулах арга замыг эрэлхийлэхэд оршино.

Судалгааны арга зүй

Дундговь аймаг дахь Политехник коллежид суралцаж буй хөгжлийн бэрхшээлтэй суралцагчдын хүрээнд хийгдсэн нөхцөл байдлын судалгаануудын тайланд агуулгын шинжилгээ хийн үр дүнг боловсруулав.

Үр дүн

Хүснэгт 1. Дундговь аймаг дахь политехник коллежийн хөгжлийн бэрхшээлтэй суралцагчидтай ажиллах ажлын төлөвлөгөө
2022–2023 оны хичээлийн жил

№	Үйл ажиллагааны чиглэл	Хүрэх үр дүн	Хугацаа	Хариуцах эзэн	Хамтран ажиллах
1	Дундговь аймаг дахь Политехник коллежид суралцаж буй суралцагчдын тоон судалгаа гаргах	Хөгжлийн бэрхшээлтэй суралцагчдын мэдээллийн сантай болно.	9 сард	Багийн гишүүд	Сургалтын алба, АУБ
2	Суралцагчдын хөгжлийн түвшинг оношлох	Хөгжлийн бэрхшээлтэй суралцагчдын хөгжлийн түвшинг тогтооно.	9 сард	Багийн гишүүд	СНА, АУБ
3	Хөгжлийн бэрхшээлтэй суралцагчтай ажиллах төлөвлөгөө боловсруулж ажиллах	Суралцагчдын чадварыг хөгжүүлнэ	10 сард	Багийн гишүүд	Дугуйлан секц удирдан ажиллуулдаг багш нар
4	Ахиц өөрчлөлтийг үнэлж цаашид сайжруулах төлөвлөгөө гаргах	Үйл ажиллагаагаа үнэлж үр дүнг үнэлнэ.	5 сард	Багийн гишүүд	

Дүгнэлт: Сүүлийн жилүүдэд манай сургуульд элсэн суралцаж байгаа хөгжлийн бэрхшээлтэй суралцагчдын тоо жил бүр нэмэгдэж байгаа ба эдгээр суралцагчдыг анхаарч хөгжүүлэх, дэмжих зорилгоор дээрх ажлын төлөвлөгөөг боловсруулан туршин хэрэгжүүлсэн.

Хүснэгт 2. Дундговь аймаг дахь Политехник коллежид суралцаж байгаа хөгжлийн бэрхшээлтэй суралцагчидын тоо ба хөгжлийн бэрхшээлийн төрөл (мэргэжлээр)

№	Мэргэжлийн нэр	2020–2021 он	2021–2022 он	2022–2023 он	2023–2024 он	Бүгд
1	Цахим тоног төхөөрөмж үйлчилгээний ажилтан	1 – Хавсарсан	1 – Сэтгэц	0	1 – Сэтгэц	3
2	Оёмол бүтээгдэхүүний оёдолчин	0	2 – Сэтгэц	0	1 – Сэтгэц	3
3	Ойжуулагч	0	0	1 – Сэтгэц	0	1
4	Тогооч	0	0	1 – Сэтгэц	0	1
	Бүгд	1	3	2	2	8

Дүгнэлт: Сүүлийн 4 жилийн хугацаанд хөгжлийн бэрхшээлтэй 8 суралцагч байгаа боловч, үүний 7 нь албан ёсоор хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын салбар комиссоор оношлогдсон. 1 суралцагч бага ангидаа оношлогдож байсан боловч одоо эмчийн магадлагаагаар тогтоогдоогүй.

Хүснэгт 3. Дундговь аймаг дахь Политехник коллежид суралцаж байгаа хөгжлийн бэрхшээлтэй суралцагчдын дугуйлан секцийн хамрагдалт

№	Мэргэжлийн нэр	2020–2021 элсэгчид	2021–2022 элсэгчид	2022–2023 элсэгчид	2023–2024 элсэгчид	Бүгд
1	Цахим тоног төхөөрөмж үйлчилгээний ажилтан	1 – Үгүй	1 – Үгүй		1 – “Залуу судлаач” клуб	1
2	Оёмол бүтээгдэхүүний оёдолчин		2 – Үгүй	2 – “Хобби” гар урлал	“Хобби” гар урлал	3
3	Ойжуулагч			1 – Ногоон зүрх – Эко клуб.		1
4	Тогооч			1 – Үгүй		1
	Бүгд			2	2	8

Дүгнэлт: Судалгаанд хамрагдсан суралцагчдын 62.5%-г суралцагчын онцлогт тохируулан дугуйлан, клубд хамруулж байна.

Хүснэгт 4. Дундговь аймаг дахь Политехник коллежид суралцаж байгаа хөгжлийн бэрхшээлтэй суралцагчдын хөгжлийн түвшин

Суралцагчийн нэр	Сайн чадвар		Сул чадвар					
	Хөдөлгөөн эрүүл мэндийн чадамж	Нийгэм-шихүйн чадамж	Сонсож, ойлгох	Ярих	Уншиж бичих бэлтгэл	Орчноо шинжлэн судлах	Сэтгэлийн хөдөлгөөнөө илэрхийлэх	Бусадтай харилцах
И	4,8	4,4	2.1	1.8	1,6	2.2		
И	4.12			2.25	2,5	2.2	2,8	2,5
Н	4.76	4		1.6	2.5	2.2		
Ш	3,3	3,5					2,6	2,8
О	4.6	4,3	2.6	1	2	1		

Дүгнэлт: Хүүхдийн хөгжлийн ахицыг үнэлэх ажиглалтын хуудас ашиглан суралцагчдын хөгжлийн түвшинг үнэлэхдээ эзэмшсэн чадвар болон сул чадварыг харьцуулан гаргаснаар цаашид ямар чадварыг хөгжүүлэх шаардлагатай байгааг тодруулсан.

Хүснэгт 5. Дугуйланд хамрагдсан хөгжлийн бэрхшээлтэй суралцагчдын ажиглалтын судалгаа

Суралцагчийн нэр	Дугуйлан эхлэх үеийн зан байдлын судалгаа	Дугуйланд суралцах үеийн өөрчлөлтийн судалгаа	Цаашид дахин сайжруулах чадвар
Н	<ul style="list-style-type: none"> Уншиж бичих чадваргүй Цифр мэдэхгүй улмаас регистрийн дугаар, утасны дугаараа мэдэхгүй 	<ul style="list-style-type: none"> Мэндлэх хүндлэх ёсонд суралцсан Хариуцлагатай Багаар хамтран ажиллах чадвартай болсон 	<ul style="list-style-type: none"> Зохион бүтээх чадвар, эргэцүүлэн бодох чадвар, Бие даан суралцах, чөлөөт оролцоо,

	<ul style="list-style-type: none"> • Шаардлага хүлээн авдаггүй • Үг даадаггүй • Цаг баримталдаггүй • Бүрэг ичимхий 	<ul style="list-style-type: none"> • Цагийг үр бүтээлтэй өнгөрүүлдэг. • Хүлээцтэй болж, бусдыг сонсдог чадвар сайжирч байгаа • Өөртөө итгэлтэй болсон • Цэвэрч нямбай, тусч 	<ul style="list-style-type: none"> • Хөгжүүлэх чадваруудыг түлхүү хөгжүүлэх
Ш	<ul style="list-style-type: none"> • Өөрийн сонирхолгүй зүйлд залхуурах хандлагатай • Өөрийгөө ялгаварлах дургүй • Ээжээс хамааралтай • Бичиж бодох чадвар тааруу • Бусдын үг даадаггүй 	<ul style="list-style-type: none"> • Мэндлэх хүндлэх ёсонд суралцсан. • Найрсаг • Идэвхтэй • Хариуцлагатай • Өөрийгөө илэрхийлэх чадвар сайн • Хүлээцтэй болж, бусдыг сонсдог чадвар сайжирч байгаа • Өөртөө итгэлтэй болсон 	<ul style="list-style-type: none"> • Багаар ажиллах чадварыг сайжруулах • Өөрийгөө дайчлах, өөртөө итгэлтэй болох чадварыг хөгжүүлэх • Шаргуу, тууштай байх чадварыг хөгжүүлэх, • Мэдээлэл харилцааны технологиор дамжуулан мэдээлэл олж авах чадварыг сайжруулах
О	<ul style="list-style-type: none"> • Цифр мэдэхгүй улмаас анги танхимын дугаар, утасны дугаар, регистрийн дугаар мэддэггүй • Бичиг үсгийн чадвар тааруу 	<ul style="list-style-type: none"> • Мэндлэх хүндлэх ёсонд суралцсан. • Зөв хандлагатай • Шаргуу хөдөлмөрлөдөг өгсөн үүрэг даалгаврыг сайн биелүүлдэг 	<ul style="list-style-type: none"> • Эргэцүүлэн бодох • Шийдвэр гаргах чадвар • Чөлөөт оролцоог сайжруулах • Мэдээлэлд дүн шинжилгээ хийх
И	<ul style="list-style-type: none"> • Бие дааж шийдвэр гаргаж чаддаггүй ээж мэднэ, ээжээс асууя гэх мэт шийдвэр гаргаж чадахгүй. • Үг даахгүй гомдох гуних асуудал гардаг байсан. 	<ul style="list-style-type: none"> • Мэндлэх хүндлэх ёсонд суралцсан. • Шаргуу хөдөлмөрлөдөг • Хариуцлагатай • Бусдыг сонсдог 	<ul style="list-style-type: none"> • Зохион бүтээх чадвар, • Эргэцүүлэн бодох чадвар, • Бие даан суралцах, чөлөөт оролцоо, • Зохион байгуулах чадвар, нээлттэй байх
И	<ul style="list-style-type: none"> • Шаардлага хялбар хүлээж авахгүй уйлдаг • Хүүхдүүдтэй нийтэч биш • Харц тулгарахад дальдардаг • Ээжээс хамааралтай 	<ul style="list-style-type: none"> • Мэндлэх хүндлэх ёсонд суралцсан. • Цаг сайн баримталдаг • Эелдэг • Хариуцлагатай • Хүлээцтэй болж, бусдыг сонсдог чадвартай 	<ul style="list-style-type: none"> • Зохион бүтээх чадвар, • Эргэцүүлэн бодох чадвар. • Бие даан суралцах, чөлөөт оролцоо, • Зохион байгуулах чадвар, нээлттэй байх

Дүгнэлт: Дээрх бэрхшээлүүдээс харахад сурлагын хоцрогдолоос (унших бичих, бодох суурь чадвар эзэмшээгүй) гадна гэр бүлийн гишүүдээс тэр дундаа ээжээс хамаарагтгай (бие даасан байдал байхгүй) байгаа нь ажиглагдаж байна. Энэ нь эцэг эх асран хамгаалагчид хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдээ хамгаалж хайрлаж байгаа нь гээд бусдаас өмөөрсөөр ирсэн нь ирээдүйн амьдралд бие даах чадваргүй иргэн болоход нөлөөлж байна.

2021 оноос хойш сургуулийн хэмжээнд нийт 20 дугуйлан хичээллэж байгаагаас давхардсан тоогоор нийт 517 суралцагч хамрагдаж байгаа ба 2021–2022 оны хичээлийн жилд 0, 2022–2023 оны хичээлийн жилд 3, 2023–2024 оны хичээлийн жилд 5 хөгжлийн бэрхшээлтэй суралцагч хамрагдсан байна.

Дугуйлан секцэд хамрагдсан суралцагчдын сэтгэл ханамжийн судалгаа

График 1. Асуулга 1: Дугуйланд суралцсанаар харилцаа хандлагын хувьд ямар эерэг өөрчлөлт гарсан бэ?



Хүснэгт 6. Асуулга 1–3

1. Дугуйланд хамрагдсанаар юу сурч мэдсэн бэ?	2. Хэрэв дугуйланд хамрагдаагүй бол...	3. Цаашид юу сурч эзэмших хүсэлтэй байна вэ?
<ul style="list-style-type: none"> • Экологи байгаль хамгааллын талаар мэдлэгтэй болсон • Хог ангилах, цахилгаан, ус хэмнэх талаар суралцсан. • Дэрний уут оёсон • Судалгаа авахад суралцсан • Эсгий чимэглэл, дэрний уут • Эсгий ширмэл – Эпокси бүтээл 	<ul style="list-style-type: none"> • Бүрэг, экологийн зөв ойлголтгүй байна • Мэдлэг эзэмшихгүй байсан • Гар утсаар л тоглох байх • Мэргэжлийн зааснаас өөр зүйл суралцахгүй байсан • Бусадтай нээлттэй харилцаж чадахгүй 	<ul style="list-style-type: none"> • Өөрийгөө зөв илэрхийлэх • Юмыг хурдан ойлгодог болгох • Олны өмнө гарах зоригтой • Өөртөө итгэх итгэлтэй • Манлайлах чадварт суралцах

Дүгнэлт: Суралцагчдын сэтгэл ханамжийн судалгаанаас харахад харилцаа хандлагын хувьд цаг баримтлах, бусдыг сонсох, багаар ажиллах, цагийг үр бүтээлтэй өнгөрөөх зэрэг олон эерэг өөрчлөлтүүд гарсан бол мэдлэг ойлголтын хувьд амьдрал ахуйд хэрэгцээтэй чадваруудад суралцсан байна. Хэрвээ дугуйланд суралцаагүй боп дээрх мэдлэг, чадваруудыг эзэмшихгүй байсан бөгөөд бүрэг ичимхий, бусдаас хамааралтай, цахим орчинд донтох зэрэг дадал хэвшилтэй хэвээр үлдэх байсан. Цаашид юу сурч эзэмших хүсэлтэй байна вэ? гэж асуухад цаашид сурч хөгжих сонирхолтой, манлайлах чадварыг өөртөө суулгах хүсэл эрмэлзлэл дүүрэн болсон байгаа нь харагдаж байна.

Дугуйланд хамрагдсан суралцагчдын эцэг эхийн сэтгэл ханамжийн судалгаа

График 2. Асуулга 1: Таны хүүхдээ дугуйланд хамрагдахад дэмждэг байсан уу?




График 3. Асуулга 2: Таны хүүхдээ дугуйланд суралцсанаар харилцаа хандлагын хувьд ямар зэрэг өөрчлөлт гарсан бэ?





График 4. Асуулга 3: Таны хүүхдээ дугуйланд хамруулах хүсэлтэй байна уу?



Хүснэгт 6. Асуулга–4

4. Таны хүүхдэддугуйланд суралцсан мэдлэг чадвараа амьдралд хэрэглэж байна уу?
<ul style="list-style-type: none"> • Гэр бүлийн гишүүддээ тус бүр дэрний уут хийж өгсөн. • Хогоо ангилж тог цахилгаанаа хэмнэдэг болсон. • Эерэг хандлага нэмэгдсэн (дүү нартайгаа сайн ойлголцдог болсон) • Хос дэрний уут захиалгаар хийж зарсан. • Гуталны эсгий улавч хийсэн.

Дүгнэлт: Эцэг эхчүүдийн сэтгэл ханамжийн судалгаанаас харахад хүүхдийнхээ төлөвшил хандлага, мэдлэг чадварын ахиц дэвшилд сэтгэл хангалуун байгаа ба энэ нь цаашид үргэлжүүлэн суралцахыг 100% дэмжсэнээр харагдаж байна.

Дүгнэлт

Судалгаанд хамрагдсан суралцагчдын хөгжлийн түвшинд тохируулан “Хобби” гар урлал, “Ногоон зүрх” эко клуб, “Залуу судлаач” илтгэлийн клуб зэрэг дугуйланд хамруулан суралцуулж байгаа бөгөөд хичээлээс гадуурх сургалтын ажлаар эзэмшвэл зохих шүүмжлэлт болон шинэлэг сэтгэлгээ, хүмүүс хоорондын харилцаа, хувь хүний чадвар, дэлхийн иргэн, мэдээллийн технологийн хэрэглээ зэрэг чадваруудыг нэмэгдүүлэхийг зорьсон. Хөгжлийн бэрхшээлтэй суралцагчдын хийсэн бүтээлээр үзэсгэлэн гаргаж сурталчлан таниулах, арга хэмжээ зохион

байгуулах замаар өөртөө итгэх итгэлийг нэмэгдүүлэх, амьжиргаанд нь дэмжлэг болох, нийгмийн амьдралд оролцоход түлхэц болох зэрэг давуу тал үүснэ.

Туршилт эхлэхэд ажиглагдсан нэг тулгамдсан асуудал нь эцэг эх асран хамгаалагчид (ялангуяа ээжүүд) хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдээ хамгаалж хайрлаж байгаа нь гээд бусдаас өмөөрдөг нь ирээдүйн амьдралд бие даах чадваргүй иргэн болоход сөргөөр нөлөөлөх болж байсан.

Эцэг эхчүүдийн сэтгэл ханамжийн судалгаанаас харахад хүүхдийнхээ төлөвшил хандлага, мэдлэг чадварын ахиц дэвшилд сэтгэл хангалуун байж цаашид дугуйлан секцэд үргэлжлүүлэн суралцахыг 100% дэмжсэн нь энэхүү туршилтыг дээрх тулгамдсан асуудлыг шийдвэрлэхэд бага ч гэсэн нөлөө үзүүлж байна гэж дүгнэж байна. Цаашид эцэг эх, асран хамгаалагчдад сургалт сурталчилгаа тогтмол зохион байгуулах шаардлагатай.

Түлхүүр үг: *Дэмжлэг, оролцоо, дугуйлан секи, ахиц.*

Ашигласан материал:

1. Дундговь аймгийн Засаг Даргын Тамгын Газар (2023). *Дундговь аймгийн 2022–2023 оны хөгжлийн бэрхшээлтэй иргэний статистик мэдээ*. Монгол Улс, Дундговь аймаг.
2. Боловсрол, шинжлэх ухааны сайдын А/288 дугаар тушаал. Монгол Улс, Улаанбаатар хот.
3. Дундговь аймгийн Засаг Даргын Тамгын Газар (2023). *Дундговь аймгийн Засаг даргын 2020–2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр*. Монгол Улс, Дундговь аймаг.
4. Боловсрол, соёл шинжлэх ухаан спортын сайдын А/155 дугаар тушаал А/155. Монгол Улс, Улаанбаатар хот.
5. Дундговь аймгийн Засаг Даргын Тамгын Газар (2023). *Дундговь аймаг дахь Политехник коллежийн 2021–2023 оны гүйцэтгэлийн үнэлгээний төлөвлөгөөний хэрэгжилтийн тайлан*. Монгол Улс, Улаанбаатар хот.

ЯЛГААТАЙ ХЭРЭГЦЭЭТЭЙ СУРАГЧДЫН ХӨГЖЛИЙН АХИЦ (Ерөнхий боловсролын “Сод эрдэм” сургуулийн жишээн дээр)

Д.Мөнхбаатар¹, Л.Жавзанпагма², А.Дуламсүрэн³, Б.Цэрэнханд⁴

¹Захирал, ²Сургалтын менежер, ³Нийгмийн ажилтан, ⁴Тусгай хэрэгцээт боловсролын багш

Үндэслэл

Тэгш хамруулан сургах боловсрол нь хүүхэд бүрд өөр өөр, харин сургууль, боловсролын тогтолцоо хүүхдийг хөгжлийн бэрхшээлтэй эсэхээс үл хамааран суралцагч бүрийн хувийн хэрэгцээг хангах ёстой гэж үздэг. Эдгээр хүүхдийн өөрийн гэсэн онцлог давуу тал, чадвар боломжид итгэх итгэл, хүүхэдтэй ажиллах шинэ хандлага аргуудын ачаар тэдний нийгэмшлийн болон бие даах чадвар нэмэгдэж байна. Манай улсын хувьд дээрх хандлага чиглэлийн хүрээнд хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд, иргэдийн талаар анхаарч, ялангуяа багш бэлтгэх чиглэлд тодорхой бодлого үйл ажиллагаа явуулсны үр дүнд ахиц өөрчлөлт гарч байна. Орон нутгийн хэмжээнд ялгаатай хэрэгцээтэй суралцагчдад дэмжлэг үзүүлэх, боловсролын үйлчилгээнд тэгш хамруулах хэрэгцээ шаардлага байна. Учир нь Хөвсгөл аймгийн хэмжээнд ердийн сургалтай сургуульд ТХБ төвтэй үйлчилгээ явуулдаг 34 сургуулиас 3 сургууль байна.

Зорилго

Ялгаатай хэрэгцээтэй суралцагчдын хөгжлийн ахицыг орон нутгийн сургуулийн жишээнд хэрэгжүүлэх.

Үр дүн

Ерөнхий боловсролын Сод–Эрдэм сургууль нь тэгш хамруулах сургалтыг чанартай хүргэхийн тулд өөрсдийн нөөц боломж, орчиндоо тулгуурлан 7 дох жилдээ хэрэгжүүлж байна. Хэрэгжүүлэх явцад бидэнд дараах хүндрэл бэрхшээл тулгарсан.

- ОРЧИН: - Шаардлага хангасан анги танхимын бэлэн байдал хангалтгүй
- ХҮНИЙ - Мэргэжлийн бус багштайгаар үйл ажиллагаагаа эхлүүлсэн (2016–2022 оны 2 сар)
- НӨӨЦ: - 2022 оны 2 сараас мэргэжлийн багшаар хангагдсан.
- ХАНДЛАГА: - Багш ажилчдын ойлголт, мэдлэг мэдээлэл дутмагаас хандлагын өөрчлөлт удаан байсан.
 - Шинээр хөгжлийн төв нээж дэмжлэг шаардлагатай хүүхдэд үйлчилгээ үзүүлнэ гэхээр итгэл төгс бус байсан
 - Хүүхдээсээ ичих, нуух хандлагатай байсан
 - Хүүхдээ хүргэж өгөх авах тал дээр эерэг хандлага суугаагүй улмаас таслуулах хандлагатай байсан.
 - Ердийн ЕБС-ийн хүүхдүүд ангид нь зэрэгцэн сууна гэдэгт итгэлгүй байх гэх мэт олон хүндрэл бэрхшээл тулгарч байсан.

Нэг. Ялгаатай хэрэгцээтэй хүүхдүүдийн нийгмийн нөхцөл байдлыг судалсан байдал

Сурагчдын ам бүлийн судалгааг харахад 2 ам бүлтэй 1, 3 ам бүлтэй 2, 4 ам бүлтэй 4, 5 болон 6 ам бүлтэй 3 сурагч байна. Сурагчийн ам бүл болон өрхийн орлогыг харьцуулж харахад Өрхийн сарын орлого нь 300000 – 8%, 500000 – 23%, 600000–15%, 800000 – 8%, 1000000 – 38% байгаа боловч ам бүлийн тоо их байх тусам нэг хүнд ногдох хэмжээ нь хөдөлмөрийн хөлсний хэмжээнээс доогуур үзүүлэлттэй болж харагдаж буй нь хөгжлийн ялгаатай суралцагчид суурь хэрэгцээ хангагдахгүй байгааг харуулж байна.

Сургуульд суралцаж буй хугацааны хувьд 6 жил суралцаж байгаа 8%, 5, 2, 4 жил суралцаж байгаа 17%, 3 жил суралцаж байгаа 25%, эхний жилдээ суралцаж байгаа 16% байна. Хэдийгээр 5, 6 жил суралцаж байгаа сурагчид байгаа боловч тусгай хэрэгцээт боловсролын үйлчилгээг хөгжлийн төвөөр дамжуулан хэрэгжүүлснээр нийгэмшиж, хөгжих боломж илүү нээлттэй болсон.

Мөн тус төв нь тогтмол үйл ажиллагаа явуулж эхэлснээр шинээр суралцах суралцагчид нэмэгдсэн байна. Одоогоор 18 хүүхэд суралцаж байна

Хоёр. Хөгжлийн ялгаатай хэрэгцээтэй хүүхдүүдийн хөгжлийн байдалд дүн шинжилгээ хийсэн байдал

Ерөнхий боловсролын “Сод–Эрдэм” сургуульд 2017 онд – 3, 2018 онд – 3, 2019 онд – 4, 2020 онд – 5, 2021 онд – 7, 2022 онд – 11, 2023 онд – 18 суралцагч суралцаж байгаагаас 4 суралцагчийг суурь боловсролын түвшинд сурган гэрчилгээ олгосон байна. Үүнээс 2 суралцагч МСҮТ-ийн оёдол, гоо сайхны ангид элсэн суралцаж, 2 суралцагч амьдралд бэлтгэгдэн гарсан байна. Одоогоор ХХТ-д суралцаж байгаа даун, аутизмтай хүүхдүүдийн сурцын хөгжлийн байдлыг тодорхойлбол:

Хүснэгт 1. Чанарын судалгаанд оролцсон сурагчдын үндсэн мэдээлэл хэлбэр

Хэлбэр	Төвд суралцсан хугацаа	Бодит байдлын судалгаа	ГСТ боловсруулсан байдал (арга зүй)	ГСТ боловсруулсан байдал Хугацаа	Хүүхдэд гарсан, ахиц өөрчлөлт	
					Эерэг	Сөрөг
Тархины саажилт	2	<ul style="list-style-type: none"> Хоолоо өөрөө идэж чадахгүй, Үсэг, тоо мэдэхгүй Өмнө нь сургууль, цэцэрлэгт хамрагдаж байгаагүй. 	Бодит байдлын судалгаанд үндэслэн, сайжруулмаар байгаа	Ганцаарчилсан сургалтын төлөвлөгөөгөөр 2 дахь жилдээ суралцаж байна.	<ul style="list-style-type: none"> Бүх үсгээ мэддэг болсон. Уншиж сурсан. 1–20 хүртэл нэмж, хасаж сурсан. Хүрд цээжилсэн. Шүлэг Цээжилж сурсан. Анги хамт олонтойгоо нийтэч болсон. 	Хичээл таслалт их байсан.
Тархины саажилт 1	3	<ul style="list-style-type: none"> 6 настай сургуульд орсон. Үзэг, бал, харандаа, халбага барьж чаддаггүй, хуурай хүнсийг идэж чаддаг. Үсэг тоо мэдэхгүй, бичиж чадахгүй. Алхахдаа муу, гүйж чадахгүй. 	зүйл дээр тулгуурлан дараах арга зүйгээр ажилласан. 1. Үсэг, тоо таниулах арга зүй: Бүх үсэг, тоогоо мэддэг болсон. 2. Нэмэх, хасах үйлдэл таниулах	3 жилийн турш Ганцаарчилсан сургалтын төлөвлөгөөгөөр хичээллэж байгаа.	<ul style="list-style-type: none"> Бичиж сурсан. Халбага барьж хооллодог болсон. Эгшиг 7 үсгээ цээжилж, тогтоосон. Савх, шугам ашиглан 100 дотор бодож сурсан. Баганан бичиглэлээр бодож сурсан. Алхахдаа сайжирсан. Хурдан явж чаддаг болсон. Зураг зурах дуртай болсон. Сэдэвт баригдахгүйгээр зурж зурсан. 	<ul style="list-style-type: none"> Мартах хандлагатай Эцэг эхийн анхаарал халамж сул Хичээлд нь хүргэж ирэхгүй байх Ойлголт хандлага сул
Даун	3	<ul style="list-style-type: none"> Үсэг мэдэхгүй, 10 хүртэл тоо мэднэ. Нэмэж, хасаж чадахгүй. Хоолоо өөрөө идэж чадна. Алхаж, гүйж чадна. 	3. Баримлын шавар ашиглан гарын жижиг булчинг хөгжүүлэх арга зүй 4. Зурган арга		<ul style="list-style-type: none"> Бүх үсгээ мэддэг болсон. 1–2 үетэй үгнүүдийг уншиж сурсан. 100 хүртлэх тоогоо нүдлэж тогтоосон. Баганан бичиглэл сурсан. Шугам ашиглан 100 дотор нэмж хасаж сурсан. Зураг зурах сонирхолтой болсон. 	
Аутизм	3	<ul style="list-style-type: none"> Ярьж чадахгүй, ангид суух дургүй, Маш их хашхичдаг, Хаашаа ч хамаагүй гүйдэг. Бал харандаа барьж чаддаггүй. 	5. Тоо тоолол 6. Мөнгөний арга		<ul style="list-style-type: none"> Ангид 5–15 минут сууж сурсан. Ангид хашхичих нь багассан. Багштай хамтран харандаа барьж, зураг буддаг болсон. 	

Гурав. Ганцаарчилсан сургалтын төлөвлөгөөний хэрэгжилт, ахиц, үр дүн, аргагүй, хэрэглэгдэхүүн

Хөгжлийн төвд суралцаж буй сурагчдын дийлэнх нь оюун ухаан болон тархины саатай суралцагчид байгаа учраас тухайн сурагчдаас түүвэр байдлаар ахиц амжилтыг хүүхэд нэг сурагчаар харуулбал, тухайлбал:

Кейс 1. Сурагч А тархины саажилттай. 9 настай. Огт сургууль цэцэрлэгт хамрагдаж байгаагүй бөгөөд хамрагдах, олон найзуудтай болох чин хүсэл эрмэлзэлтэй байсан боловч хүлээж авах цэцэрлэг, сургууль, багш олдохгүй байсан. 2022 онд “Сод Эрдэм” сургуульд элсэн орсноор түүний сурах, нийгэмших их үйлсийн гараа эхэлсэн юм.

Сурагчийн сургуульд орох үеийн түвшинг Монгол улсын Боловсрол, соёл шинжлэх ухаан, спортын сайдын 2018 онд гаргасан “Үлгэрчилсэн загвар, аргачлал батлах тухай” А155 тоот тушаалын дагуу Ганцаарчилсан сургалтын төлөвлөгөөний Хөгжлийн дөрвөн ай – н хүрээнд бодит байдлын судалгаа хийж, тодорхойлоход:

- **Өөртөө үйлчлэх энгийн чадварууд:** Халбага барьж чадахгүй, хоолоо өөрөө идэж чадахгүй, Тэргэнцэр болон хүүхдийн машин ашигладаг. Заавал бусдын тусламжтайгаар бие засдаг.
- **Хэл яриа, танин мэдэхүй тоо тоолол:** Тоо, үсэг мэдэхгүй, Нэмэх, хасах үйлдэл мэдэхгүй. Өнгө мэднэ.
- **Нийгэмшихүй:** Өөрийгөө илэрхийлэх арга барил сайн. Бусадтай ярилцах, өөрийн үзэл бодлоо илэрхийлэх дуртай.
- **Бие бялдар, хөдөлгөөн:** Бусдын тусламжтай алхах гэж хичээдэг. Бал, харандаа, халбага, бөмбөг барьж чадахгүй. гэх мэт чадваруудтай байсан.

Сурагч А-тай ажилласан багшийн арга зүйгээс дурдвал:

1. Баримлын шавар ашиглан хурууны мэдрэхүйг сайжруулах арга
 - 3D баримлын шавар ашиглан тоглох.
 - Хичээлийн эхэнд болон дунд алжаал тайлах хэлбэрээр тоглуулах.
 - Баримлын шаврыг бөөрөнхийлөх, таслах гэх мэтийг чөлөөтэй хийлгэх. Анхаарах зүйл: хурууны дасгалыг хичээлийн нэг хэсэг болгон, хийсэн бүтээлээ бусдад үзүүлэн болгон харуулахгүй байх нь хүүхэд алдаанаас айлгүйгээр хийж гүйцэтгэхэд үр дүнтэй.
2. А–Я 35 үсгийг нүдлэн тогтоолгож, уншуулж сургах, давхарлан бичүүлэх арга
 - Эгшиг 7 үсгийг томоор хэвлэж гаргаж өгөх, нүдлүүлэх
 - Дэвтэрт томоор бичиж өгч, хамтран давхарлаж бичих
 - Задгай үе, битүү үеийг таниулж, тогтоолгох м
 - 1, 2-р гийгүүлэгчийг таниулж, тогтоолгох
 - Дэвтэрт бичсэн үсгийг давхарлан бичих, нүдэлж тогтоох
 - Гадаад үсгүүдийг таниулах, дэвтэрт бичиж өгч давхарлан бичүүлэх.
 - Богино үетэй үгнүүдийг уншуулах, дэвтэрт бичиж, давхарлан бичүүлэх.
 - Бүх үсгийг зургийн хамт хэвлэж, сурагчид харагдахуйц байдлаар байрлуулах.
 - Онъсого, зүйр цэцэн үг зэргийг бичиж өгч давхарлан бичүүлэх, хамтарч унших
 - Богино үгтэй эхүүдийг хамтарч унших
 - Шүлэг цээжлэх.

Сургалтын явцад багшид анхаарах зүйл: Сурагчийг хэт их шахах болохгүй мөн хичээлийг таслуулахгүйгээр бага багаар алхам алхмаар зааж, сонирхолтой байдлаар дуртай зүйлээр нь жишээ татаж заавал илүү хурдан тогтоох, тогтоосноо мартахагүй байх боломжтой байсан. Мөн сурагчийн онцлогийг ойлгож, аль болох хүлээцтэй, үгээ хэлж дуустал нь тайван байлгах нь зүйтэй байсан.

Дөрөв. Ялгаатай хэрэгцээтэй хүүхдийг нийгэм хүлээж буй байдал

Ерөнхий боловсролын “Сод Эрдэм” сургууль нь ялгаатай хэрэгцээтэй хүүхдийн сурч боловсрох эрхийн хангахын тулд ТХБ төвийг ажиллуулж эхэлсэн боловч нийгэм, болон сургалтын

байгууллагын хандлага төдийлөн хүлээж авахгүй байсан. Тиймээс хандлага өөрчлөх олон талт сургалтуудыг шат дараатай зохион байгуулсан байна. 2023 байдлаар авч үзэхэд хандлага өөрчлөх ойлголт нэмэгдүүлэх сургалт 12 төрлийг танхимаар, цахимаар 6 хичээлийг бэлтгэн түгээсэн байна. Анх 2019 онд хандлагын судалгаа авч үзэхэд ердийн сургуульд ялгаатай хэрэгцээтэй хүүхэд суралцах нь зөв эсэх дээр буруу гэж 42% нь хариулж байсан бол 3 жилийн хандлага өөрчлөх сургалт нөлөөллийн ажил, ярилцлага, таниулах сургалтын үр дүнд 2022 оны 5 сарын байдлаар 28% болтлоо буурч мөн 18 сурагч 11 ангид үе тэнгийн найзтайгаа суралцаж байна.

Танай хүүхдийн ангид ХБХ суралцах нь зөв эсэх



ХБХ Ердийн сургалттай сургуульд сурах нь зөв эсэх



Танай хүүхдийн ангид ХБХ сурах эсэх талаар тандалт судалгаа авч үзэхэд 2019 онд дэмжихгүй гэж нийт эцэг эх асран хамгаалагч, харгалзан дэмжигч 49.5% нь хариулж байсан бол 2022 оны 5 сарын байдлаар 20%-иар буурч хандлагын өөрчлөлт гарсан байна.

Би найзтайгаа ярихын тулд дохионы хэл сурч байгаа

10 ангийн охины ярианаас

Дүгнэлт

- Хөгжлийн ялгаатай суралцагчдад зориулсан Тэгш хамруулах боловсрол олгох хууль эрх зүйн орчин хангалттай хэдий ч мэдлэг ойлголтын хувьд иргэд харилцан адилгүй байна.
- Хөвсгөл аймгийн хэмжээнд Тэгш хамруулах боловсролын үзэл санаа хандлага, хэрэгжилт орон нутгийн тогтолцоог бүрэлдүүлэх шатандаа явагдаж байна.
- Тэгш хамруулах боловсролд хүүхэд нэг бүр хамрагдаж чадахгүй байгаа нь эцэг эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч, багш сурагчдын хандлага нөлөөлж байна.
- Орон нутагт тэгш хүртээмжтэйгээр Тэгш хамруулах боловсролын үйлчилгээ явагдахгүй байна.
- Нэг сургууль дээр олон төрлийн бэрхшээлтэй хүүхдүүд зэрэгцэн суралцахад хүний нөөц, орчин хангалтгүй байна.
- Хөгжлийн ялгаатай сурагчдад тохирсон арга зүйгээр ганцаарчилсан сургалтын төлөвлөгөөг боловсруулан хэрэгжүүлэхэд хөгжлийн дөрвөн айд ахиц гарч байна.
- Эцэг эхчүүд хүүхдүүдээ сургуульд явуулснаар өрхийн санхүүгээ нэмэгдүүлэх боломжтой болж байна.
- Хөгжлийн ялгаатай суралцагчид ердийн ангид сурахад ангийн суралцагчдын хандлагад эерэг өөрчлөлтүүд гарч байна.
- Даун, аутизмтай хүүхдүүдэд боловсрол олгоход А–Я, тоо тооллогын арга, мөнгө таниулах арга, картын аргууд тохиромжтой байсан.
- Тархины саажилт болон даун хам шинж оноштой хүүхдүүдэд суралцахуйн ахиц илүү байсан бол аутизмтай хүүхдүүдэд марталт их байх байдал ажиглагдаж байлаа.
- Хөгжлийн ялгаатай суралцагчдыг хичээлдээ бүрэн хамруулснаар бэрхшээлийн хэлбэрээс үл хамааран ахиц гарч байна.

- Ялгаатай хэрэгцээтэй суралцагчдын дийлэнх гэр бүл нь амьжиргааны баталгаажих түвшнээс доогуур орлоготой, 4–5 ам бүлийн гишүүдтэй байна.
- Орон нутгийн түвшинд Хөгжлийн ялгаатай суралцагчид боловсролд хамрагдах бүрэн боломж байна.

Түлхүүр үг: *Тэгш хамруулан сургах боловсрол, орчин, хүний нөөц, хандлага.*

Ашигласан материал:

1. Болормаа.З, Үүлэнсолонго.Б, Мөнхтуул.Ц, & Ганцэцэг.Д (2014). *Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй ажиллах арга зүй*. Монгол Улс, Улаанбаатар хот.
2. Цэвэгмид.Ц, Алтанцэцэг.Ч, Отгонцэцэг.Ж, Мөнхцэцэг.О, & Наранчимэг.Т (2019). *Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн хөгжлийн түвшинг тодорхойлох, багшлах арга зүйн гарын авлага*. Монгол Улс, Улаанбаатар хот.
3. Лхагвасүрэн.Ч & Баасансүрэн.Д (2020). *Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг боловсролд тэгш хамруулах бодлогыг хэрэгжүүлэх нь*. Монгол Улс, Улаанбаатар хот.
4. Одгэрэл.Д, Ганболд.Д, Мөнхцэцэг.О, Нямдорж.Ч, Бадамцэрэн.А, & Бат–Оюун.Б (2018). *Тэгш хамруулах боловсрол*. Монгол Улс, Улаанбаатар хот.
5. Батцэнгэл.Г (2020). *Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн сургалтын сэтгэл зүйн үндэс*. Монгол Улс, Улаанбаатар хот.
6. ХНХЯ (2018). *Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан хууль тогтоомжийн эмхэтгэл*. Монгол Улс, Улаанбаатар хот.
7. Эрдэнэчулуун.Д (2019). *Мэргэжил сонголтын сэтгэл зүйн үндэс*. Монгол Улс, Улаанбаатар хот.
8. Монгол Улсын их хурлын 2015 оны 01 сарын 29-ний өдрийн 12 дугаар тогтоол. Төрөөс боловсролын талаар баримтлах бодлого батлах тухай. Монгол Улс, Улаанбаатар хот.

НАСАН ТУРШИЙН БОЛОВСРОЛЫН ТӨВД ХӨГЖЛИЙН ЯЛГААТАЙ ХҮҮХДИЙН БОЛОВСРОЛД ХАМРАГДАЛТ, ӨНӨӨГИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ

Б.Одбаяр, Б.Нансалмаа, Т.Алтанбаясгалан, М.Насанжаргал¹

¹Чингэлтэй дүүргийн Насан туршийн боловсролын төв

msueod932@gmail.com

Үндэслэл

Төрөөс хөгжлийн ялгаатай хүүхдүүдийг бусдаас ялгаж тусад нь тусгай сургуульд сургах, ингэхдээ тусгай сургуулиудыг дотор нь хөгжлийн ялгаагаар нь бас заагладаг. Гэхдээ буруу ойлголт, хэвшмэл хандлагын улмаас хөгжлийн бэрхшээлтэй хүний хэрэгцээг харгалзалгүй бий болгосон орчинд ямар нэгэн дэмжлэггүйгээр бусадтай адил байх шаардлага тавихыг интеграцлал буюу нэгтгэх, нэгтгэн сургах гэж нэрлэдэг. Гэхдээ энэ загварын нөлөөгөөр насан туршийн боловсролын төвд хөгжлийн ялгаатай хүүхэд суралцагдаг ч тухайн хүүхдийн ялгааг тодорхойлох, тохирсон сургалтын арга зүйг ашиглан боловсролын үйлчилгээнд хамруулах нэн шаардлага тулгардаг. Бодит байдалд дээр суралцагч бүрд материаллаг болон сэтгэл зүйн таатай орчин бүрдээгүй, багшийн арга зүй туршлага, мэргэжлийн ур чадвар дутмаг байдал нь хичээл сургалтын үйл ажиллагаанд бэрхшээл тулгарч байна. Насан туршийн боловсролын төв дээр тусгай хэрэгцээ шаардлагатай суралцагчдад боловсролын үйлчилгээ үзүүлэх дэмжлэг тусламжаа, тулгарсан асуудлыг шийдэх шийдэл олоход үндэслэл оршино.

Зорилго

Хөгжлийн ялгаатай хүүхдүүдийг боловсролын үйлчилгээнд хамруулах, багш, суралцагчдын сэтгэл зүйн таатай, сурах орчин, нөхцөлийг бүрдүүлэх, боловсрол эзэмшихэд учирч байгаа саадыг арилгах, асуудал дэвшүүлэн гаргалгаа олох болон боловсролыг тэгш хүртээхэд оршино.

Судалгааны арга зүй

Хөдөлмөр, Нийгмийн хамгааллын яам, Жайка олон улсын хамтын ажиллагааны байгууллага хамтран боловсруулсан “Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн асуудал: Бодлого үйл ажиллагаа”-ны асуултуудад тулгуурлан өөрийн дүүргийн нөхцөлд байдалд тохируулан аргачлалыг боловсруулсан. Судалгаанд Чингэлтэй дүүргийн 1–24 хороодын 123 хөгжлийн ялгаатай сургуулийн насны хүүхдүүд хамрагдсанаас 47 эмэгтэй 76 эрэгтэй хамрагдсан байна.

Үр дүн

Хүүхдийн боловсрол эзэмшихэд тулгарч буй гол бэрхшээлийг **согог доголдол эсвэл хөгжлийн бэрхшээл, эмзэг бүлгийн, тусгай хэрэгцээт** гэх мэтээр ангилан хаягласнаар асуудлыг шийдвэрлэж чадахгүй. Ингэж харах нь **ялгаварлан гадуурхах** бүхий л нөхцөлийг бүрдүүлж байдаг. Бидэнд нийтлэг байдаг нэг зүйл бол бидний ялгаатай байдал юм. Энэхүү ялгаатай байдлаас үүдсэн ялгаатай хэрэгцээ хүүхэд бүрд байдаг. Насан туршийн боловсролын төвд “Холимог бүлэг”-ээр суралцаж буй суралцагчдын хөгжлийн ялгаатай байдлыг танин мэдэж асуудалд дүн шинжилгээ хийж үзэхэд суралцагчийг оношлох үйл ажиллагааг тодорхой шат дараалалтай зохион байгуулах, суралцагчдад тохирсон багшийн ур чадварт тулгуурлан агуулга арга зүйн тусламж, дэмжлэг өгөх шаардлагатайг олж харлаа.

График 1. Боловсролын үйлчилгээнд хамрагдалт



Гэрээр боловсрол нөхөн олгох сургалт

Кейс-1

Суралцагч Н нь 17 настай. НТБТөвийн гэрээр боловсрол нөхөн олгох сургалтад 4 дэх жилээ хамрагдаж байна. Үндсэн онош нь дөрвөн мөчний саажилттай, нүдний харааны мэдрэмж болон сонсголын мэдрэхүй алдагдалтай, өөрөө өөртөө үйлчлэх чадвар сул, хэл яриа муутай, булчингийн чангарал ихтэй, оюун ухааны хоцрогдолтой суралцагч юм. Багш анхан шатны өөрөө өөртөө үйлчлэх дадал хэвшүүлэх хичээлийг сонирхолтой хэлбэрээр заасан боловч тодорхой ахиц амжилт гараагүй. Эцэг эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчийн зүгээс хүүхдээ Бүрэн дунд боловсролын үйлчилгээнд хамруулах хүсэлтэй байна.

Кейс-2

Багш Н нь 23 настай. НТБТөвд Насан туршийн боловсролын багшаар 2 дох жилдээ ажиллаж байна. Гэрээр боловсрол нөхөн олгох сургалтын үйл ажиллагааг 1 жил зохион байгуулж ажилласан. Ажиллах явцад мэргэжил арга зүйн туршлага дутмаг байсан ба суралцагчтай хэрхэн харилцах, ойлголцох хичээлийн ахиц үр дүн гарахгүй байгаа нь багшид сэтгэл зүйн хувьд таагүй нөхцөл байдал үүссэн. Мөн гэрээр боловсрол нөхөн олгох сургалтыг явуулахад суралцагчийн гэрт ирж, очих замын нөхцөл байдал хүнд, багшийг дэмжсэн дэмжлэг байхгүй байгаа нь асуудал болж байна.

Хүснэгт 1. Кейс шинжилгээний үр дүн

	Багш	Сурагч	Эцэг эх
Ямар бэрхшээл тулгарч байна	<ul style="list-style-type: none"> Хөгжлийн ялгаатай суралцагчтай ажиллах сэтгэл зүйн бэлтгэлгүй Хүүхэд бүр хөгжлийн түвшний хувьд өөр байдаг тул багшаас ажиллах арга зүй маш их шаарддаг Сэтгэл зүйн эмгэгийн шинж тэмдгийг танин мэдэх хэрэгцээ шаардлага үүсэх Хөгжлийн ялгаатай хүүхдийг оношлох арга зүйгээр дутмаг 	<ul style="list-style-type: none"> Хөгжлийн ялгаатай хүүхдэд суралцахаас айх айдас элбэг илэрсэн Бие даах чадвар сул Шийдвэр гаргах чадвар сул 	<ul style="list-style-type: none"> Хүүхдийнхээ онцлогийг хүлээн зөвшөөрөхгүй байх Хүүхэдтэй ажиллах арга зүй дутмаг Хүүхдийн эзэмшсэн суурь чадвараас дээш түвшний боловсролын бичиг баримт шаардаж сургах хүсэлтэй.

Дүгнэлт

Насан туршийн боловсролын төвөөс боловсролын үйлчилгээнд хамрагдаж буй хөгжлийн ялгаатай суралцагчид болон Дүйцсэн хөтөлбөрийн сургалтад суралцаж байгаа суралцагчдын боловсролын үйл ажиллагааг бодлогоор системтэй, уялдаа холбоотой, салбар дундын хамтын ажиллагааг бэхжүүлж ажиллах, тулгамдсан асуудалд гарц гаргалгааг хамтран зохион байгуулах хэрэгтэй байна. Ингэхдээ тусгай хэрэгцээт боловсролын мэргэжлийн боловсон хүчинтэй хамтран ажиллах, зөвлөн туслах, боловсролын салбарын хамтын ажиллагааг дэмжсэн шинэ тогтолцоог бүрдүүлж ажиллах нь чухал юм. Тухайлбал, МУБИС болон ТХБ салбарын байгууллагатай хамтран:

- Тусгай хэрэгцээт боловсролын сэтгэл зүйчтэй хамтран ажиллаж судалгааны үр дүнд суурилсан сурах арга барилыг мэргэжлийн түвшинд олж авах, түүнд суурилсан суралцах явцад ахиц гарах бодит дэмжлэг авах
- Сэтгэл зүйн тав тухтай суралцах орчныг бий болгох
- Хөгжлийн ялгаатай суралцагчдыг оношилж, тохирсон арга зүйгээр хичээл, сургалтын үйл ажиллагааг зохион байгуулахад туслалцаа үзүүлэх
- Хөгжлийн ялгаатай суралцагчдад тохирсон анги танхим, материаллаг бааз бүрдүүлэх

Уг судалгаагаар илэрсэн асуудлуудыг цаашид хэрэгжүүлэх бодлого, төлөвлөгөөнд тусган ажиллах шаардлагатай байна.

Түлхүүр үг: Албан бус–Насан туршийн боловсролын багш, дүйцсэн хөтөлбөрийн сургалт, хөгжлийн ялгаатай байдал, гэрээр боловсрол нөхөн олгох сургалт.

Ашигласан материал:

1. Хаяаши Кензо, Торигое Такаши, Исава Шинзо, & Ишикура Кенжи (2018). *Тусгай хэрэгцээт боловсрол*. Монгол Улс, Улаанбаатар хот.
2. ХНХЯ (2018). *Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан хууль тогтоомжийн эмхэтгэл*. Монгол Улс, Улаанбаатар хот.
3. Эрдэнэчулуун.Д (2019). *Мэргэжил сонголтын сэтгэл зүйн үндэс*. Монгол Улс, Улаанбаатар хот.
4. Монгол улсын их хурлын 2015 оны 01 сарын 29-ны өдрийн 12 дугаар тогтоол. Төрөөс боловсролын талаар баримтлах бодлого батлах тухай. Монгол Улс, Улаанбаатар хот.
5. <https://kpfu.ru/portal/docs/F1083214858/Specialnaya.psihologiya.pdf>

ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮҮХДИЙН БОЛОВСРОЛД НАСАН ТУРШИЙН БОЛОВСРОЛЫН ТӨВ*, НЭГЖИЙН ОРУУЛЖ БҮЙ ҮҮРЭГ, ОРОЛЦОО

Г.Халиун, Э.Баясгалан¹

¹Боловсролын Судалгааны Үндэсний Хүрээлэн
khaliun@mnier.mn bayasgалан@mnier.mn

Удиртгал

Боловсролын хөгжлийн дэлхий нийтийн чиг хандлага нь ялгаатай хэрэгцээндээ нийцүүлэн боловсролд тэгш хамрагдах, ялангуяа хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд сурч, хөгжихөд таатай, ээлтэй, үнэт зүйлс, соёлыг бий болгосон орчныг бий болгоход зорьж байгаа билээ. Манай улсад тэгш хамруулах боловсролын тогтолцоо хөгжиж байгаа ба үүнд насан туршийн боловсролын тогтолцоо чухал үүрэг гүйцэтгэж байна. Боловсрол нөхөн олгох сургалтад хамруулах замаар хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдэд зохих шатны боловсрол олгож байгаа ба 1997 оноос эхлэн дүйцсэн сургалтын хөтөлбөр нь насан туршийн боловсролын үйлчилгээний нэг үндсэн хэсэг болж, ямар нэгэн шалтгаанаар сургууль завсардсан болон сургуульд огт хамрагдаж байгаагүй хүүхэд, залууст боловсрол эзэмшүүлж эхэлсэн байна. Боловсрол нөхөн олгох хөтөлбөрөөр хичээллэж буй хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн тоо 2022–2023 оны хичээлийн жилд 478 байсан бол энэ хичээлийн жилд 305 байна. Боловсролын ерөнхий хууль батлагдаж насан туршийн боловсролын тогтолцоо улам өргөжиж байгаа энэ үед насан туршийн боловсролын төв, нэгжүүдийн хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд боловсрол олгож буй өнөөгийн нөхцөл байдлыг илрүүлэхийг зорьсон нь судалгааны ажлын ач холбогдол болно.

Судалгааны арга зүй

Чанарын болон тоон судалгааны арга ашиглав. 21 аймаг, 9 дүүргийн насан туршийн боловсролын төвийн 2022 оны үйл ажиллагааны тайланд таван шалгуураар баримт бичгийн шинжилгээ хийсэн. Мөн 30 төвийн багш, удирдах ажилтан, нийгмийн ажилтнаас тэгш хамруулах боловсролын талаарх ойлголт мэдлэг, бодлогын хэрэгжилт, тулгамдаж буй асуудлыг илрүүлэх зорилгоор асуулга авсан.

Үр дүн

Үйл ажиллагааны тайланд хийсэн шинжилгээний үр дүн дараах байдалтай байна.

- a) Нийт 30 төвийн 93% буюу 28 төв нь тухайн хичээлийн жилийн зорилго, зорилтод иргэдийн ялгаатай хэрэгцээнд нийцүүлэн боловсрол эзэмших нөхцөл боломжийг бүрдүүлж, сургалтын үйл ажиллагааны чанар, хүртээмжийг сайжруулах талаар тусгажээ.
- b) Үндсэн чиглэлийн хүрээнд Боловсрол нөхөн олгох хөтөлбөрт хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүд хамрагдаж, хөтөлбөрийн агуулга, арга зүй, хэлбэр, хугацааг суралцагчдын хувийн болон хөгжлийн онцлогт нийцсэн, хувилбартай, уян хатан байхад чиглэн боловсруулж хөгжлийн ахиц, амжилт үр дүнг тооцон ажиллаж байна. Бүх дүүрэг, аймгийн хэмжээнд танхимын сургалтад хамрагдах боломжгүй хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд гэрээр, явуулын багшийн үйлчилгээгээр хүрч ажиллаж байна.
- c) Эцэг эхчүүдэд зориулсан сургалт, нөлөөллийн үйл ажиллагааг 11 төв зохион байгуулсан байна. Эдгээр үйл ажиллагаа нь ихэвчлэн төслийн хүрээнд хүүхдийн хөгжлийг дэмжих, арга зүйн зөвлөгөө, мэдээллийг хүргэсэн шинжтэй байна.
- d) Насан туршийн боловсролын 7 төв багш, ажилчдаа тэгш хамран сургах боловсролтой холбоотой сургалтад хамруулсан нь шинжилгээний хүрээнд илэрсэн. Харин 8 төв нь хэрэгжиж буй төслийн хүрээнд эсвэл ТББ-ын зохион байгуулсан сургалтад суусан байгаа ба энэ нь тогтмол биш нэг удаагийн шинжтэй сургалтууд байна.

* Хуучин нэршлээр: Боловсролын Ерөнхий Хуулийн 17.1-т "...насан туршийн суралцахуйн төв..." гэж заасан бөгөөд энэхүү судалгаа нь 2022–2023 оны хичээлийн жилд хийгдсэн тул Боловсролын Тухай Хуульд заасан хуучин нэршлээр авсан болно.

е) Алслагдсан хөдөө сумдын суралцагчдын эцэг эх, асран хамгаалагчидтай нь холбогдон гэрийн даалгавар өгөх, тараах материал тараах, ном хэрэглэгдэхүүн, сурах бичиг хүргэж өгөх хэлбэрээр хамтран ажиллаж байгаа сайн туршлага байна. Гэсэн хэдий ч ялгаатай хэрэгцээтэй хүүхэдтэй ажиллах мэргэжлийн хүний нөөцийн хомсдол, сургалт явуулах байр, сургалтын хэрэглэгдэхүүний дутмаг байдал тулгамдсан асуудал болж байгаа нь шинжилгээний үр дүнд илэрлээ.

Асуулга судалгаанд хамрагдсан аймаг, дүүргийн 30 насан туршийн боловсролын төвийн хоёрт нь тэгш хамран сургах боловсрол хариуцсан мэргэжилтэн ажилладаг, тавд нь өөр орон тоотой хавсран гүйцэтгэдэг бол хорин гуравт нь хариуцсан мэргэжилтэн байхгүй байна.

Мэргэжлийн хувьд 1 сэтгэл судлаач, 42 багш байгаа ба тусгай хэрэгцээт боловсролын мэргэжилтэй багш байхгүй байна. Оролцогчдын хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг боловсролд тэгш хамруулахад чиглэсэн эрх зүйн баримт бичиг, холбогдох журмын заалт, тэгш хамруулан сургах боловсролын талаарх ойлголт, мэдлэг хангалттай сайн байна. Харин хоёр багш тутмын нэг нь хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн ялгаатай хэрэгцээнд суурилсан сургалтын хөтөлбөр боловсруулах чадвар, сургалтын хэрэглэгдэхүүнд тохируулга хийх ойлголт тааруу гэж харагдаж байна. Дохионы хэл болон брайл үсгийн анхны шатны ойлголттой гэж хамгийн бага хувь буюу 15.0% нь хариулжээ. Нээлттэй асуулгын үр дүнг боловсролын бүтцийн бүрэлдэхүүн хэсгээр авч үзвэл дараах байдалтай байна.

- Сургалтын хөтөлбөрийн тухайд хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн ялгаатай хэрэгцээнд суурилсан сургалтын хөтөлбөр боловсруулах арга зүйн мэдлэг тааруу, ажиллаж байсан туршлага бага гэж нийт багш нарын 72% нь үзжээ.
- Мэргэжлийн хүний нөөц зайлшгүй шаардлагатай байгааг бүгд онцолсон. Нэгж дээр ажиллаж буй багш болон явуулын багш хичээл, сургалтын үйл ажиллагаа явуулахад санхүүгийн нөөц, унаа, бензиний асуудал бэрхшээл үүсгэдэг гэсэн байна. Мөн эцэг эх, асран хамгаалагчийн дэмжлэг, хамтын ажиллагаа сул, ажиллах орчны аюулгүй байдалд сэтгэл хангалуун бус байна.
- Сургалтын орчин, хэрэглэгдэхүүний хувьд дийлэнх насан туршийн боловсролын төвүүдэд хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд шаардлагатай сургалтын үндсэн болон нэмэлт хэрэглэгдэхүүний хангамж, хүртээмж байхгүй, материаллаг орчин бүрдээгүй гэжээ.
- Удирдлагын зүгээс хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй ажиллаж буй багш нарыг боломждоо түшиглэн дэмждэг ба төлөвлөгөө боловсруулах, хэрэгжүүлэх, ар гэрээр явж уулзах, туршлага судлах ажлын цагийн боломж гаргаж өгч ажиллуулж байна. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй ажилласны 10%-ийн нэмэгдэл өгдөг гэж 38% үзсэн бол удирдлагын энэ талын ойлголт, хандлага муу, дэмжлэг сул гэж 62% хариулжээ.
- Санхүүжилтийн хувьд НТБТ-д олгогдож буй санхүүжилтээс хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн сургалтын орчин бүрдүүлэх, багшийн чадавхыг бэхжүүлэх хэрэгцээнд санхүүгийн дэмжлэг үзүүлж чаддаггүй байна.
- Хяналт, үнэлгээний хувьд нийт төвийн 30% нь хяналт, үнэлгээ хийдэггүй, хангалтгүй гэсэн бол 70% нь БШУ-ны сайдтай хийсэн гэрээний биелэлт, аймгийн хөгжлийн төлөвлөгөө, үйл ажиллагааны төлөвлөгөөний заалтуудын биелэлтээр, мөн тухайн багш хэдэн удаа явуулын үйлчилгээгээр очсон, хэдэн удаа сургалт хийсэн, мөн эцэг эхтэй гэрээ байгуулж, тэдний саналыг сонсох, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг хөгжүүлэхэд чиглэсэн нөлөөллийн үйл ажиллагаагаар үнэлдэг гэсэн байна.

Хүснэгт 1. Тэгш хамруулах боловсролын чиглэлийн хууль, эрх зүйн баримт бичгийн хэрэгжилтэд тулгамдаж буй асуудал /давхардсан тоогоор/

	Тоо	Хувь
Тусгай хэрэгцээт боловсролын багш нарын хэрэгцээ	15	38
Сургалтын гадаад болон дотоод орчин, анги танхимын хүрэлцээ	11	28
Ялгаатай хэрэгцээтэй хүүхэдтэй ажиллах арга зүй	8	21
Сургалтын хэрэглэгдэхүүн, ном, гарын авлага	7	18

Дүгнэлт

НТБТ-ийн үйлчилгээнд хамрагдаж байгаа иргэдийн дотор хөгжлийн бэрхшээлтэй сургуулийн насны хүүхэд зонхилох хувийг эзэлж тэдэнд танхим, зайн, гэрээр зэрэг сургалтын олон хэлбэрээр боловсролын үйлчилгээ үзүүлж байна. Ингэхдээ өөрийн орон нутгийн онцлог, нөөц бололцоонд тулгуурлан төрийн болон төрийн бус байгууллага, төсөл хөтөлбөртэй хамтран сургалтаа зохион байгуулж байна.

Баримт бичгийн болон асуулга судалгааны үр дүнд хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй ажиллаж байгаа сайн туршлагауд байгаа ч нээлттэй биш байгаа ба ялгаатай хэрэгцээтэй хүүхэдтэй ажиллах давуу талуудыг сайн ойлгож сургалтын арга зүйгээ өөрчлөх сонирхол байгаагаас харахад тэгш хамруулах боловсролын ач холбогдлыг түгээн дэлгэрүүлж, багшийн тасралтгүй хөгжлийг дэмжих, мэргэжил арга зүйн сургалт явуулах шаардлагатай нь харагдаж байна. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй ажиллахад тулгарч буй асуудлыг нэгтгэн харвал мэргэжлийн хүний нөөц, сургалтын орчин хэрэглэгдэхүүн, санхүү төсөвтэй холбоотой асуудлууд дийлэнх байна.

Цаашид НТБТ-ийн тогтвортой үйл ажиллагааг хангах төвийн бүтэц, орон тоо, нийгмийн асуудал, үйл ажиллагааны зардал бүхий төсөв санхүүг бүрэн шийдсэн эрх зүйн орчныг бүрдүүлэх, иргэдэд үйлчлэх шаардлага хангасан орон байр, танхимын асуудлыг шийдвэрлэх, орон нутгийн иргэдэд үйлчлэх унааг шийдвэрлэх зэрэг байна.

Түлхүүр үг: *Тэгш хамран сургах боловсрол, хөгжлийн бэрхшээл, боловсрол нөхөн олгох хөтөлбөр.*

Ашигласан материал:

1. Батчулуун.Е (2019). *Насан туршийн боловсролын дэд салбарын судалгааны тайлан*. Монгол Улс, Улаанбаатар хот.
2. БМТТ (2023). *2023–2024 оны хичээлийн жилийн статистик мэдээ*. Монгол Улс, Улаанбаатар хот.
3. Насан туршийн боловсролын үндэсний төв (2018). *“Насан туршийн боловсрол”. Бодлогын баримт бичгийн эмхэтгэл*. Монгол Улс, Улаанбаатар хот.
4. НСБТ (2022). *21 аймгийн насан туршийн боловсролын төвийн 2022 оны үйл ажиллагааны бичмэл тайлан*. Монгол Улс, Улаанбаатар хот.
5. НСБТ (2022). *9 дүүргийн насан туршийн боловсролын төвийн 2022 оны үйл ажиллагааны бичмэл тайлан*. Монгол Улс, Улаанбаатар хот.

АУТИЗМТАЙ ХҮҮХДИЙН СУРАЛЦАХУЙГ ДЭМЖИХ ТУРШИЛТ, ҮР ДҮН

Д.Аззаяа¹

¹Увс аймгийн Улсын Тэргүүний Ерөнхий боловсролын
Лаборатори Нэгдүгээр Цогцолбор сургууль
azzayadawaanyam@gmail.com

Үндэслэл

Судалгааны ажлын хүрээнд тухайн хөнгөн хэлбэрийн аутизмтай хүүхдийг бие даан сургах туршилт судалгааны үр дүнд сурлагын ахиц 16% дээшилсэн бөгөөд сурах ерөнхий арга барил 6 оноогоор ахисан үр дүн өгч байна. Хөнгөн аутизмтай хүүхдийг бие даан сургахад сэтгэл зүйн асуудал чухал болохыг энд онцлон тэмдэглэх нь зүйтэй. Учир нь өөрийн дуртай үлгэрийн баатрын дүн үнэлгээ авах, өөртөө дүн тавих, өөрийн хийсэн ажлыг зааврын дагуу ажиллах нь тухайн туршилтын оролцогчдод идэвхжүүлэх сэдэлжилт болж өгсөн.

Зорилго

Хөнгөн хэлбэрийн аутизмтай хүүхдийн бие даан суралцахуйг дэмжих туршилт судалгааны үр дүнг тооцоолох.

Судалгааны арга зүй

Тухайн сурагчийн сурах ерөнхий арга барилыг сайжруулахын тулд бие даан суралцах арга барил эзэмшүүлэх туршилтыг төлөвлөн 2 жил ажилласан байна. Суралцахуйг дэмжих туршилт 4 үе шаттай явагддаг. Үүнд:

- Алхам 1: Суралцах бэлэн байдлыг үнэлэх
- Алхам 2: Суралцахуйн зорилгыг тогтоох
- Алхам 3: Суралцахуйн үйл явцад оролцуулах
- Алхам 4: Суралцахуйг үнэлэх (Pintrich, 2000)

Үр дүн

Тухайн туршилтын үр дүнд сурагчдад дараах өөрчлөлт ажиглагдсан. Үүнд:

Хүснэгт 1. Туршилтын үр дүн

Туршилт тооцох үзүүлэлт	Туршилтын өмнөх тоо баримт (сараар) цаг	2020-2021 он 6-р анги (10 сарын дундаж)	2021-2022 он 7-р анги (10 сарын дундаж)	2022-2023 он 8-р анги 1-р улирал (2 сарын дундаж)
Хичээл таслах	10 цаг	9.6	8.5	7.5
Дэвтэрт хичээл тэмдэглэх тоо (биологийн хичээл 7 хоногт 1 удаа)	2 удаа	25 удаа	28 удаа	3 удаа
Багшаас авсан дэмжлэгийн тоо	2 удаа	28 удаа	23 удаа	2 удаа
Хичээлийн үед бусдаас авсан дэмжлэг тоо	1 удаа	14 удаа	10 удаа	1 удаа
Сурах ерөнхий арга барил оноо	26 оноо	26 оноо	32 оноо	44 оноо
Гэрийн даалгавар хийгээгүй тоо	4 удаа	35 удаа	25 удаа	1 удаа

Тухайн суралцагчийн 2 жилийн турш өөрчлөгдсөн зүйлсийг жагсаав.

Хүснэгт 2. Туршилтын үр дүн

Туршилтын өмнө	Тоо давтамж сард дунджаар	Туршилтын дараа	Тоо давтамж сард дунджаар
Нийгмийн харилцаа сул	Хааяа	Нийгмийн харилцаа сул	Ихэнхдээ
Заримдаа хэтэрхий чанга орилдог	Сард нэг удаа	Заримдаа хэтэрхий чанга орилдог	3 сард нэг удаа
Нүүрний булчин чангарч татдаг	Сард нэг удаа	Нүүрний булчин чангарч татдаг	2 сард нэг удаа
Багшийн тусламж хүсдэггүй	Туршилтын өмнө багштай холбоогүй байсан.	Багшийн тусламж хүсдэггүй	Туршилтын дунд үед сард 12 удаа дээд тал нь тусламж хүсдэг болсон.
Хичээл дээр цаасаар урлал хийдэг	Хичээл бүр дээр	Хичээл дээр цаасаар урлал хийдэг	Цаасаар урлал хийх завгүй өөрийн дуртай карт, зураг эвлүүлэх, өөртөө дүн тавих ажил гүйцэтгэдэг болсон.
Хийсвэр сэтгэхүй давамгай	Цаг, бөгж титэм, гар утас цаасаар хийж тоглодог.	Хийсвэр сэтгэхүй давамгай	Одоо харин өөрийн сонирхолтой дүнгээ авах, өөртөө дүн тавих гэж цаг зарцуулдаг болсон.
Бие даан дасгал ажиллах чадвар сул	Өөрөө бие даан дасгал ажиллах чадваргүй хичээл тэмдэглэх чадвар сул	Бие даан дасгал ажиллах чадвар сул	Өөрөө хичээл тэмдэглэх нь ихэссэн. Сардаа 4 удаагийн хичээл оролтод 3 удаа тэмдэглэх, дасгал бие даан ажиллах тоо 2 удаа нэмэгдсэн.

Дүгнэлт

Хөнгөн хэлбэрийн аутизмтай хүүхдийг ердийн ЕБС-д тэгш хамруулан сургах боломжийг судалж сурах ерөнхий арга барилыг сайжруулахын тулд бие даан суралцах үйл ажиллагааны үе шаттай туршилт хэрэгжүүлэн дараах үр дүнг тооцсон.

- Хөнгөн хэлбэрийн аутизмтай хүүхдийг магтах дуртай зүйлийг үнэлгээнд тооцож оруулснаар хүүхдийн сэдэлжилт нэмэгдэж хичээл хийх, түүнийг гүйцэтгэхийн тулд багш, болон найзаас тусламж авах тоо ихэссэн.
- Тэгш хамруулан сургахад багшийн тусгай хэрэгцээт сурагчидтай харилцах, онол арга зүйн мэдлэг, ихээхэн шаардаж байна.
- Ганцаарчилсан бие даан суралцах туршилтыг явуулахад багшийн ажлын ачаалал их боловч тухайн сурагч өөрөө хичээлээ хийх, бие даан өөрөө бодох, хичээл тэмдэглэх, дэвтэр мартаггүй байх сайн талууд ажиглагдсан.
- Суралцах чадвар удаан, хурдны хувьд ялгаа байгаа боловч бие даан суралцах, сурах ерөнхий арга барил дээшилсэн.
- 6-р ангийн оношлох үнэлгээ 25% байсан бол жил эцсийн үнэлгээ 32%-тай, 7-р ангид оношлох үнэлгээ 38 байсан бол жил эцсийн үнэлгээ 46 болж өссөн үзүүлэлт байгаа бөгөөд үүний бодит үзүүлэлт нь сурах ерөнхий арга барил дагаад 6 оноогоор дээшилж бодит байдал дээр ахиц мэдрэгдсэн.

Түлхүүр үг: Аутизм, бие даан суралцахуй, суралцах чадвар.

Ашигласан материал:

1. Ишикура.К, Исава.Ш, & Батцэнгэл Г. (2010). *Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй ажиллах онол арга зүй*. Монгол Улс, Улаанбаатар хот.
2. Ялахбаатар.Б (2022). *“Хөнгөн хэлбэрийн аутизмтай хүүхдийг боловсролд тэгш хамруулах боломж арга зам” нийгмийн ажлын магистрын бүтээл*. Монгол Улс, Улаанбаатар хот.
3. JICA (2018). *Аутизмын хүрээний бэрхшээлийн тухай ойлголт*. Монгол Улс, Улаанбаатар хот.



II БҮЛЭГ

ДЭД БҮТЭЦ

ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮМҮҮСИЙН СУРЧ БОЛОВСРОХ ХҮРТЭЭМЖ

(Мэдээлэл харилцаа холбоо, технологи–харааны бэрхшээл)

Ц.Нямаа¹, Г.Ууганбаатар²,

¹УБЭИС, Инженерийн сургууль, судлаач, ²УБЭИС, ИС, судлаач

1nyamka07@gmail.com

Үндэслэл

Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст боловсрол, ажил эрхлэлт, олон нийтийн газар, үйлчилгээ, мэдээлэл зэрэг амьдралын янз бүрийн талбарт тэгш боломж, хүртээмжтэй байх боломжийг хангаж, сурах боломжийг нь Мэдээлэл харилцаа холбоо, технологи хэрэглээг цаашид хүртээмжтэй сургалт зохион байгуулах боломжтой байна. Энэхүү судалгаанд Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс сурч боловсроход “Мэдээлэл харилцаа холбооны технологи – МХХТ” ашиглах нь бага байгаагаас сурах боломж тэгш хүртээмжийг судалж, харааны бэрхшээлтэй иргэдэд хүртээмжтэй болгох нь мэдээлэл, технологийн тэгш хүртээмжийг хангахад нэн чухал бөгөөд хүртээмжтэй сургалт туршлагыг бий болгох хэрэгтэй байна.

Зорилго

Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс сурч боловсроход МХХТ ашиглан сурах боломж, тэгш хүртээмжийг судлах зорилготой.

Судалгааны арга зүй

Судалгааг асуулга хэлбэрээр биечлэн болон цахим хэлбэрээр авч, суралцагч, багш, ажилчдын нийслэлийн түүвэр судалгааны үр дүнгээс шалтгааныг тодруулах, агуулгын шинжилгээ хийж, дүгнэлт гаргав.

Үр дүн

Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн сурч боловсрох түүн дотроо дэлгэцийг хэр ашиглаж, мэдээлэл авч байгааг тогтоосон. Хоёрдогч эх сурвалжтай харьцуулах мэдээлэл олдоогүй өмнө судлагдаагүй болно. Харааны бэрхшээлтэй хүмүүс янз бүрийн карьерын боломжийг эрэлхийлэх боломжтой бөгөөд тэднийг ажиллах хүчинд хамруулахад МХХТ чухал ач холбогдолтой байна.

Хөгжлийн бэрхшээлтэй ба тэгш эрх

Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст тэгш хүртээмжтэй (Хүснэгт 1) байх нь хүний үндсэн эрх бөгөөд илүү хүртээмжтэй, олон талт нийгмийг бий болгоход хувь нэмэр оруулдаг. Энэ нь зөвхөн бие махбодын болон дижитал саад бэрхшээлийг арилгахаас гадна хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн өвөрмөц хэрэгцээ, туршлагыг хүндэтгэх, ойлгох соёлыг төлөвшүүлэх явдал юм.

Хүснэгт 1. Хөгжлийн бэрхшээл ба тэгш хүртээмжийн зарим гол асуудал


№	Хөгжлийн бэрхшээл ба тэгш хүртээмжүүд	
1	Хүртээмжтэй байдлын тухай хууль	хууль тогтоомж
2	Бие махбодын хүртээмж	орон зай, дэд бүтцийг хүртээмж
3	Дижитал хүртээмж	дэлгэц уншигч, хэрэгсэл зэрэг туслах технологи
4	Хүртээмжтэй тээвэр	тээврийн үйлчилгээг тэгш хүртэх нь чухал.
5	Боловсрол	ижил боловсрол эзэмшүүлэх
6	Хөдөлмөр эрхлэлт	саадгүй ажиллах орчныг бүрдүүлэх явдал юм.
7	Хүртээмжтэй харилцаа холбоо	харилцааны хүртээмж нь сонсгол, ..
8	Нийгмийн оролцоо	тэгш хүртээмж нь биет болон дижитал хүртээмж

Харааны бэрхшээлтэй хүн бол ердийн нүдний шил, контакт линзээр засаж залруулах боломжгүй харааны ихээхэн алдагдалтай хүнийг хэлнэ. Харааны бэрхшээлийн түвшинг бага,

хууль ёсны, бүрэн сохор гэж ангилж тодорхойлдог. Харааны бэрхшээлтэй хүмүүст суралцах боломж нь боловсрол, мэргэжлийн сургалт, хувь хүний хөгжил зэрэг өргөн хүрээг хамардаг. Харааны бэрхшээлтэй хүмүүст зориулсан **брайл үсгийн заавар, туслах технологи, онлайн курс ба зайны сургалт, хүртээмжтэй сургалтын платформууд, төрийн болон ашгийн бус байгууллагын дэмжлэг** зэрэг сургалтын боломжууд байна. Харааны бэрхшээлтэй хүнд үйлчилгээ авах боломж нь бүс нутгаас хамаарч өөр өөр байж болох тул харааны бэрхшээлтэй хүмүүс орон нутгийнхаа нөөцийг судлах нь чухал юм.

Харааны бэрхшээлтэй хүмүүст компьютер ашиглаж сурахад chatgpt, дэлгэц уншигчид jaws, nvda, voiceover, text-to-speech (tts), томруулах программ хангамж, брайл дэлгэцүүд, хүртээмжтэй үйлдлийн системүүд windows, macos, болон linux зэргийг хэрэглэх боломжууд байдаг. Сүүлийн 2 жил үргэлжилсэн хөл хорио, цахим хичээлтэй холбоотойгоор сургуулийн насны хүүхдүүдийн хараа муудах эрсдэл улам нэмэгдэж байна. Сул хараатай иргэдийн 90% нь хөгжил буурай улс оронд амьдарч байна. Олон улсын хэмжээнд харааны шил шаардлагатай 1.2 тэрбум хүн амьдарч байгаагаас манай улсад харааны асуудалтай 30.000 гаруй иргэд байдаг. Статистик мэдээллээс харвал 2022 оны байдлаар улсын хэмжээнд 34% нь (12.696) харааны хөгжлийн бэрхшээлтэй, иргэн байгаагийн 33% (3.708) нь Улаанбаатар хотод амьдардаг, улсын хэмжээнд өмнөх онтой харьцуулахад 8%-иар өссөн. Түүнчлэн бүс нутгаар авч үзвэл Хангайн бүсэд хамгийн их буюу 22% (25.177) нь харааны бэрхшээлтэй (График 1) иргэн амьдардагас эрэгтэйчүүдийн дунд эл бэрхшээл түгээмэл байна.

График 1. Харааны бэрхшээлтэй хүний тоо хувиар, бүс, аймаг, нийслэлээр



Судалгаанаас авч үзэхэд харааны бэрхшээлтэй 50%-иас дээш хувь тогтоолгосон “МХҮХ” болон “МХҮХ”-ны дэргэдэх “МСҮТ”-ийн багш ажилтан, суралцагчдад болон хараагүй хүмүүсийн хөдөлмөр сургалт үйлдвэрлэлийн төвийн ажилчдад мөн 116-р тусгай сургуулийн багш, сурагчдын 59% нь эрэгтэй, 41% нь эмэгтэй хамрагдсан (Хүснэгт 2).

Хүснэгт 2. Судалгаанд оролцогчид (хувь, хүйс, нас, ажил байдал)

	Эр				Эм				Нийт
	16–20	21–25	26–30	31-ээс дээш	16–20	21–25	26–30	31-ээс дээш	
“МХҮХ” ажилтан	0	0	0	1	0	0	0	9	10.0%
“МХҮХ”-ны дэргэдэх МСҮТ-ийн багш	0	0	0	4	0	0	0	3	7.1%
“МХҮХ”-ны дэргэдэх МСҮТ-ийн суралцагчид	4	6	4	1	0	3	4	3	25.7%
МХХСҮТ-ийн ажилчид	0	4	4	7	0	0	3	1	20.0%
116-р тусгай сургуулийн багш нар	0	0	1	3	0	0	1	1	7.1%
116-р тусгай сургуулийн суралцагчид	17	0	0	0	13	0	0	0	30.0%
	21%	10%	10%	17%	13%	3%	9%	17%	
	59%				41%				100%

Судалгаанд харааны бэрхшээлтэй (55.7% нь суралцагчид, 30% нь ажилчид, 14.3% нь багш нар) иргэд оролцсон. Судалгаанд оролцогчид 100% ухаалаг утас, мөн 50% нь суурин компьютер, 25% нь нөүтбүүк хэрэглэдэг бөгөөд Та компьютер дээр ямар дэлгэц уншигч хэрэглэдэг вэ? гэсэн асуултад 62.5% нь NVDA (None Visual Desktop Access), 37.5% нь NVDA – Чимэгэ сонур

хэрэглэдгээс нийт оролцогчдын 74% нь дунд зэрэг ашигладаг гэж хариулсан байна. Тиймээс судалгаанд оролцогчдын мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх шаардлагатай байгаа нь харагдаж байна.

Та гар утсан дээр ямар дэлгэц уншигч хэрэглэдэг вэ? гэсэн асуултад 50% нь App-voiceover-Чимэгэ сонур хэрэглэдгээс судалгааны явцад ажиглахад гар утсан дээр дэлгэц уншигчийг ашиглах мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх шаардлагатай байна. Хэрэв танд сурахад хүртээмжгүй нөхцөл байдал тулгарвал хэрхэн шийдэх вэ? гэсэн асуултад 50% нь эргэн тойрны хэн нэгэн гэр бүл, найз нөхдөөс тусламж авна, 37% нь хамааралтай төрийн бус байгууллагуудад хандан, цаашид сургалтанд суух шаардлагатай гэж 100% хариулсан байна.

Харааны алдагдлаас хамаарч компьютер дээр дэлгэц уншигч хэрэглэж байгаа нь 0.4 үзүүлэлтээр хамааралтай байгаа нь судалгаанаас харагдаж байна. Тиймээс цаашид харааны бэрхшээлтэй хүмүүс компьютерын дэлгэц уншигчийн сургалт болон бусад сургалт нэн тэргүүнд шаардлагатай байна.

Model Summary

Model	R	R Square	Adjusted R Square	Std. Error of the Estimate	Change Statistics				
					R Square Change	F Change	df1	df2	Sig. F Change
1	.482 ^a	.232	.221	.747	.232	20.578	1	68	.000

a. Predictors: (Constant), компьютер дээр ямар дэлгэц

Дүгнэлт

Технологийн тасралтгүй хувьслыг харгалзан үзэхэд харааны бэрхшээлтэй хүмүүс хүртээмжтэй байдлын онцлогуудын шинэчлэлт, сайжруулалтын талаар мэдээлэлтэй байх нь чухал байна. Харааны бэрхшээлтэй 50%-иас дээш хувь тогтоолгосон “МХҮХ” болон “МХҮХ”-ны дэргэдэх “МСҮТ”-ийн багш ажилтан, суралцагчдад болон хараагүй хүмүүсийн хөдөлмөр сургалт үйлдвэрлэлийн төвийн ажилчдад мөн 116-р тусгай сургуулийн багш, сурагчдын 59% нь эрэгтэй, 41% нь эмэгтэй хүмүүс хамрагдсан. Судалгааны үр дүнд харааны алдагдлаас хамаарч компьютер дээр дэлгэц уншигч хэрэглэж байгаа нь 0.4 үзүүлэлтээр хамааралтай байгаа нь харааны бэрхшээлтэй хүмүүс компьютерын дэлгэц уншигчийн сургалт болон бусад сургалт нэн тэргүүнд шаардлагатай байна.

Түлхүүр үг: Харааны бэрхшээл, Мэдээлэл харилцаа холбооны технологи, сургалт.

Ашигласан материал:

1. Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газар – <http://www.gadpwd.gov.mn/>
2. Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хууль – <https://legalinfo.mn/mn/detail/11711>
3. Тэргэнцэртэй иргэдийн үндэсний холбоо (2016). “Хөгжлийн бэрхшээл ба олон нийт” хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэйчүүдэд зориулсан эрүүл мэндийн гарын авлага. Монгол Улс, Улаанбаатар хот.
4. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хууль, эрх зүйн орчин, стандартын хэрэгжилтийн өнөөгийн байдал – <https://www.unescap.org/sites/default/files/>
5. Монголын Хараагүйчүүдийн үндэсний холбоо – <http://mnfb.mn>

ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ИРГЭДИЙН АРХИТЕКТУР ОРОН ЗАЙН ХҮРТЭЭМЖИЙН АШИГЛАЛТЫН ШИНЭЛЭГ СИСТЕМ

Н.Нарантуяа¹

¹Архитектор, Хот төлөвлөлтийн судлаач, ШУТИС, БАС,
Архитектурын салбарын ахлах багш

Үндэслэл

Улаанбаатар хот төлөвлөлтийн архитектур орон зайн шийдэлд 60 оны үеийн баригдсан сууцны барилга, олон нийтийн барилга нэлээдгүй барилга нийгмийн хөгжлийн явцад чухал үүрэг гүйцэтгэсэн байдаг. Тухайн эртний болон дунд үеийн баригдсан барилгуудын архитектур төлөвлөлтөд хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн зориулалтаар ашиглах тусгай элементийн дутагдлаас шалтгаалан хөгжлийн бэрхшээлтэй иргэд бүрэн ашиглах эрх зүйн орчин зөрчигдөж байдаг.

Судалгааны зорилго

Бүрэн ашиглалтад орсон, олон жил ашиглалт үргэлжилсэн барилгад орчин үед хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хүртээмжтэй орон зайн шийдлийг бий болгох, зориулалтын элементийг нэмж төлөвлөх, шинэчлэх сэргээн засварлах боломжийг бодит дүн шинжилгээнд үндэслэлтэй судалж дэвшүүлэх юм.

Судалгааны арга зүй

- Мэдээлэл цуглуулах, цуглуулсан материалын боловсруулалтын явцад хотын орон зайн архитектур төлөвлөлт шийдэл, нутаг дэвсгэрийн бодит судалгааны аргачлал ашиглан бодит байдлыг судлах, ажиглах, компьютерын аргуудыг ашигласан мэдээллийг нэгтгэх, анализ дүн шинжилгээ хийх
- Олон улсын хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн ашиглалтын орон зайн архитектур төлөвлөлтийг судалсан материалд дүгнэлт хийх, гадаадын өндөр хөгжилтэй орны жишээ, туршлагаас шинжилгээ хийх
- Судалгааны арга зүй, схем зураглал хийх, зураглалын явцыг (Photoshop, CorelDRAW гэх мэт) компьютерын программ ашиглан, төлөвлөлтийн өөрчлөлт, ашиглах тусгай элементийн үндсэн зарчмыг судалгааны явцтай уялдуулах илэрхийлэх
- Шинэлэг системийн элементийн үндсэн зарчмыг судалгааны ШУТИС-ийн БАС-ийн Архитектурын салбарт хэлэлцүүлэх гэх мэт аргачлалыг ашиглав.

Үр дүн

Өнөөдөр Улаанбаатар хотын хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн ашиглах хүртээмжтэй орон зайн архитектур төлөвлөлт, мөн ашиглалтын тулгамдсан асуудлыг сайжруулахад зориулагдсан хууль тогтоомж хангалттай баталж гаргасан байна. Үүнд:

1. Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хууль, 2016 он
2. Хөдөлмөрийн тухай хууль, 1999 он
3. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хууль, 2011 он
4. Нийгмийн халамжийн тухай хууль, 2012 он
5. Боловсролын багц хууль, 2002 он
6. Барилгын тухай хууль, 2016 он
7. Эрүүл мэндийн тухай хууль, 2011 он гэх мэт мөн барилга байгууламжтай холбоотой норм дүрэм, гарын авлага боловсруулсан байдаг.
 1. БД 31–101–04 Тахир дутуу иргэдэд зориулсан барилгын төлөвлөлтийн гарын авлага,
 2. БД 31–112–11 Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн амьдрах орчны шаардлагад нийцсэн зураг төсөл зохиох гэх мэт.

Хууль тогтоомж олноор гарч хэрэгжин мөрдөж байгаа ч Улаанбаатар хотын дотор орон зайн архитектур шийдэлд дээрх хууль тогтоомжид нийцэхгүй ашиглалтын дэд бүтэц, хүртээмжгүй орон зайн шийдэл, объект байсаар байна.

Тулгамдаж буй асуудал

- Олон сэдэвтэй холбоотой хууль тогтоомж батлагдаж гарсан ч нийтийн хэрэгцээний ашиглалтыг орчин бүрдүүлээгүй
- Хотын орчны хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан элементийн дутуу төлөвлөлтөөс болж олон хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрх зөрчигдөх (сурах, хөдөлмөрлөх, зугаалах, чөлөөт цагаа өнгөрөөх)
- Удирдлага, судлаач эрдэмтдийн оролцоо, анхаарал сул судалгаа, оновчтой гаргалгаа шийдвэр цөөн байх
- Хотын барилгажилтын хөгжилд орхигдсон байх
- Нэгэнт баригдсан байгууламж гэдэг ойлголтоор дотор ашиглалт энгийн хүмүүст зориулсан хэвээр үлдэх олон нийтийн байгууламжууд олноор орших байх
- Барилга байгууламжид төлөвлөсөн хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн ашиглах элемент норм дүрмийн дагуу биш, хэмжээ стандартын зөрчилтэй зэрэг нэн тэргүүнд шийдэх асуудлууд байна.

Философийн ухааны доктор профессор Т.М.Дридзены бүтээлд тулгуурлан судалгааг баталж тодорхойлоход: Хотын орчны бүтцийг байгалийн, материаллаг, соёлын, нийгэм– хүн судлалын гэж дөрвөн загварыг дэвшүүлсэн нь энэхүү судалгааны өнөөгийн нийгмийн ашиглалтын орон зайн, архитектур шийдэлд хотын хүн амын бүхий хүртээмж оновчтой байх ёстойг баталсан. Налуу зам төлөвлөхөд архитектур төлөвлөлтийн зарчмын алдаа зөрчил үүсэх цөөн тохиолдол байдаг. Энэ нь анх архитектур төлөвлөлтөд тусгаагүй, нэмж төлөвлөсөн байдаг мөн стандартын алдаа, барилгын гадна нүүр талын харагдах байдал, уран сайхны шийдэл алдагдах зэрэг зөрчилтэй шийдэл олон нийтэд илэрхий байдаг.

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн зайлшгүй шаардлагатай архитектур орон зайн шийдэл ашиглалтын дутмаг элемент бүхий объектууд:

- Хуучны барилгажилтын шийдэл
 - 40;50 мянгатын орон сууц
 - Угсармал орон сууцууд (5;9;12 давхар)
 - Боловсролын барилга байгууламжууд
- Явган хүний орон зайн ашиглалт
 - Явган хүний замын эвдрэл
 - Стандарт хэмжээ
 - Оновчтой төлөвлөлт
- Орчин үеийн захиргаа удирдлагын байгууламж
 - Иргэдийн нэг цэгийн үйлчилгээний

байгууламж гэх мэт онцлог барилга байгууламжуудыг хөгжлийн бэрхшээлтэй иргэд онцгой ашиглаж байдаг тул онцлон төлөөлөл болгон сонгож судалсан болно.

Тухайн барилгуудын архитектур төлөвлөлтийн шийдлүүдээс эртний хуучин бүрэн ашиглагдаж буй барилга байгууламжуудын хүрээнд нөхцөлийг сайжруулах, хэрэгжүүлж болох бодит нэмэлт шинэчлэлтийн дэвшүүлж байна. Хүн амын онцлог шаардлагатай объектыг сонгож тодорхойлсон. Үүнд:


- Угсармал орон сууц
- Их сургуулиудын барилга
- Захиргаа удирдлагын барилга

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн ашиглах элемент орц гарц, урсдаг шат, цахилгаан шат нэмж төлөвлөхөд үндсэн орон зайн гурван чиглэлийн судалгааг хийх шаардлагатай (Зураг 1.).

1. Барилга байгууламжийн орц гарц, цахилгаан шат нэмж төлөвлөх боломжтой ДОТОР ОРОН ЗАЙН ШИЙДЛИЙН судалгаа
2. Барилгын орц гарц, цахилгаан шат нэмж төлөвлөх боломжтой ГАДНА ОРЧНЫ төлөвлөлтийн шийдэл, барилгын нүүр талуудын архитектур төлөвлөлтийн шийдлийн судалгаа
3. Тусгай элементийг суурилуулах барилгын байгууламжийн сэргээн засварлах шинэчилсэн системийн хэрэгжилтийн (Схем 1)¹ судалгаа гэх мэт хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн ашиглалтын орон зайн хүртээмжийг ашигтай болгох зориулалтын шийдэл, стандартын дагуу тааламжит орчин нөхцөлийг нэмж бүрдүүлэх, нүүр талын архитектур, уран сайхны шийдлийг алдагдуулахгүй, уялдуулж төлөвлөх олон улсын жишээнд тулгуурлан дэвшүүлсэн (Зураг 2). Дээрх үндсэн гурван судалгаанд тулгуурлан шинэ системийн шийдлийг хотын бодит орчинд төлөвлөх нөхцөл байдал Улаанбаатар хотын олон газар байна. Эртний орон сууцны шийдэл, Боловсролын байгууламжууд (Их дээд сургуулийн барилга) барилга байгууламжууд руу шилжих элементийн шийдлийн зөрчил хотын орон зайн төлөвлөлтөд бодитоор оршин байна.



Зураг 1. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн ашиглалтын орон зайн архитектур төлөвлөлтийн шинэчлэлтийн системийн гурван үндсэн судалгаа



Зураг 2. Сэргээн засварлах, нэмж төлөвлөх элементийн шийдлийг судалгаанд үндэслэнэ.

Хүртээмжтэй орчныг сайжруулахын тулд бодит оршин байгаа ашиглалтын орон зайн зөрчлийг тодорхойлох нь нэн чухал гэж үзсэн.

¹ Тайлбар: шинэчилсэн системийн хэрэгжилтийн судалгаа тусгай онцлон авч судлах сэдэв юм. Үүнд хэрэгжүүлэх загвар, хэрэгжүүлэх төлөвлөгөө гэх зэргийг агуулсан судалгаа байна.

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хүртээмжтэй орон зайн шийдлийн ЗӨРЧИЛТЭЙ ШИЙДЭЛ болон ашиглалтын нөхцөлийг тодорхойлоход:

1. Эртний баригдсан одоог хүртэл бүрэн ашиглагдаж байгаа барилга байгууламжуудын ашиглалт
2. Орчин үеийн архитектур төлөвлөлтөд хангалтгүй хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн ашиглалтын элементийн дутагдал
3. Хотын орон зайн явган хүний зам талбай, задгай орон зайн шийдлийн ашиглалтын элементийн дутагдал
4. Орчин үеийн нийтийн тээврийн хөгжлийн бэрхшээлтэй иргэн хүнд зориулсан тоног төхөөрөмжийн дутагдал
5. Олон жил иж бүрэн ашиглалттай байгаа барилгын олон нийтийн хүртээмжийн элемент, шаардлагат хүртээмжтэй нөхцөл бүрдээгүй байх
6. Хот сууринд хүн амын орон сууцны нөхцөлийг гол хангаж буй хорооллын шийдлүүдийн архитектурын төлөвлөлтийн зөрчил
7. Мэргэжилтэн судлаач нарын хийсэн судалгаа, үндэслэл, хэрэгжилт, дэвшүүлэх гаргалгаа шийдэл цөөн, бага хийгдэж хэрэгжилтийн дутагдал
8. Явган хүний зам болон авто зам руу шилжих архитектур төлөвлөлтийн зөрчил дутагдал
9. Орчин үеийн барилгын хүлээлгэж өгөх үйл ажиллагаанд хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хүртээмжтэй орон зайн төлөвлөлт орхигдох гэх мэт Улаанбаатар хотын архитектур орон зайн шийдэл, ашиглалтын орчинд олон дутагдал, зөрчил оршиж байна.

Гадаадын орны практик туршлага

Гадаадын өндөр хөгжилтэй орны туршлага хотуудын түүхэн дурсгалт бүсийн сэргээн засварлалтын явцад тухайн хотод амьдарч буй хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст зориулсан нийгмийн дэд бүтцийн барилга байгууламж, элементийн ашиглалт, хүртээмжийг сайжруулах бодлого нийт хотын нутаг дэвсгэрт хэрэгжүүлдэг. Жишээлбэл: Архитектурын дурсгалт барилга, шашны барилгууд, 60–70 оны үеийн орон сууцны барилгажилтын төлөвлөлт рүү чиглэх болсон байна. Орон сууцны барилга байгууламжийн одоогийн ашиглагдаж байгаа хэсэгт хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст хүртээмжтэй орчныг бүрдүүлэхэд дараах зүйлийг анхаарах ёстойг тодорхойлсон.

- Тээврийн хүртээмжийг сайжруулах, түүнийгээ байгалийн тааламжит орчныг хослуулах ашиглах хүртээмжийг
- Нийгмийн нэн шаардлагатай объектуудын гадаад орчин болон дотоод орчны хүртээмжийг
- 60–70 оны эртний 5 давхар орон сууцны барилгын сэргээн засварлалыг илүү хүртээмжтэй болгож нэмэлт элементийг төлөвлөж хүртээмжийг сайжруулах
- Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан амралт сувиллын ашиглалтын хүртээмжит орчныг сайжруулж, тусгайлан тоногдосон харилцаа холбоо, зогсоолын(гаражийн) орчны хүртээмжийг гэх мэт асуудлуудыг нэн тэргүүнд хотын орчин болон объектын дотор орчныг төлөвлөх зэрэг асуудлууд байна гэж үзсэн.

Дүгнэлт

1. Орон сууцны, болон олон нийтийн барилга, архитектурын дурсгал барилга байгууламжуудыг сэргээн засварлалтын ажил хот, суурин бүрд хийгддэг. Энэхүү сэргээн засварлах ажил өнгө будаг болон барилгын гадна нүүр талын шийдэл засагдаад сэргээн засварын ажил бүрэн хийгдлээ гэж үзэх асуудал байдаг. Жишээ нь Хотын төвийн Энхтайван өргөн чөлөөний хоёр талын эртний 4;5 давхар орон сууцны нүүр талын тагтнуудыг хөндлөн чиглэлтэй сараалжин хэлбэрээр өнгөлөн дарах сэргээн засвар хийсэн нь одоог хүртэл байдаг. Энэхүү сэргээн засварлалтын ажлыг нийгэмд ашиглалт сайтай олон нийтэд хүртээмжтэй, судалгаанд суурилсан албан ёсны хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн ашиглалтыг орхихгүй, хэрэгтэй элементийн нэмэлт төлөвлөдөг шинэчилсэн системийг бий болгох нь нийгмийн хэрэгцээ шаардлага сайжирсан шийдэл болно гэж үзэж байна.

2. Орон сууцны дунд давхрын барилга (4–5 давхар эртний сууц) болон олон нийтийн барилга, нийгмийн нэн шаардлагатай хэрэгцээт барилга байгууламжуудад хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст зориулсан тусгай тоног төхөөрөмжийг нэмж төлөвлөх (Лифт, налуу зам, урсдаг зам)
3. Хот суурины нийгмийн ашиглалтын орон зайн шийдэл засварлалт болон шинэчлэлтийн ажилд хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн ашиглалтын тусгай элементийг цогц шийдлээр тусгаж хослуулан шийдэж байх нь бүх нийтийн ашигтай орон зайн архитектур төлөвлөлтийн оновчтой шинэчлэлтийн системийн эхэн үе гэж үзэж байна.
4. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн ашиглалтын орон зайн архитектур төлөвлөлтийн шинэчилсэн системийн загвар судалгааг мэргэжилтэн нарт санал болгож тухайн сэдвийг үргэлжлүүлэн боловсронгуй болох талын “шинэчилсэн системийн хэрэгжилтийн судалгаа” судалгааг хийнэ гэж үзэж байна.

Түлхүүр үг: Хот төлөвлөлт, хот байгуулалт, барилга, орчин үе, хөгжил, сэргээн засварлах.

Ашигласан материал:

1. Dridze.T.M (2004). *“Хот төлөвлөлт: нийгмийн оношилгооноос эхлээд зөрчилдөөний нөхцөл байдлаас урьдчилан сэргийлэх, сонирхогч талуудын хоорондын бүтээл”* (ху. 492 (29)). Обнинск: Хотын удирдлагын хүрээлэн.
2. (2011). *“Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай НҮБ-ын конвенцын хэрэгжилтийн талаарх монгол улсын анхдугаар илтгэл”* (ху. 88). Монгол Улс, Улаанбаатар хот.
3. Маргарет Чен, & Роберт. Б. Зеллик (2011). “Всемирный доклад об инвалидности” Отделе прессы ВОЗ, *Всемирная организация здравоохранения*, 27 (2–28).
4. Тунгалагтамир.С (2017). *“Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн асуудал: Бодлого, үйл ажиллагаа. Мэдээллийн лавлах”* (ху. 103). Монгол Улс, Улаанбаатар хот.
5. Амаржаргал.П & бусад (2018). *“Судалгааны тайлан”* (ху. 46). Монгол Улс, Улаанбаатар хот.
6. Статистик <http://www.ubstat.mnStatTable=20>
7. <https://www.google.com/earth/> (22.08.2016)
8. БНБД (2003). *“Хот, тосгоны төлөвлөлт барилгажилтын норм ба дүрэм”* (ху. 85). Монгол Улс, Улаанбаатар хот.
9. БД (2011). *“Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн амьдрах орчны шаардлагад нийцсэн зураг төсөл зохиох дүрэм”* (ху. 32). Монгол Улс, Улаанбаатар хот.

ТЭРГЭНЦЭРТЭЙ ИРГЭНИЙ СУРАЛЦАХ ОРЧНЫ ҮНЭЛГЭЭНИЙ АСУУДАЛ (ШМТДС-ийн жишээн дээр)

Б.Эрдэнэзул¹

¹Шинэ Монгол Технологийн Дээд Сургууль

erdenezul@nmit.edu.mn

Үндэслэл

Манай орны хувьд хөгжлийн бэрхшээлтэй иргэд нийт хүн амын 3%-ийг эзэлдэг бөгөөд хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс хүн амын бусад бүлгийнхээс ядуу байх магадлал өндөр байдаг байна (Шелциг, 2020). Тухайлбал, 2016 оны судалгаанаас харахад ядуурлын хувь нь хөгжлийн бэрхшээлтэй 1 эсвэл түүнээс олон гишүүнтэй өрхүүдийн хувьд хөгжлийн бэрхшээлтэй гэр бүлийн гишүүнгүй өрхүүдтэй харьцуулахад хоёр дахин өндөр байгааг судалгаагаар тогтоожээ. Аливаа хүний сургуульд сурсан жил 1 жилээр нэмэгдэхэд тухайн хүний орлого 10%-иар нэмэгдэж ажлын сэтгэл ханамж ч мөн нэмэгдэх хандлагатайг (О.Жаргалсайхан, 2021) судалгаагаар тогтоосон ба хэрвээ хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн орлогын түвшинг сайжруулах зорилттой бол тэдний боловсролын түвшин буюу их дээд сургуульд сургах нь илүү үр дүнтэй гэж үзсэний учир энэхүү судалгааг хийлээ.

Зорилго

Ковид–19 цар тахлын нөхцөл байдалд Монгол Улсын Засгийн Газраас авч хэрэгжүүлж буй үйл ажиллагаа, хүүхдүүдийн сурч боловсрох эрхэд тулгамдаж буй асуудлыг тодорхойлох зорилгоор энэхүү судалгааг хийв.


Судалгааны арга зүй

Объект дээрх хэмжилтийн судалгаа. 2022 онд шинээр батлагдсан “Барилга байгууламжид хөгжлийн бэрхшээлтэй иргэний хүртээмжийг төлөвлөх” БНБД 35–01–22-г үндэслэн ШМТДС-н гадаад, дотоод орчинд хэмжилт хийж ХБИ-дэд хүртээмжгүй цэгүүдийг тодорхойлж хэмжилтийн үр дүнг Excel программ дээр боловсруулав.

Хэмжилтийг хийхдээ:

- 10 м-н метр
- 0.6 м-н тэгш ус

Схем 1. Хэмжилт хийсэн маршрутын дараалал, байршил



Үр дүн

Объект дээрх хэмжилтийн үед норм дүрмийн шаардлага хангасан бол 1, норм дүрмийн шаардлагыг хангаагүй бол 0 гэж тэмдэглэв. Мөн хэмжилтэд биеийн тамирын заал, хоолны газар луу явах чиглэлийг оруулаагүй болно.

Дээрх хэмжилтийн үр дүнгээс харахад нийт үзүүлэлтүүдийн 57% нь норм дүрмийн шаардлага хангаж байна. Хэмжилтийн үр дүнд тулгуурлан дараах байдлаар орчны төлөвлөлтийг сайжруулахад тэргэнцэртэй оюутан суралцах боломж сайжрахаар харагдаж байна.

Дүгнэлт


ШМТДС-ийн барилгын орчинд БНБД 35-01-22-т үндэслэсэн асуумж зохион хэмжилт хийхэд нийт хэмжилтийн 57% нь норм дүрмийн шаардлага хангаж байгаа бөгөөд хэд хэдэн төлөвлөлтийг сайжруулснаар 99% хүртээмжтэй орчин болох боломжтойг харуулж байна. ШМТДС-ийн авто зогсоол, орц гарцын хэсэг, ариун цэврийн өрөө болон 9-10 давхар, 1-Б1 давхар луу зорчих хэсэгт төлөвлөлтийг сайжруулах шаардлагатай нь харагдаж байна. Гэхдээ байнгын ажиллагаатай лифт, коридор анги танхимын түвшний зөрүү байхгүй, амрах орон зай хангалттай байгаа нь сайшаалтай. Хэмжилт болон харьцуулсан судалгааг үндэслэн гол орчны баруун талд зориулалтын авто зогсоол төлөвлөх, гол хаалгыг автомат хаалгаар солих, ариун цэврийн өрөөнд зориулалтын тоног төхөөрөмжүүдийг байрлуулах, налуугүй шаттай хэсэгт тэргэнцэртэй иргэдийг зөөх зориулалтын тавцант шатыг байрлуулах гэх мэт өөрчлөлтүүдийг хийснээр ШМТДС-ийн орчин тэргэнцэртэй оюутнуудад ээлтэй суралцах орчныг бүрдүүлж чадна гэж үзэж байна.

Түлхүүр үг: Түгээмэл загвар, суралцах эрх.

Ашигласан материал:

1. <https://dac.tsukuba.ac.jp/shien/en/barrier-free/promotion-of-a-barrier-free-campus/>
2. Mariana Mohamed Osman, F. H. (2015). *Procedia – Social and Behavioral Sciences*, 134–144.
3. <https://www.yok.gov.tr/en/Sayfalar/news/2021/barrier-free-university-awards-ceremony.aspx>
4. Энхжин.Г (2020). Хөгжлийн бэрхшээлтэй сурагчдын их дээд сургуульд суралцах сонирхол, нөлөөлөх зарим хүчин зүйлсийн судалгаа. ХБХХЕГ (зэрэг), “Хөгжлийн бэрхшээл судлал ба инновац-2020 эрдэм шинжилгээний онол, практикийн хурлын эмхэтгэл” (ху.73–80). Монгол Улс, Улаанбаатар хот.
5. Ариунгэрэл.Д (2020). Монгол улсын хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн ажил эрхлэлт ба Норвеги улстай харьцуулсан судалгаа. ХБХХЕГ (зэрэг), “Хөгжлийн бэрхшээл судлал ба инновац-2020 эрдэм шинжилгээний онол, практикийн хурлын эмхэтгэл” (ху.334). Монгол Улс, Улаанбаатар хот.
6. Карин Шелциг, К. Н. (2020). *Монгол улсад тэгш хамруулах боловсролыг дэмжих нь*. Филиппин: Азийн хөгжлийн банк.
7. (2019). *Монгол улсад хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн нийгмийн оролцоог хангах нь*. Манила, Филиппин: Азийн Хөгжлийн Банк.
8. Жаргалсайхан.О (2021). Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн ажлын сэтгэл ханамжийг судалсан нь. ХБХХЕГ (зэрэг), “Хөгжлийн бэрхшээл ба хөдөлмөр эрхлэлт-2021 эрдэм шинжилгээний онол, практикийн хурлын эмхэтгэл” (ху.65–66). Монгол Улс, Улаанбаатар хот.

Диаграм 1. Хэмжилтийн үр дүн



ТУСГАЙ ХЭРЭГЦЭЭТ СУРАЛЦАГЧ ОЮУТНУУДЫН ОНЦЛОГТ ТОХИРОХ СУРГАЛТЫН ОРЧИН БҮРДҮҮЛЭХ НЬ (ШУТИС-ийн жишээн дээр)

С.Ариунцэцэг¹, Д.Наранцацрал²

¹ШУТИС, Бизнесийн Удирдлага Хүмүүнлэгийн сургуулийн
Нийгмийн ухааны салбарын ахлах багш, докторант,

²ШУТИС, Бизнесийн Удирдлага Хүмүүнлэгийн сургуулийн
Хүмүүнлэгийн ухааны салбарын ахлах багш, доктор, дэд профессор
Narantsatsral5@must.edu.mn

Үндэслэл

Дэлхий нийтийн боловсролын чиг хандлага нь хөгжлийн бэрхшээл, ядуурал, хүйсийн ялгаа, яс үндэс, шашин шүтлэг зэргээс шалтгаалан нийгмийн үйлчилгээний гадна үлдэж болзошгүй суралцагч хүүхэд, оюутан залуучуудыг бусдын адил чанартай боловсрол эзэмших эрхийг хамгаалсан тэгш хамруулан сургах тогтолцоонд чиглэж байна. ББМТ-ны ISO 21001:2018 стандартыг ШУТИС-д хэрэгжүүлэхэд нэг хэсэг болсон тусгай хэрэгцээт боловсролын шаардлагыг тус сургуульд хангахад зориулж. хөгжлийн бэрхшээлтэй суралцагчийг хэрхэн дэмжих талаар судалгаа хийж, хэрхэн хэрэгжүүлж болох саналыг дэвшүүлэх үүднээс ШУТИС-д тусгай хэрэгцээт суралцагч оюутнуудын онцлогт тохирох сургалтын орчин бүрдүүлэх талаар судлах шаардлагатай болсон.

Зорилго

НҮБ-ын тогтвортой хөгжлийн зорилт 2030-д: “... чанартай техникийн болон мэргэжлийн боловсрол, дээд боловсролд хамрагдах тэгш боломжоор хангагдсан байх ...” гэж дээд боловсролын талаар зорилт дэвшүүлсэн. Мөн Монгол Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолоор батлагдсан “Алсын хараа – 2050” Монгол Улсын Урт Хугацааны хөгжлийн бодлогын баримт бичгийн Боловсрол хэсгийн 2.1-д “Хүн бүрд чанартай боловсрол эзэмших тэгш боломж бүрдүүлж, боловсролыг хувь хүний хөгжил, гэр бүлийн амьдралын баталгаа, улс орны хөгжлийн суурь болгон насан туршдаа суралцахуйн тогтолцоог бэхжүүлнэ” гэсэн зорилтыг тодорхойлсон байна. Иймд бид уг зорилтыг хангах үүднээс чанартай боловсрол эзэмших эрх тэгш боломж бүрдүүлэх боломжийг ШУТИС-ийн хэмжээнд тодорхойлон гаргах зорилготой болно.

Судалгааны арга зүй

Баримт бичгийн шинжилгээний арга

Баримт бичгийг цуглуулах арга нь баримт бичгийг судлах замаар тусгай хэрэгцээт боловсрол, хөгжлийн бэрхшээлтэй суралцагчдын талаар баримтыг цуглуулж, тодорхойлж, ангилсан.

Ярилцлагын арга

ШУТИС-ийн бүрэлдэхүүн сургуулиудын чанарын менежерүүд, эмч, Бизнесийн удирдлага Хүмүүнлэгийн Сургуулийн нийгмийн ажил, сэтгэл судлал, соёл судлалын багш нартай ярилцлагын аргыг ашигласан.

Ажиглалтын арга

Ярилцлагын агуулгыг нарийвчлан шинжлэхийн тулд объектив бодит байдал дээр хэрхэн, ямар арга хэмжээ авч буй талаар ярилцаад зогсохгүй ажиглалтын аргыг ашигласан.

Харьцуулан шинжлэх арга

Олон улсад ямар арга хэмжээ авч, хэрхэн шийдвэрлэж байгааг харьцуулан шинжилсэн.

Үр дүн

Тусгай хэрэгцээт боловсролын үйлчилгээг төлөвлөхдөө тун хариуцлагатай, уян хатан байдлаар хандах ёстой. Тусгай хэрэгцээт суралцагч нь бүх төрлийн үйлчилгээг байршил, давтамж, хүний нөөц, үргэлжлэх хугацаа зэргээс үл хамаарч саадгүй хүлээн авч байх нь чухал ач холбогдолтой юм.

- Бусад суралцагчдын адил өөрийн зохих мэдлэгийг бүтээхийн тулд суралцах явцыг өөрт нь ойлгомжтой байдлаар тохируулга хийн дэс дарааг тодорхой болгож, хуваарийн дагуу мөрдүүлэх журамтай байх
- Хичээлээс гадуурх үйл ажиллагаагаар хөгжих боломжийг бүрдүүлж өгөх
- Өөртөө үйлчлэх энгийн аргад суралцахад дэмжлэг үзүүлэх
- Зааж байгаа хичээлтэйгээ холбож ялгаатай байдлын даалгавар хийж өгөх
- Суралцагч оюутны чадах зүйлд тулгуурлан хөгжүүлэх
- Итгэл өгч урамшуулах
- Завсарлагаагаар эсвэл хичээлийн дараа ярих цаг гаргаж, орчныг нь бүрдүүлж өгөх
- Багш хамтран түүнтэй өөрийгөө танилцуулах болон үзэл бодол, санаагаа илэрхийлэх цаг гарган ярилцахад нь дэмжих
- Харааны бэрхшээлтэй суралцагчдад зориулсан сурах бичгийг брайл хэлбэрт шилжүүлэн хэвлэх, зарим сурах бичгийг Дейзи буюу сонсох хэлбэрт шилжүүлэх, харааны болон сонсголын бэрхшээлтэй сурагчдад нэн тэргүүн шаардлагатай техник хэрэгсэл, төхөөрөмжөөр хангах үйл ажиллагааг эхлүүлэн дэмжих
- Дохионы хэлний багш нар шинжлэх ухааны хэллэгийг хэрхэн яаж дохих вэ гэдгийг хамтран боловсруулах хэрэглэх
- Засгийн газрын 2020 оны “Журамд нэмэлт өөрчлөлт оруулах тухай” 208 дугаар тогтоолоор ердийн цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуульд хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй ажиллаж буй багшид үндсэн цалингийн 10 хувийн нэмэгдэл хөлс олгохоор шийдвэрлэсэн үүний адил их, дээд сургуулийн багш нарт дэмжлэг урамшуулал өгөх
- Хөгжлийн бэрхшээлийн талаар нийт ажилтнууд нь сургалтад хамрагдсан байх, сургалтыг боловсруулах, явуулахдаа үйлчилгээг хүртэгчдийг хамруулж сургалтыг зохион байгуулах
- Хөгжлийн бэрхшээлтэй суралцагчийн эрхийг нь, мөн гомдол гаргах механизмыг мэдээлэх урсгалыг нэмэгдүүлэх, эргэх холбоотой байх
- Хөгжлийн бэрхшээлтэй оюутан, ажилтныг элсэн орох, оролцоход тулгарах саад бэрхшээлийг арилгахад нь илүүтэй анхаарах
- Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд, оюутан залууст боловсрол эзэмших сурах олон төрлийн аргачлалыг хүлээн зөвшөөрөх
- Их, дээд сургуулийн багш нар, тусгай хэрэгцээт боловсролын багш нар, дохионы хэлмэрч-орчуулагч, сэтгэл зүйч, IT-ийн инженерүүдийн хамтарсан багаар цахим контент, цахим болон теле хичээлүүдийг хөгжүүлэх
- Сургалтад ашиглагдаж буй ном, сурах бичгийг хөгжлийн бэрхшээлтэй суралцагчдын онцлог хэрэгцээнд нийцүүлэн хүртээмжтэй хэлбэрээр түгээх (аудио, видео, DVD, брайл, дохионы хэлээр бэлтгэсэн контент, хичээлүүд, дүрс зурган өгүүлэмжтэй цахим сургалтын талбарыг уламжлалт сургалттай хослуулан хөгжүүлэх) хамгийн сайн дэмжлэг болно.

Дүгнэлт

Манай улсад хөгжлийн бэрхшээлтэй суралцагчдын боловсролын тухай бие даасан хууль байхгүйгээс гадна хөгжлийн бэрхшээлтэй болон тусгай хэрэгцээт боловсролын үйлчилгээ шаардлагатай суралцагчийн хэрэгцээний талаар нарийвчлан тусгасан зүйл заалтууд Монгол улсын Боловсролын болон нийгмийн хамгаалал, халамжийн хуульд аль алинд нь тусгагдаагүй байна. Тиймээс тусгай хэрэгцээт боловсролын мэргэжлийн ямар бэрхшээлтэй суралцагчдад ямар тусгай хэрэгцээ шаардлагатай болохыг олон улсын практик, баримт, судалгаа, стандарт, гэрээ, конвенцоос судлан хэрэглэн хэвшүүлэх шаардлагатай байна. Хөгжлийн бэрхшээлтэй суралцагчийн дэд бүтцийн хүртээмжгүй байдлаас үүдэн их дээд сургуулийн орчин, багш нарын хөгжлийн бэрхшээлтэй суралцагчтай ажиллах туршлага, нөөц бололцоогүй байдал, олон нийтийн хөгжлийн бэрхшээлтэй суралцагч оюутнуудад, иргэдийн талаарх ойлголт мэдлэг, дутмаг зэрэг байдлаас шалтгаан боловсролд хамрагдалт хангалтгүй байна.

Санал:

- ШУТИС-ийн хэмжээнд хийсэн судалгаа, саналыг ийнхүү танилцуулж байгаа нь тэгш хамруулан сургах боловсролыг төлөвшүүлэх, эрүүл мэндийн асуудалтай оюутнуудыг өнөөгийн нөхцөл байдал, орчиндоо тэдний хэрэгцээ, онцлогийг тусган тохируулах шаардлага зүй ёсоор бий болоод байна. Иймээс бусад их дээд сургууль, төр болон ТББ хамтарч ажиллах;
- Суралцагчийн бодит байдалд нийцүүлэн сургуульд зааж сурах, бие даан судлах агуулга, багшлах арга зүй, холбогдох мэргэжилтнүүдийн зүгээс үзүүлэх дэмжлэгээ тодорхой болгох;
- Тусгай хэрэгцээт суралцагчийн ахицад үнэлгээ хийж, ахуй амьдрал, дотуур байр гэх мэт суралцахад тулгамдаж буй асуудлуудыг шийдвэрлэх;
- Их, дээд сургууль хөгжлийн бэрхшээлтэй суралцахад хүндрэлтэй тусгай дэмжлэг шаардлагатай оюутнуудад “Оюутны дэмжлэгийн төв”-ийг оюутны хөгжил үйлчилгээний албаны дэргэд байгуулах;
- Их, дээд сургуулиудад хөгжлийн бэрхшээлтэй суралцагсдад зориулсан техник хэрэгсэл суурилуулах, шинэ тоног төхөөрөмж бий болгох үүднээс нийгмийн хариуцлагын хүрээнд компаниуд тусламж дэмжлэг үзүүлэх хэрэгтэй байна.

Түлхүүр үг: *Боловсролын байгууллагын чанарын менежментийн тогтолцоо, ISO21001:2018, нэр томъёо, чанарын зорилт.*

Ашигласан материал:

1. Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай конвенцийн 24 дүгээр бүлгийн 24.2 заалт. Монгол Улс, Улаанбаатар хот.
2. Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн 14 дүгээр бүлгийн 14.1.3 заалт. Монгол Улс, Улаанбаатар хот.
3. Стандартчилал хэмжил зүйн газар (2021). MNS, “ISO21001:2021”. Монгол Улс, Улаанбаатар хот.
4. АНУ-ын хөгжлийн бэрхшээлтэй хүний боловсролын тухай хууль.
5. <https://www.meds.gov.mn/>
6. World Health Organization (2011), *Word report on disability*, World Health Organization.
7. ХНХЯ (2008), “*Нийгмийн халамжийн тухай хууль - Эрх зүйн баримт бичгийн эмхэтгэл*” (ху.49). Монгол Улс, Улаанбаатар хот.
8. Одгэрэл.Д (2009). *Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй ажиллах мэргэжилтнүүдэд зориулсан гарын авлага*. Монгол Улс, Улаанбаатар хот.

ХҮРТЭЭМЖТЭЙ НАЛУУ ЗАМ 2023–2024 “УГСАРМАЛ НАЛУУ ЗАМ”

Э.Бумжинсүрэн¹, Д.Золзаяа²

¹Рояль Олон Улсын Их сургуулийн Архитектурын 204-р бүлгийн оюутан,

²Рояль Олон Улсын Их сургуулийн Архитектурын хөтөлбөрийн удирдагч багш
bumjii2015@gmail.com

Үндэслэл

Аливаа хот, суурин газарт барилга, байгууламж, авто зам, гүүрэн байгууламж нь бүх хүнд тэгш хүртээмжтэй, ээлтэй байх ёстой. Олон улсад болон Монгол улсын барилгын норм, дүрмүүдэд ч орон сууц, олон нийтийн үйлчилгээ, оффисын барилгыг бүх төрлийн хөгжлийн бэрхшээлтэй иргэд болон энгийн иргэд ажиллаж амьдрахад саадгүй байх шаардлагыг тусгасан байдаг.

Зорилго

Улаанбаатар хотын хүртээмжийг нэмэгдүүлж, налуу замын стандарт, шаардлагыг хангуулах, төлөвлөлтийг чанарын өндөр түвшинд гүйцэтгүүлэхийг зорьж, налуу зам нь зөвхөн хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хэрэглээ гэх ташуу ойлголтыг үгүй болгож олон нийтийн барилга байгууламжуудын хүртээмжтэй налуу замуудыг судлан, Монгол улсад мөрдөгдөж буй стандарт, норм дүрмийг хангаж байгааг харьцуулсан судалгаа хийсэн.

Судалгааны арга зүй

Тандалт, хэмжилтийн судалгааг олон нийтийн барилга байгууламжид хэмжилт хийж тэдгээрийн хураангуйг хөтлөн баримтжуулсан. Мөн тулгуур болон хөдөлгөөний бэрхшээлтэй, тогтмол шат налуу замаар зорчих шаардлагатай иргэдээс асуулга авч тоон судалгааг гүйцэтгэсэн. Ярилцлагын аргаар мэргэжлийн хүмүүст хандан 8–30 асуулт асуун төлөөлөл болгож судалсан. 12 барилгын хэмжилт, харьцуулсан судалгааг хийж “Иргэний барилгын төлөвлөлтөд хөгжлийн бэрхшээлтэй хүний шаардлагыг тооцсон орон зай, орчин” MNS 6055:2009 стандарттай харьцуулж, нийт 150 хүнээс анкетын аргаар сэтгэл ханамжийн судалгаа авсан. Түүний 45% нь хөгжлийн бэрхшээлтэй иргэд байсан.

Үр дүн

Хүснэгт 1. Их сургууль, эмнэлэг, орон сууц, зочид буудлын налуу замын харьцуулалт


	<i>Рояль Олон Улсын Их сургууль</i>	<i>Сүхбаатар дүүргийн нэгдсэн эмнэлэг</i>	<i>144 айлын орон сууц</i>	<i>“Хүннү” зочид буудал</i>	<i>Хувийн эмнэлэг</i>	<i>MNS 6055:2009 Стандарт</i>
Өргөн	1830 мм	1460 мм	–	1170 мм	770 мм	1200 мм
Өндөр	1525 мм [433 мм]	156 мм [92.5 мм]	–	1360 мм [591 мм]	960 мм [290 мм]	1:12
Налуу замын урт	5200 мм [22875 мм]	1110 мм [23400 мм]	–	7100 мм [16320 мм]	3490 мм [11520 мм]	
Бариулны өндөр 900 мм	990 мм	–	–	970 мм	–	900 мм
Бариулны өндөр 700 мм	710 мм	–	–	720 мм	–	700 мм

Хүснэгт 2. МУИС, Цахим номын сан, Эрдэм Тоур, МУТИТ, ХМХХЕГ, СУ сүлжээ дэлгүүрийн налуу замын харьцуулалт

	МУИС	Цахим номын сан	Эрдэм Тоур	МУТИТ	ХМХХЕГ	СУ сүлжээ дэлгүүр	MNS 6055:2009 Стандарт
Өргөн	1000 мм	1160 мм	2600 мм	1000 мм	1000 мм	1100 мм	1200 мм
Өндөр	1005 мм [23.7 мм]	50 мм [34 мм]	901 мм [891.6 мм]	750 мм [17.71 мм]	90 мм [18.2 мм]	70 мм [10.4 мм]	1:12
Налуу замын урт	2850 мм [12060 мм]	4080 мм [6000 мм]	10700 мм [10812 мм]	2126 мм [900 мм]	2190 мм [1080 мм]	1250 мм [840 мм]	
Бариулны өндөр 900 мм	–	900 мм	–	900 мм	–	–	900 мм
Бариулны өндөр 700 мм	–	700 мм	–	700 мм	–	–	700 мм

Туршилт судалгааны үр дүн

График 1. Их сургууль, эмнэлэг, орон сууц, зочид буудлын налуу замын харьцуулалт





Сэтгэл ханамжийн судалгааны үр дүн

График 2. МУИС, Цахим номын сан, Эрдэм Тоур, МУТИТ, ХМХХЕГ, СУ сүлжээ дэлгүүрийн налуу замын харьцуулалт

Хамгийн их зорчдог буюу гэрээс ажил хүртэл маршрутдаа зорчдог газруудад налуу зам байдаг уу?


Гол төлөв мар газруудад байдаг вэ?




Налуу замыг ашиглахад хэр хүртээмжтэй байдаг вэ?




Налуу замыг ашиглахад ямар бэрхшээл тулгардаг вэ?



Энгийн шатаар өгсөж уруудахаас илүү хялбар байж чаддаг уу?



Улирлаас хамаарч налуу замыг ашиглах асуудал хэр тулгардаг вэ?



Шийдвэрлэх арга зам

- Налуу замын шаардлага хангаагүй барилга байгууламжийг ашиглалтад хүлээж авахгүй байх
- Налуу зам төлөвлөгдөөгүй барилга байгууламжид хяналт тавьж, төлөвлүүлэх, торгууль ноогдуулж, хуулийн арга хэмжээ авах
- Нүхэн гарцын шаардлага хангаагүй налуу замыг дахин төлөвлөж нураалгүй нэмэлтээр угсармал налуу зам тавьснаар шийдэл бий болно. Төсвийн хувьд цутгамал налуу замаас илүү хямд тусна.
- Улсын болон хувийн хэвшлийн байгууллагууд орц, гарцдаа угсардаг налуу замыг төлөвлөж, дотор орон зайд автомат өргүүрийг төлөвлөж өгснөөр шийдлийг 100% бий болгоно.
- Нийгмийн хариуцлагын хүрээнд аж ахуй нэгжүүдэд асуудлыг олж харж, гагцхүү хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд бус бүх нийтэд хүртээмжтэй хөгжил гэж харснаар шийдэл бүрэн гүйцэд бий болж чадна.

Шийдэл

Миний гаргаж ирж буй шийдлийн хувьд угсармал налуу замыг илүү хүртээмжтэй, хялбар угсрагдаж болох тал дээр анхаарч зураг төслөө гаргасан байгаа (Зураг төслийг судлаачтай холбогдож дэлгэрүүлж асууж болно.).

Дүгнэлт

Судалгаанаас үзвэл 75%-ийн үзүүлэлтэйгээр хүртээмжтэй налуу зам нь “Иргэний барилгын төлөвлөлтөд хөгжлийн бэрхшээлтэй хүний шаардлагыг тооцсон орон зайн, орчин” MNS 6055:2009 стандартыг хангахгүй гэж үзэв. 12 барилгаас стандартын шаардлагыг бүрэн хангасан 2 барилга байсан. Бусад нь хүртээмжээ налуу замын шаардлага хангаагүй. Үүнд:

- Налуу замын өргөн хэт нарийн, эсвэл хэт өргөн байна. Тэргэнцэр багтахгүй, эсвэл тэргэнцэртэй хүн ганцаар бие дааж тус замуудаар явах боломжгүй байна. Орон сууцанд налуу зам төлөвлөж өгөөгүй нь маш том асуудлыг дагуулж байлаа. Хүртээмжтэй байснаар орон сууцанд амьдарч буй хүүхэд, настай хүн, ачаа зөөвөрлөх, хөгжлийн бэрхшээлтэй иргэнд ээлгүй нь харамсалтай байлаа. Стандартаар 1200–1500мм байх ёстой.
- Налуу замын өндөр хэт өндөр байгаагаас налууугийн уртыг урт хийх зай талбай байхгүйгээс налуу ихтэй төлөвлөсөн байна. Мөн шаардлага хангахгүй, хүн ганцаар явахад хүртэл хүндрэлтэй байлаа. Стандартаар Нэг налуу замын өргөлтийн өндөр 800 мм-ээс ихгүй, налууугийн өнцөг 1:12-оос ихгүй байна.
- Налуу замын хоёр талд бариул заавал төлөвлөнө. Гэтэл нэг талд нь төлөвлөсөн, зарим барилгад бариул төлөвлөөгүй байна. Үүнд нөлөөлсөн олон шалтгаан байгааг нарийн судлан үзэх шаардлагатай бөгөөд судалгааг үргэлжлүүлэн хийж, стандарт хангахгүй байгаа налуу замыг хүртээмжтэй болгох шаардлагатай.
- Олон улсын хэмжээнд угсармал налуу зам нь хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулагдаж, зөвхөн хийгддэг бол үүнийг бүх хүмүүст хүртээмжтэй гэх талаас нь илүү хандах хэрэгтэй. Мөн орц, гарцдаа төлөвлөсөн бол зайлшгүй дотор орон зайд өргүүрийг төлөвлөх ёстой.

Олон улсын жишгээс авч үзвэл угсармал налуу замын загвар нь гол төлөв үе үеэр нь хооронд нь тогтоож холбодог бол шинээр гаргах санаагаа ямар ч тохиолдолд салгаад угсрах зориулалттайгаар гаргаж ирж байгаа. Үүний үр дүнд ямар ч төрлийн байгууллага үйлчилгээний газар цутгамал налуу замаас илүү хямд үнээр орон зайдаа тохирсон налуу замыг хийлгүүлэх боломжтой гэх дүгнэлтэд хүрсэн.

Түлхүүр үг: *Тэгш хүртээмж, хөгжлийн бэрхшээл, налуу замын стандарт, хөдөлгөөний бэрхшээл.*

Ашигласан материал:

1. Иргэний барилгын төлөвлөлтөд хөгжлийн бэрхшээлтэй хүний шаардлагыг тооцсон орон зай, орчин, MNS 6055:2009 стандарт. .
2. Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хууль. Монгол Улс, Улаанбаатар хот.
3. Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хууль. Монгол Улс, Улаанбаатар хот.
4. Ахмад настны тухай /Шинэчилсэн найруулга/. Монгол Улс, Улаанбаатар хот.
5. www.barilga.mn/n/9615/
6. <https://www.richmondramps.com/>

ТЭРГЭНЦЭРТЭЙ ИРГЭДИЙН НИЙТИЙН ТЭЭВРЭЭР ЗОРЧИХ ТЭГШ ХҮРТЭЭМЖИЙГ НЭМЭГДҮҮЛЭХ АРГА ЗАМЫГ СУДАЛСАН НЬ

А.Оюун-Эрдэнэ, Б.Пүрэвсүрэн¹

¹МУИС-ийн Шинжлэх ухааны сургуулийн Нийгмийн ухааны сургууль

puuceeneee66@gmail.com

Үндэслэл

2023 оны мэдээллээр Монгол Улсад 115115 хөгжлийн бэрхшээлтэй иргэн байгаа бөгөөд үүний 18.2% нь буюу 21064 тулгуур эрхтний (хөдөлгөөний) бэрхшээлтэй иргэн байна. Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн 8.1-т зааснаар Орон сууц, олон нийтийн барилга байгууламж, зам талбай, нийтийн тээвэр, мэдээлэл, харилцаа холбооны технологи нь хөгжлийн бэрхшээлтэй хүнд хүртээмжтэй байна гэж заасан байх бол 2022 оны байдлаар Нийтийн тээврийн үйлчилгээний 1207 тээврийн хэрэгсэл бүртгэлийн санд бүртгэгдсэнээс 56 нь буюу дөнгөж 4.6% нь хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд үйлчлэх нам шалтай, зориулалтын шаттай бөгөөд зөвхөн нэг чиглэлд буюу Таван шар–Офицеруудын ордон байна. Энэ нь нэг талаас хэлбэр төдий сайжруулалт хийгдэж байна. Нөгөө талаасаа иргэдийн ойлголт хандлага, жолоочдын мэдлэг мэдээлэлгүй байдал, хүний эрхийн мэдрэмжгүй байдал нь тэргэнцэртэй иргэд нийгмийн харилцаанаас өөрсдийгөө тусгаарлах нэг хөшүүрэг болж байна. Солонгос болон Япон улс тэргэнцэртэй иргэдийнхээ тэгш хүртээмжийг нэмэгдүүлэх зорилгоор нийтийн тээврийн апплекейшны бүтцэд тэргэнцэртэй иргэдийн цэс бий болгож, тэргэнцэртэй иргэдийн ашиглах боломжтой байгууламж болон зориулсан маршрут гэсэн үндсэн хоёр агуулгын хүрээнд ашиглах боломжийг олгохын сацуу хуульдаа тээвэрлэгчийн эрх үүрэг, хариуцлага шийтгэлийг тусгаж өгсөн байдаг бөгөөд энэхүү Азийн бусад орны сайн туршлагын адилаар аль хэдийнээ ашиглалтад орсон нийтийн тээврийн апплекейшиныг хөгжүүлэн шинэ цэс үүсгэх, тэргэнцэртэй иргэдийн тэгш хүртээмжийг нэмэгдүүлэх нэн хэрэгцээтэй байна.

Зорилго

Ковид–19 цар Тэргэнцэртэй иргэд нийтийн тээвэрээр зорчих тэгш хүртээмжийг нэмэгдүүлэх арга замыг эрэлхийлэх.

Судалгааны арга зүй

Судалгаанд хосолмол аргыг ашигласан ба анхдагч чанарын мэдээллийг тэргэнцэртэй иргэнийг нийтийн тээвэрээр зорчиход даган ажигласан тэмдэглэл, мөн жолоочидтой ярилцлага хийсэн, хоёрдогч мэдээллийг холбогдох хууль, олон улсын судалгааны тайланд баримт бичгийн судалгаа хийсэн.



Үр дүн

Тэргэнцэртэй иргэд нийтийн тээврээр зорчиход жолооч болон дэд бүтэцтэй холбоотой жолоочийн харилцаа хандлага ойлголт дутмаг, зориулалтын талбайд зогсоогүй бэхэлгээний бүсээ зүүгээгүй байхад шууд хөдлөх, налуу зам тоос орж гацсан, санал гомдлоо хэлсэн ч шийдвэрлэдэггүй зэрэг асуудлууд тулгарч байна. Иргэдийн ойлголт хандлагатай холбоотой зориулалтын талбайд зогсох, тусламж шаардлагагүй үед тав тух алдагдуулах зэрэг тохиолдлууд тулгарч байна. UB bus апплейшнтай холбоотой хүртээмжтэй нийтийн тээврийн тэмдэглэгээ байдаггүй нь ямар автобусанд суух боломжтой талаар мэдэх боломжийг хязгаарладаг байна. Мөн автобусны буудлын стандартыг ажиглахад ажигласан 4 талбар бүгд стандарт бус буудалтай байгаа төдийгүй автобусны буудал дээр машинууд зогсох энэ нь шахаж зогсоход хүндрэл үүсгэж байгаа юм.

Хүснэгт 1. Автобусны буудлын стандартыг ажигласан үзүүлэлт

Буудлын нэр	Урт улаан (130)	Хуучин солонгос (95)	Давхар автобус (30)	Ногоон шинэ автобус (40)	Урт терллабус (25)
Багшийн дээд	Өндөр (-)	2 шаттай (-)	Хаалга нарийн (-)	Өндөр (-)	Өндөр (-)
ТБД андууд	Өндөр (-)	2 шаттай (-)	Хаалга нарийн (-)	Өндөр (-)	Өндөр (-)
19-р байр (Хархорин)	Өндөр (-)	2 шаттай (-)	Хаалга нарийн (-)	Өндөр (-)	Өндөр (-)

Дүгнэлт

Тэргэнцэртэй иргэд нийтийн тээврээр зорчиход олон бэрхшээл тулгарч байгаа бөгөөд энэ нь тэдний эрхийг зөрчиж, нийгмийн амьдралд тэгш хүртээмжтэй оролцоход хүндрэлтэй байгаа тул нийгмийн тулгамдсан асуудалд зүй ёсоор орно. Уг судалгааг тэргэнцэртэй иргэд, жолоочидтой ганцаарчилсан ярилцлагын аргаар тулгамдаж буй асуудал хэрэгцээ шаардлагыг тодорхойлж, тэднийг ажиглах замаар судлаачид нөхцөл байдлыг биечлэн судалж, UB smart bus апплейшны хөгжүүлэлтийн мэргэжилтэнтэй шийдлийг эрэлхийлэн ярилцаж судаллаа. Солонгос, Япон азийн орнуудын сайн туршлагыг судлан, Монголын нөхцөлд буулгах боломжийг судалсан. Хэдийнээ хүмүүсийн өдөр тутамдаа ашиглаж буй UB smart bus апплейшн хэрэглээнд нэвтэрсэн тул энэхүү байгаа нөөц боломжоо ашиглан тэргэнцэртэй иргэдийн нийтийн тээврээр зорчих тэгш хүртээмжийг нэмэгдүүлэх боломжтой гэсэн шийдлийг дэвшүүлсэн. Энэхүү санаа хэрэгжсэнээр зөвхөн тэргэнцэртэй иргэд бус хүүхдийн тэрэгтэй ээжүүд, ахмад настанд мөн үр нөлөөгөө үзүүлэх боломжтой хэмээн харж байна. Мөн зөвхөн апплейшныг хөгжүүлэх бус жолооч болон иргэдийн мэдлэг мэдээллээр хангах, нөлөөлөх, интервенц үзүүлэх хэрэгцээ шаардлага байна.

Түлхүүр үг: Цахим шийдэл, жолооч, UB smart bus апплейшн.

Ашигласан материал:

1. Тэргэнцэртэй иргэдийн холбоо (2023). *Үйл ажиллагааны тайлан*. Монгол Улс, Улаанбаатар хот.
2. Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хууль. Монгол Улс, Улаанбаатар хот.
3. <https://ulaanbaatar.mn/news/18115>
4. <https://ikon.mn/n/304c>
5. <https://legalinfo.mn/mn/detail/29>



III БҮЛЭГ

ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙ

ХОРИХ ЯЛААР ШИЙТГҮҮЛСЭН ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ИРГЭДИЙН ЯЛ ХЭРГИЙН БАЙДЛЫГ СУДАЛСАН НЬ

Д.Өлзийчимэг, Б.Гомбо, Б.Бэхбаатар, Г.Цэрмаа¹

¹401 ХХА–НЭ, Мэдрэлийн тасаг

Namuunaagii1@gmail.com

Үндэслэл

Монгол Улсын хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуульд заасны дагуу “Хөгжлийн бэрхшээлтэй хүн” гэдэгт бие махбод, оюун санаа, сэтгэл мэдрэл, мэдрэхүйн байнгын согог нь орчны бусад саадтай нийлсний улмаас бусдын адил нийгмийн амьдралд бүрэн дүүрэн, үр дүнтэй оролцох чадвар нь хязгаарлагдсан хүнийг хэлдэг байна. Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн өдөр тутмын амьдралд хүрээлэн буй орчны зүгээс тулгарч буй саад бэрхшээл, тэдгээрийн аж амьдралын байдал, зорилтот үйл ажиллагааны оролцооны хязгаарлалт, ялгаварлан гадуурхалт, хэрэгцээт шаардлагыг тодорхойлох зэрэг нийгэм, эдийн засаг болон хүрээлэн буй орчны хүчин зүйлүүдээс шалтгаалан Хөгжлийн бэрхшээлтэй иргэд нийгэмд гэмт хэрэг хийх нь Үндэсний статистикийн хорооны гаргасан судалгаагаар жил ирэх тусам нэмэгдсээр байгааг харуулж байна. Эдгээр гэмт хэрэг хийсэн Хөгжлийн бэрхшээлтэй хоригдлуудыг ямар эрүүгийн хуулиар ял эдэлж байгааг судлах нь энэхүү судалгааны үндэслэл болж байна.

Зорилго

Монгол Улсын хэмжээнд хорих ангиудаар хоригдож байгаа Хөгжлийн бэрхшээлтэй хоригдлуудын ял хэргийн байдлыг судалснаар нийгэмд дахин гэмт хэрэг хийхээс урьдчилан сэргийлэх арга хэмжээг авахад судалгааны зорилго оршино.

Судалгааны арга зүй

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын харьяа 401 дүгээр хаалттай хорих анги–Нэгдсэн эмнэлэгт хэвтэн эмчлүүлж буй хөгжлийн бэрхшээлтэй хоригдлуудын дунд “Хорих ялаар шийтгүүлсэн хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн ял хэргийн байдлыг судлах нь” сэдэвт энэхүү судалгааг 2021–2023 оны хооронд хөдөлмөрийн чадвар алдалт сунгуулсан хоригдол, хөдөлмөр чадвар алдалт шинээр тогтоолгосон хоригдлуудад явуулсан болно.

Судалгааны үед баримталсан үндсэн арга зүй нь

- Статистик тоон мэдээнд боловсруулалт хийх.
- Баталгаажуулсан байдалд дүн шинжилгээ хийх (бичиг баримтын шинжилгээ, харьцуулсан шинжилгээ).
- Өмнө нь хийгдсэн судалгааны үр дүн, асуулга, чанарын мэдээлэлд үнэлгээ хийх.

Судалгааны ажлын хугацаа богино, ажлын материал ихтэй тул нийтлэг үзүүлэлтүүдийн байдалд үнэлэлт өгч баталгаажуулсан болно.

Үр дүн

Хөгжлийн бэрхшээлийг төрлөөр нь авч үзэхэд:

Хүснэгт 1. Нэгдсэн эмнэлэгт хэвтэн эмчлүүлсэн хоригдлуудын хөгжлийн бэрхшээлийн төрөл

<i>Бэрхшээлийн төрөл</i>	<i>2021 он</i>	<i>2022 он</i>	<i>2023 он</i>
Оюун ухааны	19	21	25
Сонсгол	23	19	19
Хараа	9	12	14
Хэл яриа	9	7	5
Тулах, хөдлөх	42	39	43
Эплепси	15	8	11

Эрүүгийн хуулиар ял шийтгэлээр шийтгүүлсэн байдал:

- Оюун ухааны бэрхшээлтэй иргэн Эрүүгийн хуулийн 10 дугаар бүлэгт хамаарах “Хүний авьд явах эрхийн эсрэг гэмт хэрэг”, Эрүүгийн хуулийн 12 дугаар бүлэгт хамаарах “Хүний бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг” үйлдэж ял шийтгэлээр шийтгүүлж байна.
- Сонсголын бэрхшээлтэй, хэл ярианы бэрхшээлтэй иргэн Эрүүгийн хуулийн 17 дугаар бүлэгт хамаарах “Өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг” үйлдэж ял шийтгэлээр шийтгүүлж байна.
- Харааны бэрхшээлтэй иргэн Эрүүгийн хуулийн 11 дүгээр бүлэгт хамаарах “Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг” үйлдэж ял шийтгэлээр шийтгүүлж байна.
- Тулах, хөдлөх эрхтний бэрхшээлтэй иргэн Эрүүгийн хуулийн 27 дугаар бүлэгт хамаарах “Хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг” үйлдэж ял шийтгэлээр шийтгүүлж байна.

Дүгнэлт

Судалгааны хүрээнд 2021–2023 онд 401 дүгээр хаалттай хорих анги–Нэгдсэн эмнэлэгт хөдөлмөр чадвар алдалт шинээр тогтоолгосон болон хөдөлмөр чадвар алдалт сунгуулсан хөгжлийн бэрхшээлтэй хоригдлууд хорих ялаар шийтгүүлсэн байдлыг судлахад Эрүүгийн хуулийн 10, 11, 12, 17, 27 дугаар бүлэгт хамаарах зүйл ангитай гэмт хэргийг дийлэнх хувийг эзэлж байна. 2021 оны байдлаар 67 хоригдол, 2022 оны байдлаар 84 хоригдол, 2023 оны байдлаар 78 хоригдол тус бүр Нэгдсэн эмнэлэгт хэвтэн эмчлүүлсэн байна. Энэ судалгаанаас үзэхэд хууль ёсны төлөөлөгч (эцэг, эх, асран хамгаалагч)-ийн анхаарал халамж, хараа хяналт сул байгааг харуулж байна. Иймд хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг нийгэмшүүлэх, тэдгээрийн дуу хоолойг сонсох, хууль ёсны төлөөлөгчийн үүрэг хариуцлагыг нэмэгдүүлэх шаардлагатай, хөдөлмөр эрхлэлтэд чиглэсэн эрх зүйн боловсрол олгох мэдээлэл, сургалтыг сайжруулах ажил хийгдэх нь ажиглагдаж байна.

Түлхүүр үг: *Хөдөлмөрийн чадвар алдалт, хоригдол, шийтгэл.*

ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ЭМЭГТЭЙ ХОРИГДЛЫН ХОРИХ ЯЛ ЭДЛҮҮЛЭХ АЖИЛЛАГААНД ТУЛГАМДАЖ БУЙ АСУУДАЛ, ШИЙДВЭРЛЭХ АРГА ЗАМ

Н.Удвалцэцэг¹

¹407 дугаар нээлттэй, хаалттай хорих ангийн
нийгмийн ажилтан, хууль зүйн ухааны магистр, хошууч

Үндэслэл

Монгол Улсын засгийн газар хийгээд харьяалах төрийн болон төрийн бус байгууллагын зүгээс хүний эрхийг хангах чиглэлээр олон төрлийн ажил, арга хэмжээг зохион байгуулж, нийгэм олон нийтэд хүрч байгаа хэдий ч хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах, тэдэнд тулгамдаж буй асуудлыг шийдвэрлэх ажил цаг үеэсээ хоцрогдсон, олон нийтийн мэдээллийн хэрэгслээр “... ярианы хэлийг дохионы хэлмэрч тайлбарлах, төрийн байгууллага, аж ахуй нэгжийн үүдний хэсэгт налуу шат байрлуулахаас өөр төвшинд хүрээгүй, бодлогын хэмжээнд анхаарал хандуулж, шинжлэх ухааны төвшинд судалж, цаашдын чиг баримжааг тодорхойлох зайлшгүй шаардлагатай...” гэж судлаачийн зүгээс үздэг. Энэ ч утгаараа хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг бүх төвшинд хангах, тэр дундаа “...хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэй хүмүүжигч нарын эрхийг хамгаалах, нийгмийн баталгааг хангах, тэднийг сурч боловсрох, нөхцөл бололцоогоор хангах, эрх зүйн шинэтгэлийн хүрээнд тулгарч буй асуудлыг шийдвэрлэх...” цаг үеийн зайлшгүй шаардлага байна.

Зорилго

Хорих ял шийтгүүлсэн хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэй хоригдлын эрх зүйн байдалд бодит дүн шинжилгээ хийж, тэдэнд тулгамдаж буй асуудлыг нээн илрүүлж, шийдвэрлэх арга замыг эрэлхийлэх.

Судалгааны арга зүй

Хорих ялаар шийтгүүлсэн хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэйчүүдэд тулгамдаж буй асуудлын талаар хууль эрх зүйн үүднээс холбогдох хууль журмыг судалж, судалгаа болон зайлшгүй хэрэгцээнд үндэслэн энэхүү илтгэлийг боловсруулав.

Үр дүн

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын харьяа 407 дугаар нээлттэй, хаалттай хорих анги нь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай Монгол Улсын хуульд зааснаар хорих ялыг биечлэн эдлүүлэхээс гадна “...хорих ял шийтгүүлсэн эмэгтэй хоригдлын гэмт санаа бодлыг арилгах, засан төлөвшүүлэх, ажил, мэргэжлийн чиг баримжаа олгох, их дээд сургуульд элсэн суралцуулах...” зэрэг бүхий л талын чиг үүргийг хэрэгжүүлэн ажиллаж байна. Монгол Улсад хэрэгжиж, даган мөрдөж буй хууль эрх зүйн акт болох Монгол Улсын нэгдэн орсон Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай НҮБ-ын конвенц, Монгол Улсын Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хууль цаашлаад Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль, Хорих ангийн дотоод журам зэрэгт “Хөгжлийн бэрхшээлтэй хоригдлыг ял эдлүүлэх” талаар зохицуулсан заалт огт тусгагдаагүй байдаг. Иймд хорих ялаар шийтгэгдсэн хөгжлийн бэрхшээлтэй хоригдлыг энгийн /бүрэн чадвар, чадамжтай/ хоригдлын нэгэн адил эрх эдэлж, үүрэг хүлээх орчин нөхцөлд ял эдлүүлж байна. Гэсэн хэдий ч хорих анги нь өөрийн нөхцөл боломжид тулгуурлан, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүжигчдэд түлхүү анхаарал хандуулж, тэдний эрх зөрчигдөхөөс урьдчилан сэргийлж, анхаарал хандуулан ажилласаар ирсэн.

407 дугаар нээлттэй, хаалттай хорих анги (эмэгтэйчүүдийн хорих анги) нь хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэй хоригдлыг “...ажлын байраар хангах, мэргэжил эзэмшүүлэх, нийгмийн баталгааг хангах...” чиглэлээр шат дараатай ажил эхлүүлж, тэдэнд чиглэсэн зорилтот хөтөлбөрийг дэвшүүлж, хорих ангид хуваарилагдаж ирсний дараа 50–60%-д нь “...тогооч, барилгын засал чимэглэлчин мэргэжил эзэмшүүлж, гар урлал, зүү ороох, гар урлал зэрэг хөдөлмөрийн дадал олгож”, 2 хоригдлыг ерөнхий боловсролын сургалтад хамруулан ББД боловсролын гэрчилгээ олгуулж, мөн тухайн хоригдлын чадвар чадамжид тохирсон ажлын байраар 100% ханган ажиллаж байна.


Мөн хөдөлмөр, сургалтад хамруулахаас гадна сэтгэл зүйн байдлыг тогтвортой байлгах, ар гэртэй холбон зуучлах, хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, тогтоолгох, сунгах, эрүүл мэндийн болон нийгмийн бусад үйлчилгээ үзүүлэх чиглэлээр Нийгэм, сэтгэл зүйн нэгж ажиллаж байна.

Диаграмм 1. Хорих ялаар шийтгүүлсэн хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэй хүмүүжигчдийн тоон үзүүлэлт



Тус ангийн удирдлагын зүгээс хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэй хоригдлын “...ажил хөдөлмөр эрхлэх, сурч боловсрох эрхийг хангах, нийгмийн баталгааг хангах...” хүрээнд “...хорих ангид ирсний дараа мэргэжил эзэмшүүлж, ажлын байраар хангаж байгаа ч хөдөлмөрийн чадвар алдалтын хувь өндөр, суллагдан гараад хөдөлмөрт хамрагдах боломж бага, өөрийн гэсэн өмчлөлийн орон байр үгүй, нийгмээс гадуурхагдах хандлага их...” зэргээс шалтгаалан давтан гэмт хэрэг үйлдэж ял шийтгүүлэх асуудал буурахгүй байгаа нь судлаач миний анхаарлыг ихээхэн татаж байна.

Диаграмм 2



Дүгнэлт

Дээрхээс дүгнэхэд хөгжлийн бэрхшээлтэй хоригдлын хорих ял эдлэх үйл ажиллагааг энгийн хүний нөхцөлөөс тусгайлан авч үзэх, суллагдсаны дараах нийгэмд дасан зохицож, ажил амьдралд дэмжлэг үзүүлэх, ажлын байранд зуучлах, нийгэмд ялгаварлан гадуурхалтаас ангид амьдрах боломжийг хангах тал дээр анхаарал хандуулах, нийгэмд эерэг мэдээлэл тогтмол түгээх зэрэг асуудлыг харьяалах засаг захиргааны байгууллага, албан тушаалтны ажлын байрны тодорхойлолтод тусгах, цаашид Монгол улсад дагаж, мөрдөгдөж буй хөгжлийн бэрхшээлтэй хүний талаарх хууль эрх зүйн акт, журам зааварт хөгжлийн бэрхшээлтэй хүн хорих ялаар шийтгэгдсэн үед хэрхэн хорих ялыг эдлүүлэх талаар нарийвчлан тусгах, хорих ангид хөгжлийн бэрхшээлтэй хүн байрлах тусгай хэрэгсэл, тоног төхөөрөмж бүхий шаардлага хангасан өрөөтэй болох зэрэг асуудлуудын шийдвэрлэж эдгээр хүмүүсийг дахин гэмт хэрэг үйлдэхээс урьдчилан сэргийлэх, нийгэм өөрийн гэсэн байр суурийг эзлэн, өөртөө итгэлтэй, аюулгүй амьдрах боломжийг бүрдүүлэх нь зүй ёсны хэрэг юм.

Түлхүүр үг: Тэгш хүртээмж, ялгаварлан гадуурхалтаас ангид, хөдөлмөрлөх боломжийг нэмэгдүүлэх.

Ашигласан материал:

1. Очгэрэл.Ц. “Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын үйл ажиллагааны эрх зүйн шинэтгэлд: Хуулийн шинэчлэлийн ач холбогдол ба хэрэгцээ, шаардлага” Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын 100 жилийн ойд зориулсан эрдэм шинжилгээний хурлын эмхэтгэл. Монгол Улс, Улаанбаатар хот.
2. Жамбалрагчаа.Э. “Монголын төрт улсуудын эрүүгийн эрх зүйн ялын бодлого, түүхэн уламжлал, түүний үр нөлөө - Албадлагын арга хэмжээнд тавих хяналтын тогтолцоо, хэрэгжилт, чиг хандлага” сэдэвт эрдэм шинжилгээний хурлын эмхэтгэл. Монгол Улс, Улаанбаатар хот.
3. 407 дугаар нээлттэй, хаалттай хорих анги (2023). Судалгааны тайлан. Монгол Улс, Улаанбаатар хот.

ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮНИЙ ОРОН БАЙРНЫ ЭРХИЙН ТАЛААРХ МОНИТОРИНГ

Я.Авирмэд, Г.Давааням¹, Н.Тамирхүү, Х.Мөнхтуул², З.Насандэлгэр³, Д.Ууганбаяр⁴

¹ Түгээмэл хөгжил төв. ² Японы олон улсын хамтын ажиллагааны агентлагийн Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тогтолцоог бэхжүүлэх төсөл

³ Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй гэр бүлийг дэмжих “Ундарга” төв

⁴ ЖИ ПИ ЭИ Глобал Монгол ХХК, Менежер

avir5108@gmail.com

Үндэслэл

НҮБ-ын ХБХЭК-ыг хүлээн авснаар хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрхийг хамгаалах хууль эрх зүйт тогтолцоо бүрэлдэх суурь нөхцөл бий болжээ. Улмаар манай улс хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийг батлан хэрэгжүүлээд 6 жил өнгөрсөн байна. Энэхүү ХБХЭК, ТХЗ, ХБХЭХ, түүнийг дагалдан гарсан журмууд зэрэг дагаж мөрдөх эрх зүйн орчин бий болсон ч хэрэгжилт, улмаар хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн нийгмийн хамгааллын гол хэрэгцээ болох тэдний орон байрны эрхийн хэрэгжилт манай улсын түвшинд ямар байгааг тодруулах, цаашид хэрхэн энэхүү эрхийг хамгаалах, хэрэгжүүлж болох арга замыг тодруулах шаардлагатай байна.

Зорилго

Монгол Улс дахь хөгжлийн бэрхшээлтэй хүний орон байрны бодлого, энэ талаарх хууль, эрх зүйн хэрэгжилт, өнөөгийн байдал, боломжит хэрэгжүүлж болох хувилбаруудыг тодорхой болгох.

Судалгааны арга зүй

ХБ хүний орон байрны эрхийн талаар суурь ойлголтын хүрээнд ХБХЭК-ын 2, 28, 19, 3, 4, 5, 9, 23 дугаар зүйлүүд, ТХЗ-ын 11 дүгээр зорилго, түүний үзэл санааг тэргүүн ээлжид авч үзсэн. Бид тоон болон чанарын судалгааг гүйцэтгэсэн. ҮСХ-ны 2010 ба 2020 оны Хүн ам, орон сууцны тооллогын сангийн Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн сэдэвчилсэн судалгаа, Статистикийн нэгдсэн сан, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Өрхийн мэдээллийн нэгдсэн сангийн тоон мэдээллүүд, Төрийн орон сууцны корпорац, Нийслэлийн орон сууцны корпорац, Монголын ипотекийн корпорацын тоон мэдээллүүдийг тоон судалгаандаа, харин чанарын судалгаанд хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн орон сууцны талаар баримтлах бодлогын дараах баримт бичгүүдийг судлалаа. Үүнд:

- ХБ хүний орон сууцны эрхийн олон улсын баримт бичиг, Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн орон сууцаар хангах бодлогын баримт бичиг, Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн орон сууцжуулах бодлогын баримт бичгийг хэрэгжүүлэх зохицуулалтын тогтоол, тушаал зэргийг судалсан. Бодлогын баримт бичигт Алсын хараа – 2050 Монгол улсын урт хугацааны хөгжлийн бодлого, мөн бусад Хууль, УИХ-ын тогтоол, журмуудыг хамруулан судлалаа.

Үр дүн

ХБХЭК, ТХЗ-өөс урган гарч байгаа хэрэгцээнд тохирсон орон сууц, орлогод нийцсэн, тэгш хамруулсан орчин, хүртээмж, түгээмэл загвар, тэгш байдал, эрсдэлд тэсвэртэй чанартай орон сууц гэсэн үндсэн үзүүлэлт олон улсад мөрдөгдөгч манайд тэгш хамруулсан, хэрэгцээнд тохирсон, тэгш байдлыг хангасан гэсэн ойлголтуудыг манайд мөрддөггүй байна. Хүн ам, орон сууцны 2020 оны тооллогын дүнгээс харахад ХБИ-ийн 20 хүртэлх хувь нь өөрийн орон сууцанд буюу ус, дулаан, цахилгааны хангамжтай орон сууцанд амьдарч байна. Мөн ХБИ-ийн 80% нь дундаж болон байв.

Дүгнэлт

Хэрэгцээнд тохирсон, орлогод нийцсэн, тэгш хамруулсан орчин, тохирох хэрэглэгдэхүүн, хүртээмж, түгээмэл загвар гэсэн ойлголтуудыг Алсын хараа – 2050, Монгол улсын урт хугацааны бодлогын баримт бичигт тусгах, ХБ хүмүүсийг хэрэгцээнд тохирсон, орлогод нийцсэн, хүртээмжтэй, тэгш хамруулсан орчинтой орон байраар хангахад төр ямар үүрэгтэй оролцохыг тодорхой заах, Алсын хараа 2050-д 2041 оноос эхлэн Хэрэгцээнд нийцсэн чанартай, тохилог

орон сууцны хангамж, хүртээмжийг нэмэгдүүлэх үе гэж заасныг өөрчлөн эхний үе шатнаас эдгээр асуудлыг шийдэн хэрэгжүүлэх, улмаар ХБ хүний орон байрны эрхийг хангах үндэсний хөтөлбөр боловсруулан гаргаж хэрэгжүүлэх, хууль эрх зүйн баримт бичгийн давхардлыг арилгаж, хэрэгжилтийг хангах шаардлагатай нь харагдаж байв. Хууль, журам тогтоолын давхардлыг арилгах, хэрэгжилтийг хангах хэрэгтэй байна. ХБИ байр, орон сууц авахад барьцаа хөрөнгө хангалтгүй, ихэнх нь өөрийн өмчлөлийн эсвэл эзэмшлийн газаргүй байдаг байна, тиймээс тэдэнд хэрэгцээнд нь нийцсэн газрыг олгох хэрэгтэй байна.

Түлхүүр үг: *Хэрэгцээнд тохирсон, орлогод нийцсэн, хүртээмжтэй, тэгш хамруулсан орон сууц.*

Ашигласан материал:

1. Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай конвенц.
2. Эрүүл мэндийн сайд, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын хамтарсан A/758, A/197 дугаар тогтоолын 1, 2 дугаар хавсралт.
3. Nairobi- UN–Habitat (2014). Accessibility of Housing: Handbook of inclusive affordable housing solutions for persons with disabilities and older persons, *Concept of disability*, 7.
4. United Nations Human Settlement Programme (2015). The Right to Adequate Housing for Persons with Disabilities Living in Cite, (8).

ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮНИЙ ЭРХИЙН ТУХАЙ ХУУЛЬД ХИЙСЭН СИСТЕМИЙН АРГА ЗҮЙН ШИНЖИЛГЭЭ

Г.Уянга¹, Л.Долгор²

¹ ХААИС-ийн багш, ² Нийгмийн эрүүл мэнд судлаач

Uyanga.g@mul.s.edu.mn

Үндэслэл

Дэлхий дахинаа 1948 оноос, манай улсад 1992 эхлэн холбогдох эрх зүйн баримт бичгийг батлах замаар хөгжлийн бэрхшээлтэй иргэний эрхийн асуудлыг баталгаажуулж ирсэн. “Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хууль, эрх зүйн орчин, стандартын хэрэгжилтийн өнөөгийн байдал”-ыг тодорхойлсон судалгаа цөөнгүй бий. Харин бидний энэхүү судалгаа нь хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хамгаалах тогтолцоог бүрдүүлж буй эрх зүйн гол баримт бичигт системийн шинжилгээ хийх замаар уг системийг оношлох болно. Бидний энэхүү судалгаа нь хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах хууль нь “зорилгоо хэрэгжүүлэх чадвартай систем”-ийг бүрдүүлж чадаж байгаа эсэхийг тодорхойлж байгаагаараа онцлог.

Зорилго

Монгол улсад хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах, хамгаалах үндсэн харилцааг зохицуулж буй гол хуульд системийн инженерчлэлийн аргаар шинжилгээ хийж, тус хуулийн зохицуулалтаас үүдэн системд бий болсон доголдлыг илрүүлж холбогдох санал зөвлөмжийг боловсруулах зорилготой.


Судалгааны арга зүй

Энэхүү судалгаанд нийгмийн нэгж системийг судалж онолоход ашигладаг ТУС¹ загварыг ашиглав. Манай улсад хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах, хамгаалахад чиглэсэн нэн тэргүүнд нэрлэж болох 8² эрх зүйн баримт бичиг байгаагаас “үндсэн харилцааг зохицуулж буй” гэсэн шалгуураар 2016 онд батлагдсан “Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хууль”-ыг сонгон системийн арга зүйн шинжилгээг гүйцэтгэв.

Үр дүн

Монгол улсад хөгжлийн бэрхшээлтэй эрхийг хангах, хамгаалахад чиглэсэн суурь тогтолцоог бүрдүүлж буй тус хууль нь 12 бүлэг, 44 зүйл, 262 заалтаас бүрддэг. Уг хуульд хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах үндэсний тогтолцооны зорилгыг оновчтой тодорхойлсон эсэх (Зорилгын тайллын дэд тогтолцоо), зорилгыг хэрэгжүүлэхэд оролцогч талуудын хүлээх үүргийг нарийвчлан тусгасан эсэх (Үүргийн гүйцэтгэлийн дэд тогтолцоо), хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангахад чиглэсэн үйл ажиллагааны мэдээллийг бүртгэж, боловсруулж, шийдвэр гаргахад ашигладаг эсэх (Мэдээллийн урсгалын дэд тогтолцоо), хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангахад чиглэсэн үйл ажиллагааны үр дүнг хэмжиж, үүрэг хүлээсэн субъектүүдийг урамшуулдаг эсэх (Хэмжүүр үзүүлэлтийн дэд тогтолцоо), хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах үйл ажиллагаанд тулгамдаж буй асуудлыг оношилж хариу арга хэмжээг тогтмол авдаг эсэх (Эргэх холбооны дэд тогтолцоо) гэсэн 5 багц шалгуураар үнэлэхэд дараах үр дүн гарсан болно.

График 1: Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуульд (2016) хийсэн системийн шинжилгээний үр дүн



¹ ТУС: Тохируулгатай угсардаг систем буюу логик сэтгэлгээнд тулгуурласан нийгмийн нэгж системийг судалдаг арга. Энэхүү аргыг Монгол судлаачид хөгжүүлж байгаа бөгөөд INCOSE буюу олон улсын инженерчлэлийн зөвлөлийн хурлаар амжилттай хэлэлцүүлж салбарын эрдэмтдээр хүлээн зөвшөөрүүлсэн.

² Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газар. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан хууль тогтоомжийн эмхэтгэл. УБ.,2022.

Хүснэгт 1. Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуульд (2016) хийсэн системийн шинжилгээний үр дүн

№	Дэд тогтолцооны нэр	Хэв шинжийн тоо	Жишиг оноо	Гүйцэтгэлийн оноо	Гүйцэтгэлийн хувь	Системийн төлөв байдлын ангилал
1	Зорилгын тайллын дэд тогтолцоо	7	21	17	80.9	ASA-II
2	Хэмжүүр үзүүлэлтийн дэд тогтолцоо	11	33	11	33.3	ASA-V
3	Мэдээллийн урсгалын дэд тогтолцоо	10	30	22	73.3	ASA-II
4	Үүргийн гүйцэтгэлийн дэд тогтолцоо	6	18	16	88.9	ASA-I
5	Эргэх холбооны дэд тогтолцоо	6	18	8	44.4	ASA-V
6	Нийт	40	120	74	61.6	ASA-III

Эх сурвалж: Судлаачдын боловсруулалт

Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хууль нь системийн шалгуурыг 61.6-тай хангаж “тодорхой орчинд л оршин тогтнох чадвартай систем”-ийн ангилалд хамаарч байна. Хамгийн өндөр хувиар үнэлэгдсэн (88.9%-тай) нь үүргийн дэд тогтолцоо нь бөгөөд шалгуурыг 100 хангаж чадаагүй шалтгаан нь “оролцогч тал бүрээр үүргүүдийг тодорхойлсон боловч үүргүүдийг гүйцэтгэх эзэн, нөхцөл, баримтжуулах шийдлүүд” дутмаг байсан нь нөлөөлөв.

Хамгийн бага хувиар үнэлэгдсэн (33.3%-тай) нь хэмжүүр үзүүлэлтийн дэд тогтолцоо бөгөөд ингэж үнэлэгдсэн нь “хуулийн зорилгын хэрэгжилт, үр дүнг хэмжих хэмжүүргүй, зорилгын хэрэгжилтийг оролцогч тал бүрийн үүргийн гүйцэтгэлээр хэмждэггүй, хуулийн зорилгын тэмүүлэх түвшин тодорхойгүй” байдал нөлөөлөв.

Дүгнэлт

Бид “нэг хууль–нэг систем” гэсэн зарчмыг баримтлан “Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг тухай хууль”-д системийн аргачлалаар шинжилгээ хийв. Системийн шинжилгээний дүнгээс үзвэл уг хуулийн бүрдүүлж байгаа үндэсний тогтолцоо нь “зорилгоо хэрэгжүүлэх чадамж маш сул, зөвхөн тодорхой орчинд нь оршин тогтнох чадвартай систем”-ийн ангилалд хамаарч байна. Тийм учраас цаашид уг хуульд шинэчлэл, өөрчлөлт хийхдээ системийн доголдолтой хэсэгт хамаарах зохицуулалтуудыг нэн тэргүүнд оруулах зарчмаар ажиллах шаардлагатай. Хэрэв энэ хууль цаашид энэ хэвээр байсаар байвал “хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах үндэсний тогтолцоо”-ны доголдол улам бүр лавширч хуулиар дэвшүүлсэн зорилгодоо хүрч чадахгүй.

Түлхүүр үг: Монгол улс, нэг хууль–нэг систем, хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах үндэсний тогтолцоо, системийн доголдол.

Ашигласан материал:

1. НХХЯ, ХБХХЕГ (2019). *Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хууль, эрх зүйн орчин, стандартын хэрэгжилтийн өнөөгийн байдал*. Монгол Улс, Улаанбаатар хот.
2. Сэмжидмаа.Б (2018). *Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн хөдөлмөрлөх эрх. Хүний эрх сэтгүүл*, 2.
3. Өнөржаргал.З (2016). *Хөгжлийн бэрхшээлтэй хүний сонгох эрхийн хэрэгжилт. Хүний эрх сэтгүүл*, 1.
4. НХХЯ, Хөдөлмөр нийгмийн хамгааллын судалгааны институт (2018). *“Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлт” судалгааны тайлан*. Монгол Улс, Улаанбаатар хот.
5. Залуу судлаач сан (2019). *“Үндсэн хуулийн үзэл баримтлалыг системийн загвараар шинжилж, дүрслэх” судалгааны тайлан*. Монгол Улс, Улаанбаатар хот.
6. Залуу судлаач сан (2021). *“Монгол улсын боловсролын нэгдсэн тогтолцооны суурь хэв шинжүүдийг тодорхойлж, системийн загвараар дүрслэх нь” судалгааны тайлан*. Монгол Улс, Улаанбаатар хот.
7. ШУА, Философийн хүрээлэн (2022). *Монгол дахь боловсролын философийн асуудал, хандлага*. Монгол Улс, Улаанбаатар хот.
8. Уянга.Г & Долгор.Л. *Хүмүүнлэгийн боловсролын тухай хуулийн төсөлд хийсэн системийн шинжилгээний үр дүн*. Монгол Улс, Улаанбаатар хот.
9. Бадарч.Ш & Мөнххүж.Б (2018). *Системийн сэтгэлгээ*. Монгол Улс, Улаанбаатар хот.

СОНСГОЛ, ХЭЛ ЯРИАНЫ БЭРХШЭЭЛТЭЙ ХҮН ГЭМТ ХЭРГИЙН СУБЪЕКТ БОЛОХ НЬ ТЭДНИЙ БИЕЙН ХЭЛЭМЖ, ОНЦЛОГ

Н.Бадамцэцэг¹

¹ Нийслэлийн Шүүх шинжилгээний газар, Цагдаагийн дэслэгч

badamtsetseganbaatar@yahoo.com

Үндэслэл

Хэл яриа нь хүн төрөлхтний хамтран амьдрах оршихуйн тогтолцоонд чухал ач холбогдолтой төдийгүй, угсаатны онцлог шинж, хэв маягийг хадгалахаас гадна, нийгмийн харилцаанд голлох үүрэг гүйцэтгэхийн зэрэгцээ, хүний наад захын бүхий л хэрэгцээгээ хангахад хүртэл онцгой нөлөө үзүүлдэг зүйл юм. Үндсэн монгол хэлнээс салаалсан дохионы хэл гэх ойлголтын хувьд сонсгол, хэл ярианы бэрхшээлтэй хүний харилцааны эх үндэс болно. Монгол хэлний үгийн сан бүтэх өөрийн гэсэн арга, хэлбэртэй байдгийн адил дохионы хэлний сан өөрийн гэсэн аргатай.

Зорилго

Сонсгол, хэл ярианы бэрхшээлтэй этгээдийн биеийн хэлэмж нүүрний хувирлыг эрүүл сонсголтой хүнээс ялгаатайг тайлбарлах зорилгоор, мөн өнөөгийн хэрэглэж буй Монгол Улсын Эрүүгийн хуулийн хэрэглээнд тэдний онцлогт тохирсон зүйл заалтыг тусгуулах санал, зорилготойгоор энэхүү өгүүллийг бичлээ.

Судалгааны арга зүй

Баримт шинжилгээ болон туршилт судалгааны үр дүнг нэгтгэж дүгнэв.

Үр дүн

Сонсгол, хэл ярианы бэрхшээлийн хүний онцлог

Тэдний онцлог, биеийн хэлэмжийг, нүүрний хувирлыг энэ мэт шууд үзүүлэх цухас үйлдлээс ялгалгүйгээр андуурах тохиолдол гардаг бөгөөд сонсгол, хэл ярианы бэрхшээлтэй хүнийг ярианы / дохиогоор ярих/ үйлдлээр нь буруутгаж болох юм. Мөн сонсгол хэл ярианы бэрхшээлтэй хүн бичиг үсгийн мэдлэг, боловсрол 3 дугаар ангийн хүүхдийн хэмжээнд дийлэнх нь байх бөгөөд бичгийн хэлээр өөрсдийгөө бүрэн илэрхийлэх, үнэн зөв мэдээлэл өгөх боломж хангалтгүй байдаг. Хэвийн сонсголтой хүмүүс эргэн тойрон, орчны талаарх мэдээллийг өөрийн сонсголоор дамжуулан бүрэн ойлгож хүлээн авдаг бол сонсголын бэрхшээлтэй хүнд ийм боломж байдаггүй, танин мэдэхүй, бусад төсөөлөл нь сөргөөр нөлөөлөх хандлагатай байдаг. Сонсгол, хэл ярианы бэрхшээлтэй иргэд дохио зангаа, хүрэлцэх, чичиргээ, уруул, амны хөдөлгөөн, нүүрний хувирлаар орчинтой харилцаа үүсгэдэг. Аливаа төрлийн гэмт хэрэгт сонсгол, хэл ярианы бэрхшээлтэй хүн холбогдоход өөрийн бэрхшээлээс шалтгаалан шууд харьцах, анхан шатны мэдээлэл, тайлбарыг авч чадахгүй орхигдсон, мартагдсан, гадуурхагдсан мэдрэмжийг авсаар ирсэн. Өнөөдрийг хүртэлх хугацаанд гэмт хэргийн субъект болсон сонсгол, хэл ярианы бэрхшээлтэй этгээдэд хэрэглэж буй эрүүгийн хууль өнгөн талаас харахад энэрэнгүй, харж үзсэн байдлаар цаасан дээр буух авч практикаас харахад тэдний онцлогоос шалтгаантайгаар (судлаач Сансармаагийн судалгааны ажлын үр дүн нь хэдийгээр тэрээр сонсголгүй сурагчдын зан харилцааны доголдол, ганцаардмал, зожиг байдлын уг шалтгааныг эрэлхийлээгүй боловч Олон Улсын судалгааны үр дүнг баталгаажуулах ач холбогдолтой болжээ. Олон арван судалгаагаар дохионы хэлд эрт суралцаагүй болон гэр бүлийнхэн нь түүнтэй чөлөөтэй харилцаж чаддаггүй хүүхдүүд зан харилцааны доголдолтой, нийгэмшил, харилцаа, биеэ авч явах чадварын хувьд асуудалтай байхаас гадна өөртөө итгэлгүй, гутранги зан төлөв ажиглагдсан байдаг тухай дурдсан¹) орхигдуулсан, мартагдсан байдалтай байна.

Мөн сонсголын бэрхшээлтэй хүн хүний гаднах төрхөд хууртагдан төсөөллөөр хүртэх ба өөрт үүссэн сэтгэгдлийг өнгөцхөн нэг үгээр хязгаарлагдмал буулгаж нэрлэдэг. Энэ нь тэдний үгийн сангийн хомсдол, төсөөлөл, харьцах хүрээ хязгаарлагдмалтай холбоотой. Сонсголгүй хүн сэтгэл

¹ Намираа.Б “Сонсголын бэрхшээлтэй хүүхэд, түүний боловсрол” 2016 он 109 дүгээр тал

зүйн гутрал, нийгэмших, бие даах, өөртөө итгэлтэй байх чадвар зэрэг олон талаар бусдаас буюу эрүүл сонсголттой хүнээс дутуу, доголдолтой байдаг тул өөрт байхгүй зүйлээ өөр зүйлээр орлуулах буюу гэмт хэргийн субъект болох нь элбэг.

Хэдийгээр сонсгол, хэл ярианы бэрхшээлтэй хүмүүс оюун ухаан, бие махбодын хувьд хэвийн, эрүүл боловч наад захын харилцааны чадварыг бүрэн эзэмшээгүй, бичгийн хэлээр бусадтай бүрэн ойлголцох чадвар сул байдгаас үүдэн хэл, яриа, сонсголын бэрхшээлтэй иргэд нийгмийн харилцаанд идэвхтэй оролцох, өөрсдийгөө бүрэн ойлгуулах, таниулах байдал нь хязгаарлагдмал, зөвхөн хараагаар хүртэж аливаа зүйлийг хүлээн авч, зөв буруугийн заагийг ялгах чадвар сулаас шалтгаалан гэмт явдалд хөл тавьж байна. Хонгконгийн “Тэгш боломжийн хороо”-ноос 2022 оны 11 дүгээр сарын 15-ны өдөр “Сонсгол, хэл ярианы бэрхшээлтэй хүнд шүүхийн тогтолцоонд тэгш эрх олгох” удирдамж гаргаж, уг удирдамжийн дагуу “Сонсгол, хэл ярианы бэрхшээлтэй хүнтэй харилцах хуулийн мэргэжилтнүүдэд зориулан дохионы хэлээр гарын авлага” гарган үйл ажиллагаандаа нэвтрүүлсэн бөгөөд сонсгол, хэл ярианы бэрхшээлтэй хүмүүс хууль эрх зүйн үйл ажиллагааны явцад үл ойлголцол, харилцан ойлголцоогүйгээс болж хуулийн хүрээнд саад бэрхшээл учирдаг талаар дурдаж, тухайн удирдамжийг боловсруулан сонсгол, хэл ярианы бэрхшээлтэй хүнтэй харилцах зааварчилгааг өгч, шүүхийн үйл ажиллагаанд ашиглах, тохиромжтой нөхцөлийг санал болгосон байна. Тэгш боломжийн хорооны тэргүүн доктор Чу Чонгвэн энэхүү гарын авлага нь сонсгол, хэл ярианы бэрхшээлтэй хүмүүс, хуульч, өмгөөлөгч, шүүгч, шүүхийн ажилтнууд, хууль зүйн туслалцааны ажилтан, шүүхийн захиргааны ажилтан зэрэг хуульчдад зориулсан практик хэрэглүүр, мэдээллийн нөөцөөр хангах зорилготой юм хэмээн онцолсон бөгөөд уг удирдамжид сонсгол, хэл ярианы бэрхшээлтэй болон дохионы хэлний хэлмэртэй харилцахдаа урьдчилан сэргийлэх арга хэмжээ, ерөнхий зарчмуудыг тусгаж, сонсгол хэл, ярианы бэрхшээлтэй хүмүүстэй харилцахдаа анхаарал хандуулж, тэдэнтэй харилцахад төвөгтэй үг хэллэг хэрэглэхээс зайлсхийхийг уриалсан байна.²

Монгол Улсын хувьд Үндэсний статистикийн хорооноос гаргасан судалгааг түшиглэн гаргасан тоон баримтаас авч үзвэл сонсгол, хэл ярианы бэрхшээлтэй 13000 хүн бүртгэгдсэн байдаг бол тэдгээр иргэд нийгмийн харилцаанд оролцох нь бага байгаа тухай сонсгол, хэл ярианы бэрхшээлтэй хүний боловсролын талаар судалгааны ажил бичсэн судлаач нарын тодорхойлолт зэргээс үзэхэд сонсгол, хэл ярианы бэрхшээлтэй хүн гадаад орчинтой бусдын тусламжтайгаар холбогддог, төрөлхийн өөрсдийн бэрхшээлийн онцлогоос шалтгаалан хаагдмал хязгаарлагдмал, зөвхөн сонсгол, хэл ярианы бэрхшээлтэй иргэдтэй холбоотой, тэдний хүрээлэл мэдээлэл, зөв буруугийн хуулийн мэдлэггүй, бусдаар бодол, санаа, үгээ дамжуулдаг зэрэг нь тэднийг улам дотогшоо, нуугдмал байдалд оруулж байна.

Монгол Улсын Шүүхийн тогтолцоо, аль ч шатны шүүхэд сонсгол, хэл ярианы бэрхшээлтэй хүнд чиглэсэн онолын болоод практикийн хувьд тэдний онцлог, амьдралын хэвшил, биеийн хэлэмж зэргийг харгалзан бусад орны жишгийг судлан хэрэгжүүлсэн тохиолдол, сонсгол, хэл ярианы бэрхшээлтэй хүнд чиглэгдсэн үйл ажиллагааг нэвтрүүлээгүй, шууд бусдын адилаар тэдний онцлогийг тусгайлан авч үзэж, тэдний ялгаатай байдлыг харгалзан үзэлгүйгээр гэм бурууг тогтоон, ял оногдуулсаар байна.

Сонсгол, хэл ярианы бэрхшээлтэй хүн зөвхөн дохионы хэлээр харилцаж, ойлголцдог бөгөөд энэ хэл нь дохио, зангаа, нүүрний хувирал, биеийн хэлэмжээр илэрхийлэх үгээ бодитоор өөрийн бие дээр шууд үзүүлж, илэрхийлдэг.

Пол Экманы “Хүнийг нүүрний хувирлаар нь тодорхойлох арга”³ номд хүний нүүрний хувирлыг зураг, текст хэлбэрээр тайлбарлан бичсэн байх бөгөөд “айх, гайхах, жигших, зэвүүцэх, худлаа ярих, үл итгэх, гайхширах, баярлах, гуниглах” гэх мэт энгийн хүний сэтгэл хөдлөл, харилцааны үед гаргах реакцуудыг нэг бүрчлэн тоочиж бичсэнээс харахад энэ бүх үйл, хөдлөл, гаргаж буй нүүрний хувирал нь сонсгол, хэл ярианы бэрхшээлтэй хүмүүсийн хувьд эрс ялгаатай хүлээн зөвшөөрөх аргагүй юм.

Сонсгол, хэл ярианы бэрхшээлтэй хүн: Худал хэлэх, худалч гэх үгийг нүүрний хувирлаар ярвайж, нүдээ онийлгон, хамраа зангидаж, долоовор, дунд хуруугаар хамрын үзүүр дээр ээлжлэн

² ЭЕШ вэб сайт олон нийт “Удирдамж” дохионы хэл дээрх хувилбар ЕОС YouTube суваг 2022.11.15.

³ Пол Экман “Хүнийг нүүрний хувирлаар нь тодорхойлох арга” 2012 он.

хөнгөн товшиж дохиогоор илэрхийлдэг бол хулгайлах, хулгайч гэх үгийг нүдээ хурц болгон дух, хамраа үрчийлгэн хурдан хөдөлгөөнөөр нэг гарын 4 хуруунд эрхий хуруун завсар нөгөө гарын долоовор болон дунд хурууг хавчуулан огцом татаж авах, алах, алуурчин гэх үгийг илэрхийлэхдээ харгис, хэрцгий дүр гарган хөмхийгөө зууж, хөмсгөө зангидаж, нүдээ дүрлийлгэх нүүрний хувирал гарган 2 гарыг атган зангидаж, нэг нэгэн дээр нь давхарлан тавьж, эргүүлэх хөдөлгөөн үзүүлдэг.

Гэмт хэрэг үйлдсэн сонсгол, хэл ярианы бэрхшээлтэй этгээдийн нөхцөл байдал

Сонсгол, хэл ярианы бэрхшээлтэй хүний харилцах хүрээ хязгаарлагдмал, зөв буруугийн ялгаатай байдлын заагийн талаар ойлголтгүйгээс шалтгаалан өөрийн хувь ертөнцдөө амьдардаг бөгөөд хүний хувийн эд зүйл, бусдын биед халдах, гутаан доромжлох, өөрийн зөв гэж бодсон тохиолдолд түрэмгий үйлдэл гаргахаа хэвийн зүйл мэт хүлээн авах нь элбэг.

Сонсгол, хэл ярианы бэрхшээлтэй хүн огцом ууртай, биеэ барих чадваргүй, нийгэмшээгүй, хязгаарлагдмал ойлголттой, автамтгай, итгэмтгий гэх мэт маш олон хүчин зүйлээс шалтгаалан гэмт хэргийн субъект болсоор иржээ.

Сонсгол, хэл ярианы бэрхшээлтэй хүний зүгээс үйлдэгдэж буй гэмт хэрэг ихэвчлэн өөрсдийгөө хамгаалах байдалд үйлдэгдэж, тэдний бэрхшээлийн талаар ямар нэгэн ойлголт хомс зэрэг шалтгаанаас үүдэлтэйгээр субъектив шинж нь өөрөө эргээд эдгээр хүмүүсийг үл хайхрах, үл тоох, мартаж мэт хандлагаар ханддагаас шалтгаалан, мөн хөгжлийн хоцрогдол, ялгаатай байдал нь нөлөөлж байна.

Дүгнэлт

Гэмт хэрэгт тодорхой байдлаар холбогдсон сонсголтгүй, насанд хүрээгүй 4 хүүхэд, гэм буруутай байдал нь тогтоогдон шүүхээс хорих ял шийтгүүлсэн 2 хоригдолд ажиглалт, ярилцлагын аргыг хэрэглэхэд: гэмт хэрэг үйлдсэн сонсгол, хэл ярианы бэрхшээлтэй хүний онцлогийг илүүтэйгээр нээн ойлгуулж, гэмт хэрэг үйлдэх үеийн сэтгэл хөдлөлийн үед гаргах төрх, гэмт хэрэг үйлдсэний дараах байдлыг сэтгэл зүйч, нүүрний хувирлын байдлаар тодорхойлох арга манай улсад нэвтрүүлэх шаардлагыг үүсгэж байгаагаас гадна эрүүгийн эрх зүйн орчин энэ төрлийн бэрхшээлтэй хүмүүст бүрдээгүй байна.

Түлхүүр үг: *Тэгш хамран сургах боловсрол, мэргэжлийн бүлэг, сэтгэл зүйн тест.*

Ашигласан материал:

1. Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хууль. Монгол Улс, Улаанбаатар хот.
2. Намираа.Б (2016). “Сонсголын бэрхшээлтэй хүүхэд, түүний боловсрол” (ху.109). Монгол Улс, Улаанбаатар хот.
3. ХБХХЕГ (2022). *Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газрын 2022 оны судалгаа.* Монгол Улс, Улаанбаатар хот.
4. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар (2021). *Сургалт, нийгэм, сэтгэл зүйн хэлтсийн хөгжлийн бэрхшээлтэй хоригдлын 2021 оны жилийн эцсийн судалгаа.* Монгол Улс, Улаанбаатар хот.
5. ЭЕШ вэб сайт олон нийт “Удирдамж” дохионы хэл дээрх хувилбар ЕОС YouTube суваг /2022.11.15/
6. Пол Экман (2012). *Хүнийг нүүрний хувирлаар нь тодорхойлох арга.* Монгол Улс, Улаанбаатар хот.

ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮМҮҮСТ ХУУЛЬ ЗҮЙН ТУСЛАЛЦАА ҮЗҮҮЛЖ БУЙ ХЯТАД УЛСЫН ҮНДЭСНИЙ ТОГТОЛЦОО БА ТУРШЛАГА

А.Хандмаа LL.M¹

¹ Их Засаг ОУИС-ийн Их Засаг хууль зүйн сургууль,
Эрх зүйн тэнхимийн ахлах багш
khandmaa@ikhzasag.edu.mn

Үндэслэл

Манай улсад 2022 онд Хууль зүйн туслалцааны тухай хуулийг батлан гаргаж, хууль зүйн туслалцааг үнэ төлбөргүй авах хүн, хууль зүйн туслалцаа үзүүлэх тогтолцоог бүрдүүлсэн боловч тус хуулийн 4-р зүйлд үйлчлүүлэгч буюу гэмт хэргийн хохирогч, гэмт хэргийн гэрч хүүхэд, ахмад настан, хөдөлмөрийн чадвараа бүрэн алдсан хүн, олон хүүхэдтэй өрх толгойлсон эх, эцэг хууль зүйн туслалцааг авч болохоор тусгасан боловч энэ хэсэгт хөгжлийн бэрхшээлтэй хүн хууль зүйн туслалцаа талаар тусгаж оруулаагүй нь учир дутагдалтай байна.

Зорилго

Монгол улсын найрамдалт хөрш Хятад улсын туршлага тогтолцоог холбогдох эх сурвалжид тулгуурлан судлан үзэх нь цаашид хууль зүйн туслалцааны хууль тогтоомжийг илүү боловсронгуй болгоход чиглэнэ.

Судалгааны арга зүй

Хятад улсын хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн хууль зүйн туслалцаа авах эрхийг хуулийн дагуу хамгаалах, хууль зүйн туслалцаа үзүүлж буй байгууллагын үйл ажиллагаа, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст хууль зүйн туслалцаа үзүүлэхэд төрөөс тавих хяналтын систем, хууль зүйн туслалцаа үйлчилгээний хүртээмжийг сайжруулах талаар гүнзгийрүүлэн авч судлалаа.

Үр дүн

Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст хууль зүйн туслалцаа үзүүлэх, хууль ёсны эрх ашиг сонирхлыг хуульчид, өмгөөлөгчид шүүхэд төлөөлөх нийтлэг асуудлын хүрээнд судлах нь зайлшгүй асуудал юм. Дээрх асуудлын хүрээнд хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай НҮБ-ын конвенцын зарчмуудыг судлах явцад хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн хувьд хүрээлэн буй орчин, мэдээлэл, холбоо харилцааны технологи, нийтэд нээлттэй үйлчлэх буюу зориулагдсан бусад төрлийн объект, үйлчилгээг тэгш хүртээмжтэй байхад чиглэсэн байна.

Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст үзүүлэх хууль зүйн туслалцаа үзүүлэх тогтолцоо нь төлбөрөө төлөх чадваргүй эсвэл бүрэн төлж чадахгүй байгаа санхүүгийн бэрхшээлтэй хүмүүст зориулсан хууль зүйн туслалцааны талаарх үндэсний тогтолцоо юм. Энэхүү агуулга нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн хууль ёсны эрх, ашиг сонирхлыг хамгаалах зорилгоор өмгөөллийн үйлчилгээний төлбөр төлж буй хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд хөнгөлөлттэй уян хатан нөхцөлөөр хууль зүйн туслалцааг үзүүлдэг шүүхийн процесс ажиллагааны явцад үзүүлж тусламжийн тогтолцоо юм. Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай НҮБ-ын Ерөнхий Ассамблейгаас 1975 онд батлан тунхагласан бөгөөд “хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс эд хөрөнгөө хамгаалах, өмчлөх эрхтэй холбоотой хууль ёсны эрх ашиг сонирхол хөндөгдсөн тохиолдолд мэргэшсэн хуульчдаас тусламж авах боломжтой байх ёстой,” талаар тусгаснаас гадна хэрэв хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст хуулийн дагуу эрүүгийн хэрэгт холбогдсон бол тэдгээр хүмүүсийн бие махбодын болон сэтгэцийн эрүүл мэндийн нөхцөл байдлыг бүрэн харгалзан үзэх ёстой.

Дүгнэлт

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд хууль зүйн туслалцаа үзүүлэх нь төрийн үүрэг боловч нийгмийн оролцоог дайчлах нь бүх талууд хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст хууль зүйн туслалцаа үзүүлэхийн тулд өмгөөлөгч, хуульчид хууль зүйн туслалцаа үйлчилгээний байгууллагуудыг нэгдмэл шинжээр дэмжлэг үзүүлж ажиллах нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст хууль зүйн туслалцаа үзүүлэх тогтолцоог илүү боловсронгуй болгох төрийн бодлогоор дэмжихэд чиглэх тусгай бүлэгт хууль зүйн туслалцааг жигд хүртээмжтэй болгоход чухал ач холбогдолтой юм.

Манай улсын хувьд хууль зүйн туслалцааны тухай хууль батлагдан хэрэгжиж байгаа боловч хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст хууль зүйн туслалцаа үйлчилгээ үзүүлэх талаар тусгаж оруулаагүй байгаа нь учир дутагдалтай байгааг анхааран үзэж хууль зүйн туслалцааны хуулийн хэрэгжилтийг боловсронгуй болгоход хуульчид судлаач өргөн цар хүрээтэй судлан үзэх нь цаг үеийн тулгамдсан асуудал болоод байна. БНХАУ-ын хувьд хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст нийтлэг шинжээр зориулагдсан бие даасан эрх зүйн хэм хэмжээг боловсруулан гаргасан нь чухал ач холбогдолтойг нарийвчлан судлан сайн туршлагыг өөрийн улсын хууль тогтоомжийг боловсронгуй болгох эрх зүйн ач холбогдолтой юм.

Түлхүүр үг: Хөгжлийн бэрхшээлтэй хүн, хууль зүйн туслалцаа үзүүлэх.

Ашигласан материал:

1. Xiang Zicheng (2003). *Historical Review of Legal Issues on the Protection of Disabled Persons in China*. Beijing: China Legal Publishing House.
2. Zhang Geng (2007). *Comparative study of legal aid systems*. China, Beijing: Law Press.
3. Li Xuekuan, Hu Yuxia (2011). State responsibility in the modern legal aid system. *Modern Law*, 5.
4. Олон Улсын Хөдөлмөрийн Байгууллага (2015). “Мэргэжлийн сургалтад хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн оролцоог хангах практик” гарын авлага. Монгол Улс, Улаанбаатар хот.
5. Сун Жэньжун (2019). Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст үзүүлэх хууль зүйн туслалцааны үнэлэмж, чиг хандлага, *Улс төр, хууль зүйн онол арга зүйн сэтгүүл*, 1.
6. Хууль зүйн туслалцааны тухай хууль (шинэчилсэн найруулга). Монгол Улс, Улаанбаатар хот.
7. БНХАУ-ын Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль.
8. БНХАУ-ын Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хамгаалах тухай хууль.



IV БҮЛЭГ

ЭРҮҮЛ МЭНД

АУТИЗМЫН ХҮРЭЭНИЙ ЭМГЭГТЭЙ ХҮҮХДИЙН “НИЙГМИЙН ХАРИЛЦААНЫ ХЭВ ШИНЖ”-Г ҮНЭЛЭХ НЬ

С.Сувдмаа¹, Б.Дорждэрэм²

¹ ХБХСЗХТөв, Сэргээн засахын эмч, ² Сэтгэл зүйч

Suvdmaasuvdmaa14@gmail.com

Үндэслэл

Аутизмын хүрээний эмгэг (ASD) нь ихэвчлэн нийгмийн харилцааны алдагдал болон давтагдмал үйлдэл, хязгаарлагдмал зан төлөвийн хэв шинжүүд хавсарсан байдлаар илэрдэг мэдрэлийн хөгжлийн эмгэг юм (APS, 2013). Сүүлийн 50 жилийн тархвар зүйн судалгаануудаас үзэхэд Аутизмын хүрээний эмгэг маш эрчимтэй өсөх хандлагатай байна. Олон улсад энэхүү эмгэгийн тохиолдлын өсөлтийг үнэлгээ, оношилгооны хэрэглэгдэхүүн сайжирсантай холбон тайлбарлаж байна. Аутизмын хүрээний эмгэгийг хэдий чинээ эрт оношлон төдий чинээ үр дүнтэй, тохирох арга хэмжээ авч хэрэгжүүлэх боломжтой гэж судлаачид үздэг. Тиймээс улс орон болгон өөрсдийн нөхцөл байдал, соёлын онцлогтоо тохируулан шаардлагатай үнэлгээ, оношилгооны арга хэрэгслийг боловсруулсаар байна. Монгол улсад одоогоор Аутизмтай хүүхдийн нийгмийн харилцааг оношлох, үнэлэх үнэлгээний арга аргачлал, хэрэглэгдэхүүн хомс байгаагаас гадна энэ чиглэлээр судалгаа хийгдээгүй байгаа нь энэхүү судалгааг хийх үндэслэл боллоо.

Зорилго

Аутизмын хүрээний эмгэгийг илрүүлэх, оношлоход “Нийгмийн харилцааны асуумж” буюу Social Communication Questionnaire (SCQ)-г ашиглан монголын нөхцөлд сэтгэц хэмжил зүйн анхан шатны тооцоолол хийн үнэлгээний найдварт чанар, мэдрэг болон өвөрмөц чанарыг тогтоох, улмаар бусад хүчин зүйлсийн нөлөөг тодруулах.

Судалгааны арга зүй

Бид “Нийгмийн харилцааны асуумж”-г ашиглан Аутизмын хүрээний эмгэгтэй гучин хоёр (n=32) хүүхэд болон хэвийн хөгжиж буй хорин (n=20) хүүхдийн эцэг эхийг оролцуулан хийсэн. Асуулгын сэтгэц – хэмжил зүйн найдварт чанарыг тогтоохдоо Cronbach alpha-г, асуулгын мэдрэг болон өвөрмөц чанарыг тогтооход ROC шинжилгээний аргыг ашиглан өмнөх судалгааны үр дүнгүүдтэй харьцуулав.

Үр дүн

Аутизмын хүрээний эмгэгтэй хүүхдүүдийн Нийгмийн харилцааны асуулгын нийт оноо нь энгийн хүүхдүүдээс илт өндөр байгааг бид илрүүлсэн ($p < 0.001$) ба SCQ асуумжийн найдварт чанар ($\alpha = 0.82$), харин мэдрэг чанар нь 0.96, өвөрмөц байдал нь 0.86 гарсан.

Дүгнэлт

Энэхүү туршилтын судалгаагаар бид “Social Communication Questionnaire”-г 3–6 насны Аутизмын хүрээний эмгэгийн эрсдэлтэй хүүхдүүдийг оношлоход үр дүнтэй ашиглаж болохыг харууллаа. Цаашдын энэхүү асуумжийг Монголын нөхцөлд албан ёсоор нутагшуулах буюу адаптаци хийж илүү олон түүвэр хамруулан системтэй судлахыг зорьж байна.

Түлхүүр үг: Аутизмын хүрээний эмгэг, Нийгмийн харилцааны асуумж (SCQ), мэдрэг чанар, өвөрмөц байдал.

Ашигласан материал

1. American Psychiatric Association (2013). *Diagnostic and Statistical Manual of Mental Disorders DSM-5*. USA.
2. Mohammed Aldosari, Eric Fombonne, Hesham Aldhalaan, Mohammed Ouda, & Saba Elhag (2019). *Validation of the Arabic version of the Social Communication Questionnaire*.
3. Rutter M, Bailey A, & Lord C (2003). *The Social Communication Questionnaire (SCQ)*. Los Angeles: Western Psychological Services.
4. Berument SK, Rutter M, & Lord C (1999). Autism screening questionnaire: Diagnostic validity. *The British Journal of Psychiatry*.
5. Themis Karaminis & Stavroula Stavrakaki (2022). *The psychometric properties of the Greek version of the Social Communication Questionnaire*.

АУТИЗМТАЙ ХҮҮХДИЙГ ДЭМЖИХ ҮЙЛ АЖИЛЛАГАА

Б.Анхмаа, Ё.Ууганбаяр¹

¹ Нийслэлийн 263 дугаар цэцэрлэг
unafunny9@gmail.com

Үндэслэл

Тэгш хамруулах боловсрол нь хувь хүний онцлог хэрэгцээ шаардлагад нийцсэн нэмэлт дэмжлэг үзүүлэх замаар бүх хүүхдийг хамтдаа суралцах боломжтой болгодог. Хүүхэд бүрийн чанартай боловсрол эзэмших эрхийг хангах үүрэг хариуцлагын хүрээнд хөгжлийн ялгаатай хэрэгцээтэй хүүхдүүд үе тэнгийнхэнтэйгээ мөр зэрэгцэн суралцах замаар боловсрол эзэмших боломжийг бүрдүүлэх тогтолцоог дэмжиж байгаа билээ. Зарим боловсролын байгууллагын багш, ажилтан, эцэг, эх, асран хамгаалагчид хөгжлийн ялгаатай хэрэгцээтэй хүүхдүүдийг ердийн сургуулийн өмнөх боловсролын байгууллагад суралцуулах тохиолдолд тэд тусгай мэргэжлийн багш хичээл заах сургалтад хамрагдахгүй эсвэл нэг ангид хамтдаа суралцаж буй бусад хүүхдийн суралцахуйд сөрөг нөлөө үзүүлж болзошгүй гэж үздэг. Гэвч сайтар зохион байгуулалт бүхий тэгш хамруулах боловсролын үйлчилгээ нь хөгжлийн ялгаатай хэрэгцээтэй хүүхдүүд болон тэдэнтэй хамтдаа суралцаж буй бусад хүүхдүүдийн аль алиных хувьд ашиг тустай байдаг гэдгийг баталсан баримт нотолгоо нэмэгдсээр байна. Иймд тус цэцэрлэгт хамрагдсан хөгжлийн ялгаатай хэрэгцээтэй (аутизмын хүрээний эмгэгтэй) хүүхдийг ажиглан, хүүхдийн хөгжлийг дэмжих, хөгжлийн хоцрогдлыг багасгах зорилгоор энэхүү судалгааг хийсэн.

Зорилго

Аутизмын хүрээний бэрхшээлтэй хүүхдийн бие бялдар, хэл яриа, танин мэдэхүй, нийгэмшихүйн хөгжлийг дэмжих.

Судалгааны арга зүй

Аутизмын оношилгооны стандарт (DSM) “Сэтгэцийн эмгэгийн ангилал, оношилгооны гарын авлага (Diagnostic and Statistical Manual of Mental Disorders: DSM)” гэдэг нь АНУ-ын сэтгэцийн эмч нарын холбооны (American Psychiatric Association) боловсруулсан сэтгэцийн эмгэгийг оношилдог стандарт юм. Судалгаанд оролцогчийг Монголын хүүхдийн хөгжлийн түргэвчилсэн сорил “Морбас”-ыг ашиглан үнэлсэн. Энэхүү судалгаанд хамрагдаж буй хүүхэд DSM-V дахь Аутизмын оношилгооны стандарт 299.00 (F84.0) оношилгооны Түвшин 3 дэмжлэг шаардлагатай хүүхэд юм.

Судлуулагч Э хүүхэд 51 сартай. 2022 оны 08 дугаар сард цэцэрлэгийн элсэлт, бүртгэлийн үеэр хүүхдийн хөгжлийн тухай ярилцаж ээжээс мэдээлэл өгсөн.


Хүснэгт 1. Үйл ажиллагаа (2022 оны 09 дүгээр сараас 2023 оны 05 дугаар сар)

Хийгдэх үйл ажиллагаа	IX сар	X сар	XI сар	XII сар	I сар	II сар	III сар	IV сар	V сар
Ажиглалт									
Судалгаа 1									
Дэмжих үйл ажиллагаа									
Судалгаа 2									
Дэмжих үйл ажиллагаа									

Үр дүн

Судалгаа 1, 2 харьцуулахад 34%, судалгаа 2, 3 харьцуулахад 16%-иар нэмэгдсэн. Эхний судалгааны дараах хөгжлийн үзүүлэлт эрчимтэй нэмэгдсэн боловч судалгаа 2-оос хойш хүүхдийн үзүүлэлт бага зэрэг удаашралттайгаар хөгжсөн. Гэвч хүүхдийн хөгжил тасралтгүйгээр хөгжиж байгаа нь харагдаж байна.

График 1. Судалгааны үр дүнгийн харьцуулалт



Дүгнэлт

Цэцэрлэгт хамрагдсан эхний саруудад хүүхдийн дадал хэвшил, нийгэм сэтгэл зүйн хөгжил нь эрчимтэй ахисан байгаа нь судалгаа 1, 2 харьцуулсан графикт харагдсан. Энэ нь цэцэрлэгийн өдөр тутмын үйл ажиллагаанд хүүхдийг тэгш хамруулах дэмжих үйл ажиллагааг идэвхтэй зохион байгуулсны үр дүн гэж үзэж байна.

Судалгаа 2, 3 харьцуулсан судалгааны үр дүнд том, жижиг булчингийн хөгжил, хэл ярианы хөгжлүүд нь ахиц өндөртэй байхад өмнөх судалгааны хамгийн их ахицтай байсан дадал хэвшил, нийгэм сэтгэл зүйн хөгжил нь хамгийн бага ахиц үзүүлсэн.


Эхний судалгааны дараах хөгжлийн үзүүлэлт эрчимтэй нэмэгдсэн боловч судалгаа 2-оос хойш хүүхдийн үзүүлэлт бага зэрэг удаашралтайгаар хөгжсөн. Энэ нь хүүхэд шинэ орчинд дасан зохицох үйл явц эхний саруудад эрчимтэй байсныг илтгэж байна. Энэхүү судалгааны явцад судлуулагч хүүхдийн жижиг булчингийн хөгжил хамгийн ихээр ахицтай байхад том булчингийн хөгжил хамгийн бага ахиц үзүүлсэн. Хүүхэд шатны өөд, уруу бие даан алхаж чаддаггүй байсан бол шатны бариулын тусламжтайгаар шатаар алхаж чаддаг болсон. Живх хэрэглэдэг байсан живх хэрэглэхээ больж бие засах гэж буйгаа дуу авиагаар илэрхийлдэг болсон. Халбага, аягыг хэрэглэн бие даан хооллож чаддаггүй байсан боловч бие даан халбага, аяга хэрэглэн, хооллох оролдлогыг маш сайн хийдэг болсон. Багшийн зааврыг ойлгодог болж, ангид баримтлах дүрэм журмыг мэддэг болсон. Аутизмын хүрээний эмгэгтэй судлуулагч Э-ийн ангийн хүүхдүүд эхлээд гайхаж хүлээн авдаг байсан бол өдөр тутмын үйл ажиллагаанд хамтдаа оролцсоноор судлуулагчийг анхааран дэмжлэг үзүүлж, бусдаас өөр гэж үзэлгүй бүлгийн нэг хүүхэд хэмээн хүлээн зөвшөөрч, бүлгийн эцэг эх, асран хамгаалагч нарт эерэг хандлага бий болсон.

Түлхүүр үг: Тэгш хамруулах боловсрол, хөгжлийн ялгаатай хэрэгцээ, хөгжлийн дэмжлэг, ахиц.

Ашигласан материал:

1. Дэлхийн эрүүл мэндийн байгууллага (2015). *Бага насны хүүхдийн хөгжил, хөгжлийн бэрхшээл, асуудал дэвшүүлсэн тайлан*. Монгол Улс, Улаанбаатар хот: Нээлттэй Форум сан.
2. Жайка олон улсын байгууллага (2021). *Аутизмын хүрээний бэрхшээлийн тухай ойлголт*. Монгол Улс, Улаанбаатар хот.
3. Жайка олон улсын байгууллага (2021). *Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй ажиллах арга зүйн гарын авлага*. Монгол Улс, Улаанбаатар хот.
4. Кимико, Т (2019). *Хүүхэд бүрийн хөгжлийг дэмжих аргазүй*. Монгол Улс, Улаанбаатар хот.
5. Кимико, Т (2018). *Юуны чимээ вэ?*. Монгол Улс, Улаанбаатар хот.
6. Кимико, Т (2018). *Гол дагаад явцгаая*. Монгол Улс, Улаанбаатар хот.
7. Монгол улсын боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яам (2019). *Сургуулийн өмнөх боловсролын сайжруулсан сургалтын хөтөлбөр*. Монгол Улс, Улаанбаатар хот.

График 2. Судалгааны үр дүнгийн харьцуулалт



ҮГЭЭРЭЭ ЯРИХ ЧАДВАР МАШ БАГА ЭСВЭЛ БАЙХГҮЙ АУТИЗМТАЙ ХҮҮХДҮҮДИЙН ХЭЛ ЯРИАГ ХӨГЖҮҮЛЭХЭД “МИНИЙ ХООЛОЙ” ХЭЛ ЯРИАГ ОРЛУУЛАХ, ХӨГЖҮҮЛЭХ АППЛИКЕЙШНИЙГ ХАВСРУУЛАН АШИГЛАСАН СУДАЛГААНЫ ДҮН

М.Нандинхүслэн¹, Ч.Сүрэнжав^{1,2}, А.Долгорлхам^{1,2}, Б.Солонго^{1,3,4}

¹ Аутизм ба Бусад Онцгой Хүүхдүүдийн Академи, ² Сэтгэл зүйч, Зан үйл засалч,

³ Хүний их эмч, Хөгжлийн эмгэг ба тэгш хамруулах боловсролын мэргэжилтэн,

Зан үйл засалч, Колумбын Их Сургуулийн төгсөгч, ⁴ Төслийн удирдагч

autismacademy.mn@gmail.com

Үндэслэл

Аутизмын хүрээний эмгэгийн (АХЭ) нь хүүхдийн хэл яриа, харилцааны бэрхшээлээр голчлон илэрдэг хөгжлийн эмгэг юм. Сүүлийн жилүүдэд АХЭ эрчимтэй нэмэгдэж байгаа бөгөөд ДЭМБ-ын 2023 оны тоо баримтаар дэлхий дахинд 100 хүүхэд тутамд 1 хүүхэд АХЭ-тэй төрж байна δ гэсэн тоо баримт байдаг ба дэлхийн өндөр хөгжилтэй улс орнуудад дээрх тохиолдол улам өндөр байдаг. Аутизмтай хүүхэдтэй гэр бүлүүдийн хувьд хүүхдээ үгээрээ яриулж сургах нь хамгийн чухал хэрэгцээ нь байдаг боловч харамсалтай нь олон улсын хэмжээнд аутизмтай хүүхдүүдийн 30% орчим нь олон жилийн хугацаанд эрчимтэй сургалт, зан үйл засалд хамрагдсан хэдий ч үгээрээ ярих чадвар маш бага эсвэл байхгүй хэвээрээ үлддэг α бөгөөд АХЭ-тэй хүүхэд 5 нас хүртлээ үгээрээ ярьж сураагүй бол цааш үгээрээ ярьж сурах магадлал маш бага буюу 1% хүрдэггүй β гэдгийг тогтоосон ба үгээрээ ярих чадвар маш багатай хүүхдүүдийн 90% орчим нь уншиж бичиж суралгүйгээр насанд хүрч байна γ гэсэн харамсалтай судалгаа байдаг. Иймд АХЭ-тэй үгээрээ ярих чадвар маш бага эсвэл байхгүй хүүхдүүдийн хэл яриаг хамгийн үр дүнтэйгээр хөгжүүлдэг АВА терапи болон ААС технологийг өргөн нэвтрүүлэх хэрэгцээ шаардлагатай байна.

Зорилго

Үгээрээ ярих чадвар маш бага эсвэл байхгүй аутизмын хүрээний эмгэгтэй хүүхдүүдэд ААС технологийн “Миний хоолой” хэл яриаг орлуулах болон хөгжүүлэх аппликейшнийг зан үйл засалтай хавсруулан хэрэглэснээр хэл яриа хөгжиж, уншиж бичих академик чадвар нэмэгдэж байгаа эсэхийг тодорхойлох зорилгоор энэхүү судалгааг хийв.

Судалгааны арга зүй

Судалгаанд зан үйл засалд эрчимжүүлсэн байдлаар 3 сараас дээш хугацаанд хамрагдсан боловч үгээрээ ярих чадварыг илтгэх шинжүүд илрэхгүй байсан нийт 11 хүүхдийг хамруулан 2022 оны 1 сараас 2023 оны 10 сарын хооронд Монгол улсын Аутизм ба Бусад Онцгой Хүүхдүүдийн Академийг түшиглэн даган судлах аргаар гүйцэтгэж үр дүнг боловсруулсан.

Судалгаанд хамруулах шалгуур:

- 1) Зан үйл засалд хамрагдаад хөдөлгөөн дуурайж сурсан боловч үгээрээ ярих чадвар байхгүй байдал 1-ээс дээш сар үргэлжилсэн
- 2) Зан үйл засалд хамрагдаад хөдөлгөөн, үг дуурайж чадах боловч үгээрээ ярих чадвар маш бага байдал 1 ба түүнээс дээш хугацаанд үргэлжилсэн хүүхдүүд

Судалгааг “Миний хоолой” хэл яриаг орлуулах болон хөгжүүлэх хэрэглэхээс өмнөх зан үйл заслын үр дүнг хавсруулан хэрэглэсэн үр дүнтэй харьцуулан судалсан.

Үр дүн

Судалгаанд хамрагдсан хүүхдүүдийн дундаж нас = 5.7 стандарт хазайлт SD= 1.76 насны хамрах насны хүрээ Range = 3–9 нас, хүйсийн харьцаа эр 82% (9), эм 18% (2) байсан. Судалгаанд оролцогчдын 45% (5) нь огт үгээрээ ярих чадваргүй, 55% (6) нь үгээрээ ярих чадвар маш бага түвшинд байсан.

Зан үйл засалд хамрагдахаас өмнөх (А үе гэх), Академийн зан үйл засалд хамрагдах үеийн (Б үе гэх) болон Ярианы аппликейшн хавсран хэрэглэх үеийн (В үе гэх) чадварын харьцуулан үзэхэд А үед нийт хүүхдүүдийн 18% нь хөдөлгөөн дуурайх болон үг хэлэх чадвартай боловч 0% нь бусдын тусламжгүйгээр 5-аас дээш үг чадвар үзүүлсэн. Б үед хүүхдүүд 100% хөдөлгөөн дуурайх чадвар

нь хөгжиж, 54% нь үг хэлэх чадвар хөгжсөн боловч 0% нь бусдын тусламжгүйгээр 5-аас дээш үг хэлэх чадвартай байсан. В үед хөдөлгөөн дуурайх чадвар бүх хүүхдүүдэд буюу 100% хөгжсөн, 90% нь үг хэлэх чадвар хөгжиж, 81% нь бусдын тусламжгүйгээр 5-аас дээш үг чадвартай болсон.

Академийн зан үйл заслыг ярианы аппликейшн хавсран хэрэглэх үеийн чадвар болон хэлсэн үгийн тоог хугацаагаар харьцуулан судлахад нийт хүүхдүүдийн 36% (4) нь 1 сарын дотор үг ярьж эхэлсэн, 81% (9) нь 1–3 сарын дотор үг ярьж эхэлсэн. Харин 3-аас дээш сар зан үйл заслыг ярианы аппликейшн хавсран хэрэглэсний дараа нийт хүүхдүүдийн 18% нь ярианы аппликейшн хэрэглэх шаардлагагүйгээр өөрөө ярьж эхэлсэн бөгөөд 27% нь үгийн баялаг 300%-иас дээш нэмэгдсэн. Судалгаанд хамрагдсан 6-гаас дээш насны сургуулийн насны хүүхдүүд Унших чадвар (Үсэглэж унших, Үелж унших, бүтэн үгээр унших), Бичих чадвар (Үсэг бичих, Үе бичих, Бүтэн үг бичих) ярианы аппликейшн хэрэглэхээс өмнө 0% байсан бол аппликейшн хэрэглэсний дараа 100% (3) амжилттай уншиж бичиж сурсан.

Дүгнэлт

- 1) Үгээрээ ярих чадвар байхгүй бүх насны хүүхдүүдийн ихэнх буюу 82% нь зан үйл засалтай хамт Ярианы аппликейшн хавсруулсан хэрэглэхэд 2 сарын дотор үг хэлж эхэлсэн нь богино хугацаанд үр дүнгээ өгч эхэлж байгааг харуулж байна.
- 2) Ярианы аппликейшнийг 3-аас дээш сарын хугацаанд хэрэглэсэн хүүхдүүдийн 67% нь үгээрээ ярих чадвар хангалттай сайжирч, цаашид ярианы аппликейшн хэрэглэх шаардлага багасаж өөрийн хоолойгоор ярьдаг болсон нь тууштай үргэлжлүүлэн хэрэглэсэн байдал хэл ярианы хөгжилд шууд хамааралтай харуулж байна.
- 3) Судалгаанд хамрагдсан 6-гаас дээш насны үгээрээ ярих чадвар багатай хүүхдүүд 100% (3) амжилттай уншиж бичиж сурсан нь сургуулийн насны хүүхдүүдэд ч зан үйл заслыг ярианы аппликейшнтэй хавсран хэрэглэх боломжийг харуулж байна.
- 4) Олон улсад ч бага үр дүнтэй байдаг хожуу үеийн буюу 5 наснаас хойш үгээрээ ярьж сурах магадлал маш багатай хүүхдүүдийн 80%-д үг хэлэх чадвар гарч ирж байгаа нь манай судалгааны үр дүн олон улсын түвшнээс ч өндөр байгаа нь Зан үйл заслыг Ярианы аппликейшнтэй хавсруулан хэрэглэсэн байдал болон Академийн хөтөлбөр аргачлалтай хамааралтай гэж урьдчилан таамаглаж байгаа ч цаашид энэ төрлийн судалгааг эрчимжүүлж, манай улсад үгээрээ ярих чадвар багатай зан үйл засалд хамрагдаж байгаа хүүхдүүдэд ярианы аппликейшнийг ашиглан хэл яриаг эрчимтэй хөгжүүлэх боломж байгааг энэхүү судалгаанаас дүгнэж байна.

Санал зөвлөмж:

Дараах тохиолдлуудад Зан үйл заслыг Миний Хоолой ярианы аппликейшнтэй хавсруулан хэрэглэх нь өндөр үр дүнтэй байна.

- 1) Хөдөлгөөн дуурайх чадвар гарч ирсэн боловч үгээрээ ярих чадвар байхгүй эсвэл маш бага хэвээр байгаа хүүхдүүдэд үгээрээ ярих чадварыг үр дүнтэй хөгжүүлэхийн тулд,
- 2) Ярианы аппликейшн шаардахгүйгээр хангалттай сайн хэл яриаг хөгжүүлэхийн тулд эрт зан үйл засал буюу 5-аас доош насанд
- 3) Сургуулийн насны үгээрээ ярих чадвар багатай хүүхдүүдийг амжилттай уншуулж бичүүлж сургахад.

Түлхүүр үг: Аутизм, хэл яриаг орлуулах технологи, ярианы аппликейшн, зан үйл засал, миний хоолой апп.

Ашигласан материал:

1. Tager-Flusberg. H & Kasari. C (2013). *Minimally verbal school-aged children with autism spectrum disorder: the neglected end of the spectrum*. Autism Res.
2. Pickett A, Pullara O, O’Grady J., & Gordon B (2009). Speech acquisition in older nonverbal individuals with autism: A review of features, methods and prognosis. *Cognitive Behavioral Neurology*, 22(1), 1–21.
3. Foley, B.E & Wolter, J. (2010). Literacy intervention for transition-aged youth: What is and what could be. In D.B. McNaughton & D.R. Beukelman (Eds.), *“Transition strategies for adolescents and young adults who use AAC”* (pp. 35–68). Baltimore: Paul H. Brookes Publishing Co.
4. Zeidan. J et al. (2022). Global prevalence of autism: A systematic review update. *Autism Research*.

ТАРХИНЫ СААТАЙ ХҮҮХДИЙН БУЛЧИНГИЙН ЧАНГАРЛЫГ ЦОХИЛТОТ ДОЛГИОНООР ЭМЧИЛСЭН ҮР ДҮН

Х.Туул, С.Сувдмаа, Б.Бат-Уянга¹, Ц.Наранцэцэг, А.Балжинням²

¹ Хөгжлийн бэрхийлэлтэй хүүхдийн сэргээн засах хөгжлийн төв

² АШУУИС АУС СЗАУТ

amd22e329@gt.mnnums.edu.mn

Үндэслэл

Тархины саа (ТС) нь хүүхдийн мэдрэлийн тогтолцооны пренаталь эмгэгийн дотор хамгийн элбэг тохиолддог, тархины хөгжлийн эрт үеийн гэмтлээс үүдсэн байршлын болон хөдөлгөөний өөрчлөлтийн бүлэг хамшинжээр илэрдэг эмгэг юм¹⁻³. Тархины саагийн тархалт Монголд 1000 амьд төрөлтөд 1.89 тохиолддог. Тархины саагийн эмнэл зүйн хэлбэрүүдээс булчин чангаралтай хэлбэр 70–80% тохиолддог⁷. Сүүлийн үед судлаачид цохилтот долгион эмчилгээг өвдөлт намдаах, үрэвсэл бууруулах, эдгэрэлтийг дэмжих, эд эсийг нөхөн сэргээх, булчингийн чангарлыг бууруулах зорилгоор олон төрлийн эмгэгийн эмчилгээнд ашиглаж болох инвазив бус эмчилгээ гэж үзэж байна.¹³⁻¹⁸

Зорилго

Тархины саатай хүүхдийн өлмий жийгч булчингийн чангарлыг цохилтот долгионы эмчилгээгээр эмчилж, сэргээн засах эмчилгээний үр дүнг судлах.

Судалгааны арга зүй

- Цохилтот долгион: m.gastrocnemius, soleus → 7 хоногт 1 удаа, 4 долоо хоног (15 мм голчтой хошуу, 1500 – цохилт, 10Hz – давтамж, 2 бар – даралтын хүч)
- Хөдөлгөөн засал: 30–40 мин, 7 хоногт 3 удаа, 4 долоо хоног сунгалтын дасгал, булчингийн хүч хөгжүүлэх дасгал, тэнцвэр сайжруулах дасгал, идэвхит хөдөлгөөний дасгал, хүүхэд бүрийн хөдөлгөөний чадвар дээр тулгуурлана.

Үр дүн

Судалгаанд нийт 22 оролцогч хамрагдсан. Хүснэгт 1-ээр бидний оролцогчдын хүн ам зүйн ерөнхий мэдээллийг харууллаа.

Хүснэгт 1. Хүн ам зүйн ерөнхий үзүүлэлт

Үзүүлэлт	Дундаж (СХ) ба N	p утга
Нас	5.1(1.756)	0.273
Хүйс	13(59%) 9 (41%)	0.184
Жин	18.977(5.45)	0.056
Өндөр	108.318(14.018)	0.344
ТС	15(68.2%) /7 (31.8%)	0.307
GMFCS I/II	2.18(0.08)	0.274
Гаж нөлөө	80%/ 20%	0.000
VAS	2.05(1.046)	0.001

Хүснэгт 2. Оролцогчдын булчингийн чангарал ба динамик чангарлын өөрчлөлт

	Дундаж (СХ)	Эмчилгээний өмнө	Эмчилгээний дараа	P- утга
MAS				
Ankle PF өвдөг нугалсан үед	Б	1.909(0.86)	1.045(0.72)	0.000
	З	1.727(0.19)	0.935(0.15)	0.000
Ankle PF өвдөг тэнийсэн үед	Б	2.136(0.94)	1.318(0.83)	0.000
	З	1.909(0.207)	1.13(0.18)	0.000

MTS–R1 өнцөг				
Ankle PF өвдөг нугалсан үед	Б	3.81(10.28)	12.63(6.70)	0.000
	З	5.54(8.35)	12.36(7.68)	0.000
Ankle PF өвдөг тэнийсэн үед	Б	-1.86(11.85)	6.95(7.93)	0.000
	З	-1.95(13.16)	6.13(10.09)	0.000
MTS–R2 өнцөг				
Ankle PF өвдөг нугалсан үед	Б	19.22(9.46)	25.45(6.62)	0.000
	З	21.18(7.22)	27.13(6.30)	0.000
Ankle PF өвдөг тэнийсэн үед	Б	11.09(9.50)	19.68(6.54)	0.000
	З	15.72(11.00)	22.86(8.43)	0.000

Хүснэгт 2-т оролцогчдын булчингийн чангарал ба динамик чангарлыг MAS болон MTS-ээр хэмжиж, статистикийн ач холбогдолтой өөрчлөлтийг харуулсан. Өвдөг нугалсан болон тэнийсэн байрлалд тавхай нугалагч, тэнийлгэгч булчингийн чангарлыг эмчилгээний өмнөх болон дараахтай харьцуулахад булчингийн чангарал ба динамик чангарал нь мэдэгдэхүйц буурсан болохыг харуулсан ($p=0.0001$).

Хүснэгт 3. Оролцогчдын их биеийн хөдөлгөөний чадварын өөрчлөлт

GMFM–88	Дундаж (СХ)		p утга
	Эмчилгээний өмнө	Эмчилгээний дараа	
A	51(0.000)	51(0.000)	0.378
B	58.72(3.29)	60.0(0.000)	0.085
C	39.18(6.63)	40.90(3.14)	0.091
D	32.00(11.31)	34.95(9.73)	0.047
E	39.22(21.15)	46.40(25.68)	0.005
Нийт	220.13(39.94)	231.68(35.94)	0.004

Хүснэгт 3-т оролцогчдын их биеийн хөдөлгөөний үйл ажиллагааны өөрчлөлтийг нэгтгэн харуулав. Оролцогчдын их биеийн хөдөлгөөний чадвар эмчилгээний өмнөхөөс эмчилгээний дараахтай харьцуулахад статистикийн хувьд ач холбогдол бүхий сайжирсан. Харин GMFM–88 үнэлгээний А–хүрээ (хэвтэх ба эргэх) В–хүрээ (суух), С–хүрээ (мөлхөх ба өвдөглөх)-ний үзүүлэлт эмчилгээний өмнө ба дараа статистикийн хувьд ялгаа гараагүй. Энэ нь бидний судалгаанд GMFCS I ба II түвшний хүүхдүүд өөрөө хэлбэл зогсох, алхах чадвартай хүүхдүүд хамрагдсантай холбоотой.

Дүгнэлт

Энэ судалгааны хүрээнд бидний хийсэн дүн шинжилгээ нь цохилтот долгион (rESWT)–ыг сэргээн засах эмчилгээтэй хослуулан хийхэд доод мөчдийн булчингийн чангарлыг хурдан, үр дүнтэй бууруулж үйл ажиллагааг сайжруулсан. Эмчилгээний явцад өвдөлт бага, гаж нөлөө гараагүй. Иймд энэ эмчилгээ аюулгүй, өвдөлтгүй, эрсдэл багатай арга юм.

Түлхүүр үг: Мэдрэлийн тогтолцооны пренаталь эмгэг, сэргээн засах эмчилгээ.

Ашигласан материал:

1. Цагаанхүү.Г (2011). “Мэдрэл судлал” (ху.547–553). Монгол Улс, Улаанбаатар хот.
2. Pakula AT, Van Naarden Braun K, & Yeargin–Allsopp M (2009). Cerebral palsy: classification and epidemiology. *Phys Med RehabilClin N Am*, 20, 425–452.
3. Rosenbaum P, Paneth N, Leviton A, & et al. (2007). A report: the definition and classification of cerebral palsy, *Dev Med Child Neurol*, 49(109), 8–14.
4. (2003). “Тархины саатай хүүхдийг бага насанд нь илрүүлж зөв өсөж бойжиход нь туслах гарын авлага” орчуулга. Монгол Улс, Улаанбаатар хот.
5. Cans C, De–La_Cruz. J, & Mermet.M (2008). Epidemiology of cerebral palsy. *Paediatr child Health*, 18, 393–8.

АУТИЗМЫН ХҮРЭЭНИЙ ЭМГЭГТЭЙ ХҮҮХДҮҮДЭД ЗУРАГ СОЛИЛЦОХ ХАРИЛЦААНЫ СИСТЕМ (PECS)-ИЙГ АШИГЛАСАН ҮР ДҮН

Л.Лхагвасүрэн, Б.Цэнд-Аюуш, Б.Солонго¹, Б.Мөнх-Эрдэнэ²

¹ Нийслэлийн 186 дугаар цэцэрлэг,

² Бие Бялдар Судлалын Тэнхим, Сувилахуйн сургууль, АШУҮИС

Үндэслэл

Аутизмын хүрээний эмгэг (АХЭ) нь хүний бусадтай харилцах, нийгмийн харилцаанд орох, мэдээллийг хүлээж авч ойлгох чадварт нөлөөлдөг насан туршийн өргөн хүрээний эмгэг.¹ Ерөнхийдөө харилцааны хүндрэлийг үүсгэх бөгөөд хэл ярианы хөгжлийн хоцрогдол, давтагдмал зан үйл, нийгэмшихүйн бэрхшээлээр илэрдэг.² Аутизмтай хүүхдүүд хүрээлэн буй орчинд нь юу болж байгааг анзаарахгүй байгаа мэт байдаг. Мөн хүний нүд рүү харахаас зайлсхийнэ. Энэ нь ихэнх хүмүүст тухайн хүүхэд харилцах ямар ч сонирхолгүй байгаа мэт ойлгогддог. Хэрэв тэдэнд ямар нэгэн зүйл хэрэгтэй болбол тэд ихэвчлэн том хүнийг “гараар нь чиглүүлдэг”. Ингэхдээ авахыг хүссэн зүйл дээрээ эцэг эхийнхээ гарыг аваачих буюу хүсэл, сонирхлоо ойлгуулах ХЭРЭГСЭЛ болгодог.³ Эдгээр хүүхдүүдэд харилцан ярианы нөхцөл байдлыг эхлүүлэх, дэмжих, өргөжүүлэх арга чухал хэрэгцээтэй байгаа бөгөөд манай улсад тухайн чиглэлээр хийсэн судалгааны ажил ховор, хязгаарлагдмал байгаа нь биднийг АХЭ-тэй хүүхдүүдэд зураг солилцох харилцааны систем буюу Picture exchange communication system (PECS)-ийг практикт ашиглах нь хэрхэн үр дүнтэй болохыг судлах үндэслэл болсон.

Зорилго

АХЭ-тэй хүүхдүүдэд зураг солилцох харилцааны систем (PECS)-ийг практикт ашигласан үр дүнг судлах.

Судалгааны арга зүй

Судалгаанд Нийслэлийн 186 дугаар цэцэрлэгт хамрагдаж байсан F84.0 гэж оношлогдсон 2–6 насны эрэгтэй 26, эмэгтэй 4 нийт 30 хүүхдийг хамруулсан. Судалгаанд оролцогчдоос PECS эхлэхийн өмнө болон дараа аутизмын эмчилгээний үнэлгээний хяналтын хуудас буюу Autism Treatment Evaluation Checklist (ATEC) үнэлгээг хийсэн. Хүүхдүүдийн эцэг эх, асран хамгаалагчаас зөвшөөрөл авч судалгааны талаар танилцуулж 15 долоо хоногийн турш 7 хоногт 3 өдөр 20–30 минутаар хамруулсан.

Үр дүн

Судалгаанд хамрагдсан нийт хүүхдүүдийн дундаж нас 4.7 ± 1.0 жил, хүйс эрэгтэй 26 (87%), эмэгтэй 4 (13%), биеийн өндөр 108.2 ± 7.2 см, биеийн жин 18.7 ± 2.7 кг, БЖИ 15.9 ± 1.6 тус тус тодорхойлогдож байна (Хүснэгт 1).

Хүснэгт 1. Судалгаанд оролцогчдын ерөнхий мэдээлэл

Үзүүлэлтүүд	Дундаж утга болон стандарт хазайлт
Нас (жил)	4.7 ± 1.0
Өндөр (см)	108.2 ± 7.2
Жин (кг)	18.7 ± 2.7
БЖИ	15.9 ± 1.6

Тайлбар: Дундаж утга±стандарт хазайлт

Хүснэгт 2. PECS хэрэгжүүлэхийн өмнөх болон дараах АТЕС онооны харьцуулсан үр дүн

Үзүүлэлт	Өмнөх (n=30)	Дараах (n=30)	p утга
Хэл яриа, харилцааны чадвар	22.1±6.1	19.8±6.0	<0.05
Нийгэмшихүйн чадвар	27.7±10.8	23.2±9.4	
Мэдрэхүйн дадал, танин мэдэхүйн чадвар	22.8±7.4	19.9±7.2	
Эрүүл мэнд бие бялдрын хөгжил	25.4±8.8	21.4±8.1	
Нийт	97.9±30.4	84.3±28.5	<0.0001

Тайлбар: Дундаж утга±стандарт хазайлт, p утга: PECS хэрэгжүүлэхийн өмнөх болон дараах АТЕС онооны харьцуулалтын статистик ач холбогдол

PECS хэрэгжүүлсний дараагаар АТЕС оноо буурч хэл яриа харилцааны чадвар, нийгэмшихүйн чадвар, мэдрэхүйн дадал, танин мэдэхүйн чадвар болон эрүүл мэнд бие бялдрын хөгжил статистик ач холбогдол бүхий сайжирсан.

Хэлцэмж

Судалгаанд F84.0 гэж оношлогдсон 2–6 насны (эрэгтэй 26, эмэгтэй 4) нийт 30 хүүхдүүдийг 15 долоо хоногийн турш 7 хоногт 3 өдөр 20–30 минутаар зураг солилцох харилцааны систем (PECS)-ийг хэрэгжүүлсэн. PECS хэрэгжүүлэхийн өмнөх болон дараах үр дүнг аутизмын эмчилгээний хяналтын хуудас буюу Autism Treatment Evaluation Checklist (АТЕС) үнэлгээгээр үнэлж харьцуулан судлав. Бидний судалгаанд хэл яриа, харилцааны чадвар сайжирсан үр дүнтэй гарсан нь Судлаач Patricia de Almeida Santos нарын АХЭ-тэй хүүхдүүдэд PECS хэрэгжүүлсэн судалгаанд PECS нь аутизмтай хүүхдүүдийн хараагаар ойлгох ($p < 0.0002$), аман заавар ойлгох чадвар ($p < 0.001$) статистикийн хувьд чухал эерэг нөлөө үзүүлсэн нь энэ арга нь хүүхдүүдэд өөрийгөө илэрхийлэх чадварыг сайжруулах хүүхдийн анхаарал төвлөрөл, нэрэнд хариу үзүүлэх, зарим нэг заавар команд биелүүлэх мөн хэл яриаг дэмжихэд хувь нэмэр оруулдаг болохыг харуулсан⁴ бидний судалгааны үр дүнтэй нийцэж байна.

Дүгнэлт

Аутизмын хүрээний эмгэг (АХЭ)-тэй хүүхдүүдэд PECS хэрэгжүүлсэн үр дүнд хэл яриа харилцааны чадвар дээр өөрийн нэрэнд хариу үзүүлэх чадвар, зарим нэгэн команд биелүүлэх чадвар болон үгсийн сан нэмэгдсэн бол нийгэмшихүйн чадвар дээр нүдэн харилцаа, даган дуурайх, бусадтай харилцах чадварууд дийлэнх хүүхэд дээр мэдэгдэхүйц нэмэгдсэн тул судалгаанд хамрагдсан хүүхдүүдийн мэдээллийг ойлгоход Зураг солилцох харилцааны систем (PECS)-ийг хэрэгжүүлснээр эерэг нөлөө үзүүлснийг бидний судалгааны үр дүн харуулж байна. PECS нь зааварчилгааг ойлгох, илүү үр дүнтэй харилцах харилцааг сайжруулахад чухал нөлөө үзүүлсэн тул аман бус харилцаатай буюу үг хэллэг багатай хүүхдүүдэд зориулсан үр дүнтэй харилцааны систем болох нь харагдаж байна.

Түлхүүр үг: Аутизмын хүрээний эмгэг, зураг солилцох харилцааны систем, АТЕС үнэлгээ.

Ашигласан материал:

1. www.autism.mn
2. Монголын Аутизмын холбоо. *Багш, эмч, мэргэжилтнүүдэд зориулсан аутизмын тухай гарын авлага*. Монгол Улс, Улаанбаатар хот.
3. Монголын Аутизмын холбоо (2022). *Үгээр хязгаарлахгүй харилцаа*. Монгол Улс, Улаанбаатар хот.
4. Patricia de Almeida Santos & Daniela Bordini (2021). The Impact of the Implementation of the Picture Exchange Communication System, *PECS on Understanding Instructions in Children with Autism Spectrum Disorders*, (2), 5-33. 20200041.

ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮҮХДИЙН ЭРТ ИЛРҮҮЛЭГ, ДЭМЖЛЭГИЙН ҮЙЛЧИЛГЭЭ

(Портеж хөтөлбөрийн жишээн)

Э.Нэргүй¹

¹ 10 дугаар цэцэрлэг
ne526761@gmail.com

Үндэслэл

Сургуулийн өмнөх боловсролын хуульд заасанчлан хөнгөн хэлбэрийн хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг ердийн цэцэрлэгт тэгш хамруулах боломжтой хэдий ч тэднийг нийгэмд бие хүн болгон төлөвшүүлэхэд хэрхэн яаж дэмжин ажиллах тал дээр төдийлөн сайн ойлголтгүй, багш нарын мэдлэг чадвар дутмаг байдаг нь ажиллаж байх явцад ажиглагдсан. Монгол улсын хувьд Японы Жайка олон улсын хамтын ажиллагааны нийгэмлэгийн шугамаар эрт үеийн хөгжлийн Портеж хөтөлбөрийг туршин нутагшуулах ажлыг 2017–2018 оны хичээлийн жилээс эхлэн хэрэгжүүлж эхэлсэн бөгөөд 2022 оноос Эрдэнэт хотын СӨБ-д хэрэгжүүлэн туршилт судалгаа хийгдэж байна. Миний хувьд Дауны хам шинжтэй хүүхдийг сонгож эрт үеийн Портеж хөтөлбөрийн арга зүйгээр ажиллах зорилго тавьж ажилласан нь юуны өмнө энэхүү арга зүйд суралцахаас гадна Дауны хам шинжтэй хүүхдийг судлахад ямар онцлог илэрч байгаа нь миний сонирхлыг татсан юм. Энэ нь уг сэдвийг сонгох болсон нэг үндэслэл юм.

Зорилго

Эрт үеийн хөгжлийн Портеж хөтөлбөрийн аргазүйгээр Дауны хам шинжтэй хүүхдийн хөгжлийг дэмжиж, үр дүнг тооцох.

Судалгааны арга зүй

Портеж хөтөлбөрийн суралцахуйн ай чадварын картаар хүүхдийг үнэлж, дасгал даалгавруудыг сонгохдоо хүүхдийн чаддаг зүйл дээр тулгуурлан бусад чадваруудыг хөгжүүлэх, боломжийг судлан авч ажиллан ахиц үр дүнг зурган хэлбэрээр баталгаажуулав.

Үр дүн

Портеж хөтөлбөрийн шалгах хуудасны 5–6 насны үечлэлээр судалгаанд хамрагдсан Н хүүхдийн хөгжлийн төлөв байдлыг 5 айгаар үнэлэхэд 28 үйлийн зорилтыг чаддаг, 51-ийг гүйцэтгэж чадахгүй байв. Нэг айн хувьд үзүүлэлтийг тодруулбал, Бие дааж хийх үйлдэл чаддаг 9, чаддаггүй 6, Хөдөлгөөн айн хувьд чаддаг 9, чаддаггүй 11 байлаа. Даунтай хүүхэдтэй ажиллахдаа хөгжлийн 3 ай болох даалгаврын карт 5, 20, 104 сонгон авч ажиллалаа. Хүүхдийг аль болох ойлгохыг хичээж, бусад хүүхдээс арай өөр хувь хүн гэдэг талаас нь хүндэтгэлтэй хандаж үг яриа, үйл хөдлөлийг нь анхааралтай ажиглан, магтаж урам хайрлаж харьцаж байвал хүүхдийн өөртөө итгэх итгэл нэмэгддэг юм байна. Ингэснээр бусадтай харилцах харилцаа сайжирч, юу хүсэж, сонирхож байгаагаа бусдад илэрхийлж чаддаг болсноор даалгаврыг гүйцэтгэх явцад хүндрэл бэрхшээл бага гарч 5, 20 бусдын тусламжгүй чаддаг болсон ба 1 даалгаврыг бусадтай хамтарч хийж сурсан.

Дүгнэлт

1. Портеж хөтөлбөрийн шалгах хуудасны 5–6 насны үечлэлээр судалгаанд хамрагдсан Н хүүхдийн хөгжлийн төлөв байдлыг 5 айгаар үнэлэхэд 28 үйлийн зорилтыг чаддаг, 51-ийг гүйцэтгэж чадахгүй байв. Нэг айн хувьд үзүүлэлтийг тодруулбал, Бие дааж хийх үйлдэл чаддаг 9, чаддаггүй 6, Хөдөлгөөн айн хувьд чаддаг 9, чаддаггүй 11 байлаа.
2. Эрт үеийн хөгжлийн Портеж хөтөлбөрийн цогц аргазүйг ашиглан Дауны хам шинжтэй Н хүүхэдтэй ажиллалаа. Судлаачийн сонгож авсан үйлийн зорилтын дагуу хүүхдэд зохих чадварыг суулгахад түүнд зарцуулах хугацаа, давтамж харилцан адилгүй байсан. Тухайлбал, “Бие дааж хийх” айн, даалгаврын картын дугаар 93, үйлийн зорилт “дотрыг гадагш эргүүлсэн хувцсыг буцааж хэвэнд нь оруулан зөв болгож өмсөх” даалгаврыг 35 удаагийн давтамжтайгаар, Танин мэдэхүйн хөгжлийн айн, даалгаврын картын дугаар 5,

“зурааснаас илүү гаргалгүйгээр будах” даалгаврыг 20 удаагийн давтамжтайгаар хийсний үр дүнд бусдын туслалцаагүйгээр хийж сурсан. Харин бие дааж хийх айн даалгаврын картын дугаар 104 “Үдээс үдэх” (эрвээхэй зангидалд) чадварыг олон удаа хийлгэж байсан боловч ажилласан сарын хугацаа хангалтгүй, тул бүрэн эзэмшиж чадаагүй нь судалгааны үр дүнгээс харагдлаа.

3. Портеж хөтөлбөрт дэх хүүхдийн хөгжлийг дэмжих аргуудыг видео бичлэг, нэмэлт хэрэглэгдэхүүн, хэрэгсэл, насанд хүрэгчдийн хүүхдэд урам өгч магтах, урамшуулах аргатай хавсарган хэрэглэвэл илүү үр дүнтэй болохыг судалгаа харууллаа.

Түлхүүр үг: *Портеж, дауны хам шинж, хөгжлийн ай.*

Ашигласан материал:

1. Батдэлгэр.Ж (2019). Портеж хөтөлбөрөөр аутизмын эмгэгтэй хүүхдийг судалсан судалгааны үр дүн. “Сэтгэл судлалын орчин үеийн тулгамдсан асуудлууд сэдэвт эрдэм шинжилгээний бага хурлын эмхэтгэл”. Монгол Улс, Улаанбаатар хот.
2. Батцэнгэл.Г (2016). *Тусгай хэрэгцээт боловсрол*. Монгол Улс, Улаанбаатар хот.
3. Батцэнгэл.Г & Бандихүү.Б (2012). *Гэр бүлийн сэтгэл судлал*. Монгол Улс, Улаанбаатар хот.
4. Мягмар.О (2013). *Судлаач багшийн гарын авлага*. Монгол Улс, Улаанбаатар хот.
5. Наранцэцэг.Д, Батцэнгэл.Г, Гэрэлтуяа.Ц, Төртогтох.Б, & Батжаргал.Г (2017). *Тэгш хамруулах боловсролын чиг хандалга сургуулийн өмнөх боловсролд*. Монгол Улс, Улаанбаатар хот.
6. Хаяяши Кензо, Торигое Такаши, Исава Шинзо, Ишикура Кенжи, & Такано Миюүки (2018). *Тусгай хэрэгцээт боловсрол*. Монгол Улс, Улаанбаатар хот.
7. Цэрэннадмид.Ш, Жавзандулам.Б, & Жүгдэрнамжил.Х (2016). *АРА загварын дагуу эрдмийн ажил бичих, гарын авлага*. Монгол Улс, Улаанбаатар хот.

ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮМҮҮСИЙН ШҮД, НҮҮР АМНЫ ӨВЧНИЙ ЭМЧИЛГЭЭНИЙ ХҮРТЭЭМЖИЙГ ДЭЭШЛҮҮЛЭХ НЬ

П.Эрдэнэбулган, Э.Билгүүн¹

¹ АШУҮИСИ–НАСС, Нүүр амны технологи эрүүл ахуйн тэнхим

erdenebulgan@mnums.edu.mn

Үндэслэл

Амны хөндийн эрүүл мэнд нь хүний сайн сайхан байдлын салшгүй бүрэлдэхүүн хэсэг, амьдралын чанарыг илэрхийлэх нэг үзүүлэлт тул эрүүл мэндийн тусламж үйлчилгээний талаар мэдээлэл авах, амны хөндийн эрүүл ахуйг сахих, мэргэжлийн эмчийн үзлэг, эмчилгээнд хамрагдах нь хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд чухал асуудал бөгөөд тэд бусад иргэдийг бодвол нүүр амны болон шүдний өвчлөлд өртөх өндөр эрсдэлтэй, эмнэлгийн үйлчилгээнд хамрагдах тал дээр дутагдалтай байдаг. Шүдний эмнэлгийн тусламж үйлчилгээг хөгжлийн бэрхшээлтэй иргэд рүү чиглүүлэн, хувь хүн бүрийн онцлог хэрэгцээ, эрүүл мэндийн байдалд тохирсон эмчилгээний менежмент боловсруулан хэрэгжүүлэх, тэгш хүртээмжтэй хамруулах нь өнөөгийн нийгэмд зайлшгүй хэрэгцээтэй тулгамдсан асуудлуудын нэг юм.

Зорилго

Хөгжлийн бэрхшээлтэй, тусгай хэрэгцээт иргэдийн шүд, нүүр амны өвчний эмчилгээний хүртээмжийг дээшлүүлэх боломжийг судлах

Судалгааны арга зүй

Аналитик судалгааны агшингийн загвараар АШУҮИС-ийн Нүүр Ам Судлалын Сургуулийн Нүүр Амны Технологи Эрүүл Ахуйн Тэнхимийг түшиглэн, Сэргээн Засах Клиник Эмнэлэг, Хөгжлийн Бэрхшээлтэй Хүүхдийн сэргээн засах эмнэлэг, Сэргээн засалт, сургалт үйлдвэрлэлийн төвөөр үйлчлүүлэгч хөгжлийн бэрхшээлтэй иргэд, тэдний асран хамгаалагч нарыг хамруулан хийж гүйцэтгэсэн. Мөн Монгол улс болон олон улсын анагаах ухааны сургуулиудын сургалтад хэрэгжиж буй хөгжлийн бэрхшээлтэй, тусгай хэрэгцээт хүмүүсийн нүүр амны өвчний эмчилгээнд туслах нь хичээлийн хөтөлбөрийн сургалтын баримт бичгүүд, цахим эх сурвалж; улсын болон хувийн хэвшлийн эмнэлгүүдийн мэдээллийг судалгааны эх материал болгон ашиглаж, ажиглалт хийн, харьцуулсан.

Үр дүн

Хөгжлийн бэрхшээлтэй иргэд, тэдний асран хамгаалагчдын эрүүл мэндийн мэдлэг хангалтгүй, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст шаардлагатай нүүр амны эмч, эрүүл ахуйч зэрэг мэргэжилтнүүдийн хэрэгцээг тодруулахад улсын болон хувийн хэвшлийн аль ч эмнэлгүүдэд тусгай хэрэгцээт хүмүүст үйлчлэх нарийн мэргэшсэн нүүр амны эмч, эрүүл ахуйч мэргэжилтний орон тоо байдаггүй. Шүд, нүүр амны эмнэлгүүдийн ажлын байрны хөгжлийн бэрхшээлтэй, тусгай хэрэгцээт хүмүүст үйлчлэх дэд бүтэц, орчин нөхцөл хангалтгүй байсан бөгөөд энэ нь шүдний эмнэлгээр үйлчлүүлэхээс татгалздаг гол шалтгаан болж байна. Монгол Улсад үйл ажиллагаа явуулж буй анагаах ухааны боловсрол олгох сургуулиудын хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн нүүр амны эмчилгээнд туслах хичээлийн хөтөлбөрийн талаар тандахад зөвхөн АШУҮИС-ийн НАСС-д “Хөгжлийн бэрхшээлтэй хүний нүүр амны өвчний эмчилгээнд туслах нь” 2 багц цагийн хичээлийг хөтөлбөртөө оруулсан, бусад нь үүнд анхаардаггүй байна.

Дүгнэлт

1. Хөгжлийн бэрхшээлтэй, тусгай хэрэгцээт хүмүүст үйлчлэх мэргэшсэн нүүр амны эмч, эрүүл ахуйч зэрэг мэргэжилтнүүд нэн хэрэгцээтэй байна.
2. Хөгжлийн бэрхшээлтэй, тусгай хэрэгцээт хүмүүсийн амны хөндийн эрүүл ахуйн мэдлэг хангалтгүй учраас тэдэнд болон асран хамгаалагчдад нь амны хөндийн эрүүл ахуй сахих, шаардлагатай хэрэглэгдэхүүнүүд, шүд угаахын ач холбогдлын талаар мэдлэг олгох

3. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд тэгш хүртээмжтэй үйлчлэх орчин, нөхцөлийг бүрдүүлэх, сайжруулах тал дээр шүдний эмнэлгүүдэд барилга, өрөөний зохион байгуулалтын стандарт, өвчтөнийг аюулгүй зөөвөрлөх, шилжүүлэн ажиллах жишиг удирдамж боловсруулан түгээх шаардлагатай байна.

Түлхүүр үг: *Нүүр ам судлал, тусгай хэрэгцээ, ээлтэй орчин, тэгш хүртээмж.*

Ашигласан материал:

1. Mohamed Rohani M, Calache H, & Borromeo GL (2017). Referral patterns of special needs patients at the Royal Dental Hospital of Melbourne, 62, 173 179.
2. Natrah AF, Jacob J, Wen Thong K, Shani AM, Wan Lin Sarah L, Chee Soon. W, & et al. (2015). Special care dentistry curriculum at undergraduate level, *Students' perspective* 22, 75 79.
3. Klang, Selangor (2016). *Malaysia Pro Tem Dental Specialty Board (DSB) Meeting*.
4. Chol O Han (2016). Social Development Division, Disability statistics in the ESCAP region: An overview – A review of available statistics on, presented in United Nations Regional Meeting on Disability Measurement and Statistics in support of the 2030 Agenda for Sustainable Development and the 2020, *World Population and Housing Census Programme*, 26–28.
5. Naimie, & et al. (2020). Curriculum for Special Care Dentistry, *Journal of International Oral Health*, 12(1).

ХӨГЖЛИЙН ХӨТӨЧ ВАДЕМИКУМ ХЭРЭГСЛИЙГ АШИГЛАН ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮҮХДИЙН ХӨГЖЛИЙН ТҮВШНИЙГ ҮНЭЛЭХ НЬ

Э.Цэнгэл¹

¹ Энэрэлийн Түүчээ ТББ-ын судлаач, багш

tsengel.tuuchee@gmail.com

Үндэслэл

Балчир, бага насны хүүхэд гэр бүлд маш олон шинэлэг зүйл, өөрчлөлтийг авч ирдэг. Бүгд шинэ туршлага хуримтлуулж хорвоод мэндэлсэн шинэ хүндээ өөрсдийгөө нийцүүлнэ. (Шлингер, 2019) Хөгжлийн бэрхшээлтэй эсэхээс үл хамааран 0–4 хүртэлх насны хүүхдийн хөгжил ирээдүйн бие даасан иргэнийг бүтээх суурь хөгжлийн үе тул эцэг эх, багш нар зөв дэмжлэгийг хэдий эрт хүргэнэ, төдий чинээ тухайн хүүхдийн хүүхдийн хөгжилд саад учруулах эрсдэлээс сэргийлж чадна.

Зорилго

Хөгжлийн хөтөч Вадемикум хэрэгслийг ашиглан хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн хөгжлийн насыг тодорхойлж, түүнд тохирсон дэмжлэгийг үзүүлснээр хүүхдийн хөгжлийн түвшинд ахиц гарч байгаа эсэхийг илрүүлэх зорилгоор энэхүү судалгааг хийсэн.

Судалгааны арга зүй

Энэхүү өгүүлэлд ДЭМБ-ын ICF–CY (ҮАОУА–Хүүхэд/Залуучууд) тулгуурлан боловсруулсан 0–4 насны хүүхдийн хөгжлийн түвшнийг тогтоон, хөгжлийн хоцрогдлыг эрт илрүүлэх үнэлгээний программыг ашиглан хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн хөгжлийн түвшнийг хэрхэн үнэлсэн туршлагыг авч үзлээ.

Вадемикум үнэлгээний тухай

Вадемикум үнэлгээ нь хөгжлийн 5 ай бүхий (А ай – Бие бялдрын хөгжил, В ай – Харах, барьж авах хөдөлгөөний хөгжил, С ай – Сонсгол, хэл ярианы хөгжил, D ай – Бие даах чадварын хөгжил, E ай – Сэтгэл хөдлөл, нийгэмшихүйн хөгжил) чиглэлтэй. Чиглэл тус бүрд ажиглалтын төрөл бүрийн асуулт, тоглоомын санаанууд байгаа бөгөөд та өөрийн туршлага болон шууд ажиглалтаар хүүхэд гүйцэтгэж чадаж байгаа эсэхийг дүгнэх боломжтой. Асуулт бүр дугаартай байгаа нь төгсгөлийн хүснэгтэд харгалзах тоог тэмдэглэхэд зориулсан. Ажиглалтын асуултууд хөнгөнөөс хүндэрч байгаа нь хүүхдийн хөгжлийн явцтай холбоотой (Шлингер, 2019). Ингэж хүүхдийн хөгжлийн түвшнийг үнэлж тохирох дэмжлэгийг өгч ажилласнаас 1–3 сарын дараа хүүхдийг дахин ажиглаж ямар өөрчлөлт гарсныг тэмдэглэж болно. Мөн Вадемикум нь цаасан болон цахим гэсэн 2 хувилбартай ба хүн өөрийнхөө хэрэгцээнд нийцүүлэн аль ч хувилбарыг хэрэглэх боломжтой юм.



В	Хаягт өгөгдөлчид
42	Хаягт өгөгдөлчид чинэ.
43	Сүлжээ байрлалд өөрсөд нь өөрсөн эрх буюу биеийг буцаан өөрчлүүлнэ.
44	Харилцаанд нэгдсэн өөр зүйлийг өөр өөр гэр бүлд дээдгүй байхад өгөгдөлчид.
45	Хүрээлдэй, биеийг буцаан эхлэн гэр бүлийн талонд Үсэг нь савнаа, мэддэг хоолоороо хийнэ.
46	Дарсан өгөгдөлчид нь давхарган эрх савнаа бүтэнэ.
47	Нэгэн аударь нэг нэгээр нь эргүүлнэ.
48	Хүрээлдэй, биеийг буцаан эхлэн гэр бүлийн талонд, Савнаа даар суулгагчид эхлэн гэр бүлийн талонд.
49	Эд зүйлийг буцаан эхлэн гэр бүлийн талонд, Савнаа даар суулгагчид эхлэн гэр бүлийн талонд, Савнаа даар суулгагчид эхлэн гэр бүлийн талонд.
50	Хүрээлдэй, биеийг буцаан эхлэн гэр бүлийн талонд, Савнаа даар суулгагчид эхлэн гэр бүлийн талонд.
51	Ус (цах, сүүл) нь нэг савнаа нэгэнд ажиглагчид эхлэн гэр бүлийн талонд.
52	Шүүрэг аравс дугуйн зурна.
53	Дугуйн савнааг нэг өрөөнөөс нөгөө рүү зөөнэ.
54	Харилцаа буюу ахуйн гарвараа итгэлгүй, эхнэ хуруунаараа барьж савнаа дээр савнаа.

Үр дүн

Судалгааг Хүслийн Ордон тусгай цэцэрлэгт хамрагдаж байсан 20 хүүхдийн 3 удаагийн Вадемикум ажиглалт дээр хийсэн бөгөөд 3 удаагийн ажиглалт тус бүр дээр хүүхдийн хөгжлийн

насыг тодорхойлсон. Энэхүү судалгаагаар 3 удаагийн ажиглалтаар хүүхдийн хөгжлийн түвшинд ямар ахиц гарсан байна, тэдгээр ахиц өөрчлөлт нь хэр үр дүнтэй байгааг харьцуулан шинжилж үзлээ. Судалгааны найдварт байдлыг хэмжиж үзэхэд (Cronbach's alpha=0.834) хангалттай байна. Судалгаанд хамрагдсан хүүхдүүдийн 65% нь эрэгтэй, 35% эмэгтэй хүүхэд байсан бөгөөд бэрхшээлийн хувьд 55% нь хөдөлгөөний, 5% нь дауны хам шинжтэй, 2% нь аутизмын хүрээний эмгэгтэй, 10% нь хавсарсан, 15% нь бусад бэрхшээлтэй хүүхдүүд байв.

Хүүхдүүдийн ерөнхий мэдээллийг дараах хүснэгтүүдэд харуулав.

Хүснэгт 1. Ажиглалтын үеийн биологийн нас

	1-р ажиглалт	2-р ажиглалт	3-р ажиглалт
Дундаж нас	66.25	69.8	73.9

Хүснэгт 2. Ажиглалтын үеийн хүүхдийн хөгжлийн нас ай тус бүрээр

	1-р ажиглалт	2-р ажиглалт	3-р ажиглалт
Дундаж нас (сараар) А ай – Бие бялдрын хөгжил	16.3	17.1	18.7
Дундаж нас (сараар) В ай – Харах, барьж авах хөдөлгөөний хөгжил	15.9	17.26	19.5
Дундаж нас (сараар) С ай – Сонсгол, хэл ярианы хөгжил	13.8	15	17.3
Дундаж нас (сараар) D ай – Бие даах чадварын хөгжил	17.45	20.31	21.5
Дундаж нас (сараар) E ай – Сэтгэл хөдлөл, нийгэмшихүйн хөгжил	15.8	17.4	19.7
Дундаж нас (сараар)	15.5	17.4	19.3

Ажиглалтын үнэлгээгээр хүүхдүүдийн хөгжлийн дундаж нас 15.5 сартай байсан бол 2 дахь үнэлгээгээр 17.4 болж 1.8 сараар нэмэгдсэн байна. Харин 3 дахь үнэлгээгээр 19.3 сар буюу эхний үнэлгээнээс 3.5 сараар, 2 дахь үнэлгээнээс 1.9 сараар нэмэгдсэн байна. 3 удаагийн ажиглалт үнэлгээний үр дүнд гарсан хөгжлийн насны өөрчлөлт нь статистикийн хувьд ач холбогдолтой эсэхийг шинжилж үзэхэд Р утга 0.05-аас бага буюу статистикийн хувьд ач холбогдол бүхий ялгаатай байгааг харуулж байна.

Хүснэгт 3. Хамааралт 2 түүврийн т–тестийн үр дүн (хөгжлийн нас дээрх)

Ажиглалт	Хөгжлийн дундаж нас	Хөгжлийн насны зөрүү	Р утга (ач холбогдлын түвшин)
Эхний ажиглалт	15.8	1.6	0.003
Хоёр дахь ажиглалт	17.4		
Эхний ажиглалт	15.8	3.5	0.001
Гурав дахь ажиглалт	19.3		
Хоёр дахь ажиглалт	17.4	1.9	0.013
Гурав дахь ажиглалт	19.3		

Sig<0.05***

Дүгнэлт

Судалгаанд хамрагдсан хүүхдүүдийн биологийн нас дунджаар 73.9 сар буюу ойролцоогоор 5–7 настай хүүхдүүд байсан ба Вадемекум хэрэгслийг ашиглан хүүхдүүд дээр 3 удаагийн ажиглалт хийсэн. Хүүхэд ялангуяа хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийг биологийн насаар үнэлэн түүндээ тохирох үйл ажиллагааг явуулах нь элбэг байдаг. Гэтэл хүүхдүүд 5, 6, 7 настай боловч хөгжлийн насаараа дөнгөж 2 настай, 1 настай, бүр хэдхэн сартай хүүхдийн түвшинд ч байдаг. Вадемекум хэрэгслийг ашиглан хүүхдийн хөгжлийн насыг тодорхойлж түүнд тохирсон үйл ажиллагааг явуулахад ямар үр дүнтэй байгааг бид дээрх судалгаанаас харлаа. Иймд хүүхдийн хөгжлийн насыг тодорхойлох үнэлгээний хэрэгслийн хэрэглээндээ нэвтрүүлж, ашиглах шаардлага гарч байгаа юм.

Түлхүүр үг: Хөгжлийн бэрхшээл, үнэлгээ, хөгжлийн түвшин.

Ашигласан материал:

- Schlienger, I (n.d.). VADEMECUM – Basics, main questions, methods and results of the mixed longitudinal and cross-sectional study. Zurich.
- Шлингер, И (2019). ВАДЕМИКУМ – Нялх, балчир насны хүүхдийн хөгжилд үзүүлэх дэмжлэг. Цюрих.



V БҮЛЭГ

НИЙГМИЙН ХАМГААЛАЛ

ТҮГШҮҮРИЙН ТҮВШИН, ТҮҮНИЙГ БУУРУУЛАХ ЗАРИМ АРГА ЗАМ (Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн жишээн дээр)

Г.Сумъяабаатар¹

¹ (Ph.D), Архангай аймгийн ГБХЗХГ-ын мэргэжилтэн
sumiyaa9603@gmail.com

Үндэслэл

Хүний хэвийн үйл ажиллагаа ба харилцаанд саад учруулж байгаа, түүний тайван байдлыг алдагдуулан айдас, болгоомжлол төрүүлдэг, хэвийн түвшнээс дээгүүр илэрч байгаа сэтгэлийн зовнилыг түгшүүр гэнэ. Түгшүүр нь харьцангуй тогтвортой илэрдэг, хувийн онцлог шинж юм. Нийгмийн нөхцөл байдлын улмаас сэтгэцийн эрүүл мэндийн асуудал чухлаар тавигдах болсон. Өдөр тутмын амьдралд тохиолдолд сөрөг мэдээ, мэдээллүүд, орчны сөрөг нөхцөл байдлууд, эдийн засаг, санхүүгийн доройтол зэрэг хүний сэтгэл зүйд тогтмол нөлөөлж түгшүүр зовнилыг үүсгэж байдаг. Тэдгээрийн зарим нь түр зуурын шинжтэй байдаг ч ямар нэгэн сөрөг нөлөөллийг үүсгэж байдаг. Ийм учраас бид сэтгэлийн түгшүүрийн түвшин, түүнийг бууруулах арга замыг хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн жишээн дээр судлан илрүүлсэн бөгөөд цаашид энэ чиглэлээр хэрэгжүүлж буй бодлого, хөтөлбөрийг сайжруулах, үр дүнтэй хэрэгжүүлэхэд ач холбогдол үзүүлэх юм.

Зорилго

Сэтгэлийн түгшүүр хэр зэрэг илэрч байгааг мэдэх, түүнийг бууруулах арга замыг мэдсэнээр цаашид хүндэрч архагших байдалд орохоос урьдчилан сэргийлэх ач холбогдолтой юм. Тийм учраас түгшүүрийн илрэх түвшинг судлах зорилго дэвшүүлж ажилласан болно.

Судалгааны арга зүй

Судалгаанд Америкийн сэтгэл зүйч Ч.Д.Спилбергер, Оросын сэтгэл зүйч Ю.Л.Ханин нарын боловсруулсан түгшүүрийн түвшинг оношлох сорил, фокус бүлгийн ярилцлага, математик статистикийн аргуудыг хэрэглэв.

Үр дүн


Сэтгэлийн түгшүүрийг тодорхойлох судалгаанд бэрхшээлтэй 20, бусад 16, нийтдээ 36 хүн хамрагдлаа.

Судалгаанд хамрагдсан хүний насыг авч үзвэл 12.5%-ийг 35–45 насны, 18.8%-ийг 18–25 насны, 31.3%-ийг 45 ба түүнээс дээш насны, 37.5%-ийг 35–45 насныхан, мөн түүнчлэн 81.3% эмэгтэй, 18.8% нь эрэгтэй хүн эзэлж байна (Диаграмм 1).

Хүснэгт 1. Судалгааны түүвэр


№	Судалгааны төрөл	Хамрагдсан хүүхэд		
		Хөгжлийн бэрхшээлтэй	Хөгжлийн бэрхшээлгүй	Нийт
1.	Сорил (түүвэр)	30	16	46
2.	Ярилцлага	10		10
	Дүн			56

Диаграмм 1. Судалгаанд хамрагдсан хүний нас, хүйс /Хувиар/



Судалгаанд хамрагдсан түүврийн хэмжээнд авч үзэхэд нөхцөл байдлын түгшүүр дунджаас бага түвшинд, харин бие хүний түгшүүр дунд зэргийн түвшинд илэрч байна. Харин хөгжлийн бэрхшээлтэй болон хөгжлийн бэрхшээлгүй хүний хувьд ялгаагүй байна (Диаграмм 2.).

Диаграмм 2. Сэтгэлийн түгшүүрийн байдал (төрлөөр)



Дүгнэлт

Хөгжлийн бэрхшээлтэй хүний сэтгэлийн түгшүүрийн түвшинг илрүүлсэн үр дүнг үндэслэн дараах дүгнэлтийг хийж байна. Үүнд:

1. Судалгаанд оролцогчдын хувьд нөхцөл байдлын түгшүүр дунджаас бага түвшинд, харин бие хүний түгшүүр дунд зэргийн түвшинд илэрч байна.
2. Хөгжлийн бэрхшээлтэй хүний сэтгэл түгшүүрийг бэрхшээлгүй хүнийхтэй харьцуулахад ялгаагүй байна.
3. Энэ нь нөхцөл байдлыг даван туулах сэтгэлийн тэнхээ, асуудлыг хүлээн зөвшөөрөх, зохицуулах чадвар төлөвшсөн зэрэгтэй холбон үзэж байна.

Түлхүүр үг: Бие хүн, нөхцөл байдал, сэтгэл ханамж, хөгжлийн бэрхшээл.

Ашигласан материал:

1. Амаржаргал.Т (2008). “Сэтгэл зүйн шилдэг тестүүд” (ху.90–93). Монгол Улс, Улаанбаатар хот.
2. Мягмар.О (2018). “Сэтгэл зүйн зөвлөгөөний арга техник” (ху.69–74). Монгол Улс, Улаанбаатар хот.
3. Цэрэндондов.П & Чимэдлхам.Ц (2013), *Сурган–сэтгэл зүйн судалгаа, түүний баримтад статистик задлан шинжилгээ хийх арга*. Монгол Улс, Улаанбаатар хот.
4. <http://gadpwd.gov.mn/index.php/page/193>
5. <http://gadpwd.gov.mn/index.php/page/201>

ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ИРГЭД СОНГОХ, СОНГОГДОХ ЭРХЭЭ ЭДЛЭХЭД ТУЛГАРДАГ СААД БЭРХШЭЭЛ, АСУУДАЛ БА ШИЙДЭЛ

Х.Батчимэг¹

¹Монгол Улсын Их Сургууль, Социологи нийгмийн ажлын тэнхимийн магистрант

Batchimeg.kh96@gmail.com

Үндэслэл

Хөгжлийн бэрхшээлтэй иргэд (ХБИ)-ийн хувьд улс төр, нийгмийн амьдралд бусдын нэгэн адил бүрэн дүүрэн, саадгүй, бие даан оролцох эрх нь дэд бүтцийн болон мэдээллийн хүртээмжгүй байдал, нийгмийн хандлага ойлголт сул, хууль, эрх зүйн зохицуулалт, хэрэгжилт хангалтгүй, сонгуулийн тогтолцоо зэргээс шалтгаалан хязгаарлагддаг. Тийм учраас ХБИ-ийн улс төрийн оролцоо, сонгох, сонгогдох эрхийн хэрэгжилтийн нөхцөл байдал, тулгамдаж буй асуудлыг тоон ба чанарын судалгааны үр дүнд тулгуурлан гүнзгийрүүлж, төлөөллийн тэгш оролцоо хангагдахгүй байгаа учир шалтгааныг олон талаас нь харьцуулан авч үзэх шаардлагатай.

Зорилго

ХБИ-ийн улс төрийн эрхээ эдлэх, сонгох, сонгогдох эрхийн хэрэгжилт, тулгамддаг асуудлуудыг хууль эрх зүйн орчин болон бодит байдалд ямар нөхцөлд байдгийг харьцуулан хөгжлийн бэрхшээлийн хэлбэр тус бүрээр шинжлэх ухааны үндэслэлтэй судлах.

Судалгааны арга зүй

Судалгаанд тоон болон чанарын судалгааны арга зүйг ашигласан. Кэйс судалгааны арга, ганцаарчилсан болон фокус бүлгийн ярилцлага, баримт бичгийн шинжилгээний арга, харьцуулалтын арга зэргийг ашиглан шинжилгээ хийж үр дүнг боловсруулав. Судалгааны түүврийг сонгохдоо ХБИ-ийн сонгох, сонгогдох эрхийн хэрэгжилт бодит байдалд ямар байгааг судлахын тулд аль болох сонгуулиа тогтмол өгдөг, өгөхийг хичээдэг ХБИ ба сонгуулийн аль нэг шатанд нэр дэвшин өрсөлдөж байсан ХБИ гэдэг шалгуураар сонгосон.

Үр дүн

Хөгжлийн бэрхшээлтэй иргэд гэсэн ерөнхий нэршил дор олон янзын бэрхшээлтэй хүмүүс байх бөгөөд бэрхшээл тус бүрд тулгардаг асуудлууд хөгжлийн бэрхшээлийн хэлбэрээс шалтгаалан өөр өөр байна.

Монгол Улсын Үндсэн хуульд тэгш байдал нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим гэж заасан. Мөн иргэн бүр чөлөөтэй, шууд сонгох, саналаа нууцаар гаргах, шууд буюу төлөөлөгчдийн байгууллагаараа уламжлан төрийг удирдах хэрэгт оролцох эрхтэй гэж заажээ. Мөн Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн 30 дугаар зүйлд улс төр, нийгмийн үйл ажиллагаанд оролцох талаар тусгайлан заасан. Сонгуулийн тухай хуулиудад сонгох, сонгогдох эрх болон хөгжлийн бэрхшээлтэй хүнийг санал өгөх боломжоор хангасан байхыг хуульчилсан. Улс төрийн намын тухай хуулийн шинэчилсэн найруулгын 8.5. Нам бодлого, үйл ажиллагаандаа эмэгтэй, ахмад, залуу, хөгжлийн бэрхшээлтэй иргэд зэрэг нийгмийн сонирхлын бүлгүүдийн төлөөлөл, оролцоог хангаж ажиллана, 27.7-д хөгжлийн бэрхшээлтэй нэр дэвшигчийн тоогоор төрийн санхүүжилтийг нэг удаа олгоно гэсэн зохицуулалтуудыг оруулжээ. Монгол Ардын Нам, Ардчилсан Нам, ХҮН намын дүрэмд шинжилгээ хийхэд ХБИ-ийн төлөөллийг хангах тал дээр ямар нэгэн зохицуулалт хийгээгүй байна.

Сонгох эрхийн хэрэгжилтийн бодит байдлын судалгаанд оролцсон харааны бэрхшээлтэй оролцогчдын 50% нь саналаа нууцаар, бие дааж өгөх нөхцөл бүрдээгүй, 21% нь санал өгөх байр хүртээмжгүй, 14% нь тохиромжтой хэлбэрээр мэдээлэл авч чаддаггүй гэж хариулжээ. Бүрэн сонсгоггүй оролцогчдын 90% нь тохиромжтой хэлбэрээр мэдээлэл авч чаддаггүй, 40% нь ойлгомжтой зааварчилгаа байдаггүй, 30% нь саналаа бие дааж өгөх нөхцөл бүрдээгүй, ойр дотно хүмүүсийн нөлөөнд автдаг гэж хариулжээ. Хөдөлгөөний бэрхшээлтэй оролцогчдын 57% нь санал өгөх байр хүртээмжгүй, 20% нь саналаа нууцаар, бие дааж өгөх нөхцөл бүрдээгүй, 13% нь харилцаа, хандлага тааруу гэсэн бол явуулын хайрцаар санал өгч байсан бүх ХБИ саналын

нууцлал алдагдаж байсан гэж хариулав. Харин хөнгөн хэлбэрийн хөдөлгөөний бэрхшээлтэй болон бусад бэрхшээлтэй иргэдэд сонгох эрхээ эдлэхэд ямар нэгэн асуудал тулгардаггүй байна. Судалгаанд оролцсон сэтгэцийн бэрхшээлтэй иргэнд ямар нэгэн асуудал тулгардаггүй, оюуны бэрхшээлтэй 2 хүний 1 нь тогтмол саналаа өгдөг, 1 нь сонгуульд огт оролцож байгаагүй гэв.

Сонгогдох эрхийн хэрэгжилтийн бодит байдлыг судлахаар УИХ-ын болон орон нутгийн сонгуульд нэр дэвшин өрсөлдөж байсан 9 хүнээс судалгаа авсан болно. Бэрхшээлийн хэлбэр нь хөдөлгөөний бэрхшээлтэй 8, сонсголын бэрхшээлтэй 1. Нам эвслээс 6, бие дааж нэр дэвшсэн 3 ХБИ байна. 2000–2020 оны хооронд болсон УИХ-ын сонгуульд 6, орон нутгийн сонгуульд 3 ХБИ нэр дэвшиж өрсөлдсөн бөгөөд орон нутгийн сонгуульд 2 нь ялалт байгуулсан байна. ХБИ сонгуульд нэр дэвшихэд хамгийн их тулгардаг нь санхүү, дэд бүтэц, хандлага ойлголтын асуудлууд байна. Сонгуульд намаас нэр дэвшихэд маш их өрсөлдөөн байдаг тул санхүүгийн боломжгүй, хүрээлэл багатай, танигдаагүй ХБИ-ийн хувьд нэр дэвших нь бараг боломжгүй зүйл юм.

2020 оны ээлжит сонгуулиар жишээ аваад үзэхэд УИХ-ын сонгуульд нийт 606 нэр дэвшигч өрсөлдсөнөөс 2 нь хөгжлийн бэрхшээлтэй нэр дэвшигч, орон нутгийн сонгуульд 17,357 нэр дэвшигч өрсөлдсөнөөс 1 нь хөгжлийн бэрхшээлтэй нэр дэвшигч байжээ.

Дүгнэлт

ХБИ-ийн сонгох эрхийг хууль эрх зүйн актуудаар зохицуулж өгсөн байдаг ч бэрхшээлийн хэлбэрээр хэт ерөнхийлсөн, бодит байдал дээр хэрэгжилт хангалтгүй байдгаас болж ХБИ зохих ёсоор, бие дааж сонгох эрхээ эдлэхэд асуудал тулгардаг. Хөдөлгөөний бэрхшээлтэй иргэдэд санал авах байрны хүртээмжгүй байдал илүү асуудал болдог бол харааны бэрхшээлтэй иргэдийн саналаа бие дааж, нууцаар, чөлөөтэй өгөх эрх нь илүү зөрчигддөг байна. Сонсголгүй иргэдийн эх хэл нь дохионы хэл байдаг бөгөөд бичгийн хэлний чадвараасаа шалтгаалан нэр дэвшигчдийн болон намын мөрийн хөтөлбөрөөс мэдээлэл авах боломж нь хязгаарлагддаг тул хэнийг сонгохоо мэдэхгүй байх, ойр дотно хүмүүсийн нөлөөнд автаж саналаа өгөх гэх мэтээр бие дааж шийдвэр гаргах эрх нь зөрчигддөг. Оюун, сэтгэцийн бэрхшээлтэй иргэдийг бэрхшээлийн хэлбэрээр нь ялгаварлан гадуурхаж, хуулиар сонгох эрхийг нь хязгаарласан заалт байдаг нь ХЭТТ-ын 21 дүгээр зүйл, ИБУТЭТОУП-ын 25 дугаар зүйлд заасан тэгш сонгох эрхийг хамгаалах олон улсын өмнө хүлээсэн үүрэгтэй зөрчилддөг. Монгол Улсад эрх зүйн чадамжгүйг нь шүүхээр тогтоосон 6,000 гаруй оюун, сэтгэцийн бэрхшээлтэй иргэд байдаг гэсэн мэдээлэл байгаа ч албаны эх сурвалж тодорхой бус, мөн энэ төрлийн бэрхшээлтэй иргэдийн сонгох, сонгогдох эрхийн хэрэгжилт ямар түвшинд байгааг тогтоох мэдээлэл хангалтгүй байна. Иймд оюун, сэтгэцийн бэрхшээлтэй иргэдийн улс төр, нийгмийн оролцооны эрхийн хэрэгжилтийг илүү гүнзгийрүүлж судлах шаардлагатай.

Сонгогдох эрхийн тухайд төлөөллийн оролцоог дэмжих хууль эрх зүйн орчин хангалтгүй, дэд бүтэц, улс төрийн намууд бодлогоор төлөөллийн оролцоог дэмждэггүй, хөгжлийн бэрхшээлийн талаар хандлага ойлголт сул байдгаас шалтгаалж ХБИ улс төрийн болон шийдвэр гаргах түвшинд гарах боломж тун хомс байна. Илтгэлийн хүрээнд хийсэн судалгааны үр дүнд тулгуурлан үзэхэд ХБИ-ийн сонгох, сонгогдох эрхийн хэрэгжилтийн төлөв байдал хангалтгүй байгааг тэмдэглэж байна.

Түлхүүр үг: *Хөгжлийн бэрхшээлтэй иргэн (ХБИ), сонгууль, улс төрийн оролцоо, хэрэгжилт.*

Ашигласан материал:

1. Монгол улсын үндсэн хууль. Монгол Улс, Улаанбаатар хот.
2. Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хууль. Монгол Улс, Улаанбаатар хот.
3. Ардчилсан Институт. *Хүний Эрхийн Газар-ын сонгуулийн ажиглалтын тайлангууд*. Монгол Улс, Улаанбаатар хот.
4. Сонгуулийн ерөнхий хороо. *Ардчилсан сонгуулийн түүхэн товчоон*. Монгол Улс, Улаанбаатар хот.
5. Сонгуулийн тухай хууль. Улс төрийн намын тухай хууль. Монгол Улс, Улаанбаатар хот.
6. Хүний эрхийн түгээмэл тунхаглал. Монгол Улс, Улаанбаатар хот.
7. Иргэний болон улс төрийн эрхийн тухай ОУ-ын пакт.
8. Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай конвенц.
9. Инчеоны Стратеги.

ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮҮХЭДТЭЙ ЭЦЭГ ЭХЧҮҮДИЙН СТРЕСС, ТҮГШҮҮРИЙН СУДАЛГАА

А.Отгонбаатар¹

¹ Хүслийн Ордон тусгай цэцэрлэг, Сэтгэл зүйч

otgon.ordon@gmail.com

Үндэслэл

Хөгжлийн бэрхшээлтэй, ялангуяа хүнд хэлбэрийн хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн хөгжлийг дэмжих үйлчилгээ нь урт хугацааны үйл явц байдаг. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн хөгжилд эцэг эхийн оролцоо маш чухал. Төрөл бүрийн сэтгэцийн асуудлууд нь гэр бүлийн харилцаа болон хүүхдийн хөгжилд олон төрлийн сөрөг нөлөөг үзүүлэх боломжтойн дээр хөгжүүлэх үйл ажиллагааны чанар болон хүүхдийн хөгжилд сөргөөр нөлөөлөх бүрэн боломжтой. Иймд эцэг эхчүүдийн стресс түгшүүрт нөлөөлөх хүчин зүйлүүдийг тодруулах нь цаашид хүүхдийн хөгжлийг дэмжиж эцэг эхчүүдэд чиглэсэн үйлчилгээг төлөвлөхөд чухал ач холбогдолтой.

Зорилго

Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй эцэг эхийн стресс түгшүүрийн түвшинг тодорхойлох.

Судалгааны арга зүй


Судалгаанд тусгай цэцэрлэг, явуулын үйлчилгээ, энгийн цэцэрлэгт хүүхэд нь хамрагддаг 24 эцэг эхийг хамруулж 2023 оны 02-р сарын 01-ний өдрөөс 08-ны өдөр хүртэл ганцаарчилсан байдлаар тест бөглүүлэх хэлбэрээр зохион байгуулсан.

- Судалгаа 1: Түгшүүрийн хэмжүүр: Оросын сэтгэл зүйч Ю.Л.Ханины өөрчилсөн хувилбар
- Судалгаа 2: Стрессийн түвшин тодорхойлох тест:

Статистик шинжилгээг SPSS 26 программ ашиглан дотоод нийцлийг тодорхойлж, тойм анализ хийсэн. Хүчин зүйлийн шинжилгээг хэвийн бус тархалттай ординал агуулга учир chi-square тестээр, хувьсагчуудын хамаарлын хүчний Пирсоны корреляцийн коэффициентээр үнэлж үр дүнг тодорхойлсон болно.

Үр дүн


Судалгаа 1: Түгшүүрийн хэмжүүрийн үр дүн



Түгшүүрийн хэмжүүрийн тестийн үр дүнд судлуулагчдын бие хүний түгшүүрийн түвшин дунд /79.2%/ буюу түүнээс дээш /20.8%/ байгаа нь бие хүний түгшүүр өндөр байж болохыг харуулж байна.

Харин нөхцөл байдлын түгшүүрийн хувьд дунджаас бага буюу дунд зэргийн түгшүүрийн түвшин илүү буюу 87.5% байна.

Судалгаа 2: Стрессийн түвшинг тодорхойлсон байдал



Нийт судлуулагчдын 20.8% нь туйлдсан байдалтай байгаа нь эцэг эхчүүдэд чиглэсэн стресс тайлах дэмжлэг үйлчилгээ тодорхой хэмжээнд хэрэгтэй байгааг харуулж байна.

Дүгнэлт

Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй эцэг эхчүүдийн стресс, түгшүүрийн түвшин 20–45% -д өндөр буюу дунджаас дээгүүр байна. Эцэг эхчүүдийн бие хүний түгшүүр нь нөхцөл байдлын түгшүүрээс илүү өндөр байгаа нь судалгааны түүврийг нэмэгдүүлж дахин судлах хэрэгцээ байгааг илэрхийлж байна. Стресс болон түгшүүрийн үзүүлэлтүүд нь хоорондоо эерэг хамааралтай байгаа нь судалгааны үр дүнд гарсан. Стресс болон түгшүүрийн түвшинд нас, хүйс, хөгжлийн бэрхшээлийн төрөл, эцэг эх, гэр бүлийн гишүүний хэн болох, үйлчилгээний төрөл зэргээс хамаарах ялгаа байхгүй байгаа зэрэг шалтгаанаар стресс, түгшүүрийн уялдаа холбоо, үүсгэх хүчин зүйлийг илүү нарийвчлан судлах шаардлагатай. Цаашид тусгай цэцэрлэг болон эцэг эхэд чиглэсэн үйлчилгээнд хамруулах нь эцэг эхийн стресс түгшүүрийн түвшинг бууруулахад нөлөөлж буй эсэхийг хичээлийн жилийн эхлэл болон төгсгөлд ре-тест хэлбэрээр авах, мөн үйлчилгээний сэтгэл ханамжийн үр дүнтэй харьцуулан судлах замаар үр дүнг нарийвчлах боломжтой гэж үзэж байна.

Түлхүүр үг: Хөгжлийн бэрхшээл, эцэг эх, стресс, түгшүүр, сэтгэл ханамж.

Ашигласан хэвлэл:

1. Наранцэцэг.Д, Батдэлгэр.Ж, Гэрэлтуяа.Ц, Цэрэннадмид.Ш, & Төртогтох.Б (2018). *Тусгай хэрэгцээт боловсролын үндэс*. Монгол Улс, Улаанбаатар хот.
2. Мягмар.О (2016). *Хүний хөгжлийн сэтгэл зүйн лекцүүд*. Монгол Улс, Улаанбаатар хот.
3. Мягмар.О (2019). *Сэтгэл заслын зөвлөгөөний онол, арга зүй*. Монгол Улс, Улаанбаатар хот.
4. Сарантуяа.Г (2020). *Сэтгэл оношилгоо*. Монгол Улс, Улаанбаатар хот.
5. Dervishaliq Erjona (2013). Parental Stress in Families of Children with Disabilities: A Literature Review. *Journal of Educational and Social Research*, 3.
6. Rajan Santhosh. (2022). Role of Stress and Age in Resilience Among Parents of the Children with Intellectual Disability. *Research Anthology on Physical and Intellectual Disabilities in an Inclusive Society*, 1428–1438.

ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ИРГЭДТЭЙ ХАРИЛЦАХ ХАРИЛЦАА, НИЙГМИЙН ХАНДЛАГА, ХҮНИЙ ЭРХЭД БЭЛТГЭХ НЬ

Д.Цэндмаа¹

¹ Говьсүмбэр аймаг, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн
“Өөдрөг” зөвлөл холбооны тэргүүн
dashzevegtsendmaa245@gmail.com

Үндэслэл

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг зөвхөн эмнэлгийн үйлчилгээг хүртэгч, бие даан амьдрах чадваргүй, сул дорой гэж үзэн тэдний ялгаатай байдлыг үл хүндэтгэн “эвэртэй туулай үзсэн” мэт харьцаж, үл ойшоон тусгаарлаж, тухайн хүнтэй “өвчтөн” мэтээр харилцдаг “эмнэлгийн загвар” хандлага одоо ч манай улсад байна. Ийнхүү хандах нь хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг нийгмээс тусгаарлаж, өөртөө итгэх итгэлийг үгүй хийж, тэгш бус нөхцөлд амьдарч, нийгэмтэй харилцах харилцааг нь үгүй хийж, тэднийг идэвхгүй амьдрал, өөрийгөө илэрхийлэх чадваргүй болгож, тэд цоожтой хаалганы цаана үлддэг. Хөгжлийн бэрхшээлтэй хүнийг хөгжлийн бэрхшээлийнх нь улмаас аливаа хэлбэрээр ялгаварлахгүй байх, хүний эрхийг хамгаалах, хүний эрхийн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, нийгмийн амьдралд адил тэгш, бүрэн дүүрэн оролцох, хүртээмжтэй орчныг бүрдүүлж, сурч боловсрох, хөдөлмөрлөх нөхцөл бололцоог нь хангах, хөгжлийн бэрхшээлтэй хүний оролцоотой нийгмийг бий болгох хамгийн гол үндэс нь тэдгээр хүмүүсийн ялгаатай байдлыг хүлээн зөвшөөрөх, хүний эрхийн соёлыг бага наснаас нь эхлэн төлөвшүүлэх, тэдэнтэй харилцах харилцааг хөгжүүлэх зайлшгүй шаардлага үүссээр байна.

Зорилго

Судалгааны хүрээнд хөгжлийн бэрхшээлтэй хүний нэр төрийг хүндэтгэн харьцаж, бусдын адил эрх эдэлж, үүрэг хүлээх чадвартай Монгол Улсын иргэн гэдгийг ухамсарлуулах арга замыг тодорхойлоход оршино.

Судалгааны арга зүй

Өөрийн амьдарч буй Говьсүмбэр аймаг болон хотын хөгжлийн бэрхшээлтэй иргэд, төрийн албан хаагч болон энгийн иргэдээс ганцаарчлан уулзах, анкет бөглөх асуумж хэлбэрээр судалгаа авсан.

Үр дүн

Судалгаанаас үзэхэд хөгжлийн бэрхшээлтэй иргэд өөрийгөө илэрхийлэх, бусадтай харилцах, ойлголцох байдал нь хангалтгүй байна. Энэ нь хөгжлийн бэрхшээлтэй хүний талаарх ойлголт хандлага нийгмийн аль ч түвшинд хангалтгүй, хүний эрхийн хувьд тэгш бус, халамж хүртэгч, нийгмийн идэвхгүй гишүүн, юу ч чадахгүй мэтээр дүгнэх, үл ойшоох, түүнээс зайгаа барих, гадуурхах, өөрийгөө хамгаалах чадваргүйг далимдуулан хүч хэрэглэх зэрэг нь тухайн иргэний дахин нийгмийн харилцаанд орох сонирхол идэвхийг бууруулах, айдас түгшүүр бий болгох зэрэг сөрөг үр дүнд хүргэж байна.

Шигтгээ 1. Нэгэн хөгжлийн бэрхшээлтэй иргэн ажилд орохоор очиж шалгалт өгөөд тэнцсэн боловч тухайн хүнийг ажилд аваагүй. Гэвч байгууллагын удирдлага хөгжлийн бэрхшээлийг хүний эрхийн өнцгөөр харах нь сургалтад сууснаар өөрчлөгдөж тухайн хүнээс уучлалт гуйн хандлагаа өөрчилсөн байна.

Тус байгууллагын удирдлага өөрөө үүнийг ярьсан

Шигтгээ 2. Илгэгч миний хувьд нийгмийн хэлж заншсанаар одой иргэн. Нийгэм намайг багаас минь шоолж нэр хоч өгөн хаяг зүүж, гадуурхдаг байсан учир би нь өөрийгөө нийгмээс тусгаарлаж, бүрэг ичимхий болж, гэртээ бүгдэг нэгэн байсан. Гэвч аймгийн “XS” клубийн багш дасгалжуулагч ирж уулзсанаар өөрчлөлт ирсэн. Би



таныг бодибилдингийн тэмцээнд бэлдмээр байна. Та орооч, та чадна гэж урамшуулсан. Тухайн тэмцээнд орсноор би урамшиж улмаар энэ эрдэм шинжилгээний хуралд оролцох итгэл надад төрсөн

Иргэн Д. Цэндмаагийн өгүүлснээр

Дүгнэлт

Олон арван жилийн туршид хөгжлийн бэрхшээлийг зөвхөн анагаах ухааны талаас нь тодорхойлдог байсан бол одоо нийгмийн амьдралд оролцох талаас нь авч үздэг болоод байна. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн талаар зөв мэдээллийг иргэд хожуу буюу зан харилцаа, хүмүүжил төлөвшин тогтсон үедээ мэдээллийг авч байгаа нь хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг хүлээн авах сэтгэл зүй бүрдэхгүй байх нэг шалтгаан мөн юм. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд, залуучуудын бие даан амьдрах, хөгжих боломжийг бүх талаар нь нэмэгдүүлэх, эрхийг нь хүндэтгэсэн нийгмийн орчныг бүрдүүлэх нь чухлаар тавигдаж байна.

Санал

- Ерөнхий боловсролын сургуулийн бага ангийн боловсролд хөгжлийн бэрхшээл гэж юу болох хөгжлийн бэрхшээлтэй иргэний ялгаатай байдлыг хүлээн зөвшөөрөх, хүний эрхийн соёлыг тухай нас, сэтгэхүйд тааруулан иргэний боловсрол хичээлийн үндсэн хөтөлбөрт тусган хэрэгжүүлэх зүй ёсны шаардлага байна.
- “Хамт олонд түшиглэн хамруулан хөгжүүлэх” хандлагыг бий болгохын тулд сургуулиас болон шат шатны байгууллагаас зохион байгуулдаг уралдаан тэмцээн, олон нийтийг хамарсан үйл ажиллагаанд оролцуулсан эсэхээр нэг шалгуур үзүүлэлт бий болгох, үүнд ач холбогдол өгөн үр дүнг тайлагнадаг байх
- Хөгжлийн бэрхшээлийн талаар сөрөг үг, хэллэг ашиглаж аливаа мэдээ, мэдээллийг залруулах, хүмүүсийн буруу хэрэглэсэн нэр томъёо нэршлийг засаж, зөвөөр ойлгуулах

Түлхүүр үг: *Хөгжлийг бэрхшээл, харах өнцөг, сэтгэл зүй, ач холбогдол.*

Ашигласан материал:

1. Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай конвенц.
2. Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хууль. Монгол Улс, Улаанбаатар хот.
3. (2022). *Хөгжлийн бэрхшээлийг хүний эрхийн өнцгөөр харах нь*. Монгол Улс, Улаанбаатар хот.
4. (2014). *Зөв харилцааны цагаан толгой*. Монгол Улс, Улаанбаатар хот.

ХОРИХ ЯЛ ЭДЭЛЖ БУЙ ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХОРИГДЛЫГ НИЙГЭМШҮҮЛЭХ АЖЛЫН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ, ТУЛГАМДАЖ БУЙ АСУУДАЛ

Г.Батжаргал¹

¹Дотоод хэргийн их сургууль, Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн албаны сургууль

jagaajambaa@gmail.com

Үндэслэл

Олон жилийн туршид хөгжлийн бэрхшээлийг анагаах ухааны талаас нь тодорхойлдог байсан бол одоо нийгмийн амьдралд оролцох талаас нь авч үздэг болсон. НҮБ-ын Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай конвенцод “Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн хүний эрх, үндсэн эрх чөлөөгөө бүрэн, адил тэгш эдлэх, хамгаалах, хөхүүлэн дэмжих”-ийг хүлээн зөвшөөрчээ. Энэхүү баримт бичигт ялгаварлан гадуурхалтын эсрэг, адил тэгш боломж, идэвхтэй оролцооны арга хэмжээ зэрэг гол элементүүдийг багтаасан. Хөгжлийн бэрхшээлтэй хоригдлын хувьд ял эдэлж байх хугацаандаа хөгжлийн бэрхшээлийн улмаас үүдэн сэтгэл зүй, бие физиологи болон дэд бүтэц, ахуйн хэрэглээний хүндрэл бэрхшээлтэй ихээхэн тулгардаг. Энэхүү бэрхшээлийг бие даан даван туулж, суллагдсаны дараа хэвийн амьдралд буцаж орох нь тэр бүр хялбар байдаггүй. Мөн гэр бүлийн ойр дотно харилцаа, асаргаа сувилгаа, эрүүл мэндийн үйлчилгээ, нийгэм хамт олны харилцаанаас бүрэн тусгаарлагддаг.

Зорилго


Иймээс хөгжлийн бэрхшээлтэй хоригдлуудад нийгэм, сэтгэл зүй, ахуйн хэрэгцээнээс үүдэлтэй бэрхшээлийг даван туулахад туслах нийгмийн ажлын цогц үйлчилгээг сайжруулах шаардлагатай байгаа бөгөөд “Хөгжлийн бэрхшээлтэй” гэсэн онцлогт нь тохируулан нийгмийн ажлын үйлчилгээг оновчтой, үр дүнд хүргэх нь чухал гэж үзэж байна.

Судалгааны арга зүй

Хөгжлийн бэрхшээлтэй хоригдлуудаас нийгмийн харилцаанд оролцох эрхийн хэрэгжилтийн талаар асуулгын аргаар судалгаа авсан.

Үр дүн

Диаграмм 1. Бэрхшээлийн төрөл, хэв шинж



	96%	84%	93%	96%	84%	71%	80%	74%
Мэдээл Ялгаварлан гадуурхалт хүртээмж	96%							
Адил тэгш боломж		84%	93%					
Идэвхтэй оролцох			96%					
Хөдөлмөр эрхлэлт				84%				
Боловсролоо дээшлүүлэх боломж					71%			
Сэтгэл зүйн үйлчилгээ						80%		
Их	96%							
Дунд								
Бага		84%	93%	96%	84%	71%	80%	74%

Үүнээс харахад хорих ангид хөгжлийн бэрхшээлтэй хоригдлыг ялгаварлан гадуурхах, үл ойшоох, нийгмийн харилцаанд оролцох боломжийг бүрдүүлээгүй байгаа нь харагдаж байна. Мөн тэд мэдээлэл авах, аливаад идэвхтэй оролцох, хөдөлмөр эрхлэх, боловсрол эзэмших, эрүүл мэндийн, сэтгэл зүйн үйлчилгээ авах эрх, боломжууд маш бага байдаг гэж үнэлсэн байна.

Дүгнэлт

Монгол улсын хэмжээнд хорих ял эдлүүлэх ажиллагааны явцад үндсэн хуулиар олгосон эрхээ хязгаарлуулж байгаа хэдий ч хөгжлийн бэрхшээлтэй иргэний тухай хуульд заасан эрхээ хязгаарлуулаагүй юм. Хорих ял эдлүүлэх ажиллагааны явцад хөгжлийн бэрхшээлтэй хоригдлуудын хөдөлмөр чадвар алдалтын хувь хэмжээг тогтоолгох мөн сунгуулах асуудал зайлшгүй тулгардаг. Хорих ял эдлүүлэх ажиллагааны явцад хөдөлмөрийн чадвар алдалтыг тогтоолгох сунгуулах асуудал нь хүртээмжтэй биш байгаа төдийгүй хугацаандаа сунгуулж чадахгүй байх тохиолдлууд судалгаагаар гарсан. Хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хэмжээ тогтоох асуудлыг хуульдаа дээр дурдсан байдлаар тусгасан. Хорих ял эдлүүлэх ажиллагааны явцад хөгжлийн бэрхшээлтэй хоригдлуудын хөдөлмөр чадвар алдалтын хувь хэмжээг тогтоолгох мөн сунгуулах асуудлын үйл явц Хорих ангийн дотоод журам, бусад дүрэм журмаар зохицуулагдаагүй тул хуулийн хэрэгжилт хорих анги бүр дээр өөр өөр байдаг байна.

Хөгжлийн бэрхшээлтэй хоригдол нь бусад хоригдлын адил номын сангаар үйлчлүүлэх, сургалт, нийгмийн ажлын үйлчилгээнд хамрагдахад хүндрэлтэй байна. Тухайлбал харааны бэрхшээлтэй хоригдол номын сангаар үйлчлүүлэхэд уншиж ойлгохуйц тэдэнд зориулсан брайл үсгээр бичигдсэн ном сонин сэтгүүл байхгүй байна.

Санал

Дараах хууль, эрх зүй орчны хувьд өөрчлөлт оруулах, боловсон хүчний чадавхыг бэхжүүлэх, давтан мэргэшүүлэх чиглэлийн саналуудыг бодлогын түвшинд нэмэлт, өөрчлөлт оруулах эрх бүхий ШШГЕГазар, Нийгэм, сэтгэл зүйн хэлтэс, албан тушаалтанд, хорих байгууллагын орчин нөхцөлийг сайжруулах, хөгжлийн бэрхшээлтэй хоригдлын тусгай хэрэгцээнд нийцүүлэх сайжруулах агуулга бүхий саналуудыг практик байгууллагад ажиллаж буй анги, албаны удирдах, шийдвэр гаргах албан тушаалтан, нийгмийн ажилтан нарт хандан гаргаж байна.

Хууль эрх зүйн орчны хувьд өөрчлөлт оруулах, боловсронгуй болгох:

- ШШГЕГазраас хөгжлийн бэрхшээлтэй хоригдолд чиглэсэн сургалтын тусгайлсан хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлэх, нийгмийн ажилтан, сэтгэл зүйчийн аргачилсан зааварт хөгжлийн бэрхшээлтэй хоригдолтой ажиллах үйлчилгээг тодорхой тусгах
- Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 214 дүгээр зүйлийн 214.11-д хоригдлын хүсэлтийг үндэслэн хөгжлийн бэрхшээлтэй хоригдлыг бие эрүүл мэндийн нөхцөлд нь таарсан ажил гүйцэтгүүлж болно гэж заасан байна. Хөдөлмөрийн чадвартай хоригдол мөн хөдөлмөрийн чадвараа алдсан хоригдол нь бие махбодын байдал, хөдөлмөрийн бүтээмжийн хувьд харьцангуй байдаг. Иймд хорих ял эдлүүлэх ажиллагааны явцад хөгжлийн бэрхшээлтэй хоригдлыг хөдөлмөр эрхлүүлэхэд хүндрэлтэй байдаг. Тиймээс хөгжлийн бэрхшээлтэй хоригдлыг хөдөлмөрийн норм, ажлын цагийг холбогдох хууль журамд тодорхой тусгаж өгөх
- Хөгжлийн бэрхшээлтэй хоригдол хорих ангиас суллагдан гарсны дараа бие даан амьдрах, эдийн засгийн хувьд эрх мэдэлжүүлэхэд чиглэсэн төрийн байгууллагуудын хамтын ажиллагааг сайжруулах, тусламж дэмжлэгийг цаг алдалгүй, чирэгдэл багатай, хүртээмжтэй хүргэх
- Хөгжлийн бэрхшээлтэй хоригдлын нийгмийн оролцоог хангахад чиглэсэн үйл ажиллагааг хөтөлбөр, төлөвлөгөөтэй зохион байгуулах
- Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн асаргаа сувилгаа буюу асарч байгаа хүнд нь тэтгэмж олгох асуудлыг шийдвэрлэсэн байдагтай адил, хорих ангид ял эдэлж байгаа хөгжлийн бэрхшээлтэй хоригдлыг асарч байгаа /одоогоор албан бусаар/ хоригдолд шагналын хоног олгох гэх мэтээр холбогдох журам нийцүүлэн урамшуулах
- Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг ажлын байраар хангаж буй байгууллага, аж ахуй нэгжид мөнгөн урамшуулал олгох, татварын бодлогоор дэмждэгтэй нэгэн адилаар хөгжлийн

бэрхшээлтэй хоригдлыг өөрийн үйлдвэрлэлд ажлын байраар хангаж, цалин хөлс олгож буй хорих ангиудад мөнгөн эсвэл бусад хэлбэрийн урамшуулал, хөнгөлөлт олгох зохицуулалтыг холбогдох хууль, журмаар зохицуулах

- Чухал шаардлагатай хууль дүрэм, журмыг дохионы хэлээр бэлтгэн сонсголын болон харааны бэрхшээлтэй хоригдолд танилцуулан таниулах, стандартыг тогтоох,

Боловсон хүчний чадавхыг бэхжүүлэх, даван мэргэшүүлэх:

- Хорих анги, шийдвэр гүйцэтгэх газрын нийгмийн ажилтан болон бусад алба хаагчдад хөгжлийн бэрхшээлтэй иргэдтэй ажиллах арга зүйн талын мэдлэг олгох сургалт, нөлөөллийн ажлыг шат дараатай зохион байгуулж, хөгжлийн бэрхшээлтэй хүний тусгай хэрэгцээг хүндэтгэх, ёс зүйг эрхэмлэх хандлагыг төлөвшүүлэх
- ШШГЕГ-ын харьяа хорих анги, албаны алба хаагчид, тэр дундаа нийгмийн ажилтан, сэтгэл зүйч нарыг дохионы хэлний анхан шатны мэдлэгтэй болгох, цаашлаад энэ чиглэлээр дохионы хэлний хэлмэрч, хөтчөөр мэргэшүүлэх
- Иргэний нийгмийн байгууллагууд нь хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөгжилд чухал нөлөө үзүүлдэг тул тэдгээр байгууллагаар дамжуулан хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг хөгжүүлэх сайн жишиг олон улсад байдаг. Манайд ч мөн адил энэ чиглэлээр мэргэшсэн иргэний нийгмийн байгууллагууд цөөнгүй байдаг тул тэдэнтэй хамтран ажиллаж, үр дүнд хүрэх. Тухайлбал: Боловсон хүчнийг чадваржуулах, сургалт зохион байгуулах, төсөл хөтөлбөр хэрэгжүүлэх зэргээр хамтран ажиллах зэрэг саналуудыг дэвшүүлж байна.

Хорих байгууллагын орчин нөхцөлийг сайжруулах, хөгжлийн бэрхшээлтэй хоригдлын тусгай хэрэгцээнд нийцүүлэх:

- Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 210 дугаар зүйлийн 210.1.7-д хорих анги дахь номын санг үнэ төлбөргүй ашиглах эрхтэй гэж заасан байдаг. Энэ заалтыг үндэслэн харааны бэрхшээлтэй хоригдол номын сангаар үйлчлүүлэхэд уншиж чадахуйц байхаар брайл үсгээр бичигдсэн ном сонин, сэтгүүлийг боломжтой хэмжээгээр байршуулах
- Эмнэлэг хөдөлмөрийн магадлах комиссын хурлыг цахим болон иргэнийг байлцуулахгүйгээр зохих бичиг баримтад үндэслэн хуралдах хэлбэрээр зохион байгуулж болно гэж заасан байдаг. Хорих ангийн орчинд үүнээс үүдэн хөдөлмөрийн магадлах комиссыг хурлыг цахимаар зохион байгуулж хорих ангийн байршилд дотоод дүрэм журмыг зөрчихгүйгээр хурлыг зохион байгуулах
- Харааны бэрхшээлтэй, тэргэнцэртэй хоригдлуудад хорих ангийн номын сан, усанд орох байр, ариун цэвэр, бие засах газар, цайны газар, нийтийн зөвшөөрөгдсөн талбайд чөлөөтэй явах боломжийг бүрдүүлэх, тогтоосон стандартын дагуу дэд бүтцийн асуудлыг шийдвэрлэх

Түлхүүр үг: *Бэрхшээлийг даван туулах, нийгмийн ажлын цогц үйлчилгээ, ялгаварлан гадуурхалт.*

Ашигласан материал:

1. Кристофер Касобон (НҮБХХ-ийн зөвлөх) (2010). *Монгол Улсад хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эдийн засаг, нийгмийн оролцоог сайжруулах нь: Өнөөгийн нөхцөл байдал ба хэтийн төлөв.* Монгол Улс, Улаанбаатар хот.
2. Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хууль. Монгол Улс, Улаанбаатар хот.
3. Нийгмийн даатгалын тухай хууль. Монгол Улс, Улаанбаатар хот.
4. Нийгмийн халамжийн тухай хууль. Монгол Улс, Улаанбаатар хот.
5. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль. Монгол Улс, Улаанбаатар хот.
6. ҮСХ (2020). Үндэсний статистикийн мэдээллийн нэгдсэн сан. Монгол Улс, Улаанбаатар хот.
7. ШШГЕГ (2021). *Нийгэм, сэтгэл зүйн хэлтсээс гаргасан 2021 оны тоон мэдээ.* Монгол Улс, Улаанбаатар хот.
8. *Хорих анги, албаны нийгмийн ажлын аргачилсан заавар.* Монгол Улс, Улаанбаатар хот

ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮҮХДИЙН ХӨГЖЛИЙН ХЭРЭГЦЭЭГ ХАНГАХ АСУУДАЛ

М.Довууч¹

¹Отгонтэнгэр их сургууль
dovuuch@otgontenger.edu.mn

Үндэслэл

Хүүхэд багачуудын хэрэгцээг хангах, оршин амьдрах, сурч боловсрох, хөгжихөд нь дэмжлэг үзүүлэх, тэдний эрхийг хангахад эцэг эх, асран хамгаалагчдын үүрэг, оролцоо асар их юм. Ялангуяа хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн хувьд бол тусгай хэрэгцээ ихээр шаарддаг онцлогтой тул тэдгээрт илүүтэй анхаарал тавих шаардлага гардаг. Тухайн хүүхэд ямар ч байлаа ч гэсэн сурч боловсрох, өөрийгөө хөгжүүлэх, эрүүл аюулгүй орчинд амьдрах эрхтэйг үндсэн хуульд зааж өгсөн. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд бол бусад хүүхдээс ялгагдах онцлогтой тул түүнийг ямагт харгалзан үзэх, тэдэнд хүндэтгэлтэй хандах, бүх талаар хөгжүүлэх шаардлага урган гардаг.

Зорилго

Энэхүү судалгаа бол хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн өнөөгийн хөгжлийн хэрэгцээ хэрхэн хангагдаж буйг судалж, өнөөгийн байдлыг үнэлэх, түүнтэй холбоотой санал дүгнэлт гаргахад зориулагдсан болно.

Судалгааны арга зүй

Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн хөгжлийн хэрэгцээ хэрхэн хангагдаж буй өнөөгийн байдлыг судлахдаа Ерөнхий боловсролын 29-р тусгай сургуулийн ахлах ангийн 41 суралцагчдыг судалгаанд хамруулсан. Судалгааны асуултыг боловсруулахдаа Абрахам Маслоу болон В.В.Глуховын хэрэгцээний шатлалын онолд тулгуурласан болно. Мөн түүнчлэн хууль эрх зүйн орчны нэгдсэн судалгаа, баримт нотолгоонд тулгуурлах, статистик судалгааны арга, харьцуулалтын арга, нэгтгэн дүгнэх, асуулгын арга зэргийг энэхүү судалгаанд ашигласан болно.

Үр дүн

Хүүхдийн хөгжлийн хэрэгцээний судалгаанд Нийслэлийн ЕБС-ийн 29-р тусгай сургуулийн ахлах ангийн 41 суралцагч, үүнээс эрэгтэй 15, эмэгтэй 26 суралцагч хамрагдсан болно. Танай өрхийн орлого хэрэгцээг тань хангаж өгч чаддаг уу? гэсэн асуултад огт хүрэлцдэггүй 12.2%, зарим хэрэгцээг л хангаж өгдөг 46.3%, ихэнх хэрэгцээг хангаж өгдөг гэж 29.3%, бүрэн хангаж өгдөг гэж 12.2% нь хариулт өгсөн. Орон байр нь хүний анхдагч буюу зайлшгүй чухал хэрэгцээнд ордог. Хэрэгцээний шатлалын онолоор анхдагч хэрэгцээнд багтдаг. Орон байрны хэрэгцээ нь бүрэн хангагдсан 43.9%, ямар нэгэн байдлаар хангагдаагүй нь 56.1% байна. ХБХ-ийн хувьд аюулгүй байдлын хэрэгцээ нь огт хангагдаагүй буюу эрсдэлт нөхцөлт амьдарч байгаа хэмээн 19.5%, бага зэрэг хангагдсан 7.3%, дундаж гэж 17.1% хариулсан. Харин бүрэн хангагдсан гэж 46.3% хариулсан байна. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн нийгмийн хэрэгцээ хэрхэн хангагдсаныг тандахад огт хангагдаагүй 20%, бага зэрэг хангагдсан 22.5%, дундаж түвшинд гэж 45% нь хариулсан байна. Бүрэн хангагдсан гэж дөнгөж 5% нь хариулсан байна. Иймд ХБХ-ийн нийгмийн хэрэгцээг хангаж өгөхөд зайлшгүй анхаарал хандуулах шаардлагатай болсныг харуулж байна. Бусдаар хүлээн зөвшөөрүүлэх хэрэгцээний хувьд огт хангагдаагүй гэж 7.3%, бага зэрэг хангагдсан 26.8%, дундаж 43.9% нь хариулсан байна. Бүрэн хангагдсан гэж дөнгөж 9.8% хариулсан нь учир дутагдалтай, анхаарал хандуулах шаардлагатайг харуулж байна.

Хөгжлийн хэрэгцээ хэрхэн хангагдсан байдлыг судлахад бүрэн хангагдсан гэж 2.4%, ихэнхдээ хангагдсан гэж 14.6% нь хариулсан байна. Иймд бид хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн хөгжлийн хэрэгцээг нь хангаж өгч чадаагүй. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдэд нийгмийн харилцаанд ороход ямар нэгэн байдлаар хүндрэлтэй асуудал тулгардаг. Судалгааны үр дүнгээс харвал нийгэм, олон нийтийн арга хэмжээнд хамгийн их 44%, харин эрүүл мэндийн үйлчилгээ авах үед хүндрэлтэй асуудал тулгардаг гэж 22% нь хариулсан байна. Сургуулийн орчин, анги, хамт олон дотор гэж 6% хариулсан нь хамгийн бага юм. Энэ нь бие биеэ харилцан ойлголцдогтой

холбоотой байж болох юм. Судалгааны үр дүнгээс харвал бид хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийнхээ хөгжлийн хэрэгцээг хангаж чадаагүй гэсэн дүгнэлт гарч байна.

Дүгнэлт

Сургалтын хөтөлбөрийг уян хатан байдлаар боловсруулан тэгш хамран суралцах боломжийг өнөө үеийн бодит байдалд нийцүүлэн бүрдүүлж чадвал хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд үе тэнгийнхэнтэй нэгэн адил чанартай, хүртээмжтэй боловсрол эзэмших, үл алагчлалгүй орчинд сурах, хөгжих боломжтой болох юм. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн эцэг эх, асран хамгаалагчдыг эдийн засаг, санхүүгийн хувьд тодорхой дэмжлэг үзүүлэх, сэтгэл зүйн тогтвортой байдлыг хангахад боломж олгох, ажлын чөлөө олгох, хөнгөлөлт урамшуулал эдлүүлэх нь юу юунаас чухал болжээ. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн хөгжлийн хэрэгцээг хангахын тулд юуны өмнө анхдагч хэрэгцээнүүдийг бүрэн хангаж өгөх шаардлагатай бөгөөд үүнд өрхийн гишүүдийн үүрэг, оролцоо чухал хэдий ч өрхийн орлого багатайгаас шалтгаалан хөгжлийн хэрэгцээг хангахад санхүүгийн боломж хүрэлцэхгүй байх тохиолдол гардаг.

Түлхүүр үг: *Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд, хөгжлийн хэрэгцээ, хэрэгцээний шатлал, хүүхдийн эрх.*

Ашигласан материал:

1. Алтанхундага.Х (2021). “Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн илрүүлэг, эрт үеийн дэмжих хөтөлбөрийг туршсан үр дүн” докторын диссертацийн ажил. Монгол Улс, Улаанбаатар хот.
2. Монгол Улсын стандарт (MNS 5418:2008). *Бага, дунд боловсролын хэвлэмэл сурах бичигт тавих шаардлага*. Монгол Улс, Улаанбаатар хот.
3. Монгол Улсын стандарт (MNS 6055:2009). *Иргэний барилгын төлөвлөлтөд хөгжлийн ХБХ-ний шаардлагыг тооцсон орон зай, орчин*. Монгол Улс, Улаанбаатар хот.
4. *Боловсролын ерөнхий хууль*. Монгол Улс, Улаанбаатар хот.
5. *Хүүхэд хамгааллын тухай*. Монгол Улс, Улаанбаатар хот.
6. Хөдөлмөр нийгмийн хамгааллын яам (2023). “Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг тэгш хамруулан сургах ойлголт, хандлага, нөхцөл боломж” судалгаа. Монгол Улс, Улаанбаатар хот.
7. БШУЯ (2022). *Хичээлээс гадуурх сургалтын ажлын үлгэрчилсэн хөтөлбөр*. Монгол Улс, Улаанбаатар хот.
8. Цэнд.Ц, Батхүрэл.Г, & бусад нар (2019). *Менежмент сурах бичиг*, ШУТИС. Монгол Улс, Улаанбаатар хот.

ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛ СУДАЛАЛЫН ҮР ДҮНГИЙН АСУУДАЛД

О.Багтуяа, М.Ганхөлөг, Ц.Цолмон, Ө.Гангамаа¹
¹Мандах их сургуулийн СШУИТ-н багш нар
 battuya@mandakh.edu.mn

Зорилго

Бид дээрх статистик мэдээллээс үндэслэн өнгөрсөн 2003–2022 жилийн статистик мэдээллийг 3 жилийн давамжтайгаар авч үзэн иргэдийн дүгнэлт хийж дараагийн 5 жилүүдэд аль төрлийн хөгжлийн бэрхшээлтэй иргэд давамгайлах магадлалтай байна гэдгийг таамаглах, улмаар урьдчилан сэргийлэх боломж буй эсэх талаар тодруулахыг оролдлоо.

Судалгааны арга зүй


Бид энэ илтгэлдээ хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн тоон судалгааг 2003–2022 оны 20 жилийн мэдээлэл дээрээ тулгуурлан хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн тоо мэдээллийн таван жилийн төлөвийг Eviews программ ашиглан ашиглан прогнозон гаргана.

Үр дүн

Монгол улс 2022 оны байдлаар нийт 3457548 иргэнтэй түүний 3.329% буюу 115115 иргэн хөгжлийн бэрхшээлтэй иргэн бүртгэгдсэн. Үүнийг 2003 харьцуулбал 54680 буюу 47,5%-иар өссөн үзүүлэлттэй байна. Тэр дундаа хөгжлийн бэрхшээлийн төрлийн дундаж өсөлт нь: Хараа – 3.38%, хөдөлгөөн – 3.01%, сэтгэцийн бэрхшээл – 4.368% хамгийн өндөр хувийг эзэлж байна.

Дээрх 2003–2022 оны мэдээлэлд тулгуурлан 2023–2027 оны өсөлтийн дундаж хурдыг Арифметик дундын аргаар тооцоолов.

Диаграмм 1. 2003–2027 оны өсөлтийн дундаж хурдыг үзүүлэв.



2003–2022 оны тоон мэдээлэлд тулгуурдан 2023–2027 оны хөгжлийн бэрхшээлийн аль төрөл, хэр нэмэгдэх хандлагатайг дээрх зурагт үзүүллээ. Дээрх өсөлтийг 2022 онтой харьцуулахад Хараа – 9.1%, хөдөлгөөн – 8.6%, сэтгэц – 14.1% бусад бэрхшээл – 7.2%-иар өсөх төлөвтэй байна.

Тиймээс энэ бүгдэд нөлөөж буй хүчин зүйлсийг дэлгэрэнгүй судалж бууруулах арга хэмжээ авах нэн шаардлагатай болох нь дээрх судалгаанаас харагдаж байна.

Дүгнэлт

Монгол Улсын хүн ам 2003 онд 2495091 иргэнтэй байсан бол 2022 онд 34575748 иргэнтэй бол тус онтой харьцуулахад 27.89% нэмэгдсэн байна. Харин 2003 онд Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн тоо 60435 буюу хүн амын 2,4%-ийг эзэлдэг байсан. Улсын статистик мэдээн дэх гурван үзүүлэлт дээр тулгуурлан авч үзвэл дараах дүгнэлт хийж болохоор байна. Үүнд: Сэтгэцийн

бэрхшээл нь 20 жилийн туршид тасралтгүй өссөн цор ганц бэрхшээл байна. Мөн энэхүү бэрхшээл нь өмнө хамгийн бага тоон үзүүлэлттэй байсан бол одоо хамгийн их болсон буюу 3681 байснаас 21639 болж 20 жилийн дотор 17958 иргэдээр өссөн байна. 2003 онд 2495091 хүн амтай байсны 3681 хүн, нийт хүн амын 0.0014%-ийг 10000 хүний 14 хүн сэтгэцийн бэрхшээлтэй байсан байна. 2022 онд 3457548 хүн амтай байсны 21639 хүн, нийт хүн амын 0.0062%-ийг 10000 хүний 62 хүн сэтгэцийн бэрхшээлтэй болж нэмэгдсэн байна.

Хөдөлгөөний бэрхшээл нь 20 жилийн өмнө 9028 байснаас 21061 болж 12033 иргэдээр өссөн байна. Хүн амын тоотой харьцуулахад эзэлж буй хувиар үзүүлбэл 2003 онд 10000 хүний 36 хүн нь хөдөлгөөний бэрхшээлтэй байсан бол 2022 онд 10000 хүний 60 хүн хөдөлгөөний бэрхшээлтэй байна.

Харааны бэрхшээл нь 20 жилийн өмнө 4540 байснаас 12696 болж 20 жилийн дотор 8156 иргэдээр өссөн байна. 2003 онд 10000 хүний 18 хүн харааны бэрхшээл байсан бол 2022 онд 10000 хүний 36 хүн болж өссөн байна.

Бид 2003–2022 оны тоон мэдээлэлд тулгуурдан 2023–2027 оны хөгжлийн бэрхшээлийн аль төрөл, хэр нэмэгдэх хандлагатайг судалж үзлээ. Уг таамаглаж гаргасан жилүүдийг Дээрх өсөлтийг 2022 онтой харьцуулахад Хараа – 9.1%, хөдөлгөөн – 8.6%, сэтгэц – 14.1% бусад бэрхшээл – 7.2%-иар өсөх төлөвтэй байна. Цаашид эдгээр үзүүлэлт нэмэгдэх хандлагатай байна. Тиймээс энэ бүгдэд нөлөөж буй хүчин зүйлсийг дэлгэрэнгүй судалж бууруулах арга хэмжээ авах нэн шаардлагатай болох нь дээрх судалгаанаас харагдаж байна. Нэгэнт үүссэн хөгжлийн бэрхшээлийн талаар судлах нь зүйтэй. Гэхдээ хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн тоо өсөхөөс сэргийлэх талаар анхаарах нь ач холбогдолтой гэж үзэж байгаа юм.

Олдмол бэрхшээлд нөлөөлөх хүчин зүйлсийг авч үзвэл:

Монгол улсад 2022 онд зам тээврийн 24121 осолд 3418 өртөж хүн амь нас, эрүүл мэндээрээ хохирсон байна өнгөрсөн оны үзүүлэлтээс 19.6%-иар өсжээ. Дээрх мэдээллээс үзэхэд Зам тээврийн осолд өртсөн хүмүүсийн 21% нь толгой, 22.6% нь хөлдөө бэртэл гэмтэл авдаг байна. Олдмол бэрхшээлд авто осол нөлөөлдөг нь харагдаж байна. Энэ мэтээр бусад хүчин зүйлийг нь нарийвчлан тодорхойлбол хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн тоо өсөхөөс сэргийлж чадна. Энэ талын нарийвчилсан судалгааг жил бүр гаргаж, олдмол хөгжлийн бэрхшээл талаас нь олон нийтэд таниулж байвал зүйтэй гэж үзэв.

Түлхүүр үг: *Хөгжлийн бэрхшээл, хараа, хөдөлгөөн, сэтгэц, судлал.*

Ашигласан материал:

1. Ashington group: *History of disability measurement and data availability.*
2. ХНХЯ (2017). *Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн асуудал: Бодлого, үйл ажиллагаа.* Монгол Улс, Улаанбаатар хот.
3. Статистикийн мэдээллийн нэгдсэн сан (1212.mn).
4. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй эцэг эхийн холбоо. *Хөгжлийн бэрхшээлийн төрлүүд.* Монгол Улс, Улаанбаатар хот.
5. Бямбасүрэн.С (2007). *Сэтгэцийн эмгэг судлал.* Монгол Улс, Улаанбаатар хот.
6. (2022). *“Монгол улсад бүртгэгдсэн зам тээврийн осол, гэмт хэрэг, зөрчлийн статистик үзүүлэлтийн эмхэтгэл”* (ху.17–22). Монгол Улс, Улаанбаатар хот.
7. *Хүрээлэн буй орчин, агаарын бохирдол.* Монгол Улс, Улаанбаатар хот: UNICEF
8. (2021). *Улаанбаатар хотын агаарын бохирдол* (2018 ба 2021 оны харьцуулалт Сурталчилгааны нийтлэл №1). Монгол Улс, Улаанбаатар хот.
9. (2022). *“Монгол улсад бүртгэгдсэн зам тээврийн осол, гэмт хэрэг, зөрчлийн статистик үзүүлэлтийн эмхэтгэл”* (ху.17–22). Монгол Улс, Улаанбаатар хот.
10. www.worldlifeexpectancy.com

ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮНД ҮЗҮҮЛЭХ НИЙГМИЙН ХАЛАМЖ, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАГВАР, ПАРАДИГМУУД, ЧИГ ХАНДЛАГА

Ц.Энхтүвшин¹

¹Олон Улсын Улаанбаатарын Их Сургууль, Нийгмийн Ажлын Тэнхим
enkhtuvshin.ts@ulaanbaatar.edu.mn

Үндэслэл

Хөгжлийн бэрхшээлтэй холбогдох онол, парадигмууд нь ХБХ тулгамдаж буй асуудал, шийдвэрлэх арга замыг чиглүүлэгч болдог утгаараа хөгжлийн бэрхшээл судлалд томоохон байр суурь эзэлдэг. Хөгжлийн бэрхшээл судлалын ойлголтыг нэмэгдүүлэх цаашлаад бодлого үйл ажиллагаа, нийгмийн үйлчилгээний хүрээг тодорхойлох, хөгжлийн бэрхшээлтэй хүнд шинэ тутамд тулгарч буй асуудлыг шийдвэрлэх, асуудлын гаргалгааг олоход ач холбогдолтой юм.

Зорилго

Хөгжлийн бэрхшээлтэй хүний талаарх онол үзэл баримтлалын ойлголт ухагдахуун, өөрчлөлт, онцлог, хөгжлийн бэрхшээлтэй хүнд үзүүлэх нийгмийн халамж, үйлчилгээнд баримталж буй орчин үеийн парадигмын чиг хандлагыг судлахад оршино.

Судалгааны арга зүй

Баримт бичиг, эх сурвалжид анализ хийх, харьцуулах. Хөгжлийн бэрхшээл судлалын үндсэн онолын үзэл баримтлал, парадигм тэдгээрийн ойлголт ухагдахуун, онцлогийг тайлбарлах, уялдаа холбоо, давуу болон сул талуудад задлан шинжилгээ хийв.

Үр дүн

Шинжлэх ухааны парадигм нь харьцангуй тодорхой загвараас эхлээд өргөн хийсвэр ертөнцийг үзэх үзэл хүртэлх хүрээг хамруулдаг харилцан уялдаатай зарчмын багц юм. Хөгжингүй улс орнууд хөгжлийн бэрхшээлийн орчин үеийн хандлага болох хэвийнжүүлэх, бие даан амьдрах парадигмыг хэмжүүрээр халамжийн үйлчилгээний тогтолцоо, хүртээмж, үр дүнд анализ хийсэн судалгааны ажлууд хийгдэж байна.

Хүснэгт 1. Онол загваруудын онцлог, агуулга

	<i>Агуулга</i>
Ди –медикалишин загвар (demedicalization) 1960–1970	Бусдад хэт найдахаас зайлсхийж өөрийн эрүүл мэнддээ анхаарах боломж нөхцөлийг бүрдүүлэх
Ди–институшин загвар (deinstitutionalization) 1960–1970	ХБХ нийгмийн амьдралд оролцуулах, сэргээн засах, олон нийтийн оролцооны нийгмийн халамжийн үйлчилгээ
Хэвийнжүүлэх загвар (Normalization) 1970–1980	Өдөр тутмын аж байдал, хувь хүний хэвийн өсөлт хөгжил, чөлөөт сонголт тулгуурлах, туслах хэрэгслээр хангах
Нийгмийн нэгдэлийн загвар (social integration) 1980–1990	Олон нийтийн үйл ажиллагаанд оролцож бусдын адилаар нөөц боломжоо ашиглах, гэр бүл зэрэг шийдвэр гаргах
Бие даан амьдрах загвар (independent living) 1980 оноос	ХБХ өөрт буй нөөц чадвараа боломжит дээд хэмжээнд ашиглаж ажил хөдөлмөр– эдийн засгийн бие даах

¹ Luciano L’Abate. Paradigms, in Theory Construction. Springer. 2012. page. 58

Хүснэгт 2. Нийгмийн халамжийн үйлчилгээний үндсэн парадигм тэдгээрийн онцлог

	Сэргээн засах парадигм (Rehabilitation Paradigm)	Бие даан амьдрах парадигм (Rehabilitation Paradigm)
Асуудлын хүрээ	Бие махбодын бэрхшээл (хөдөлмөрийн чадвар), Сэтгэл санааны бэрхшээл (дасан зохицол)	Бусдаас хараат бус байх
Асуудлын цөм	Хувь хүнд	Орчин нөхцөлд
Шийдвэрлэх арга	Эрүүл мэнд, хөдөлмөр, ажил мэргэжлийн сэргээн засалч зөвлөгч зэрэг мэргэжлийн интервенц	Хувийн туслан зөвлөгч (дэмжигч), хэрэглэгчийн эрх ба нийгмийн бэрхшээлийг арилгах
Удирдлага, хяналт	Мэргэжилтнүүд төвт	Хэрэглэгч төвт

Эх сурвалж: 김동호. 자립생활패러다임에서 본 한국장애인복지관 연구. Journal of Korean Welfare Administration. 제6호. 2002, pp 91-117

Дүгнэлт

Судалгааны ажлын хүрээнд хөгжлийн бэрхшээл судлалын үндсэн онолын загварууд, парадигмийг объект болгож тэдгээрийн ойлголт ухагдахуун, онцлог, давуу болон сул талуудад анализ хийж дараах онцлог шинж, үр дүнг харуулж байна.

- Шинэ парадигм нь өөрийн зорилгодоо хүрэх суурь нөхцөл нь өмнөх үзэл санаанд тулгуурласан бодлого, үйл ажиллагаа, халамжийн тогтолцоо, үйлчилгээний төрөл, тэдгээрийн чанар, үр дүн чухал нөлөө үзүүлдэг байна. Жишээлбэл сэргээн засах үйлчилгээнд тулгуурлан бие даан амьдрах загвар үр дүнтэй хөгжих боломжтой юм.
- Хөгжлийн бэрхшээлийн орчин үеийн нийгмийн халамжийн үйлчилгээний парадигмид сэргээн засал болон бие даан амьдрах загвар томоохон байр суурь эзэлж байна.

Манай улсын хувьд хөгжлийн бэрхшээлтэй хүнд чиглэсэн бодлого, дамжуулах тогтолцоо, халамж, үйлчилгээг шинэчлэх, боловсронгуй болгоход онол, парадигмын орчин үеийн чиг хандлагыг тусгах, хэрэгжилтэд анхаарах зэргээр хөгжлийн бэрхшээлтэй хүнд тулгамдаж буй асуудлыг шийдвэрлэх, үйлчилгээг төрөлжүүлэх боломжтой юм.

Түлхүүр үг: Хөгжлийн бэрхшээл, загвар, парадигм, нийгмийн халамж, үйлчилгээ.

Ашигласан материал:

1. Сүжин.И & Намжил.Т (2014). *Нийгмийн халамжийн ажлын үндэс*. Монгол Улс, Улаанбаатар хот.
2. Selwyn Goldsmith (2011). *Disigning for the disabled the new paradigm*, Routledge.
3. Luciano L'Abate (2012). *Paradigms, in Theory Construction*. Springer.
4. Priestley.M (2003). A life course approach, *Concepts in Disability*, 8, 11-34.
5. 이종호, 이영미, 이은미, 장애인복지론, 학지사. 2014
6. 최윤영, 이경준. 장애인복지론. 서울. 2010
7. 박경수. 장애인복지 서비스 프로그램의 패러다임 동향 분석. 2007 page.5
8. (2020). 개선방안, *Journal of Community Welfare*, 74, 147-171.

БАГШ НАРЫН ТҮГШҮҮР БОЛОН АЖЛААС ХАЛШРАХ ХАМ ШИНЖИЙГ ХАРЬЦУУЛАН СУДАЛСАН НЬ

Э.Биндэрьяа¹

¹ МУБИС, БОСС сэтгэл судлалын магистрант

Bindereiya.tuuchee@gmail.com

Үндэслэл

Тусгай хэрэгцээт хүүхдүүд, ялангуяа хүнд хэлбэрийн хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд нь асаргаа өндөр, хөгжүүлэх үйл ажиллагааг төрөл бүрээр олон мэргэжилтэнтэй хамтран, удаан хугацаанд тасралтгүй зохион байгуулсны үр дүнд бага хэмжээний ахиц гаргадаг тул залуу багш мэргэжилтнүүдийн дунд шантрах, ажлаас халшрах үзэгдэл их гардаг. Нөгөө талаас хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй ажиллаж буй багшид тухайн хүүхдийн гэр бүл цаашлаад сэргээн засах баг, сэтгэл зүйч, тусгай хэрэгцээт боловсролын багштай хамтран ажиллах зайлшгүй хэрэгцээ үүсдэг нь эргээд ажлын байран дээр харилцааны зөрчилд орох, түгшүүр үүсэх, эсвэл стрессийн түвшин нэмэгдэхэд нөлөөлнө.

Зорилго

Үүнээс үзэхэд тусгай сургууль, цэцэрлэгийн багш нарын дундах ажлаас халшрах хам шинж, түгшүүрийг судлах нь хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн хөгжлийг дэмжих үйл ажиллагаанд чухал нөлөө үзүүлнэ хэмээн таамаглаж тус бичил судалгааны ажлыг гүйцэтгэв.

Судалгааны арга зүй

Асуулга-анкетын арга, мэдээллийг задлан шинжлэх, харьцуулах, мэдээллийг нэгтгэн дүгнэх, SPSS 26 шинжилгээний программ

Үр дүн

Судалгаанд Хүслийн Ордон тусгай цэцэрлэгийн, 21–26 насны 7 эмэгтэй /77.8%/, 2 эрэгтэй /22.2%/, нийт 9 багш хамрагдсан. Эдгээр багш 3–4 жил тус цэцэрлэгт ажиллаж байна. Насны хувьд 21 настай 1, 23 настай 3, 25 настай 4, 26 настай 1 багш байв. Үүнээс харахад тусгай цэцэрлэгийн үндсэн багш нар харьцангуй залуу хүмүүс болох нь харагдаж байна.

Хүснэгт 1. Түгшүүрийн түвшин

Код	Түгшүүрийн түвшин				Ажлаас халшрах хам шинж	
	Өмнө		Дараа		Өмнө	Дараа
	Б.Х	Н.Б	Б.Х	Н.Б		
Нийт	23	18.6	21.7	18.3	65	50
Дундаж	2.5	2	2.4	2	7.2	5

Статистик шинжилгээгээр ажлаас халшрах хам шинж өөрчлөгдсөн эсэхийг шинжлэв.

Шинжилгээгээр t утга нь 3.780, харин түүнтэй харгалзах П утга нь 0.005 гарсан нь 0.05-аас бага тул ялгаатай болох нь харагдаж байна. Өөрөөр хэлбэл ажлаас халшрах хам шинж нь зөвлөгөөнд хамрагдахаас өмнө болон дараа нь ялгаатай байна. Үүнээс үзэхэд сэтгэл зүйн зөвлөгөө нь ажлаас халшрах хам шинжид эерэг нөлөө үзүүлэх нь батлагдлаа. Цаашлан ажлаас халшрах хам шинж болон түгшүүр хоорондоо хамааралтай эсэхийг Пиерсоны корреляциар шинжлэв.

Хүснэгт 2. Ажлаас халшрах хам шинж ба бие хүний түгшүүрийн корреляци /дараа/

		АХХШдараа	Түгшүүр_БХ2
АХХШдараа	Pearson Correlation	1	-.388
	Sig. (2-tailed)		.302
Түгшүүр_БХ2	Pearson Correlation	-.388	1
	Sig. (2-tailed)	.302	

$R = -0.388$ гарсан нь ажлаас халшрах хам шинж ба бие хүний түгшүүр сэтгэл зүйн зөвлөгөөний дараа сөрөг бага хамааралтай гарав. Үүнээс харахад ажлаас халшрах хам шинж нэмэгдэх тусам бие хүний түгшүүр буурч байгаа нь сонирхолтой байна.

Харин ажлаас халшрах хам шинж болон нөхцөл байдлын түгшүүр сэтгэл зүйн зөвлөгөөний дараа хамааралтай эсэхийг шинжлэхэд $R = -0.774$ тул эерэг дунд хамааралтай гарсан. Энэ нь сэтгэл зүйн зөвлөгөөний өмнөх байдалтай адилаар нөхцөл байдлын түгшүүр нэмэгдэх тусам ажлаас халшрах хам шинжийг нэмэгдүүлдэг болохыг баталж байна. Үүнээс үзэхэд нөхцөл байдлын түгшүүр ажлаас халшрах хам шинжид нөлөөлж байгаа нь батлагдлаа.

Дүгнэлт

1. Хүнд хэлбэрийн хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд зонхилдог тус цэцэрлэгийн онцлог, хүүхдүүдийн асаргаанаас гадна эцэг эхийн өндөр хүлээлт, хүүхдэд ахиц хурдан гарахгүй байх зэрэг нь багшийг ядрах, халшрах байдалд хүргэдэг болох нь сэтгэл зүйн ганцаарчилсан зөвлөгөөний үеэр илүү тодорхой болов. Түүнчлэн эдгээр багш нарын нас, сэтгэл зүйн онцлог зэргээс харвал тусгай цэцэрлэгт ажилладаг багш нарын хувьд ачааллыг тэнцүүлж, зохицуулалт хийх шаардлагатай байна.
2. Сэтгэл зүйч, сэтгэл зүйн зөвлөгөө нь тусгай цэцэрлэгийн багш нарт эерэг нөлөөтэй ба сэтгэл зүйч нэмэлтээр ажиллах нь чухал ач холбогдолтой юм.
3. Ажлаас халшрах хам шинж нөхцөл байдлын түгшүүр хоёр нь эерэг дунд хамааралтай болох нь статистик шинжилгээгээр батлагдсан бөгөөд ажлаас халшрах хам шинж буурах тусам нөхцөл байдлын түгшүүр буурч байна.

Түлхүүр үг: *Багш, ажлаас халшрах хам шинж, түгшүүр, зөвлөгөө.*

Ашигласан материал:

1. Chenoufi, L., Ellouze, F., Cherif, W., & Mersni, M. (2012). Stress and burnout among Tunisian teachers. *The British Journal of Educational Psychology*.
2. Kokkinos, C. M. (2007). Job stressors, personality and burnout in primary school teachers. *The British Journal of Educational Psychology*.
3. Maslach, C & Marek, T. (1993). *Burnout: A Multidimensional Perspective*. Shaufeli Washington DC.

ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮҮХЭДТЭЙ ЭЦЭГ ЭХИЙН ХЭРЭГЦЭЭ ШААРДЛАГЫГ ТОДОРХОЙЛОХ НЬ (Нөхцөл байдлын судалгааны үр дүн)

Т.Бадамцэцэг, Д.Одончимэг¹

¹ Ховд аймгийн хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн төв
dcfpwd@kho.nrc.gov.mn

Үндэслэл

Гэр бүл, эцэг эхийн оролцоо “Тусгай хэрэгцээт боловсролын үйлчилгээ шаардлагатай хүүхдийн боловсролын чиглэлээр мэргэшсэн, чадварлаг багш нь сурагчийнхаа эцэг эх, асран хамгаалагчидтай нягт хамтран ажиллаж тэдэнд хүүхдийнх нь тусгай хэрэгцээ, онцлог байдлыг ухамсарлан ойлгуулж, хүүхэдтэйгээ харилцах арга барил, хүүхдийнхээ сургалт хүмүүжлийн зорилго зорилтдоо хүрэхэд нь туслан дэмжих, зөвлөн дадлагажуулах мэдлэг, ур чадвар эзэмшсэн байна” хэмээн “Тусгай боловсролыг дэмжих төвийн үүрэг оролцоо болон үйл ажиллагаа” сэдэвт нээлттэй хэлэлцүүлгийн гарын авлагад тусгасан байдаг. Тусгай хэрэгцээт боловсрол шаардлагатай хүүхэд бүр бусдын адил хөгжиж, нийгмийн амьдралд тэгш оролцох эрхтэй. Тэгш оролцоог хангахын тулд багш, эцэг эх, нийгэм, иргэдийн оролцоо маш чухал байдаг. Иймээс эцэг эхчүүдэд тулгамдаж буй асуудлыг судалж мэдэх шаардлагатай байна.

Зорилго

Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эцэг эхчүүдийн тулгамдаж буй асуудал, хэрэгцээ шаардлагыг илрүүлэх, шаардлагатай дэмжлэг туслалцааг тодорхойлох.


Судалгааны арга зүй

Тусгай сургуулийн нийт 183 эцэг эхээс урьдчилан боловсруулсан асуумжийн дагуу мэдээлэл цуглуулж дүн шинжилгээ хийсэн. Тусгай сургуулийн сурагчдын эцэг эхээс судалгаа авах асуулгыг цаг хугацаа хэмнэх, өгөгдөл нэгтгэх болон дүн шинжилгээ хийхэд хялбар байх үүднээс аль болох бүрэн нэгтгэж, зарим шаардлагатай мэдээллийн талаар тэдний санаа бодлыг мэдэх зорилгоор нээлттэй асуултыг оруулсан болно. Судалгааны мэдээлэлд дүн шинжилгээ хийхдээ SPSS 22 програмыг ашигласан.


Үр дүн

Судлуулагчдын ихэнх хувь нь гэрлэсэн байгаа боловч 14% нь гэрлээгүй байна. Үүнээс гэрлэлтээ батлуулсан нь 27.5%-ийг эзэлж байгаа бол гэрлэлтээ батлуулаагүй нь 3.5%-ийг эзэлж байна.

Зураг 2. Ажил хийдэг эсэх




Зураг 1. Гэрлэлтийн байдал



Судалгаанаас үзэхэд ажил хийдэггүй хүмүүс, ажил хийдэг хүмүүсээс 2.9%-иар илүү байна.

Судлуулагчдын орлогын эх үүсвэрийн ихэнх хувийг цалин, тэтгэмж харин хамгийн багахан хувийг тэтгэвэр, хүүхдийн мөнгө эзэлдэг байна. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн ээж нь эсвэл аав нь ажил хийдэг гэж үзвэл нэг хүний цалин нь тухайн гэр бүлд хүрэлцдэггүй байна.

Зураг 4. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй эцэг эхчүүдэд чиглэсэн ямар үйлчилгээ авахыг хүсэж байна.



Дүгнэлт


Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эцэг эхчүүдийн дийлэнх хувь нь дундаж насныхан бөгөөд ихэнх гэр бүл нь бага хэмжээний цалин бүхий орлогын үндсэн эх үүсвэртэй байна. Өрхүүдийн дундаж орлого болон ам бүлийн тооны харьцуулалт нь тэдний амьдралын түвшин дунджаас доогуур байна гэж үзэж болохоор байна. Эцэг эх, асран хамгаалагчдын хувьд хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй нь холбоотой янз бүрийн асуудал, бэрхшээлүүд тулгарч байна. Тухайлбал, олон нийтийн ойлголт хандлага, нийгмийн орчин, төр засгийн дэмжлэг туслалцаа, гэр бүлд үзүүлэх системтэй үйлчилгээтэй холбоотой тулгамдсан асуудлууд байна. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй гэр бүлд төрөөс болон иргэд, олон нийт, тусгай сургууль, мөн холбогдох бусад байгууллагын зүгээс мэргэжлийн туслалцаа дэмжлэг үзүүлэх нь чухал юм. Төр засгаас гэр бүлд санхүүгийн тусламж дэмжлэг, тэтгэвэр тэтгэмж олгох, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд үзүүлэх эрүүл мэнд, боловсролын үйлчилгээний чанар хүртээмжийг нэмэгдүүлэх, мөн холбогдох байгууллагуудын хувьд эцэг эхчүүдийг чадавхжуулахад чиглэсэн төрөл бүрийн үйлчилгээний хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлэх, арга зүйн дэмжлэг, зөвлөгөө мэдээллээр хангах шаардлагатай байна.

Түлхүүр үг: Тусгай хэрэгцээт боловсрол, амьдралын түвшин, бэрхшээл, хүртээмж.

Ашигласан материал:

1. БСШУСЯ, БХ, & UNESCO (2019). *Монгол Улсын Боловсролын суурь мэдээллийн тайлан*. Монгол Улс, Улаанбаатар хот.
2. Батцэнгэл. Г (2014). *Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн сурган сэтгэлзүйн зарим асуудал*. Монгол Улс, Улаанбаатар хот.
3. Нарантуяа. М (2013). *Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн сэтгэл зүй*. Монгол Улс, Улаанбаатар хот.
4. Саранцэцэг. О (2011). *Сонсголын бэрхшээл ба дүлийрэл*. Монгол Улс, Улаанбаатар хот.

Зураг 3. Орлогын эх үүсвэр



Дээрх үзүүлэлтүүдээс үзэхэд эцэг эхчүүдэд шаардлагатай мэдээлэл өгөх, хүүхэдтэй ажиллах арга зүйн талаарх сургалт семинарын үйл ажиллагаа явуулах нь өндөр хувийг эзэлж байна. Харин хуулийн зөвлөгөө, үйлчилгээ болон эцэг эхчүүдийн туршлага зэрэг нь дундаж хувийг эзэлсэн байгаа нь дээрх хүснэгтээс харагдаж байна.



VI БҮЛЭГ

ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТ

ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮНИЙ МЭРГЭЖЛИЙН УР ЧАДВАРЫГ ҮНЭЛЭХ НЬ ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТЭД НӨЛӨӨЛӨХ

Б.Энхзул, О.Болорчимэг¹

¹ Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сургалт, үнэлгээ, судалгааны институтийн арга зүйч

Үндэслэл

Монгол боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдын 2016 оны 04-р сарын 18-ны өдрийн Мэргэжлийн чиглэл, индексийн 16 салбарын 581 мэргэжлийн хүрээнд Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2017 оны 03-р сарын 17-ны өдрийн А/50 тоот тушаалаар Мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагын төгсөгч, мэргэжлийн ур чадвар эзэмшсэн иргэний мэргэшлийн түвшинг үнэлэх, үнэлгээг баталгаажуулах, хөндлөнгийн шалгалт зохион байгуулах журмын 2.7. Хөгжлийн бэрхшээлтэй үнэлүүлэгчийг бэрхшээлийн онцлогоос хамаарч үнэлгээний төлөвлөгөө, удирдамжийг тусгайлан боловсруулж үнэлнэ гэж зааж өгсөн нь боловсролын аль ч хэлбэрээр чадамж эзэмшсэн хөгжлийн бэрхшээлтэй төгсөгч, иргэн чадамжийн үнэлгээнд хамрагдан чадамжаа баталгаажуулах, хүлээн зөвшөөрүүлэх нөхцөл бүрдэж бий болсон.

Зорилго

Мэргэжлийн сургалтын байгууллага буюу богино хугацааны сургалтаар тодорхой хөтөлбөр агуулгын хүрээнд “чадамжтай” үнэлэгдэж төгссөн хөгжлийн бэрхшээлтэй төгсөгч, албан бус, амьдрах орчин, сонирхлоороо чадамж эзэмшсэн иргэний ур чадварыг үнэлж, баталгаажуулж, гэрчилгээжүүлэх нь хөдөлмөр эрхлэлтийн байдалд үзүүлэх үр нөлөөг судлах.

Судалгааны арга зүй

Хууль, журам, үзэл баримтлал, эрдэм шинжилгээний нийтлэл, өгүүлэл, цахим сайтаас мэдээлэл цуглуулан боловсруулах, нэгтгэн дүгнэх, харьцуулалтын арга зүйг тус тус ашиглан үр дүнг гаргасан.

Үр дүн

Судалгаанд хамрагдсан төгсөгчдийн суралцсан мэргэжлээр ангилбал 42% нь эсгий, эсгий эдлэл үйлдвэрлэгч мэргэжлээр суралцсан, 24% нь нарийн бичгийн дарга-албан хэргийн ажилтан, 17% бэлэг дурсгалын зүйл урлаач, 7% нь тогооч, 3% нь оёмол бүтээгдэхүүний оёдолчин, 1% нь хүнсний үйлдвэрийн тоног төхөөрөмжийн засварчин, хүнсний үйлдвэрийн тоног төхөөрөмжийн засварчин (цахилгаанчин) мэргэжлээр тус тус суралцаж чадамж эзэмшсэн байна.



Сургалтад хамрагдаж чадамжийн гэрчилгээтэй болсноор таны амьдралд гарсан өөрчлөлтийг нэрлэнэ үү?


Судалгаанд хамрагдсан нийт оролцогсдын 42% нь бусад гэж сонгосон нь найз нөхөдтэй болох, нийгэмших, бусадтай харилцах, гэрийн нөхцөлд хоол хийх чадвар эзэмшсэн гэх зэргээр амьдралд нь тодорхой өөрчлөлтүүд гарсан гэж хариулсан. 15% нь ажил хөдөлмөр эрхлэхэд өөртэй би тгэлтэй болсон, 23% нь орлого нэмэгдсэн гэж хариулсан нь гар урлалын бүтээлээ илүү сайн үйлдвэрлэж борлуулсан, ажилтай болсон 12%, албан тушаал ахисан 1%, цаашид суралцах мэргэжлийн чиглэл,



хэрэгцээгээ тодорхойлж чадсан 7% харагдаж байна. ХБИ-ний амьдралд илүү их нөлөө үзүүлж чадсан байна.

Тийм бол таны хөдөлмөрийн статус?

Ажил хөдөлмөр эрхлээгүй 28%, хувиараа ажил эрхэлдэг 24% байгаа нь суралцсан мэргэжлээрээ гэрээрээ оёдол хийх, бэлэг дурсгалын зүйл хийж өрхийн үйлдвэрлэл эрхэлдэг гэж хариулж байсан. Мөн байнгын ажлын гэрээтэй 17%, түр хугацааны гэрээтэй ажилладаг 7% нь байна.



Дүгнэлт

Судалгааны үр дүнгээс харахад 2022–2023 оны мэргэжлийн сургалтын байгууллагаар чадамж эзэмшсэн хөгжлийн бэрхшээлтэй 161 төгсөгч бүртгэлтэй байна. 78 төгсөгч судалгаанд хамрагдаж, 14 асуулгаар үр дүнгээ нэгтгэв. Сургалтын байгууллага төгсөгчдийг чадамжийн үнэлгээнд хамруулж, гэрчилгээжүүлэн хөдөлмөрийн зах зээлд нийлүүлэлт хийж байгаа нь тухайн хүний хөдөлмөр эрхлэлт, нийгэмших байдалд нөлөөлөл үзүүлж байгаа нь харагдаж байна. Төгсөгчдийн хүйсийн тэнцвэртэй байдал нь эмэгтэйчүүд 86%-тай байгаа нь жендерийн тэгш хүртээмж харагдахгүй байна. Орон нутгийн чадамжид суурилсан сургалт, иргэний өмнөх мэдлэг, ур чадварыг хүлээн зөвшөөрөх үнэлгээний хүртээмжийг цогцоор нэмэгдүүлэх, сургалтын байгууллагын сургалтын хөтөлбөр стандарт, хэрэглэгдэхүүн, хүний нөөц, орчин, багшийн арга зүйг сайжруулах, дэмжих чанарын баталгаажуулалтыг нэвтрүүлэх, зорилтод бүлгийн иргэдийн онцлогт тохирсон үйлчилгээний төрөл, хэлбэрийг өргөжүүлэх замаар мэргэшлийн тогтолцоог бэхжүүлэх шаардлага байна гэж дүгнэж байна.

Түлхүүр үг: Мэргэжлийн тогтолцоо, тэгш хүртээмж.

Ашигласан материал:

1. (2019). Мэргэшлийн хүрээ гэж юу вэ?, *Монголын хүн амын сэтгүүл*, 499(29), 60.
2. <https://mlsp.gov.mn/content/detail/1779>,
3. COOPERATIVE TECHNICAL AND VOCATIONAL EDUCATION AND TRAINING Quality management (QM) in Capacity Development Centers (CDCs) Project number: 18.2120.6–001.01.
4. (2019). *Мэргэжлийн боловсрол сургалтын Чадамжийн үнэлгээний ажилтан, баталгаажуулагчийн гарын авлага*. Монгол Улс, Улаанбаатар хот.
5. (2022). *Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын комиссын үйл ажиллагаатай холбоотой хууль эрх зүйн актын эмхэтгэл*. Монгол Улс, Улаанбаатар хот.
6. <https://legalinfo.mn/mn/detail/11711>

